



ХУУЛЬ САХИУЛАХЫН  
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН  
ХОЛБОО

# ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН  
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2017 №2 (60) 15 дахь жилдээ



## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

### ЭРХЛЭГЧ

#### **Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ**

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

### ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

#### **Б.БАТ-ЭРДЭНЭ**

Монгол Улсын Дээд Шүүхийн шүүгч, доктор (Ph.D),  
профессор

#### **Б.БАТЗОРИГ**

Доктор (Ph.D), дэд профессор

#### **Б.БОЛДБААТАР**

Монголын Криминологичдын холбооны гүйцэтгэх  
зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор

#### **Н.ГАНБАДРАЛ**

Доктор (Ph.D), дэд профессор

#### **Ж.ДОЛГОРСҮРЭН**

Доктор (Sc.D), профессор

#### **Н.ЖАНЦАН**

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D),  
профессор

#### **О.ЗОРИГТ**

Доктор (Ph.D)

#### **А.ЛХАГВА**

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D),  
профессор

#### **Г.ЭРДЭНЭБАТ**

Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Төрийн хууль  
цаазын шадар зөвлөх

### НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

#### **С.ГАНТУЛГА**

Доктор (Ph.D)

#### **Б.ЭНХБОЛД**

Доктор (Ph.D)

### ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

#### **С.ГАНТУЛГА**

Доктор (Ph.D)

### ЭХ БЭЛТГЭГЧ ДИЗАЙНЕР

#### **Х.БАДНААЖОНОН**



## Гарчиг

**КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

- Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг: нөхцөл байдал, шүүхийн практик **Б.Энхболд** 4
- Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд хийсэн SWOT шинжилгээ **Б.Мөнхдорж, Г.Отгонзул, Г.Золбоо** 11
- Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн бүртгэл-статистик **Д.Зүмбэрэлхам, М.Цэдэвсүрэн** 19

**ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

- Хүн худалдаалах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын үечлэлийн асуудалаа **С.Гантулга** 30
- Монгол-Ойрадын их цааз дахь хулгайлах хэрэгт хамаарах зүйл, заалтын тухай **Б.Жаргалсайхан** 39

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

- Эрүүгийн хэргийн талаарх мэдээллийн сангаас иргэдэд нээлттэй болгох мэдээллийг тодорхойлох нь судалгааны үр дүн **Б.Энхболд, Б.Мөнхдорж, Д.Сумъяацэрэн, Б.Мөнхсэргэлэн** 44
- Гэмт хэрэг мөрдөхүйд нөлөөлөх социогенетик /нийгмийн удамшил/-ийн асуудлууд **Н.Манлайбаатар** 53

**ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

- Монгол Улс дахь цагдаа судлалын төлөв байдал” судалгааны тойм **Б.Энхболд, Б.Мөнхдорж, Д.Сумъяацэрэн, Б.Мөнхсэргэлэн** 58
- Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөний загвар, түүний тогтолцоог тодорхойлох нь **Д.Булган** 73
- Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгчийн ажлын ачаалалд хийсэн дүн шинжилгээ **Б.Олзбаяр** 81

**КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

- Шүүхийн шинжилгээний байгууллага болон хууль сахиулах бусад байгууллагуудын ажлын уялдаа, эрх зүйн зохицуулалт, хүний нөөц, техник, технологийн зарим асуудал **Т.Очирбат** 90

**ЗАХИРГАА, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

- Аутсорсинг **Д.Оюунбат, Ж.Дашхүү** 99

**КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ****БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ  
ГЭМТ ХЭРЭГ: НӨХЦӨЛ БАЙДАЛ,  
ШҮҮХИЙН ПРАКТИК**

Б.Энхболд

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

**Хураангуй:** Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол улсад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг тулгамдсан асуудал болсоор байна. Судалгааны үр дүнгээс үзвэл сүүлийн 5 жилийн байдлаар бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг жилд 8900 орчим бүртгэгдэж үүнээс 1036 буюу 11.7 (%) нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл хэмжээг авч үзвэл 80 орчим хувьд нь хорих, баривчлах зэрэг нийгмээс тусгаарлах ял оногдуулж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого чанга байгааг илтгэж байна.

Түлхүүр үг: Хулгайлах, гэмт хэргийн бүрэлдэхүүн, ял, баривчлах ял, хорих ял

**1. Удиртгал**

Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-т “Иргэд хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, шударгаар олж авах, эзэмших, захиран зарцуулах, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”<sup>[1]</sup> гэж заасан бөгөөд Монгол Улсын эрүүгийн хуульд хүний өмчлөх эрхийг хамгаалж бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг бие даасан байдлаар хуульчилсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг /цаашид хулгайлах гэмт хэрэг гэх/

<sup>1</sup> Цагдаагийн ерөнхий газар. (2011). Current conditions of crimes committed in Mongolia: 2006 2010, Ulaanbaatar: National Police Agency of Mongolia

нь Монгол улс дахь гэмт явдлын бүтцэд дангаараа 39.4 хувь, шүүхээр шийдвэрлэж байгаа эрүүгийн хэргийн 11 орчим хувийг тус тус эзлэж байна. Монгол улсад хулгайлах гэмт хэргийн талаар олон тооны бүтээл, судалгааны ажил хийгдсэн боловч хулгайлах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй шүүхийн практикийн талаар дагнасан судалгааны ажил хараахан хийгдээгүй байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулж буй шүүхийн практикийг судалж дүгнэлт хийхэд оршино. Энэ зорилгын хүрээнд хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага-Онолын үндэслэл, Монгол улс дахь хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлын тойм, хулгайлах гэмт хэрэгт ял оногдуулж буй байдал гэсэн 3 асуудалд дүн шинжилгээ хийлээ. Судалгааны ажлын мэдээллийн эх сурвалжийг Цагдаагийн ерөнхий газар, Улсын дээд шүүхийн практик судалгааны төв, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн тайланд тус тус үндэслэсэн болно.

**2. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага- Онолын үндэслэл**

Гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах, ялаас чөлөөлөх асуудал нь криминологийн сонгодог онол<sup>[2]</sup>-ын үзэл баримтлалаар тайлбарлагддаг. Сонгодог онол нь хүн бүр гэмт хэрэг үйлдэх боломжтой бөгөөд гагцхүү гэмт хэрэг үйлдэх, эс үйлдэх нь тэдний чөлөөт ухамсараас шалтгаалана. Хүнийг гэмт хэрэг үйлдэхээс ухамсартайгаар татгалзуулах, тогтоон барих ухаалаг механизм нь үндэслэл бүхий хуулийн хориглолт байх ёстой, тэрхүү хориглолт нь эрүүгийн хуульд тусгасан ял хэлбэрээр илэрнэ гэсэн философи гаралгааг дэвшүүлсэн байдаг<sup>[3]</sup>. Хориглолт үндэслэлтэй байх нь ял шуурхай байх (Celerity), ял гарцаагүй байх (Certainty), ял тохирсон байх (severity) явдлаар хэмжигдэнэ. Тиймээс эрүүгийн хуульд эдгээр ойлголтуудыг зарчим болгож хуульчлах ёстой гэсэн санал

<sup>2</sup> Криминологийн сонгодог онолыг XVIII зууны үеийн соён гэгээрүүлэгч, философич Чезаре Бекарриа (Итали) болон Жерми Бентам (Англи) нар үндэслэсэн бөгөөд тэд орчин үеийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны шинэтгэлд үнэтэй хувь нэмэр оруулсан хуульч, сэтгэгчид юм.

<sup>3</sup> Ronald Akers criminological theory, New York, 2009. Oxford University press. P.21



дэвшүүлсэн нь орчин үеийн эрүүгийн эрх зүйн сонгодог зарчим болж дэлхийн ихэнх улс орнуудын эрүүгийн хуульд тусгалаа олжээ.

Нийтийн эрх ашиг сонирхолд халдсан үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох эрх нь зөвхөн хууль тогтоох байгууллагад хадгалагдах ёстой бөгөөд ял нь хатуу чанга, харигс, залхаан цээрлүүлэх шинжийг агуулахаас илүүтэйгээр гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэм буруугийн шинжид тохирсон, олон сонголттой байх учиртай. Харин шүүх хуульд зааснаас хатуу чанга болон хуулиар тогтоогоогүй ял оногдуулах ёсгүй. Түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг түргэн шуурхай илрүүлэх, нотлох ажиллагааг шударгаар явуулах нь цагдаагийн байгууллагын хариуцах үүрэг гэж тус тус үзсэн нь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны хөгжлийг шинэ шатанд гаргахад үлэмж нөлөө үзүүлсэн.

2002 онд батлагдсан Монгол Улсын эрүүгийн хууль бүхэлдээ энэ онолын үзэл баримтлалд үндэслэгдсэн бөгөөд эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3 дугаар зүйлд “хууль ёсны байх зарчим”, 6 дугаар зүйлд “шударга ёсны зарчим”, 9 дүгээр зүйлд “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим” бие даасан байдлаар хуульчлагджээ. Мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэгт “эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино” гэж заасан бол 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт “шүүх энэ хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд чанд нийцүүлж, шударга ёс, эрх зүйн ухамсарыг удирдлага болгон тусгай ангид заасан төрөл хэмжээний дотор ял оногдуулна” гэж тус тус заасан.

Хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” хэргийг хуульчилж, оногдуулах ялын төрөл хэмжээг нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг нь харгалзан 4 хэсэгт ялгамжтай хуульчилсан нь нэг талаас сонгодог онолын үзэл баримтлалд тулгууралсан, нөгөө талаас энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулах ялын төрөл хэмжээг тогтоож өгсөн.


Хууль тогтоогч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, түүний төрөл хэмжээг тогтоохдоо энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс татгалзахад нөлөөлхүйц байдлаар хориглолт тогтоож чадсан эсэх, оногдуулж

буй ялын төрөл, хэмжээ үр нөлөөтэй байгаа эсэх асуудал нь Монгол улс дахь хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, ял оногдуулж буй шүүхийн практикаар тодорхойлогдох юм.

### 3. Монгол улс дахь хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлын тойм

1990-1997 оны хооронд хулгайлах гэмт хэрэг улсын хэмжээнд тогтвортой өсч 100.000 хүн амд ноогдох дундаж түвшин 578 байсан бол 1998 оноос буурах хандлагатай болж 2003 онд дундаж түвшин 351 болжээ, харин 2004 оноос энэ үзүүлэлт өсөх хандлагатай болж дундаж түвшин 274 болсон байна. 2011-2015 оны хооронд хулгайлах гэмт 30719 бүртгэгдсэн нь жилийн дундаж 7403, 100,000 хүн амд ноогдох түвшин 251 гэсэн үзүүлэлттэй байна. 2015 оны хувьд 100,000 хүн амд ноогдох хулгайлах гэмт хэргийн түвшин 299 байгаа нь сүүлийн 8 жилийн үзүүлэлтээс хамгийн өндөрт тооцогдож, энэ үзүүлэлт өсөх хандлагатай байна. (График №1)

**График №1.** 100.000 хүн амд ноогдох хулгайлах гэмт хэрэг 1990-2015



Эх сурвалж: ЦЕГ-ын мэдээлэл, дүн шинжилгээний алба

Дээрх судалгаанаас үзэхэд Монгол улс дахь гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн нь хулгайлах гэмт хэргийн түвшингээс хамааралтай байгааг харуулж байна. Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд оногдуулахаар заасан ялын төрөл хэмжээ нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тогтоон барих хангалттай хориглолт болж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл хулгайлах гэмт хэрэг нь нийгэм, эдийн засгийн шалтгаантай боловч хууль тогтоогч ял оногдуулах зарчим, ялын төрөл, хэмжээг гэмт хэрэг үйлдсэн хүнд нөлөөлхүйц байдлаар ухаалаг хуульчлах ёстой.

Гэмт хэргийн шалтгааныг нийгмийн стрессын онолын үүднээс тайлбарлавал хувь хүний хэрэгцээ түүндээ хүрэх боломжийн хооронд үүсэх зөрүүтэй байдал гэж үздэг. Шилжилтийн нийгэм, эдийн засгийн



хямарлын үед нийгмийн гишүүдийн орлого буурч өөрсдийн хэрэгцээгээ хангаж чадахгүйгээс шалтгаалан гэмт үйлдлийн замаар эд материалыг олж авах явдал түгээмэл гардаг<sup>4</sup>.

Энэ онолын үүднээс авч үзвэл 1990-1992 оны хороонд монгол улсад үний өсөлт 4 дахин нэмэгдэж, улсын хэмжээнд 69.000 өрх амжиргааны баталгаажих түвшингээс догуур, нийт иргэдийн 35.9 хувь нь ядуу болон нэн ядуу, ажилгүйдлийн түвшин 6.3 хувьтай болжээ. Нийт гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 66.3 хувь нь ажилгүй, 71 орчим хувь нь ядуу ангилалд, 55.9 хувь нь 18-30 насны хүмүүс байжээ<sup>5</sup>. 1998 оноос хулгайлах гэмт хэрэг буурсан шалтгаан нь Монгол улсын эдийн засгийн өсөлт, иргэдийн амжиргааны болон боловсрол, соёлын түвшин дээшилсэн, гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа тогтворжсон зэрэгтэй холбоотой. Харин хулгайлах гэмт хэргийн чиг хандлага 2008-2011 оны хооронд буурч байсан бол одоогийн чиг хандлага өсөх төлөвтэй байгаа нь монгол улсын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой.

#### 4. Хулгайлах гэмт хэрэгт үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй шүүхийн практик

##### 4.1. Хулгайлах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх нэг хэлбэр нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд улсын нэрийн өмнөөс оногдуулдаг ял юм. Монгол улсын эрүүгийн хуульд заасан ялуудаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ, түүний хувийн байдалд нь тохирсон ялыг сонгон хэрэглэсэн тохиолдолд ялын үр нөлөө сайн байдаг. Иймд шүүхээс хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээг сүлийн 5 жилийн байдлаар авч үзлээ.

Хүснэгт 1-т үзүүлснээр Монгол улсын хэмжээнд 2011-2015 оны хооронд анхан шатны шүүхээр хулгайлах гэмт хэрэг 6600 шийдвэрлэгдсэн нь нийт хэргийн 21.5 хувийг эзлэж байна. Шүүхээр шийдвэрлэгдэж буй хулгайлах хэргийн тоо 2012 оноос жил дарааллан өсч, 2015 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан нь өмнөх онтой харьцуулахад 82 хэрэг буюу 5.7 хувиар өссөн байна. Шийдвэрлэгдсэн хулгайлах гэмт хэргийг түүний бүрэлдэхүүний төрлөөр нь авч үзвэл нийт хулгайлах гэмт хэргийн 9.6 хувь нь ердийн бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг /ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/, 87.3 хувь нь хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй, /ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 2, 3 дэх хэсэг/, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй /ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 4 дэх хэсэг/ 2.9 хувийг тус тус эзлэж байна.

Хүснэгт№2. Шүүхээр шийдвэрлэгдсэн хулгайлах гэмт хэрэг, зүйл хэсэг

#### (2011-2015)

Year	Хэрэг (145)	(%)	145.1	(%)	145.2	(%)	145.3	(%)	145.4	(%)
2011	1282	(100)	146	(10.5)	1064	(83.0)	55	(4.3)	27	(2.1)
2012	1281	(100)	147	(11.5)	1070	(83.5)	20	(1.6)	50	(3.9)
2013	1283	(100)	98	(7.6)	1111	(86.6)	33	(2.6)	41	(3.2)
2014	1336	(100)	129	(9.7)	1114	(83.4)	53	(4.0)	38	(2.9)
2015	1418	(100)	117	(8.3)	1234	(87.8)	16	(1.1)	37	(2.6)
Total	6600	(100)	637	(9.6)	5593	(84.7)	177	(2.6)	193	(2.9)

Монгол улсын шүүхийн ерөнхий зөвөлөлийн цахим мэдээллийн сан

Дээрх судалгаанаас үзвэл хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг тухайлбал Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 2 дах хэсгээр шийдвэрлэгдсэн нийт хэргийн 80-иас дээш хувийг эзлэж, энэ үзүүлэлт жил дарааллан өсч байна. Энэ хэсэгт хулгайлах гэмт хэргийг түгээмэл үйлддэг арга, халдлагын зүйл, газар болох орон байр

<sup>4</sup> Мертон, "Нийгмийн стрессын онол, түүнийг тайлбарлах хандлагууд" АНУ,1975 он,

<sup>5</sup> NSO and World Bank (2001).Participatory Living Standards Assessment 2000. Ulaanbaatar: National Statistical Office of Mongolia and World Bank.



агуулах сав зэргийг тусгайлан заасан байдагтай холботой юм. Түүнчлэн хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ нь энэ хэсэгт заасан хэмжээтэй ихэнх тохиолдолд тохирдог байна.

**4.2 Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж буй ялын төрөл, хэмжээ**

Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялын төрлийг хүснэгт №2-т харуулсан байна. Сүүлийн 5 жилийн судалгаанаас үзвэл 10821 хүн хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлснээс 7010 буюу 64.7 хувь нь хорих, 2073 буюу 19.4 хувь нь баривчлах, 397 буюу 3.6 хувь нь албадан ажил хийлгэх, 685 буюу 6.26 хувь нь торгох ялаар тус тус шийтгүүлсэн байна.


Хүснэгт №2 Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялын төрөл (2011-2015)

Ялын төрөл	Ял шийтгүүлэгчид									
	2011		2012		2013		2014		2015	
	2227 (100%)		2191 (100%)		2077 (100%)		2296 (100%)		2030 (100%)	
Торгох	142	(6.3)	151	(6.8)	122	(5.8)	149	(6.4)	121	(6.0)
Албадан ажил хийлгэх	71	(3.1)	94	(4.2)	88	(4.2)	73	(3.1)	71	(3.4)
Баривчлах	429	(19.2)	399	(18.2)	392	(18.8)	450	(19.5)	403	(19.5)
<b>Хорих</b>	<b>1436</b>	<b>(64.4)</b>	<b>1393</b>	<b>(63.5)</b>	<b>1381</b>	<b>(66.4)</b>	<b>1501</b>	<b>(65.3)</b>	<b>1299</b>	<b>(64.0)</b>
Хэрэгсэхгүй болгосон	45	(2.2)	153	(6.9)	94	(4.5)	123	(5.3)	121	(6.0)
Нэмэгдэл ял										
Эд хөрөнгө хураах ял	183	(8.2)	201	(9.1)	196	(9.4)	179	(7.7)	186	(9.1)

Монгол улсын шүүхийн ерөнхий зөвөлөлийн цахим мэдээллийн сан Шүүхээс 2015 онд 121 хүнийг нийт **645 сая** төгрөгийн торгох ялаар, 71 хүнийг 8400 цагийн албадан ажил хийлгэх ялаар, 103 хүнд нийт 12 сая төгрөгийн эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын шинжтэйгээр оногдуулжээ. Харин баривчлах ялаар 403 хүнийг шийтгэсэн нь дундажаар 2.6 сарын хугацаатай байна.

2011-2015 оны дундажаар хорих ял шийтгүүлсэн хугацааг авч үзвэл нийт хорих ял шийтгүүлэгчдын 63 хувь нь 2-3 жил, 20.1 хувь нь 3-5 жил, 10.3 хувь нь 5-10 жил, 6.6 хувь нь 10-15 жил хүртэл хугацаацаагаар шийтгүүлсэн байна. Энэ үзүүлэлт нь бусад оронтой харьцуулахад харьцангуй чанга ялын бодлого юм. Тухайлбал дээрх үзүүлэлтийг ХБНГУ-ын хулгайлах гэмт хэрэгт хорих оногдуулсан статистик үзүүлэлттэй харьцуулан авч үзье. /График №2 /

График №2 Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хугацаа /ХБНГУ ба Монгол улсын харьцуулалт, 2011-2015 он/





ХБНГУ-д хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ялыг аль болох оногдуулахаас зайлсхийдэг бөгөөд 10-аас дээш жилийн хорих ялыг бараг оногдуулдаггүй байна.

Харин Монгол улсын хувьд энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 1-2 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах сонголтыг хуульчлаагүй нь энэ төрлийн гэмт хэргийн 60-иас дээш хувьд нь 2-3 жилийн хорих ял оногдуулах нөхцлийг бүрдүүлжээ. Хууль тогтоогч эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дах хэсэгт хорих ялын хугацааг 1-15 жил байхаар хуульчилсан боловч 145 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг шууд 2 жилээс эхлэхээр заасан нь шүүхээс хорих ялыг нэг жилийн хугацаагаар оногдуулах боломжийг хаасан зохицуулалт болжээ.

2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 2015 онд батлагдсан эрүүгийн хуульд хорих ялын доод хэмжээг 7 хоног байсныг 6 сар болгон өөрчилөн найруулж, хулгайлах гэмт хэрэгт 7 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасныг 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тус тус өөрчлөн тусгасан нь олон улсын жишигт нийцсэн зохицуулалт болж шүүхээс энэ төрлийн гэмт хэрэгт хорих ялын доод хэмжээг хэрэглэх боломжийг олгожээ.

#### 4.3. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорих ялын гүйцэтгэл

Хүснэгт №3-т хорих ял оногдуулсан шүүхийн тогтоолыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх судалгааг харуулсан байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хорих ялаар 7010 хүн шийтгүүлсэнээс 2853 буюу 40.7 хувь нь хорих ялыг биечлэн эдлүүлсэн, үүнээс 93 хүн буюу 3.2 хувь нь эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж ял оноосон байна. Харин нийт хорих ял шийтгүүлэгчдын 3740 буюу 49.3 хувьд нь оноосон ялыг 2.1 жил хүртэл хугацаагаар тэнссэн байна. Мөн нийт хорих ялаар шийтгүүлэгчдын 440 буюу 6.2 хувь нь насанд хүрээгүй этгээдэд оногдуулсан хорих ялыг хойшлуулсан /ЭХЕА-ийн 62/, 144 буюу 1.5 хувь нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт оногдуулсан хорих ялыг /ЭХЕА-н 63/ тус тус хойшлуулсан байна. Нийт 133 хүнд өршөөл үзүүлэх тухай Монгол улсын хуульд заасан үндэслэл журмын дагуу эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлжээ.

#### Хүснэгт -3. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорих ялыг гүйцэтгэсэн байдал (2011–2015)

№		2011		2012		2013		2014		2015	
Хорих ялаар бүгд: үүнээс		1436	(100%)	1393	(100%)	1381	(100%)	1501	(100%)	1299	(100%)
1	Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	598	(41.6)	564	(40.8)	555	(40.1)	617	(41.1)	519	(40.0)
	Тусгай ангид зааснаас доогуур ял оноосон (ЭХ-н 55-1-р зүйл)	24	(1.6)	13	(0.9)	16	(1.1)	21	(1.3)	19	(1.4)
2	Тэнссэн (61-р зүйл)	681	(47.4)	706	(50.6)	710	(51.1)	765	(51.0)	608	(46.8)
3	Ял хойшлуулсан (ЭХ- 62-р зүйл)	98	(6.8)	84	(6.0)	85	(6.1)	83	(5.5)	90	(6.9)
4	Ял хойшлуулсан (ЭХ-н 63 –р зүйл)	33	(2.2)	22	(1.5)	19	(1.3)	20	(1.3)	20	(1.5)
5	Өршөөсөн ( ЭХ-н 77-р зүйл)	26	(1.8)	17	(1.2)	12	(0.8)	16	(1.0)	62	(4.7)

Дээрх судалгаанаас үзвэл шүүх хорих ялыг өндөр хувьтай оногдуулж байгаа бөгөөд оногдуулсан хорих ялын 40-өөс дээш хувьд нь уг ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуулийн зарим зохицуулалттай холбоотой гэж үзэж болно.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55.1 дүгээр зүйл “эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах”, 61 дүгээр зүйл “Тэнсэх”, 62 дугаар зүйл “насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах”





зэрэг энрэнгүй ёсны зарчмыг илэрхийлсэн зохицуулалт хуульчилж өгсөн нь ач холбогдолтой зохицуулалт болсон хэдий ч хулгайлах гэмт хэргийн хувьд дээрх журмыг удирдлага болгон хэрэг шийдвэрлэхэд хүндрэл учруулдаг байна. Учир нь хууль тогтоогч дээрх журмыг хэрэглэх тохиолдолд дараах үндсэн шалгуурыг хангасан байхыг хуульчилсан үүнд: 1) хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн байх 2) гэмт хэргийн улмаас учирсан хохиролоо нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан байх, 3) гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзан үзнэ гэж гэжээ. Дээрх 3 шалгуураас гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн байх гэсэн шаардлага ихэнх тохиолдолд хангагддаггүй байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдын 52.5 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүй этгээд, 8.9 хувь нь согтуугаар, 49.2 хувь нь бүлэглэн үйлдсэн, 17.2 хувь нь урьд шийтгэгдэж байсан этгээд буюу хувийн байдлын хувьд шалгуур үзүүлэлтийг хангахгүй этгээд байна.

Монгол Улсын эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлд хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын эрх зүйн үндсийг бэхжүүлж 5 дугаар зүйлийн 5.1-т “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд ...нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ ... үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн түгээмэл зарчим болохын хувьд чанд мөрдөгдөх учиртай. Гэвч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах шүүхийн практикт эд хөрөнгийн байдлаас шалтгаалан энэ зарчим зөрчигдөх явдал түгээмэл байна.

2015 онд баталсан Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд тэнсэх<sup>6</sup> шалгуур үзүүлэлтэд “... гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн...”, мөн зүйлийн 7 дугаар хэсэгт хугацаанаас өмнө тэнсэх албадлагыг цуцлах үндэслэлд “... гэмт хэргийн хохирлыг бүрэн төлсөн...” гэсэн шинэлэг заалт оруулсан нь өмнөх хуулийн алдааг заларуулсан зохицуулалт болсон гэж үзэх үндэстэй. Харин гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн этгээд ямар хугацаанд хохиролоо нөхөн төлөх, төлөөгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тус хуульд тусгаагүй нь учир дутагдалтай юм. Энэ нөхцөл байдлыг харгалзан үзэж 2017 оны

04 дүгээр сард батлагдсан эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “энэ хуулийн 1-д заасны дагуу гэмт хэргийн улмаас учруулсан хохиролоо төлөхөө илэрхийлж тэнсэгдсэн хүн хохиролоо нөхөн төлөх хугацааг шүүх тогтооно”<sup>7</sup> гэж заасан нь оновчтой зохицуулалт болжээ. Харин хохиролоо нөхөн төлөөгүй этгээдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, шүүхээс ямар хугацаа тогтоох эсэх асуудал нь тодорхойгүй байна.

### Дүгнэлт

1. Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн бүтэцэд хулгайлах гэмт хэрэг дангаараа 39 орчим хувийг эзлэж байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл цагдаагийн байгууллагад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 30719 бүртгэгдэж үүнээс 6600 буюу 21.4 хувийг нь шүүхээр шийдвэрлэсэн байна.

2. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл хэмжээг авч үзвэл 80 орчим хувьд нь хорих, баривчлах зэрэг нийгмээс тусгаарлах ял оногдуулж, нийт оногдуулсан хорих ялын 41 хувийг биечлэн эдлүүлдэг бол 59 хувьд нь эрүүгийн хуульд заасан үндэслэлээр ялыг тэнсэх буюу хойшлуулж байна. Энэ үзүүлэлт нь хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлого чанга байгааг илэрхийлэх бөгөөд эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан ял хөнгөрүүлэх, тэнсэх, эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж ял оногдуулах зэрэг журамд заасан шалгуур үзүүлэлтийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд хэрэглэхэд хүндрэлтэй байна.

3. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын дундаж хугацаа 4.3 жил байгаа нь бусад улс орны жишигтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дах хэсэгт хорих ялын үндсэн хугацааг 1-15 жил байхаар хуульчилсан байхад 145 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жил байхаар заасан нь хорих ялыг нэг жилийн хугацаагаар оногдуулах боломжийг хаасан зохицуулалт байсныг шинэ хуулиар зассан.

4. Хулгайлах гэмт хэрэгт үйлдсэн этгээдэд оногдуулах ялын төрөл хэмжээ, эрүүгийн хариуцлага хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал нь 2002 оны эрүүгийн хуульд оновчтой байдлаар хуульчлагдаж чадаагүй нь шүүхийн практикаас харагдаж байна.

<sup>6</sup> Монгол Улсын эрүүгийн хууль // төрийн мэдээлэл, УБ., 2016 №10-т нийтлэгдсэн.

<sup>7</sup> Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, //www.parlament.mn.



Энэ хууль тогтоогч гэмт хэргийг тогтоон барих, ухаалаг хориглолт хийж чадаагүй гэж үзэх үндэстэй. 2015 онд батлагдаж 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл хэмжээ, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлын талаар зарчмын ялгаатай хэд хэдэн өөрчлөлт туссан бөгөөд үр дүн нь хууль хэрэгжих явцад илрэн гарна гэж үзэж байна.



## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН SWOT ШИНЖИЛГЭЭ

Б.Мөнхдорж

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн

Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн хошууч

Г.Отгонзул Магистрант

Г.Золбоо ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын Статистикийн хэлтсийн сангийн эрхлэгч, цагдаагийн хошууч

**Хураангуй:** Цагдаагийн байгууллага дахь гэмт хэргийн статистикийн тогтолцоо, бүртгэлийн болон мэдээний маягт, аргачлал, үйл ажиллагааны өнөөгийн байдалд swot шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорьлоо.

### 1.Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

Цагдаагийн албаны тухай хууль 2017 оны 2 дугаар сарын 9-нд шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 76 дугаар тогтоолоор Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/55 дугаар тушаалаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг тус тус баталсан байна.

Зураг 1. Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц



Гэмт хэргийн статистикийн мэдээллийн сан бүрдүүлэх, гэмт хэргийн статистикийн мэдээ боловсруулан гаргах, мэдээлэл эрхлэн гаргаж, дүн шинжилгээ хийх чиг үүргийг ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар хэрэгжүүлдэг ба тус газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 6/617 дугаар тушаалаар байгуулагдсан. Бүтцийн хувьд ЦЕГ-ын тэргүүн дэд даргын удирдлагад харьяалагдаж, дүн шинжилгээ-судалгаа, Статистикийн гэсэн 2 хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Газрын дарга 1, Хэлтсийн дарга 2, Сангийн эрхлэгч 2, ахлах мэргэжилтэн 14, мэргэжилтэн 7, архивч-бүртгэгч 7 орон тоотойгоор ажилладаг байна.

Зураг 2. Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын бүтэц, зохион байгуулалт



Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар нь Цагдаагийн байгууллагаас хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийх, лавлагаа гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах, холбогдох санал, дүгнэлт, зөвлөмж, шийдвэрийн төсөл гаргах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Дүн шинжилгээ, судалгааны хэлтэс нь Мэдээллийн санд цугларсан мэдээлэл, хууль тогтоомжид дүн шинжилгээ, судалгаа хийх, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах, холбогдох санал, дүгнэлт, зөвлөмж, шийдвэрийн төсөл гаргах чиг үүргийн хүрээнд:

1. Хэрэг зөрчлийн гаралтын түвшин, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар албадаас ирүүлсэн цаасан мэдээллийг цахим санд бүртгэгдсэн мэдээлэлтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах;

2. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, нотлох ажиллагааны арга зүй, тактикийг боловсронгуй болгох зорилгоор криминологи судалгаа хийж үр дүн, нийгэмд өрнөж буй онцлог үйл явдлын талаар мэдээлэл цуглуулж, нэгтгэн боловсруулж удирдлагад танилцуулах;

3. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах арга тактик, бодлого төлөвлөлтийн чиглэлд дүн шинжилгээ, судалгаа хийх;

4. Алба нэгжүүдээс ирүүлсэн МНБГ-ын чиг үүрэгтэй холбоотой баримт бичгүүдийг (албан бичиг, танилцуулга) системчлэн ангилж архивлан дүн шинжилгээний ажилд ашиглах, хууль тогтоомжийн дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа явуулж байна.

Статистикийн хэлтэс нь Мэдээллийн сан бүрдүүлэх, сангийн бүрдүүлэлтэд хяналт тавих, сангийн мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийх, сангийн мэдээллийг удирдлагад танилцуулах, эрх бүхий албан тушаалтан ашиглах бололцоогоор хангах,

мэдээллийн сангаас лавлагаа гаргах, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, захиргааны зөрчлийн тоо бүртгэгч нарыг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд:

1. Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх (туслах тоо бүртгэлийн нэгдсэн сан, захиргааны зөрчлийн, захиргааны бүртгэлийн) Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлт гаргах;

2. Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын мэдээлэл, судалгааны ажил хариуцсан алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3. Дээд шатны байгууллага, албан тушаалтан, эрх бүхий бусад этгээдийг гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэл болон шаардлагатай бусад мэдээллээр хангах;

4. Цагдаагийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаанд судалгаа хийх, арга аргачлалыг боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллага төрийн байгууллага, түүний дотор хууль сахиулах байгууллагаас гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн санг онлайнаар бүрдүүлж, гэмт хэргийн болон гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, хохирол, сэжигтний мэдээллийн сангаас статистикийн мэдээлэл боловсруулан гаргаж, дүн шинжилгээ хийхдээ мэдээллийн технологийн дэвшлийг эрчимтэй нэвтрүүлж байгаа нь давуу тал юм.

## **2.Гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэлтийн байдал**

Цагдаагийн байгууллага 2016 онд гомдол, мэдээллийн санд 466736, түүний шийдвэрлэлтийн мэдээллийн санд 379063 гэмт хэргийн мэдээллийн санд 27873, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн санд 9435, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн санд 18270, түдгэлзүүлсэн хэргийн мэдээллийн санд 9101, сэргээсэн хэргийн мэдээллийн санд 10498, нөхөн илрүүлсэн хэргийн мэдээллийн санд 1360, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунгасан хэргийн мэдээллийн санд 612, прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан хэргийн мэдээллийн санд 2926, нэгтгэсэн хэргийн мэдээллийн санд 2929, зүйлчлэл өөрчлөгдсөн мэдээллийн



санд 2146, харьяаллын дагуу шилжүүлсэн мэдээллийн санд 1663, сэжигтний мэдээллийн санд 23677, яллагдагчийн мэдээллийн санд 22014, таслан сэргийлэх арга хэмжээ авсан мэдээллийн санд 14235, хохирогч иргэн, байгууллагын мэдээллийн санд 27785, хохирлын мэдээллийн санд 26501, хохирол нөхөн төлүүлтийн мэдээллийн санд 13867, хөрөнгө битүүмжилсэн мэдээллийн санд 1520 нэгж мэдээлэл байна.

Туслах тоо бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд захиргааны зөрчлийн мэдээллийн санд саатуулагдсан хүний мэдээллийн санд 81887, торгуулийн хуудсаар торгосон мэдээллийн санд 989838, шийтгэврээр торгосон мэдээллийн санд 102417, захиргааны хяналтад байгаа хүний мэдээллийн санд 1910, албадан саатуулсан мэдээллийн санд 761, түр саатуулсан мэдээллийн санд 2888, албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан иргэний мэдээллийн санд 681, захиргааны зөрчлийн улмаас хохирсон хүний мэдээллийн санд 6210 нэгж мэдээлэл тус тус санд төвлөрүүлжээ.

### 3. Гэмт хэргийн статистикийн бүртгэлийн болон мэдээний маягт, аргачлал

Цагдаагийн байгууллага нь Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр батлагдсан, гэмт хэргийн анхан шатны бүртгэлийн 27 төрлийн маягт, маягт нөхөх аргачлалын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 1 дүгээр тушаалыг үндэслэн “Гэмт хэргийн бүртгэл”-ийн системийг ашиглан Цагдаагийн ерөнхий газрын 2015 оны А/21 дүгээр тушаалаар баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам **“Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх” (код 701)-аар** зохицуулдаг байна.

Цагдаагийн байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан 21 аймаг, 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтэс нь цагдаагийн байгууллагын дотоод нэгдсэн сүлжээнд хамрагдсан ба гэмт хэргийн анхан шатны маягыг маягт нөхөх аргачлалын дагуу бөглөн онлайнаар “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх” /ЦБҮАЖ код-701/ журмыг үндэслэн мэдээллийн сан бүрдүүлдэг.

Тус газар, хэлтэст мэдээлэл судалгаа хариуцсан алба хаагч ажиллах бөгөөд (мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, захиргааны зөрчлийн тоо бүртгэгч) алба хаагчдын мэдээллийн нэгдсэн санд оруулсан мэдээллийг тасаг, албадын дарга нараар хянуулж баталгаажуулах, буруу ташаа орсон мэдээллийг зөвтгүүлэх, хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээллээр удирдлагыг хангах ба Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын Статистикийн хэлтсийн сангийн эрхлэгч, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нар нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг.

Зураг 3. Мэдээллийн сан бүрдүүлэх үе шат



#### Бүртгэлийн дараах маягтууд байна. Үүнд:

- 1/“Гомдол, мэдээллийн бүртгэл (маягт ГМБТ-1100)”;
- 2/“Гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн бүртгэл” (маягт ГМБТ-1101);
- 3/“Эрүүгийн хэрэг үүсэхээс татгалзсаныг хүчингүй болгосон гомдол, мэдээллийн бүртгэл”(маягт ГМБТ-1102);
- 4/“Гэмт хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2100);
- 5/“Сэжигтний бүртгэл” (маягт ГХТБ-2201);
- 6/“Яллагдагчийн бүртгэл” (маягт ГХТБ-2202);
- 7/“Сэжигтнийг баривчилсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан бүртгэл” (маягт ГХТБ-2203);
- 8/“Хохирогч иргэн, байгууллагын бүртгэл” (маягт ГХТБ-2301);



- 9/“Хохирлын бүртгэл” (маягт ГХТБ-2302);
- 10/“Хохирол нөхөн төлүүлэлтийн бүртгэл” (маягт ГХТБ-2303);
- 11/“Хөрөнгө битүүмжлэлтийн бүртгэл” (маягт ГХТБ-2304);
- 12/“Яллах дүгнэлт үйлдүүлэх, яллагдагчаар татсан тогтоол батлуулах саналтайгаар прокурорт шилжүүлсэн хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2101);
- 13/“Хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2102);
- 14/“Түдгэлзүүлсэн хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2103);
- 15/“Сэргээсэн хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2104);
- 16/“Нөхөн илрүүлсэн, эрэн сурвалжилж тогтоосон хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2105);
- 17/“Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунгасан хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2106);
- 18/“Прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2107);
- 19/“Нэгтгэсэн хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2108);
- 20/“Зүйлчлэл өөрчилсөн хэргийн бүртгэл” маягт (ГХТБ-2109);
- 21/ “Харьяаллын дагуу шилжүүлсэн хэргийн бүртгэл” (маягт ГХТБ-2110);
- 22/“Зарим үйлдэл холбогдол, сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон бүртгэл” (маягт ГХТБ-2111).

Статистик мэдээний дараах маягтууд байна. Үүнд:

- 1/ “Гэмт хэргийн мэдээ” (маягт ГХТБ-2401);
- 2/ “Сэжигтэн, яллагдагчийн мэдээ” (маягт ГХТБ-2402);
- 3/ “Хохирогч иргэн, байгууллагын мэдээ” (маягт ГХТБ-2403);
- 4/ “Бүртгэгдсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээ” (маягт ГХТБ-2404);
- 5/ “Түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээ” (маягт ГХТБ-2405).

#### **4.Гэмт хэргийн статистикийн эрх зүйн зохицуулалт**

Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар Цагдаагийн байгууллага нь тоо бүртгэл хөтөлж, 20 төрлийн мэдээллийн сан үүсгэн, үйл ажиллагаандаа ашиглахаар заажээ.

Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 6/617 дугаар тушаалаар байгуулагдсан. Тус газрын Статистикийн хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/21 дугаар тушаалаар баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх заавар”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Уг заавартай холбоотой эрх зүйн актууд болох Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 12 дугаар сарын 25-ны 01/174 дүгээр тушаалаар зөвшөөрсний дагуу ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тушаалаар “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт, Статистикийн мэдээний маягт, Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт нөхөх заавар”-ыг баталсан байдаг.

Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын прокурорын газрын дэргэдэх мөрдөн байцаах албаны даргын 2010 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн №43/182/223/21 дугаар тушаалаар баталсан “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг хөтлөх, мэдээллийн санд төвлөрүүлэх журам”-ын дагуу цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд гэмт хэргийн мэдээллийг оруулж байна.

#### **5.Цагдаагийн байгууллагын мэдээллийн технологийн ашиглалтын байдал, сүлжээнд холбогдсон байдал**

Цагдаагийн байгууллагын ашиглаж буй мэдээллийн нэгдсэн сан нь Web application, Desktop application гэсэн 2 хэсгээс бүрдсэн байна.

Web application хэсэгт: Мэдээллийн нэгдсэн систем, Эрэн сурвалжлалтын систем, Гэмт хэргийн бүртгэл, Захиргааны зөрчлийн бүртгэл, Хүний нөөцийн бүртгэл, Хайлт лавлагааны систем, Судалгаа хяналтын бүртгэлийн систем, Удирдлагын хэсэг, 307 буюу Мэдээ, мэдээллийн систем, [crimemap.police.gov.mn](http://crimemap.police.gov.mn), [gun.police.gov.mn](http://gun.police.gov.mn), [eis.police.gov.mn](http://eis.police.gov.mn), [sas.police.gov.mn](http://sas.police.gov.mn).







сантай болж, 21 аймгийн цагдаагийн газар, хэлтсээс шалгасан эрүүгийн хэрэг, зөрчлийн үндсэн болон туслах мэдээллийг оруулж хэвшсэн.

Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2010 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн №43/182/223/21 дугаар тушаалаар “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг хөтлөх, мэдээллийн санд төвлөрүүлэх журам”-ын дагуу цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд гэмт хэргийн мэдээллийг оруулдаг.

Цагдаагийн ерөнхий газрын Статистикийн хэлтэс нь сар бүр **15 төрлийн гэмт хэргийн статистик тайлан** тогтмол гаргаж байна. Үүнд:

1. Бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ
2. Хохирогч, иргэн байгууллагын мэдээ
3. Сэжигтэн, яллагдагчийн мэдээ
4. Бүртгэгдсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээ
5. Хороо сумдад гарсан гэмт хэргийн мэдээ
6. Гэм хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэдийн мэдээлэл
7. Амиа хорлосон болон золгүй байдлаар нас барагсдын мэдээ
8. Бүртгэгдсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээ /Товч /
9. 7 хоногийн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээ /Товч /
10. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг
11. товчоо
12. Бүртгэлийн Гэмт хэрэг үйлдэгдсэн этгээд нь тогтоогдоогүй зарим төрлийн гэмт хэрэг
13. Тухайн сард хэрэгсэхгүй болгож мэдээнээс хасагдсан хэрэг
14. Түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээ
15. Түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээ /Товч /

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 онд баталсан жагсаалтын дагуу дараах 20 гаруй байгууллага, албан тушаалтанд гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээг хүргүүлдэг байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба
2. Улсын Ерөнхий прокурорын газар
3. Хууль зүй, дотоод хэргийн яам
4. Үндэсний статистикийн хороо
5. Нийслэлийн аялал жуулчлалын газар
6. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар
7. Гадаад харилцааны яам
8. Хүн ам, нийгмийн хөгжил, нийгмийн хамгааллын яамны жендерийн Ажлын албанд хэвлэмэл байдлаар,
9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
10. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар
11. Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар
12. Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хороо
13. Төрийн тусгай хамгаалалтын газар
14. Авлигатай тэмцэх газар
15. Улсын дээд шүүх
16. Шүүхийн ерөнхий зөвлөл
17. Нийслэлийн прокурорын газар
18. Тагнуулын ерөнхий газар
19. Хууль зүйн үндэсний хүрээлэн
20. Хууль сахиулахын их сургууль
21. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
22. Хүүхдийн төлөө үндэсний газарт цахим хэлбэрээр хүргүүлдэг.


Мөн гэмт хэрэг, хохирогч иргэн, байгууллага, хохирлын, гэмт хэрэг үйлдэгсэд, гэмт хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлт, түдгэлзүүлсэн хэргийн мэдээ, насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн статистик мэдээг боловсруулан, цагдаагийн байгууллагын [police.gov.mn](http://police.gov.mn), [guide.police.gov](http://guide.police.gov) цахим хуудаст байршуулж, ЦЕГ-ын харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын удирдлага, алба хаагчдыг мэдээллээр хангадаг байна.





Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд 2010 оноос хойш бүртгэлийн нэгдсэн дугаар авч оруулсан мэдээлэл 11 сая орчим өгөгдлийн санд орсон мөр бичлэгийн тоогоор 195 сая гаран бичлэг хадгалагдаж байна.

График 1. Мэдээллийн сан дахь өгөгдөл



### 7. Гэмт хэргийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглаж буй байдал

Цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн талаарх мэдээллийн сан, статистикийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, төр засгийн холбогдох байгууллага, албан тушаалтныг статистикийн мэдээлэл, судалгааны тайлан, танилцуулга, мэдээллээр ханган ажилладаг. Түүнээс гадна гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, гэмт хэрэгтэй тэмцэх арга, тактик, үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлдэг. Уг чиг үүргийг Дүн шинжилгээ, судалгааны хэлтэс нь хэрэгжүүлэн ажиллаж байна. ЦЕГ гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн товхимлыг 2006 оноос эхлэн жил бүр эрхлэн гаргаж хэвшсэн нь давуу тал.

### 8. SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<p>1. Төрийн байгууллага, түүний дотор хууль сахиулах байгууллагуудаас гэмт хэргийн мэдээллийг онлайнар нэгдсэн сан бүрдүүлж, гэмт хэргийн үндсэн болон гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, хохирол, сэжигтний мэдээллийн сангаас статистикийн мэдээлэл боловсруулан гаргадаг, дүн шинжилгээ хийж, мэдээллийн технологийн дэвшлийг эрчимтэй нэвтрүүлж байгаа нь давуу тал.</p> <p>2. Цагдаагийн албаны тухай хуульд тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан үүсгэн, үйл ажиллагаандаа ашиглахаар тусгаж, цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөхдөө мөрдлөг болгох журмаа баталсан.</p> <p>3. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн бусад байгууллагатай жишиж үзвэл гэмт хэргийн мэдээллийн цахим сангийн баяжилт, ашиглалт харьцангуй боловсронгуй.</p> <p>4. Улсын хэмжээнд гэмт хэргийн тоо бүртгэлийг нэгтгэн хөтөлдөг.</p> <p>5. ЦЕГ-ын харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд дотоод сүлжээнд бүрэн холбогдсон.</p> <p>6. Мэдээллийн санг онлайн хэлбэрээр бүрдүүлдэг.</p>	<p>1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд мэдээлэл судалгааны чиглэлээр ажиллаж байгаа 88 алба хаагчдын 74 буюу 84.0 хувь нь эрх зүйч, 8 буюу 9.1 хувь нь эдийн засагч, 1 буюу 1.1 хувь нь статистик мэргэжилтэй, авлигал, тагнуулын байгууллагад мөн эрх зүйч мэргэжилтэй алба хаагчид ажиллаж байна. Үүнээс үзэхэд энэ чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдыг статистикийн чиглэлээр мэргэжүүлэх зайлшгүй шаардлагатай.</p> <p>2. Мэдээллийн сангийн ачаалал, сүлжээний хурднаас шалтгаалан мэдээ мэдээлэл боловсруулах үйл явц удаашралтай.</p>
Боломж	Эрсдэл
<p>1. Гэмт хэргийн тоо бүртгэл хөтөлдөг бусад байгууллагатай жишиж үзвэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт, суурь бааз сайтай.</p> <p>2. Цагдаагийн байгууллагын бааз суурь дээр үндэслэн хууль сахиулах байгууллагын гэмт хэргийн нэгдсэн санг үүсгэх боломжтой.</p> <p>3. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан болон зөрчлийн учир шалгагдсан эсэх лавлагаа авах боломжтой.</p>	<p>1. Мэдээллийн сангийн ачааллаас шалтгаалсан эрсдэл. Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд өнөөгийн байдлаар 11 сая гаруй мэдээлэл цугларсан, цугларсан мэдээллээс сар бүр гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээг боловсруулан гаргахад нийт 1300 гаруй багана, 63 мөр 21 төрлийн мэдээ, судалгааг гаргахад өгөгдлийн сангийн ачаалал ихсэж цаг хугацаа алдагдаж байгаа тул мэдээллийн сангийн өгөгдлийн баазыг өргөтгөх.</p> <p>2. Гэмт хэргийн анхан шатны мэдээллийг оруулж байгаа алба хаагчид гэмт хэргийн тоо бүртгэл, мэдээллийн сангийн талаар тодорхой ойлголтгүйгээс мэдээлэл буруу, зөрүүтэй орох эрсдэлтэй.</p>



### Санал

Дээрх судалгааны дэд ажлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Цагдаагийн албаны тухай болон Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль батлагдсантай холбогдуулан гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээний бүртгэлийн маягт, хүснэгт, программ хангамжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, программ хангамжид холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах;

Иймд “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх” (код-701), “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх” (код-702), “Судалгаа хяналтын тоо бүртгэл хөтлөх” (код-703) болон бусад журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж батлуулах;

2. Хууль сахиулах их сургуулийн сургалтын хөтөлбөрт гэмт хэргийн статистикийн мэдээллийн системд ажиллах, гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг үнэн зөв оруулах, мэдээллийн санг ашиглаж сургах чиглэлээр хичээл тусгах;

3. Шинээр томилогдон ажиллаж байгаа

алба хаагчдад Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд ажиллах гарын авлага”, “Мэдээллийн сан, түүнийг ашиглах арга зүй”, “Мэдээллийн сангийн ашиглалт, анхаарах асуудал” сэдэвт, мэдээлэл судалгаа хариуцсан алба хаагчдыг гэмт хэргийн статистикийн чиглэлийн богино болон урт хугацааны сургалтад хамруулах, “Мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих арга зүй” сэдвээр үе шаттайгаар сургалт зохион байгуулах;

4. Хүснэгтэн мэдээллийг ухаалаг тайлангийн хэлбэрт шилжүүлэх, тайланд суурилсан дүн шинжилгээ хийдэг программ хангамжийг ашиглах;

5. Статистикийн чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдыг хосолсон мэргэжлээр (статистикч) богино болон урт хугацааны сургалтад хамруулах, гадаад орны туршлага судлуулах зэрэг болно.

--0--



## ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ-СТАТИСТИК

Д.Зүмбэрэлхам

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
Эрдэмтэн нарийн бичгийн  
дарга, доктор (Ph.D), профессор

М.Цэдэвсүрэн

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм  
шинжилгээний ажилтан, магистр

### Гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн бүртгэл

Хууль тогтоомжийн зохицуулалтыг судлан үзэхэд гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн бүртгэл нь “тоо бүртгэл”, “дүн бүртгэл” зэрэг утгаар гол төлөв тусгагдсан байна. Эдгээр бүртгэл нь хүн ам, эдийн засаг, нийгмийн зэрэг олон чиглэл, салбараар хөтлөгдөж ирсний нэг төрөл нь эрх зүйн зөрчил тэр дундаа гэмт хэрэг, захиргааны зөрчил юм.

Гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн “Бүртгэл”-ийн талаар хууль тогтоомжид тусгагдсан байдлыг тоймлон үзвэл Тагнуул, Замын цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Цагдаагийн байгууллагаас олон төрлийн бүртгэлийг хөтөлж байна.

(- Гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэл;

- Гэмт хэргийн тоо бүртгэл;

- Гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоо бүртгэл;

- Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо бүртгэл;

- Зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэл;

- Биеэ үнэлсэн, эсхүл бусдын биеийг үнэлүүлсэн зөрчилд захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийн талаарх;

- гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл

- замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч болон зөрчлийн тоо бүртгэл

- гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эрүүгийн хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан хүний талаар;

- ял шийтгүүлсэн хүний талаар;

- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаар;

- эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болж цагаатгагдсан хүний талаар;

- эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялыг хойшлуулсан хүний талаар;

- хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхгүй, мөн хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа, хүүхэдтэй хэрцгий харьцаж байгаа этгээдийн талаар;

- өршөөл, уучлалд хамрагдсан хүний талаар;

- гэмт хэрэгт хохирсон хүний талаар;

- зөрчил үйлдсэн этгээдийн талаар;

- эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар;

- гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтад байгаа хүний талаар;

- цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын тоо бүртгэл;

- эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хуулийн этгээдийн талаар;

- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх нэгдсэн тоо бүртгэл;

- эрүүгийн гэмт хэргийн дүн бүртгэлийн нэгдсэн тогтолцоо.)

“Тоо бүртгэл”, “Дүн бүртгэл” гэсэн утгаар дээрх бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, тогтолцоо байгаагаас Цагдаагийн байгууллагад хамгийн олон төрөл<sup>[8]</sup>-ийн бүртгэл хөтлөгдөхөөр хууль тогтоомжид заасан байна.

Дээр дурдсан хууль тогтоомжид нэрлэн заасан бүртгэлийн төрлөөс гадна зарим төрлийн бүртгэл хөтлөх харилцааг тусгай хууль, эрх зүйн актаар зохицуулдаг. Тухайлбал, Шүүхийн, Хуулийн этгээдийн, Эд хөрөнгийн эрхийн улсын, Иргэний улсын, Аюултай хаягдлын хадгалалт, устгалын, Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэлийг тус тус нэрлэж болно.

Гэмт хэргийн болон захиргааны зөрчлийн статистик

Статистик гэдэг нь латины “статус” эд юмсын тодорхой хэмжээ гэсэн үгнээс гаралтай бөгөөд энэхүү нэр томъёог анх 1746 онд Немцийн эрдэмтэн Готфрид Ахенваль шинжлэх ухаанд оруулжээ.<sup>[9]</sup>

Аливаа мэдээллийн шинж чанарыг шалгаад үндсэн мэдээллээс тодорхой төрлийг сонгон авч түүний шинж чанарт тулгуурлан үндсэн мэдээллийг тогтоох талаар аргачилж буй онол-арга зүйн хэлбэржсэн байдлыг Статистик гэнэ.<sup>[10]</sup>

Хэлбэржилт нь 2 үндсэн төрөлтэй. Нэгдүгээрт, байгаа мэдээллийг цуглуулж хүснэгт, графикт оруулж мэдээллийн дундаж болон чиг хандлагыг тодорхойлсноор тухайн мэдээллийн онцлогийг гаргаж авах буюу мэдээллийг нэг бүрчлэн бичиж тэмдэглэх төрөл. Хоёрдугаарт, үндсэн мэдээллээс түүвэр хийх байдлаар үзүүлэлтийг сонгох

<sup>8</sup> Хавсралт 1-ээс харна уу.

<sup>9</sup> Монгол Улсын бүртгэл, статистикийн үүсэл, хөгжил УБ., 2014. 9 дэх тал. Боловсруулж эмхэтгэсэн Ц.Бардах, Х.Бажийхүү

<sup>10</sup> Albert2005.co.jp



ба сонгосон түүвэр мэдээлэлд тулгуурлан үндсэн мэдээллийн онцлог, чиг хандлагыг тодорхойлох төрөл. Энэ төрөл нь 1920-иод оны үеэс үүссэн гэж эх сурвалжид тэмдэглэгдсэн байх бөгөөд энэ төрөлд түүвэр мэдээлэл эргэлзээгүй байх нь хамгийн чухал.

Нэг дэх төрөл буюу “нэлэнхүйн статистик”-ийн давуу тал нь энэ тохиолдолд нэг бүрчлэн тэмдэглэсэн мэдээлэл өгөгдөх ба алдаа гарах магадлал бага боловч сул талууд байсан учраас эдгээрийг нөхөх зорилгоор 2 дахь төрөл буюу “түүвэр статистик” гарч ирсэн. 2 дахь төрлийн давуу тал нь цаг хугацаа, зардал, хүний нөөц зэргийг хэмнэдэг. Тэгэхдээ анхаарах хэд хэдэн зүйл байдаг. Тухайлбал, түүврийг оновчтой сонгох, үнэн эсэхийг магадлах, зорилгод нийцсэн байх зэрэг болно.

Статистикийн гол онцлог нь нийгмийн аливаа үзэгдэл, үйл явцыг тоогоор илэрхийлдэгт оршдог ба орчин үеийн ШУ-ны зарчимд тулгуурласан анхны “хүн амын тооллого” нь 1896 онд Бельги улсын статистикч А.Кетлийн удирдлага дор явагдаж байжээ. Статистик нь тоог тоолох, дунджийг гаргах, онцлог болон чиг хандлагыг тодорхойлох зэрэг олон тооны бүрдэл хэсэгтэй байж болно.

Манай улсад статистикийн буюу тоо бүртгэл хөтлөх үйл ажиллагаа хүн ам, мал, эд хөрөнгийн гэсэн төрөл хэлбэрт тулгуурлан хөгжиж ирсэн нь статистикийн түүхэн хөгжлийн талаарх эх сурвалжуудаас харагддаг.

Статистикийн буюу тоо бүртгэлийн байгууллагын албан ёсны үүсэл нь 1924 онд Дотоод хэргийн яаманд тоо бүртгэлийн бие даасан хэлтэс байгуулагдсанаас үүсэлтэй бөгөөд 1927 оны Шүүх явдлын яамны шинэчлэн тогтоосон дүрэмд “... мөнхүү цааз хууль зэргийг шинэчлэн зохиох, зааварлах, тайлбарлах, өөрчлөх устгах тухай саналыг гаргаж зохих газарт мэдүүлэн батлуулж гүйцэтгэх иргэний ба эрүүгийн хэрэг халдагсдын тоо бүртгэх...” гэж заасан байгаагаас харахад иргэний хэргийн хариуцагчийн мөн эрүүгийн хэрэгт холбогдогчийн албан ёсны тоо бүртгэл энэ үеэс эхлэлтэй байна.

Статистикийн тухай хууль анх 1994 онд түүний дараа 1997 онд тус тус батлагдсан байдаг. Хуульд зааснаар албан ёсны статистик нь “Макро эдийн засгийн, Хүн ам, нийгмийн, Үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн, Шүүхийн, Хүрээлэн байгаа орчны статистик” гэсэн үндсэн чиглэл тэдгээрт хамаарах үзүүлэлтээр гарч байхаар

хуульчлагдсан.

Түүнчлэн статистик мэдээлэл нь 1997 оны Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө албан ёсны статистик мэдээлэлд тулгуурлан гарч байсан бол шинэчилсэн найруулгаар “захиргааны статистик” мэдээлэл гэсэн төрлийг нэмж статистик мэдээллийн төрөл, агуулгыг өргөжүүлсэн байна.

УИХ-аас 2006 онд “Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөр 2006-2010”, 2011 онд “Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2011-2015”-ийг тус тус баталсан бөгөөд 2011 онд батлагдсан хөтөлбөрт **“Статистикийн тогтолцоог бэхжүүлэх, Статистикийн аргачлал, ангилал, шинжилгээ, судалгааг төгөлдөржүүлэх, Салбарын статистикийг боловсронгуй болгох, Үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх, Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, Статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх”**<sup>[1]</sup> гэсэн дэд зорилтууд тусгагдаж байжээ.

Цаашид статистикийн салбарт баримтлах чиг хандлагын талаар судлан үзэхэд “Монгол Улсын статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2020”-ийн төсөл<sup>[2]</sup>-ийг боловсруулсан байна. Энэхүү төсөлд “Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх, Статистикийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн статистикийн дэд бүтцийг хөгжүүлэх, Статистикийн мэдээллийн менежментийг сайжруулах, Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, Статистикийн чадавхыг бэхжүүлэх, Статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох” гэсэн зорилтууд тусгагджээ. Мөн УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлагдсан бөгөөд Засгийн газраас Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулж, 2018 онд УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгагдсан байна.

Монгол Улс дахь бүртгэгдсэн гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн нөхцөл байдал

<sup>1</sup> А.Дэмбэрэл. Статистикийн салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг. Сургалтад зориулсан материал.

<sup>2</sup> Монгол Улсын Их хурал Цахим хэлэлцүүлэг. <http://forum.parliament.mn/projects/78>



Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар статистик мэдээлэл нь албан ёсны болон захиргааны гэсэн хэлбэртэй байх бөгөөд мөн дээр дурдсан 5 үндсэн үзүүлэлтээр хуульчлагдсан байна. Үүнээс Шүүхийн статистик үзүүлэлтээр “Эрүүгийн хэргийн тоо, төрөл, Шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нас, хүйсийн ялгаа, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, Дампуурсан аж ахуйн нэгж, Захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт” гэсэн 5 үзүүлэлт тусгагдсан байдаг. Харин хуульд захиргааны зөрчилтэй холбоотой үзүүлэлт хуульчлагдаагүй байна.

Монгол Улсын үндэсний статистикийн хорооноос жил бүр Монгол Улсын статистикийн эмхтгэлийг эрхлэн гардаг бөгөөд энэхүү эмхтгэлд дараах төрлийн үзүүлэлт “гэмт хэрэг” гэсэн бүлэг үзүүлэлтэд тусгагдсан байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

д/д	Статистикийн эмхтгэл <sup>1</sup> д	Хуульд
1	Бүртгэгдсэн гэмт хэрэг /гэмт хэргийн ангилал, төрөл, бус аймаг нийслэлээр, гэмт хэргийн зүйл ангиар/	Хуульд энэ агуулгаараа тусгагдаагүй. Эрүүгийн хэргийн тоо, төрөл гэдэг нэршлээр хуульчлагдсан.
2	18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг /бус, аймаг, нийслэлээр/	Хуульд нэрлэн заагаагүй боловч ҮСХ-ноос энэ үзүүлэлтээр гаргадаг нь хуульд харшлахгүй.
3	Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид /бус, аймаг, нийслэлээр/	Хуульд нэрлэн заагаагүй боловч ҮСХ-ноос энэ үзүүлэлтээр гаргадаг нь хуульд харшлаагүй.
4	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт /хохилогч иргэд, эмэгтэйчүүд, нийгмийн байдал, насны бүлгээр/	Хуульд заасан.
5	Шүүхээр ял шийтгүүлсэн хүн /бус, аймаг, нийслэлээр, эмэгтэйчүүд, боловсролын түвшин, насны бүлгээр/	Хуульд заасан. Шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нас, хүйсийн ялгаа гэдэг нэршлээр хуульчлагдсан.
6	Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан /бус, аймаг, нийслэлээр, ажлаас буруу шилжүүлсэн, ажлаас үндэслэлгүй халагдсан, цалин хөлсний маргаан/	Хүн ам, нийгмийн статистикийн үзүүлэлт болж хуульчлагдсан. Захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт хуульчлагдсан.боловч эмхтгэлд нийтлэгддэггүй.
7	Шүүхээр шийдвэрлүүлсэн дампуурсан аж ахуйн нэгж /бус, аймаг, нийслэлээр/	Хуульд заасан. Тэгэхдээ “дампуурсан аж ахуйн нэгж” гэсэн өргөн агуулгаар хуульчилсан.
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн нөхөн төлүүлэлт /эрүү, иргэн, захиргаа, бусад хэргийн/	
9	Хорихоор өөр төрлийн ял /торгох, эрх хасах, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах/	Хуульд нэрлэн заагаагүй боловч ҮСХ-ноос энэ үзүүлэлтээр гаргадаг нь хуульд харшлахгүй.
10	Авлигын хэргийн шийдвэрлэлт / бүгд, мөрдөн байцаалт явуулсан, мөрдөн байцаалтын үндсэн хугацаанд шийдвэрлэсэн/	

Статистикийн эмхтгэлд нийтлэгдсэн дээрх хүснэгтэд заасан үзүүлэлтийг Статистикийн тухай хуульд заасан үзүүлэлттэй харьцуулж харвал дараах логик болоод хууль тогтоомжтойгоо уялдахгүй байгаа зөрчил ажиглагдаж байна.

- Хуулийн 6.4.а-д “Эрүүгийн хэргийн тоо, төрөл” гэсэн үзүүлэлт Шүүхийн статистикийн үзүүлэлт болж хуульчлагдсан. Гэтэл статистикийн эмхтгэлд “Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл”-ийн талаарх үзүүлэлтүүд нийтлэгдэж, харин “эрүүгийн хэргийн тоо төрөл” гэсэн үзүүлэлт нийтлэгдэхгүй байна;
- “Гэмт хэрэг” гэсэн бүлэг үзүүлэлтэд “Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан”, “дампуурсан аж ахуйн нэгж” буюу иргэний хэрэг, маргаанд хамаарах үзүүлэлт багтсан байна;



• Хуулийн 6.4.д-д “Захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт” гэж хуульчилсан боловч энэ үзүүлэлтээр нийтэлсэн мэдээлэл статистикийн эмхтгэлд бараг нийтлэгдэхгүй байна. ҮСХ-ны зөвшөөрснөөр ШЕЗ-өөс 2008 онд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн эрүүгийн, иргэний болон захиргааны хэргийн мэдээллийн маягтууд тэдгээрт хамаарах үзүүлэлтүүдийг баталсан бөгөөд хагас, бүтэн жилээр энэхүү мэдээлэл шүүхээс гардаг;

• Хуулийн 6.4.б-д “Шүүхээр шийтгүүлэгчдийн тоо” гэж хуульчилсан байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 45.2-т “эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгээр хүлээлгэнэ” гэж заасан. Үүнээс харвал ялаас гадна “эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ” шүүхээр шийтгүүлсэн гэх ойлголтод хамаарч байна;

Цагдаагийн ерөнхий газраас “Монгол Улс дахь бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал”-ыг харуулсан цогц мэдээллийг цаасаар болон цахимаар нийтэлж, олон нийтийн хүртээл болгож байгаа.

Энэхүү мэдээллээр Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Аймаг, дүүргүүдийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Зарим төрлийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Гэмт хэргийн онцлог, шалтгаан нөхцөл, Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санал зөвлөмж, Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик үзүүлэлтүүд гэсэн цогц мэдээллийг багтаадагараа онцлогтой.

Энэ мэдээллээс статистикийн эмхтгэлд бүртгэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой хэд хэдэн мэдээлэл нийтлэгдэж байна. Харин захиргааны зөрчлийн талаарх мэдээлэл огт нийтлэгдэхгүй явсаар иржээ.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн үзүүлэлтийн талаар Статистикийн тухай хуульд зохицуулалт байхгүй явсаар ирсэн нь энэ төрлийн статистик үзүүлэлт боловсронгуй болох, судалгааны эргэлтэд орох, мэдээлэл хүсэгчийн мэдээлэл авах эрх зэрэгт сөрөг нөлөө үзүүлж байгааг цаашид анхаарах хэрэгтэй.

Монгол Улс дахь захиргааны зөрчлийн нөхцөл байдал ямар байгаа талаар судлан үзэхэд 2016 онд улсын хэмжээ<sup>[13]</sup>-нд нэг

<sup>13</sup> Цагдаагийн ерөнхий газар. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ., 2016. 231 дэх тал

сая гучин найман мянга тавь /1.038050/-н захиргааны зөрчил бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл манай улсын 3 хүн тутмын 1 нь захиргааны зөрчил үйлдэж байгаа дүр зураг гарч байна.

Гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн бүртгэл-статистикийн уялдаа

Аливаа бүртгэл, дансанд орц болон гарц гэж байдаг. Шүүх болон хууль сахиулах үйл ажиллагаанд хамаарах бүртгэлд ч мөн энэ бүрдэл байгаагаас гадна эдгээр байгууллагын эрхлэн хариуцаж буй чиг үүрэгтэй холбоотойгоор үйл ажиллагааны уялдаа холбоо, мэдээлэл солилцоо болон түүний үнэн, зөв байдал зэрэг голлох асуудлууд нь энэ салбарыг хөгжүүлэх, бодлогыг тодорхойлох хүчин зүйлс болох боломжтой.

Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх асуудлыг сүүлийн үед эрх зүйн актуудад хуульчилж, энэ чиглэлээр томоохон ажлууд эрчимтэй хийгдэж эхэлсэн. Тухайлбал, цагдаа, прокурор, шүүх /эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөр бие даасан нэгдсэн систем мөн шүүхийн цахим сан ажилладаг/, ШШГ байгууллагын цахим мэдээллийн нэгдсэн систем, мөн Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээг зохион байгуулах ажил зэргийг дурдаж болох юм. Түүнчлэн ҮСХ, Шүүхийн шинжилгээ, шүүх, цагдаа зэрэг байгууллагаас эрхлэн гаргаж буй тайлан, эмхтгэл, мэдээллүүдийн төрөл, цар хүрээ, давтамж нэмэгдсэн.

Дээр дурдсанаар мэдээллийн сан, нэгдсэн тогтолцоо бүрдэх ажил эрчимтэй хийгдэж байгаатай зэрэгцүүлээд тухайн мэдээллийн уялдаа, үнэн, зөв байдлыг хангах асуудлыг орхигдуулахгүй хамтад нь хэрэгжүүлэх нь статистикийн олон улсын зарчим<sup>[14]</sup>-ыг хангах, практикт үүсээд буй тулгамдсан асуудал<sup>[15]</sup>-ыг шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх ажилд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байдаг. Үүнд:

1. Мэдээлэгчдийг нэгдсэн арга зүйгээр хангах /мэдээлэгч бүр тухайн үзүүлэлтийн

<sup>14</sup> НҮБ-аас шалгуур болгосон 10 зарчмын нэг нь статистик “Үнэн, бодитой байх” зарчим болно.

<sup>15</sup> Сүүлийн үед зохион байгуулагдсан хурал, семинар, хэлэлцүүлэг бүр дээр “үйл ажиллагааг уялдуудах” асуудал хөндөгдөж байгаа. Мөн ҮСХ болон цагдаагийн багууллага 2014 онд хамтран хийсэн “Гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн бадалд хийсэн баримтын судалгаа”-нд мэдээлэл маш их зөрүүтэй байгаа талаар тодорхой дурдсан байдаг.



тоог гаргах талаар нэгдсэн ойлголттой байх/, хүний нөөцийг бэхжүүлэх;

2. Мэдээллийн бүрдлийг хангах<sup>[16]</sup>

3. Мэдээллийн эх сурвалжийг тулгах, нягтлах<sup>[17]</sup>

4. Мэдээллийг холбох, хөрвүүлэх, хөгжүүлэх /цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх/

5. Зөвхөн бүртгэгдсэн мэдээллээс гадна тэдгээрийг боловсруулж хэрэглээнд бэлтгэх, статистик мэдээлэлд шилжүүлэх, дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Эдгээр шаардлагыг хангасан мэдээлэл нь хоорондоо уялдаатай, үнэн, зөв, ашиглахад хялбар дөхөм байж, мэдээллийн нэгдсэн тогтолцоо болж чадах юм.

Эрүүгийн хэрэг /гэмт хэрэг/ болон түүнд хамаарах үзүүлэлт нь бусад хэрэгтэй харьцуулахад шүүхээс өмнөх шатанд хэрэг нь үүсдэг мөн түүнчлэн үзүүлэлт нь хүн, хэрэг гэсэн зэрэгцсэн 2 утгаар гардаг, мөн эрх зүйн зөрчил дотроо хор уршиг, үр дагавраар хамгийн хууд тул энэ төрлийн мэдээлэл нийгэмд түлхүү нийтлэгддэг бас эрэлт хэрэгцээ ч их байдаг тал ажиглагддаг.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл<sup>[18]</sup>-ээс харахад орц буюу “бүртгэгдсэн нийт зөрчлийн тоо” байна. Харин шийдвэрлэгдсэн нийт зөрчлийн тоо, үлдэгдлийн тоо байхгүй, шийтгэгдсэн зөрчил гаргагчийн тоо түүний задаргаа болох үзүүлэлтүүд гарч байна. Эрүүгийн хэргийн шүүхийн шүүн таслах ажлын тайлан мэдээгээр гардаг “Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тайлан” гэсэн мэдээллийн үзүүлэлт түүнийг нөхөх заавраас харахад “зөрчил гаргагчаар” буюу хүний тоогоор илэрхийлэгдсэн үзүүлэлт байна. Харин энэхүү мэдээллийг Тайланд бичиж дүгнэхдээ зөрчлийн тоо, түүний шийдвэрлэлт гэж дүгнэсэн<sup>[19]</sup> байдал ажиглагдаж байна. ЦЕГ болоод ШЕЗ-өөс гаргаж буй захиргааны зөрчлийн үзүүлэлтээс гадна иргэн болон захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд шүүгч шийтгэвэр гарган захиргааны хариуцлага ногдуулах цөөн тохиолдлууд гардаг.

Дээрхээс харахад захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн бүрдэл хангагдах ажил гүйцэд хийгдэхгүй байгаа гэсэн дүр зураг харагдаж байна.

Мөн Бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийн балансын задаргаа, нөхөх зааврыг хамт нийтлэхгүй байгаа нь энэ төрлийн мэдээллийг хэрэглэгчид ашиглахад хүндрэлтэй байдал үүсгэж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Гэмт хэрэг, эрүүгийн хэргээс гадна иргэн болон захиргааны хэргийн бүртгэл-статистикийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий. Тухайлбал, ШЕЗ-өөс баталсан иргэний хэргийн мэдээллийн маягт ШС-2-ийн 11-р мөр “шийдвэрлэсэн хэрэг”-т хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг, 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг, 117 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг тус тус хамаардаг. Энд 117 дугаар зүйл нь “Хэргийг хэрэгсэхгүй болгох” гэсэн агуулгатай. Гэтэл захиргааны хэргийн маягт ШС-3-ийн 14-р мөр “шийдвэрлэсэн бүх хэрэг”-т “хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай” үзүүлэлт хамаарахгүй байгаа.

Эндээс харахад яг нэг ижил үзүүлэлт нь “Шийдвэрлэсэн бүх хэрэг” гэх үзүүлэлтийн бүрдлийг нэг бол хангах, үгүй бол хангахгүй байх гэсэн ялгамжтай байдлаар үзүүлэлт болон батлагдсан байна. Гэтэл шийдвэрлэсэн хэрэг гэдэг бол шүүхийн статистикийн хамгийн чухал үзүүлэлтийн нэг бөгөөд үүний цаанаа шүүхэд ажиллаж байгаа хүмүүсийн хийсэн ажил, зарцуулсан хөдөлмөр үнэлэгдэж байдаг. Иргэний хэрэгт энэ үзүүлэлтийг шийдвэрлэсэн хэрэгт хамааруулж байгаа бол үүнтэй ижил захиргааны хэрэгт мөн хамааруулж батлах нь ойлголтын зөрүүг арилгахаас гадна хийж гүйцэтгэсэн ажлыг нэг стандартаар үнэлэх талаар ач холбогдолтой.

Мөн захиргааны хэргийн нэлээд хувь нь хэд хэдэн шаардлагыг багтаан шийдвэрлэгддэг онцлогоосоо шалтгаалан шаардлага тус бүрийг шийдвэрлэсэн хууль, маргааны төрөл харилцан адилгүй тоологдохоор гардаг. Гэтэл практик дээр ШС-3 маягтын дагуу захиргааны хэргийн үзүүлэлтийг гаргахад хэдэн шаардлага байгаагаас үл хамааран нэг хэрэг гэж үзэн түүний шаардлагуудыг шийдвэрлэсэн хууль, маргааны төрлийг аль нэгээр нь сонгож мэдээллийг гарган, ҮСХ-д хүргүүлж байгаа.

### Санал

- Статистикийн тухай хуульд заасан албан ёсны статистик үзүүлэлтийн ангилал, төрлийг боловсронгуй болгох, ялангуяа шүүх болон хууль сахиулах үйл ажиллагааны

<sup>16</sup> Хавсралт 2-оос харна уу.

<sup>17</sup> Хавсралт 2-оос харна уу.

<sup>18</sup> Энэ мэлээлэл нь ЦЕГ-аас мөн ШЕЗ-өөс гарч байна.

<sup>19</sup> Монгол Улсын шүүхийн тайлан /2013 он/. 121 дэх тал





- статистикийг зөвхөн “шүүхийн статистик”-т багтаан хуульчилж байгааг өөрчлөх;
- “Шүүхийн статистик”-ийн үзүүлэлтийг “гэмт хэрэг” гэсэн бүлэг үзүүлэлтэд хамааруулан статистикийн эмхтгэлд нийтэлж байгааг өөрчлөх;
  - Захиргааны зөрчлийн холбогдох үзүүлэлтийг Статистикийн тухай хуульд үзүүлэлт болгон хуульчлах, статистикийн тайланд нийтэлж байх;
  - Статистикийн тухай хуулийн 6.4.а, 6.4.б, 6.4.г дэх хэсгүүдийн агуулгыг бүрэн илэрхийлэх үзүүлэлтийг нийтлэх эсхүл эдгээр хэсгүүдийг эмхтгэлд нийтлэгдэж буй утгатай ижил болгон өөрчлөх;
  - Иргэн болон захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдлууд нь ЦЕГ-аас гаргаж байгаа “Улсын хэмжээнд бүртгэгдсэн захиргааны бүртгэл, түүний шийдвэрлэлт” гэсэн мэдээлэлд тоологдохгүй байгааг анхаарах;
  - Мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхдээ мэдээллийн уялдаа, үнэн, зөв байдлыг хангах асуудлыг орхигдуулахгүй хамтад нь хэрэгжүүлэх;
  - Бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээлэлд түүний балансын задаргаа, нөхөх зааврыг хамт нийтлэх;
  - Шүүх болон хууль сахиулах үйл ажиллагааны тоо бүртгэлд иж бүрэн боловсруулалт хийж тэдгээрийг мөн чанараар нь статистик мэдээлэлд шилжүүлэх;
  - Зөвхөн гэмт хэргээр хязгаарлахгүй иргэн болон захиргааны хэргийн статистикийг боловсронгуй болгох тус тус шаардлагатай байна.

### Хавсралт 1

Гэмт хэрэг, захиргааны зөрчлийг бүртгэх талаар хууль тогтоомжид тусгагдсан зохицуулалтын түүвэр жагсаалт

д/д	Хууль тогтоомжийн нэр	Зүйл, заалт
Хууль		
1	Гүйцэтгэх ажлын тухай	9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.2.1.гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, энэ талаарх холбогдох журмыг баталж мөрдүүлэх; 9.2.3.гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл олж авах, улсын хилээр нэвтрүүлэх, ашиглахад зөвшөөрөл олгох, гүйцэтгэх байгууллагын мэдэлд байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих;
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	<b>20 дугаар зүйл.Гэмт хэргийн талаарх мэдээлэл цуглуулах, боловсруулах</b> 20.1.Шүүх, прокурор, цагдаагийн болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрх бүхий бусад байгууллага нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор гэмт хэргийн мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагааг дараах байдлаар эрхэлнэ: 20.1.1.гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх;
3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	<b>11.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</b> 11.1.4.гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталж, хэрэгжилтэд хяналт тавих;





4	З а м ы н х ө д ө л г ө ө н и й а ю у л г ү й б а й д л ы н т у х а й	<p><b>10.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ:</b></p> <p>10.1.5.зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн санд зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо бүртгэл, мэдээллийг хамруулах;</p> <p>10.1.6.жолоочийн эрүүл мэнд, зам тээврийн осолд өртсөн хүний бүртгэл, мэдээллийн санд механикжсан тээврийн хэрэгслийн жолоочийн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэл, мэдээллийг хамруулах;</p>
5	Зөрчлийн тухай	<p><b>11.2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль зөрчих</b></p> <p>1.Хуульд заасан холбогдох зөвшөөрөлгүйгээр газрын кадастрын үйл ажиллагаа явуулсан, эсхүл холбогдох материалд засвар хийсэн; газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл, эсхүл газрын улсын бүртгэлийг буруу хийсэн; газрын кадастрын мэдээллийн санд дур мэдэн өөрчлөлт хийсэн, эсхүл тэдгээрийг олшруулж бусдад дамжуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p><b>15.20 дугаар зүйл.Иргэний цэргийн үүрэгтэй холбоотой журам зөрчих</b></p> <p>1.Цэргийн тоо бүртгэлийн журам зөрчсөн, эсхүл зарлан дуудсан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл дайчилгааны сургууль, цугларалт, цэрэг татлагаас зайлсхийсэн цэргийн үүрэгтэн, цэргийн насны иргэнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>6.15 дугаар зүйл.Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих</p> <p>4.Усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс тогтоох шаардлагыг зөрчсөн; усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулаагүй, эсхүл тайлан, мэдээг гаргаж өгөөгүй бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
6	Садар явдалтай тухай самуун тэмцэх	<p><b>12 дугаар зүйл. Тоо бүртгэл</b></p> <p>12.1.Биеэ үнэлсэн, эсхүл бусдын биеийг үнэлүүлсэн зөрчилд захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийн талаарх тоо бүртгэлийг цагдаагийн байгууллага эрхлэн хөтөлнө.</p> <p>/Энэ зүйлийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p> <p><u>/Энэ хэсгийн "захиргааны" гэснийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хасахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/</u></p>




7	Цагдаагийн албаны тухай	<p><b>10.1.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</b></p> <p>10.1.10.гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах;</p> <p>10.2.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 10.1.5, 10.1.6-д заасан ажиллагаа явуулахад шаардлагатай тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, тусгай техник, арга хэрэгсэл ашиглах, халхавчийн байгууллага, нууц гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтныг ажиллуулна.</p> <p><b>13.1.Цагдаагийн байгууллага захиргааны хяналтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</b></p> <p>13.1.3.зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч болон зөрчлийн тоо бүртгэл хөтлөх;</p> <p>61 дүгээр зүйл. Үйл ажиллагаандаа тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ашиглах</p> <p>61.1.Цагдаагийн байгууллага дараах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана:</p> <p>61.1.1.гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эрүүгийн хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан хүний талаар;</p> <p>61.1.2.ял шийтгүүлсэн хүний талаар;</p> <p>61.1.3.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаар;</p> <p>61.1.4.эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болж цагаатгагдсан хүний талаар;</p> <p>61.1.5.эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялыг хойшлуулсан хүний талаар;</p> <p>61.1.6.хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхгүй, мөн хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа, хүүхэдтэй хэрцгий харьцаж байгаа этгээдийн талаар;</p> <p>61.1.7.өршөөл, уучлалд хамрагдсан хүний талаар;</p> <p>61.1.8.гэмт хэрэгт хохирсон хүний талаар;</p> <p>61.1.9.зөрчил үйлдсэн этгээдийн талаар;</p> <p>61.1.10.эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар;</p> <p>61.1.11.тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигчийн болон тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношилгооны талаар;</p> <p>61.1.12.жолоодох эрхийн үнэмлэх авсан хүний талаар;</p> <p>61.1.13.гэрээт болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн талаар;</p> <p>61.1.14.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтад байгаа хүний талаар;</p> <p>61.1.15.Галт зэвсгийн тухай хуулийн 12.9-д заасан мэдээллийн сан;</p> <p>61.1.16.цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн тохиолдлын талаар;</p> <p>61.1.17.гарын хээ, сум, хонгио, генетикийн мэдээлэл;</p> <p>61.1.18.хуулийн этгээдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн хэрэгслийн мэдээлэл;</p> <p>61.1.19.цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын тоо бүртгэл;</p> <p>61.1.20.эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хуулийн этгээдийн талаар;</p> <p>61.1.21.бусад.</p>
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай	<p><b>7.1.Шийдвэр гүйцэтгэх газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</b></p> <p>7.1.3. шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, хяналт тавих;</p> <p>7.1.4.шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтөлж;</p>
МУОУГэрээ		



9	Нэгдсэн үндэстний байгууллагын дүрэм	<b>73 дугаар зүйл</b> е) XII, XIII бүлгийн заалтуудад хамаарах нутаг дэвсгэрээс бусад хариуцлага хүлээсэн холбогдох нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгэм, боловсролын салбар дахь нөхцөл байдалд хамаарах тоо бүртгэлийн болон бусад техникийн шинж чанартай бөгөөд уг нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, хуулийн дэг ёсонд үл харшлах мэдээ сэлтийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээллийн журмаар тогтмол хүргүүлж байхыг ариун үүргээ гэж үзэж байна.
10	Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц	<b>2 дугаар зүйл</b> Хяналтад хамрагдах бодис 3. III жагсаалтад орсноос бусад бэлдмэл нь тэдгээрт орсон мансууруулах эмийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдах боловч эдгээр мансууруулах эмийн тооцоо, дүн бүртгэлээс ялгаатай тооцоо (19 дүгээр зүйл), дүн бүртгэл (20 дугаар зүйл)-ийн ийм бэлдмэлийн хувьд шаардахгүй бөгөөд 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (с) дэд хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b) (ii) дэд хэсгийг хэрэглэхгүй. 4. III жагсаалтад заасан бэлдмэлүүд нь II жагсаалтад орсон мансууруулах эм агуулсан бэлдмэлийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдана. Харин үүнд 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэг болон 3-15 дахь хэсэг, түүнчлэн тэдгээрийг олж авах болон жижиглэн худалдаалахын хувьд 34 дүгээр зүйлийн (b) хэсгийг хэрэглэх хэрэггүй бөгөөд шаардлагатай мэдээллийг ийм бэлдмэл бэлтгэхэд хэрэглэсэн мансууруулах эмийн хэмжээгээр тооцоо (19 дүгээр зүйл) болон дүн бүртгэл
11	Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц	а) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд I жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал 7 дугаар зүйлд жагсаасан хяналтын тусгай арга хэмжээг боломжийн хэрээр харгалзан үзэж, тухайн бодистой холбогдуулан: v) 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (a) дэд хэсгийн дагуу дүн бүртгэлийн илтгэлийг Хороонд өгнө; б) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд II жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал тухайн бодистой холбогдуулан: v) 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (a), (c), (d) дэд хэсгийн дагуу дүн бүртгэлийн илтгэлийг Хороонд өгнө;
<b>УИХ-ын тогтоол</b>		
12	Хуулийн байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай	1. Хуулийн байгууллагуудын хараат бус ажиллах баталгааг сайжруулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай: 2/ эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх, гэмт хэргийн дүн мэдээ, шалтгаан, эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэргийн дүн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох;



### Статистик мэдээлэл цахим хэлбэрээр



СтХ-ийн 6.4-т заасан Эрүүгийн хэргийн тоо, төрөл, Иргэн болон захиргааны хэргийн үзүүлэлт статистикийн мэдээлэл болж цахим хэлбэрээр нийтлэгдэхгүй байна.

### ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛСЭН ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН, бүс, аймаг, нийслэлээр, жилээр

ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛСЭН ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН, бүс, аймаг, нийслэлээр, жилээр

Мэдээлэл шинэчлэсэн хугацаа : 2016-04-11 | Хугацааны давтамж: Жил 2010 - 2015

Улсуур талтгаар: Үзүүлэлт(44) | Аймаг(128) | Хугацаа(16)

Аймаг	2015			
	Бүт	Ажлаас буруу шилжүүлсэн	Ажлаас үндэслэлгүй халагдсан	Цэлийн хөлсний маргаан
Улсын дүн	1,487	18	910	415

1487=18+910+415=1343 мэдээллийн бүрдэл дутуу

орц

гарц

үлдэгдэл? бусад?

хөдөлмөрийн маргааны шийдвэрлэлтийн талаар ЦЕГ-аас мэдээлэл гарах боломжгүй.

### УЛСЫН ХЭМЖЭЭНД 2016 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Үүнээс			Үүнээс				Үүнээс					
			Асран хамгаалах үүргээ урвуулах 118	Садар самууныг сурталчлах 123	Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зөвшөөр байгуулах 124		Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг 130-144		Өмчлөх эрхийн эсрэг 145-155		Бусдын эд хөрөнгийг хулгайлах 145				
					Бүх хэрэг	Бүх хэрэг	Бүх хэрэг	Бүх хэрэг	Бүх хэрэг	Бүх хэрэг	Бүх хэрэг	Бүх хэрэг			
A			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016			
61	Улсын дүн		3	1	0	28	20	279	290	141	116	13445	13336	9169	9065

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах		Үүнээс: Мал хулгайлах		Үүнээс: Авто тээврийн хэрэгсэл хулгайлах		Үүнээс: Халаасны хулгай		Үүнээс: Галт зэвсэг хулгайлах	
			Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг	
			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
A		52	53	54	55	56	57	58	59	60	61	
61	Улсын дүн	6956	7303	1180	805	367	404	621	538	14	12	

9065=7303+805+367+404+538+12=9062



## 2016 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАХИРГААНЫ ЗӨИ ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТ

№	Төв, орон нутгийн цагдаагийн байгууллага	Захиргааны зөрчлийн шийдвэрлэлт										
		Хоёр. Шийтгээрээр торгосон болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийдвэрлэлт										
		Үүнээс:										
		Цагдаагийн алба хаагч										
A	Зөрчил	Иргэн	Албан тушаалтан	Байгууллага, ажлуун нэгж	Торгосон		Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан	Зөрчил	Иргэн	Албан тушаалтан		
					Торгуулийн хэмжээ /мян.төг/							
					2015	2016						
57	Улсын дүн	103828	72541	107	1163	2701175.0	2759700.6	30017	6583	1199		

График 1.3

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах бусад ажи...



### ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ

шатны шүүхүүдийн хэргийн үлдэгдэл 3.5 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Хугацаа хэтэрсэн үлдэгдэл хэргийн хувьд эрүүгийн хэрэг 96.8 хувиар, захиргааны хэрэг 97 хувиар тус тус өссөн бол иргэний хэрэг 6.6 хувиар буурсан байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийвэл эрүүгийн хэргийн тогтоол магадлалын 44.8 хувийг, иргэний

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

30

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН 2 ДУГААР САРЫН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨНИЙ МЭДЭЭЛЭЛ №2

2017.03.06

Улаанбаатар хот

**4. Хугацаа хэтрэлт:** Хугацаа хэтэрсэн нийт 785 хэрэг байгаагаас иргэний 682, захиргааны 103 хэрэг байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн нийт хугацаа хэтэрсэн

2 ДУГААР САРЫН НЭГДСЭН ДҮН:

Д/р	Шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтрэсэн
1	Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	311	218	341	-
2	Орон нутгай дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	105	402	300	-
3	Нийслэл	416	620	641	-

График 5

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН 3 ДУГААР САРЫН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨНИЙ МЭДЭЭЛЭЛ №3

2017.04.03

Улаанбаатар хот

**4. Хугацаа хэтрэлт:** Хугацаа хэтэрсэн нийт 851 хэрэг байгаагаас иргэний 743, захиргааны 108 хэрэг байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн нийт хугацаа хэтэрсэн 743 хэргийн 660 хэрэг буюу 88%-нх.

3 ДУГААР САРЫН НЭГДСЭН ДҮН:

Д/р	Шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтрэсэн
1	Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	408	274	406	-
2	Орон нутгай дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	545	492	321	-
3	Нийслэл	953	766	727	-

График 6

Оюу

Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр. Хууль зүйн сайдын 2014 оны 12-р сарын 22-ны өдрийн А/24 тоот тушаалаар батлав.

Маягт ШГ-3

### ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧГИЙН 2017 ОНЫ 03 САРЫН МЭДЭЭ

Захиргааны хэргийн шийдвэртэй	Захиргааны шүүхийн шийдвэртэй	Гүйцэтгэх хуудас	мян.төг	25	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
				Мөнгөн дүн	тоо	26	0	0	0	0	0	0	0	0	0	
				Захиргааны шийтгээрээр оногдуулсан торгуулийн	Гүйцэтгэх хуудас	мян.төг	27	0	0	0	0	0	0	0	0	0
							Мөнгөн дүн	тоо	28	0	0	0	0	0	0	0
Дүн	Гүйцэтгэх хуудас /25+27/	мян.төг	29	0	0	0	0	0	0	0	0	0	0			
			Мөнгөн дүн /26+28/	тоо	30	0	0	0	0	0	0	0	0	0		

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШИЙДВЭРТ ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙГ БАГТААН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ГАРГАЖ БАЙГАА НЬ АГУУЛГЫН ХУВЬД АЛДААТАЙ МЭДЭЭЛЭЛ БОЛНО.

## ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН  
ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛ**

С.Гантулга

ХСИС-ийн Хэвлэл, редакцийн хэлтсийн дарга, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

**Хураангуй:** Судалгааны явцад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн уламжлалыг түүхийн тодорхой үечлэлд ангилан хууль тогтоомжуудыг харьцуулах, түүхчлэх зэрэг аргаар судлан дүн шинжилгээг хийхийн зэрэгцээ энэ цаг үед “шинэ төрлийн” гэж тодотгоод буй хүн худалдаалах гэмт хэрэг манай улсад үйлдэгдэж байсан эсэх, энэ төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хууль тогтоомжуудад хэрхэн хуульчилж ирсэн бэ, түүнтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцэл хэдий үеэс эхэлсэн, энэ нийгмийн сөрөг үзэлдэл нь манай улсын тухайд “шинэ зүйл” мөн үү зэрэг асуултанд хариулт өгсөн.

**Түлхүүр үг:** Түүхийн үечлэл, төрийн эрүүгийн бодлого, эрүүгийн эрх зүйн тэмцэл, Эрүүгийн хууль тогтоомж, хамжлагат ёс, богтлох ёс, хүн худалдаалах гэмт хэрэг

Монгол Улсын хууль цаазын баялаг уламжлалыг нэхэн судалж нүүдэлчдийн төр бүтээх, засах арга ухаан, түүний үнэт зүйлийг танин мэдэх нь зөвхөн монголчуудын хувьд төдийгүй хүн төрөлхтөний оюуны өв уламжлалд оруулах үнэтэй хувь нэмэр болно<sup>[20]</sup> хэмээсэн нь юутай үнэн.

2200 гаруй жилийн түүхтэй Монгол Улсын төрт ёс, хууль цаазын сэтгэлгээ нь хөгжлийнхөө явцад “Монголын нууц товчоо”, “Их Засаг хууль”, “Юань гүрний нэвтэрхий хууль”, “Арван буянт номын цагаан түүх”, “Алтан хааны цаазын бичиг”, “Халхын цааз

эрхэмжийн бичиг”, “Монгол-Ойрадын цааз бичиг”, “Халх журам”, “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” зэрэг хууль цаазын бичиг буюу хууль гаргаж байснаар илэрхийлэгдэх бөгөөд хэдийгээр эх байдлаараа хадгалагдаж бидний үед ирээгүй ч гадаадын болон дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд тодорхой хэмжээгээр тусгагдсан нь биднийг эх түүхээ судлах боломжийг олгож байна.

Эдгээр хуулиудыг манай нэрт хуульч эрдэмтэд “Монгол хууль” хэмээн нэрлэсэн нь монгол хүний оюун санаа, монгол ахуйн хэрэгцээнээс урган гарч, тэдгээрийн үзэл бодол, зан заншлын хэм хэмжээтэй хослон үйлчилж ердийн амьдралын хэвшил болсонтой холбоотой.<sup>[21]</sup> Үүний тод илрэл нь Оросын эрдэмтэн, монгол цаазыг судлаач И.М.Майский: “Великая яса” буюу “Их засаг хууль” нь тэр үеийн Их Монгол Улсын Үндсэн хууль<sup>[22]</sup>, Ж.А.Жувейни: “Чингис хаан үйл хэрэг болгонд тохирсон дүрэм, тухайн нөхцөл болгонд тохирсон хууль, гэм буруу болгонд оногдуулбал зохих ял шийтгэл боловсруулан мөрдүүлж эхлэв”<sup>[23]</sup> хэмээсэн тэмдэглэл юм.

Горальд Лэмбийн эмхтгэсэн 22 зүйл бүхий Чингис хааны хуульд: “Эзэнт гүрний хэмжээнд хэн ч гэсэн монгол хүнийг боол, зарцаа болгож үл болно”<sup>[24]</sup> хэмээсэн нь монгол хүнийг албадан хөдөлмөрлүүлэх, худалдаалах явдлаас сэргийлсэн монгол хүний эрхийг хамгаалсан өнөө ч ач холбогдлоо алдахааргүй заалт байсан болох нь харагдаж байна.

**Алтан хааны цааз бичигт:** “Цэргийн эхнэр, эцэг эхийг дэргэд суух цагт охин

<sup>21</sup> Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд. Монгол хууль / Уламжлал, шинэчлэл Монголын төр эрх зүйн түүхэн сэдэв/. УБ., 1997. 3 дахь тал

<sup>22</sup> И.М.Майский. Чингис хаан. Вопрос истории 1962. №5. Монгол үндэстэн бүрэлдэн тогтож, түүхийн олон хуудсыг бүрдүүлсэн Их Монгол улсын үед мөрдөгдөж байсан Их засаг хуулийн янз бүрийн хэсгүүд эртний Араб, Перс, Египет, Армений түүхч, шаштир бичигч Макризи, Мирховенд, А.Жувейни, Ибн-Батута, Вартан, Рашид-Ад-Дин, Оросын академич В.Я.Владимирцов, В.Я.Бартольд, В.А.Рязановский, Л.Н.Гумилев нарын эртний болон эдүүгээгийн түүхчид, шаштир туурвигчдын уламжлан дамжуулснаар үндэсний эрдэмтэн судлаачид нарийвчлан судалснаар өнөөг хүрсэн.

<sup>23</sup> С.Бадарчи. Их Монгол улсын цагдаа. Цагдаа судлал онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2011. №1 /01/. 9 дэх тал  
А.Жувейни. Ертөнцийн байлдан дагуулагчийн түүх. Хөх хот., 1980.

<sup>24</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимэд нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010. 43 дэх тал

<sup>20</sup> Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ /Улаан хацарт/. УБ., 2010. 7 дахь тал





төрвөл цэрэг байхгүйд оронд нь эцэг, эх охиныг тэтгэн үйлдээд охин хүүд өгвөөс тооцохгүй. Охин бусад буй бээр түүнд өг, охин үгүй бөгөөс эд гуу санг сандан бээр охины хуримын идээг тэр охины цаазанд өгч цаазны эдийг төлнө<sup>[25]</sup>, “Хулгайчийн алж идсэн махны үлдэгдлийг авбаас хүн, тэмээ алин болохоор өрд ав<sup>[26]</sup>, Халхын үйсэн дээр бичсэн цаазууд /1603/-ын нэг дэх хэсэг буюу “Зургаан хошууны цааз”-д: “Хулгай хийсэн хүнийг золио гэхүлийг тэр золигч хүнийг еслөө. Хулгайч хүний золиг нь эмийг нь ав<sup>[27]</sup> хэмээн хүнийг үүргийн гүйцэтгэлд тооцож байсан бол тав дахь хэсэг буюу “Төмөр гахай жилийн өчүүхэн цааз”-д /1611/: “Ноён хүний сүйтийг нь аваад хүнд өгвөөс тэр хүнээс анз аваад тэр эмийг хариулж өг”, ес дэх хэсэг буюу “Модон барс жилийн намрын цааз”-д /1614/ “Ноёд төрлөө авбаас тэр авагчийг нь хагацуулаад зуун гэр хүн авах болов”, арван зургаа дахь хэсэг буюу “Бичин жилийн их цааз”-д /1620/ “Хэн хүн эм босговоос<sup>[28]</sup> эмийн эр нь авбаас оргүй. “Охин хүн, хөвүүнгүй эм, боол эд гурвыг хулгайтай болов<sup>[29]</sup> гэж тэмдэглэснээс үзэхэд Эзэнт гүрний хэмжээнд хүн хулгайлах, худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэж байжээ гэж үзэх үндэстэй байна.

Мөн Энх-Амгалангийн зургаадугаар оны хуучин засгийн бичигт нэмж тогтоосон засгийн бичигт<sup>[30]</sup> /1667/: “Харц хүн хатад лугаа нэгдвээс явалдсан эрийг огтчин алму. Хатныг чавчиж алму. Явалдсан хүний ах дүүгээс эм хүүхдийг нь зарц өгмү<sup>[31]</sup> гэснээс үзэхэд ялыг халдаан хэрэглэж, хүүхдийн эрхийг ноцтой зөрчих явдлыг хуульчилснаар хүн худалдаалах гэмт хэргийг хуулиар баталгаажуулсан түүхийн нэгээхэн үе байжээ гэж үзэж байна.

Манжийн эзэрхийллийн үед гаргасан хуулиуд нь монголын эрх зүйн эх сурвалжийн дотор онцлог байр эзэлдэг ба цаазыг Манжийн хаад тогтоосон гэх боловч Монголын хууль цаазын хэв шинж ихээхэн

<sup>25</sup> Монголын төр, эрх зүйн түүх /дээж бичиг/. I дэвтэр. Эмхтгэсэн Б.Баярсайхан. УБ., 2006. 15 дахь тал

<sup>26</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимэд нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл.нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010. 85 дахь тал

<sup>27</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимэд нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл.нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010. 89 дахь тал

<sup>28</sup> Эм босгох-

<sup>29</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимэд нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл.нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010. 98 дэх тал

<sup>30</sup> Манжийн хаан Энх-Амгаланг хэлж буй

<sup>31</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимэд нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл.нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010. 127 дахь тал

агуулагдаж байжээ. Манжийн “Монгол цаазын бичиг”-ийг 1795 онд “Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг хэсэг явдлын яамны хууль зүйлийн бичиг” хэмээн нэрлэн 1811 онд барлан хэвлэсэн байна. Энэ цаазын **“Монголчууд харилцан гэнэдүүлэн<sup>[32]</sup> авч худалдах нь”** хэмээх долдугаар дэвтэрт: “Аливаа Монголчууд харилцан гэнэдүүлэн сайн хүний боол, шивэгчин эм<sup>[33]</sup>, бага эм<sup>[34]</sup>, хөвгүүд, ач нар болгон худалдваас худалдсан ба эс худалдсаныг үл ялган зуун ташуур занчигтун. Гурван есөн мал ав. Гэнэдүүлэн учир мэдэх хүнийг зуун ташуур занч. Гэнэдүүлэн учрыг үл мэдэх болбоос ял торгохыг хэлтрүүлж уг гэрт тушаан өгч хойш аваачуулагтун<sup>[35]</sup>, **“Дотоод газрын хүнийг аргадан<sup>[36]</sup>** аваачиж худалдахыг ялган салгаж яллах нь” хэмээх зүйлд: “Гадаад Монголчууд дотоод газрын эр, эм, хүүхэн, охиныг гэнэдүүлэн аваачиж, эм, бага эм, боол шивэгчин болгон худалдваас худалдсан ба эс худалдсаныг үл ялган гагцхүү гэнэдүүлэн аваачваас тэргүүлсэн хүнийг хөвчдөн алах<sup>[37]</sup> ял торгож, гянданд хорьж хүлээ. Дэд болж явсан хүнийг зуун ташуур занчиж, гурван есөн мал ав. Гэнэдүүлсэн хүн учрыг мэдэхгүй болбоос торгохыг үгүй болго. Хэрэв нэг хүн дан болбоос тэргүүлсэн хүнийг ялын ёсоор торго. Хэрэв гэнэдүүлэн авч ... худалдах нь гэнэдүүлсэн учрыг мэдвээс худалдсан ба эс худалдсаныг ялгахгүй хүнийг худалдсаныг нь зуун ташуур занчиж, гурван есөн мал ав. Гэнэдүүлсэн хүнийг зуун ташуур занч. Бүрнээ үг гэрт тушаан өгч хойш явуулагтун<sup>[38]</sup> хэмээн

<sup>32</sup> Гэнэдүүлэх- Аргалан мэхлэх. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. I боть. Ерөнхий редактор Л.Болд. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи. УБ., 2008. 582 дахь тал

<sup>33</sup> Шивэгчин эм-эм зардас, зарц эмэгтэй /эзний бүрэн өмч болж, хөдөлмөр ба амь бие нь түүний мэдэлд байх хүмүүс/. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. V боть. Ерөнхий редактор Л.Болд. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи. УБ., 2008. 3080 дахь тал

<sup>34</sup> Бага эм- Авааль эмийн дараах гэргий. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. I боть. Ерөнхий редактор Л.Болд. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи. УБ., 2008. 194 дэх тал

<sup>35</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимэд нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл.нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010. 274 дэх тал

<sup>36</sup> Аргадах- Ая байдлыг дагуулан найр тавих, аргалах, ухуулж таниулах. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. I боть. Ерөнхий редактор Л.Болд. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи. УБ., 2008. 130 дахь тал

<sup>37</sup> Хөвчдөн алах-хүний хүзүүнд дээс дээс хөвчний зэргийг торгож мушгин нурууг нь махийлган нугасыг нь тасалж үзүүлэх ял. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. IV боть. Ерөнхий редактор Л.Болд. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи. УБ., 2008. 2595 дахь тал

<sup>38</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимэд нар. Монголын



хуульчилснаар анх удаа Монгол улсад “хүн худалдах” гэсэн нэр томъёог хэрэглэж эхэлсэн байна.

Дээр дурьсан хэм хэмжээнүүдийг дүгнэн үзвэл монгол хүнийг худалдаалах явдлыг цаазлан хориглож, уг гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект, халдлагад өртөгчдийг ялгамжтай байдлаар хуульчлахын зэрэгцээ гэнэдүүлэн худалдах /хууран мэхэлж/, аргадан худалдах /ая байдлыг дагуулан найр тавих, аргалах, ухуулж таниулах/ гэхчилэн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг тодорхойлсон ба гэнэдүүлэн аваачснаар гэмт хэрэг төгсөхөөр хуульчилсан байна.

Тэргүүлсэн хүн, дэд болж явсан хүнд ялыг ялгамжтай оногдуулж байгаагаас харахад XIII зуунд эрүүгийн эрх зүйн үндсэн ойлголтууд болох ял, түүний төрөл, гэмт хэрэгт хамтран оролцогчид, гэмт хэрэг үйлдэх үе шатны ойлголт өндөр хөгжсөн байсныг илтгэнэ.

Хүнийг худалдаалахад тэргүүлсэн, дэд болж явсан хүнд ялыг ялгамжтай оногдуулж байсан нь эрүүгийн эрх зүй дэх шударга ёсны зарчмын агуулгатай нийцэж байгаа ба хөвчдөн алах, ташуур занчих, гурван есөн мал авах зэргээр яллаж, ялыг дангаар нь болон давхар оногдуулж байсан нь ялын бодлогын хувьд хатуу чанга байсныг харуулж байна. “...Хэрэв гэнэдүүлэн авч эм, бага эм, боол шивэгчин, хөвгүүн ач нар болгож худалдах нь гэнэдүүлсэн учрыг мэдвээс худалдсан ба эс худалдсаныг ялгахгүй хүнийг худалдсаныг нь зуун ташуур занчиж, гурван есөн мал ав. Гэнэдүүлсэн хүнийг зуун ташуур занч” гэнээнээс үзэхэд хохирогчид хууран мэхлэх арга хэрэглэсэн, хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхээс үл хамааран гэм буруутай этгээдэд ял оногдуулж байсан нь маш зөв зохицуулалт юм.

Өнөөдөр шүүх хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 дугаартай тогтоолыг<sup>[39]</sup> үндэслэн хохирогч биеэ үнэлэхийг урьдчилан мэдсэн, мэдээгүй эсэхийг харгалзан шүүхээс эрүүгийн хэргийн зүйлчлэлийг өөрчилж, хүн худалдаалсан гэмт этгээдэд Эрүүгийн хуулийн 124-р зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч

хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл.нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010. 274 дэх тал

<sup>39</sup> Улсын Дээд Шүүхийн 12 дугаар тогтоолын 4.5 дахь хэсэгт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч биеийг нь үнэлүүлэхийг урьдчилан мэдээгүй байдаг бол Эрүүгийн хуулийн 124-р зүйлд заасан гэмт хэргийн тухайд биеэ үнэлж байгаа этгээд үүнийг урьдчилан мэдсэн байдгаараа ялгагдана”

өөрийг нь мөлжих /мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил эрх чөлөөгүй байлгах, эд эрхтнийг авах зэргийг ойлгоно/ гэж байгааг зөвшөөрснийг хэрэгсэхгүй<sup>[40]</sup> гэсэн Олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдөж байгаа юм. Гэтэл тэртээх XIX зуунд энэхүү асуудлыг зохицуулан цаазаар тогтоосон байгаа нь манай улс хууль цаазын баялаг уламжлалтай, төрт ёс, хууль цаазын сэтгэлгээ өндөр хөгжсөн улс болох нь нотлогдож байна.

1915 онд Богд хааны зарлигаар “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” хэмээх хууль цаазыг зохиох комиссыг байгуулж, Манж Чин улсын үеийн цаазуудыг нягтлан монгол хэлээр орчуулан таван дэвтэрт нэгтгэж, улмаар “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” цаазыг боловсруулж, Улсын дээд, доод хурлаар хэлэлцүүлэн батлуулжээ.<sup>[41]</sup> Энэхүү цааз бичиг нь феодальн үеийн бусад хуулийн адил олон салбар эрхийг өөртөө багтаажээ.

Энэ хуулийн бараг бүх дэвтэрт эрүүгийн эрхийн агуулгатай хэм хэмжээнүүд тохиолддогийн гадна 9 дүгээр дэвтэр нь бүхэлдээ эрүүгийн эрхийн асуудлуудыг тогтоосон байдаг.<sup>[42]</sup> Цааз бичгийн 55 дугаар дэвтэрт: “Аргадан авч худалдах, худалдан авах” гэмт хэргийн бие даасан бүрэлдэхүүнийг “Аливаа хүн өөр данс бүхий хүнийг<sup>[43]</sup> харилцан гэнэдүүлэн худалдах”, “Аливаа хүн албат ардыг<sup>[44]</sup> зоригоор худалдах” гэсэн байдлаар тодорхойлжээ.<sup>[45]</sup> Уг гэмт

<sup>40</sup>Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 3 дугаар зүйл “6”. Хүн худалдаалах гэмт хэрэг-эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. ХЗҮХ, Хүний эрх хөгжил төв. УБ., 2010. 202 дахь тал

<sup>41</sup> Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 36 дахь тал

<sup>42</sup> Г.Совд. БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс /ерөнхий анги/. УБ., 1973. 48 дахь тал

<sup>43</sup>Өөр данс бүхий хүн- ноёдын хамжлага буюу засаг ба засаг бус ван, бэйл, гүн тайж, хутагт нарын хамжлага албат, шавь ард, гэрийн боол. Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 58 дахь тал

<sup>44</sup> Албат ард - хэн нэгний харьяалалгүй “суман ард”-ыг ойлгоно. Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 58 дахь тал

<sup>45</sup> Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 57, 58 дахь тал





хэргийг санаатай үйлдэх, худалдсан худалдан авсан этгээдийн аль алийг нэг зуун ташуур занчих, гурван есөн малаар торгох, хяналт сулруулсан засаг, чуулган дарга, туслагч тайжийг пүнлүү хасах, есөн малаар торгож тус тус шийтгэх, худалдагдсан хүнийг хошуунд тушаан өгч алба хаалгана. Худалдагдсан этгээд хэрэв энэ тухай мэдэж байсан бол түүнийг мөн зуун ташуур занч” гэсэн нь өмнөх цааз бичгүүдийн адилаар хүн худалдаалахыг цаазлан хориглосон бол ялын бодлогын хувьд Манжийн ноёрхлын үед үйлчилж байсан “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”-ээс хөнгөрүүлсэн байна. Харин гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинж болох гэм буруу, түүний хэлбэрийн талаар хууль зүйлийн бичигт тусгасан нь дэвшилттэй зүйл болжээ.

Хууль зүйлийн бичигт заасан “Өөр дан бүхий хүн” гэж ноёдын хамжлага буюу засаг ба засаг бус ван, бэйл, гүн тайж, хутагт нарын хамжлага албат, шавь ард, гэрийн боолыг, “Албат ард” гэж хэн нэгний харъяалалгүй “суман ард”-ыг хэлж буй талаар эрдэмтэд<sup>[46]</sup> тэмдэглэсэн байдаг. Хэрэв ийнхүү ойлговол тухайн үед өөрийн харъяат албат ардыг бусдад хууль ёсоор худалдах боломжтой байсан уу гэсэн асуулт зүй ёсоор урган гарах ба дээрх зохицуулалтаас хамжлагаа худалдах боломж байсан гэж үзэж болохоор байна.

1921 оны Ардын хувьсгалын үр дүнд хамжлагат ёсыг халж бүх өрийг хүчингүй болгосон билээ. 1921 онд МАХН-ын 1 дүгээр Их хурлаар баталсан “Эрмэлзэх арван зүйл” хэмээх тунхаглан зарлах бичгийн 6 дахь хэсэгт: “Гагцхүү олонд тусгүй агаад хорлолтой буюу одоо цагийн байдалд үл нийцэх бөгөөд хуучирч нэгэнт хоцорсон зэрэг харштай зүйлүүдийн зүй зохисыг үзэж, чадвал зөөлөн, ядвал хатуу аргаар устган халахаас үл татгалзана”<sup>[47]</sup> гэсэн нь тухайн үед гэмт хэрэгтэй тэмцэхэд баримтлах төрийн бодлогын, 1922 оны 01 дүгээр сарын 25-ны Засгийн газрын 37 дугаар хурлаас “Хамжлагат ёсыг халах тухай”<sup>[48]</sup> тогтоолыг гаргасан нь хүн бүрийн тэгш эрхтэй болохыг баталгаажуулж, хүнийг мөлжих, албадан хөдөлмөрлүүлэх явдлыг цаазлан

хориглосон бөгөөд “...ардын эрхт хэмжээт цаазат засгийн ёсон болбоос захирах захирагдахын ёсон ба эрүү шүүлт яллах залхаахыг бүрнээ устгасан гагцхүү дээдэс нь доордыг учиргүйгээр эзэрхэж дарлах ба доордос нь мөн түүний эрх сүрт дарагдаж өгүүлэх газаргүй болон зүдэж дарлагдах муу суртлыг халж, ард түмэнд эрх чөлөө олгосон нь болой”<sup>[49]</sup> хэмээн эрүүгийн бодлогын үндсыг тодорхойлжээ.

Энэхүү эрхийг 1924 оны Анхдугаар Үндсэн хуулиараа баталгаажуулж, хүн бүр адил тэгш эрхтэй бөгөөд хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж, өөрийн барьцаанд байлгаж, хөдөлмөрийг нь мөлжиж үл болохыг тунхаглаж, “Хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр нь устгаж, улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийцүүлж, шинэ ёсны Бүгд найрамдах улсын үндэс тулгуурыг бататган бэхжүүлэхэд БНМАУ-ын Үндсэн хуулийн зорилт оршино”<sup>[50]</sup> гэж хуульчилсан юм.

Анхдугаар Үндсэн хуулийн дээрх үзэл санаа 1929, 1934 онуудын Шүүх цаазын бичгүүд, Монгол Улсын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай болон Иргэний хууль, Биеийн хүчнээ үнэлэгчдийн зэрэг томоохон хууль, түүнд нийцүүлэн гаргасан олон тооны тогтоол, дүрэм, зааварт тусгагдсан боловч хүн худалдаалах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, бие даасан зүйл болгон хуульчилаагүй байна.

1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд: “Эмэгтэйчүүдийг боглон өгөх, насанд хүрээгүй эмэгтэйчүүдийг эхнэр болгон өгөх буюу авах, олон эхнэртэй байх ... зэргээр ямар нэгэн маягаар эмэгтэйчүүдийг боолын байдлаас ангижруулан гаргах ба тэгш эрхтэй болгох явдалд саадыг учруулбал хуулиар цээрлүүлэн шийтгэнэ”<sup>[51]</sup> хэмээн охид, эмэгтэйчүүдийг богллох явдлыг хориглосон заалт тусгагджээ.

1968 онд Монгол улс “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц”<sup>[52]</sup>, “Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс заншлыг

<sup>49</sup> 1922 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Захирах захирагдах журмын тогтоол”-д МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I боть. УБ., 1966. 124 дэх тал

<sup>50</sup> БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийн 2 дугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд /1924-1992/. Эмхтгэсэн Д.Батаа. УБ., 1998. 4 дэх тал

<sup>51</sup> БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн 93 дугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд /1924-1992/. Эмхтгэсэн Д.Батаа. УБ., 1998. 42 дэх тал

<sup>52</sup> Монгол улс 1968.10.31-нд соёрхон баталсан.

<sup>46</sup> Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011. 58 дахь тал

<sup>47</sup> МАХН-ын тогтоол, шийдвэр, баримт бичгүүд. 1 дэвтэр. УБ., 1981. 53 дэх тал

<sup>48</sup> Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга, хэмжээнүүд. УБ., 1954. 101 дэх тал



устгах тухай нэмэлт конвенц”<sup>[53]</sup>, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”<sup>[54]</sup>, 1980 онд “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц”<sup>[55]</sup>, 1990 онд “Хүүхдийн эрхийн тухай конвенц”<sup>[56]</sup>-д тус тус нэгдэн орж, соёрхон батласнаар үндсэндээ монгол улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай үүргийг олон улсын өмнө хүлээсэн юм.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, хүний эрхийн тулгуур зарчмууд Монгол улсын бусад хууль, тэдгээрийг дагалдсан эрх зүйн дэд актуудад болон төрийн эрүүгийн бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдан бэхжсэн.

1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн “Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх” гэсэн 111-р зүйлийн 1 дэх хэсэгт: *“Биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж хүмүүсийг элсүүлсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг элсүүлсэн буюу биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол 3-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”*<sup>[57]</sup> гэсэн заалтыг шинээр оруулсан нь ашиг олох зорилгоор хүний биеийг үнэлүүлсэн, хууран мэхэлж хүнийг элсүүлсэн, улсын хил давуулсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болсон юм.

2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 113 дугаар зүйлд: «Хүн худалдах, худалдан авах» гэмт хэргийг хуульчилсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн чухал алхам болсон ч уг гэмт хэргийн объектив талын шинжийг диспозицид нарийвчлан тодорхойлоогүйгээс практикт түүнийг зүйлчлэх, хянан шийдвэрлэхэд бэрхшээл учирсаар байна.

2004 онд Улсын Их Хурлаас батлагдсан “Хүн амын хөгжлийн талаар төрөөс

баримтлах бодлого”, 2002 оны “Хүүхдийн хөгжил хамгааллын сайжруулах үндэсний хөтөлбөр”-т хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, улсын хил давуулан худалдаалахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал тусгагдан улмаар Засгийн газрын 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 234 дугаар тогтоолоор “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр” батлагдсан ч санхүүгийн хязгаарлагдмал байдлаас зогсонги байдалд байна.

2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 113-р зүйлд: “Ашиг олох зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тэвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн хульчилсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүнийг насанд хүрээгүй хүнийг, хоёр ба түүнээс олон хүнийг, хулгайлах, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг, давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих, хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан. Мөн Улсын Дээд Шүүхээс 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдөр 12 дугаар тогтоол гаргаж, Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг тайлбарласан нь практикт эрүүгийн хэргийг зүйлчлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, шүүхээр хэргийг хянан шийдвэрлэхэд ихээхэн ахиц үзүүлсэн боловч тайлбарын зарим хэсэгт нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээтэй зөрчилдсөөр байна.

2008 оны 5 дугаар сард Монгол Улс Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай

<sup>53</sup> Монгол улс 1968.10.31-нд соёрхон баталсан.

<sup>54</sup> Монгол улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан.

<sup>55</sup> Монгол улс 1980.07.10-нд гарын үсэг зурж, 1981.05.14-нд соёрхон баталсан.

<sup>56</sup> Монгол улс 1990.01.26-нд гарын үсэг зурж, 1990.07.05-нд соёрхон баталсан.

<sup>57</sup> Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3/1111. Төрийн мэдээлэл. УБ., 1996. №6



протокол"-д нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжуудыг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн өөрчлөх, хохирогчдын эрхийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжих зэрэг үүргийг хүлээсэн нь хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийг өөрчлөх нөхцөл нь болсон билээ.

2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 113 дугаар зүйлийн үндсэн бүрэлдэхүүнийг "Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхийллийн бусад аргыг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аргаар хүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан бол эд хөрөнгийг хурааж, гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ", "Энэ хэргийг давтан, хоёр буюу түүнээс олон хүнийг, насанд хүрээгүй хүнийг, хүний эд эрхтэнг авах зорилгоор, сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүйд тооцогдсон хүнийг, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг, хуурамч бичиг баримт ашиглан, хохирогчийн бичиг баримтыг авах, нуух, устгах арга хэрэглэж, улсын хил давуулан, илтэд жирэмсэн хүнийг худалдаалсан бол хүндрүүлэхээр, энэ хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол хүндрүүлэх нөхцөлд тооцох, 113.1-д заасан аргыг хэрэглээгүй байсан ч арван найман насанд хүрээгүй хүнийг хүн худалдаалах зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун дарагдуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хүн худалдаалсан гэж үзэхээр хульчилжээ.

Мөн хуулийн тайлбарт: "мөлжих" гэдгийг худалдаалагдсан хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглах утгаар, энэ хэргийг үйлдэхдээ хохирогчийн эсрэг хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашигласан, эмзэг байдлыг нь

далимдуулах, эсхүл өөр хүнийг эрхшээлдээ байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлж буюу ашиг олгон хахуульдах аргын аль нэгийг хэрэглэсэн тохиолдолд хохирогч өөрийг нь мөлжихийг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ хэмээн тайлбарласан байна.

2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 113 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг: Энэ хэргийг хүний эд эрхтэнг авах зорилгоор, сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүйд тооцогдсон хүнийг, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг, хуурамч бичиг баримт ашиглан, хохирогчийн бичиг баримтыг авах, нуух, устгах арга хэрэглэж, улсын хил давуулан, илтэд жирэмсэн хүнийг худалдаалсан бол хүндрүүлэхээр өөрчлөн хуульчилсан нь практикт үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг зүйлчлэх, шүүхээр хянан шийдвэрлэх, гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд тохирсон ялыг шударгаар оногдуулахад ихээхэн ач холбогдолтой өөрчлөлт болсон гэдэг нь бидний явуулсан судалгааны үр дүнгээс харагдаж байгаа юм.

Гэвч бидний зүгээс энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд шүүмжлэлтэй хандах зүйл цөөнгүй байна гэж үзэж байна. Тухайлбал, 2008, 2012 онуудын Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнө биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүн худалдах үйлдлийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан байсныг үндсэн бүрэлдэхүүнд хуульчилсан, мөн энэхүү нэмэлт, өөрчлөлтөөс өмнө хүнийг улсын хил давуулан худалдаалах үйлдлийг онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан байсныг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан нь монгол улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн бүтцэд хүн худалдаалах гэмт хэргийн эзлэх хувийн жин өсч, нийгмийн хор аюул нь нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд ийнхүү хөнгөрүүлэн авч үзэх нь цаг үеэ олоогүй, ухралт бүхий заалт болжээ гэж үзэж байна.

Онолын хувьд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нийгмийн аюулын шинж, хир хэмжээг харгалзан үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд ангилдаг бөгөөд оногдуулах ял нь ч ялгаатай байдаг нь практикаар шалгагдсан зүйл билээ.

Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор



2011 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хурлаас “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” бие даасан хуулийг баталсан бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн, төрийн бус байгууллагууд болон хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүрэг, санхүүжилт, хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэр, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт, хохирогчийн нэр төр, алдар хүндийн хамгаалалт, хохирол нөхөн төлүүлэх, гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, урамшуулах гэхчилэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд ихээхэн ач холбогдолтой олон заалтууд тусгагдсан хэдий ч энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин төгс бүрдээгүй байна.

Ийнхүү 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн захиалга, шаардлагаар олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан ч өнөөгийн нийгмийн харилцааны хөгжил, эрэлт хэрэгцээтэй холбон авч үзвэл Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг бүрэн дүүрэн хамгаалж чадаагүй, даяарчлагдаж буй эрин үед олон улсын нийтийн эрх зүйн хөгжлөөс хоцрох хандлагатай байна.<sup>[58]</sup>

Иймээс ардчилсан нийгмийн харилцаанд тохирсон, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгох» зорилтын хүрээнд 2015 онд УИХ-аас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Энэхүү хуулийн “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн Арванхоёрдугаар бүлгийн 12.3 дугаар зүйлд “Бэлгийн мөлжлөг”, “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг” гэсэн Арвангурвдугаар бүлгийн 13.1 дүгээр зүйлд “Хүн худалдаалах” гэмт хэргийг хуулчилсан нь эрх зүйн зохицуулалтын хувьд улам боловсронгуй болж, олон улсын нийтийн эрх зүйн жишигт ойртсон байна.

Аливаа ойлголтыг хэт ерөнхийлөх буюу бүдүүвчлэх нь ойлголтыг бүрхэгдүүлэх, ойлгомжгүй эргэлзээтэй болгох талтайг харгалзан эрдэмтэн, судлаачдаас тухайн

<sup>58</sup> Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийн үзэл баримтлалаас

зүйлийн агуулга, мөн чанарыг гүнзгий ойлгож, танин мэдэх, үнэлж цэгнэх улмаар түүнийг зөв хэрэглэх, хангах хамгаалах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах боломжийг олгоно хэмээн үзэж янз бүрийн шалгууруудаар төрөл зүйл болгон системчлэлд оруулан ангилалтуудыг<sup>[59]</sup> хийж, түүнийгээ төрөл бүрээр нотлохыг зорьдог уламжлалтай. Үүний нэгэн адил хуульч эрдэмтэн, судлаачид<sup>[60]</sup> хууль тогтоомжуудыг судлахдаа тухайн цаг үеийн нөхцөл байдал, төрийн дэглэм, бодлого, хууль тогтоомжийн хөгжил зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан Монгол нутагт төр үүссэн цагаас хойш XIII зууны эхэн үе /Их Монгол улс оршин тогтнож байсан/, XIII зууны сүүлээс Монгол оронд Ардын хувьсгал ялсан 1921 он хүртэлх үе, 1921 оноос 1990-ээд оны үе, ардчилал шинэчлэл өрнөсөн 1990 оноос хойшхи үе гэсэн үечлэлд хуваан үздэг.

Харин бид энэ гэмт хэрэг Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжуудад тусгагдаж, эрх зүйн зохицуулалтын хувьд улам боловсронгуй болж, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцсэн байдлаар тусгагдсан зэргийг үндэслэн хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг түүхийн дараах үечлэлд ангилсан:

1. 1795 оноос өмнөх Монголын түүхэн хууль цаазын бичгүүдэд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг тусгасан нь<sup>[61]</sup>

<sup>59</sup> Чимид Б., Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008, Амарсанаа Ж., Хүний эрх: олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000, Сэнгэдорж Т., Экологийн эрх зүй. УБ., 2001, Хенри Ж.Стайнер, Филип Элстон “Хүний эрх-эрх зүй, улс төр, ёс суртахууны асуудлууд” I, II дэвтэр. УБ, Глушкова.С.И. Права человека в России. М., 2005, Иванов.Г.И. Права человека. Учебное пособие. М., 2004, Лукашева Е.А., /ответственный редактор/ Права человека: Учебник для вузов. М., 2003, Права человека: Сборник международных документов, М., 1998, Rhona.K.M.Smith. Text book on International Human Rights. 2007, Дэвид Боаз. Либертарианизм. УБ., 2005.

<sup>60</sup> Д.Лүндээжанцан, Ж.Болдбаатар – 1. Монголын эртний улсуудын төр, эрх зүй /МЭӨ III-МЭ XIII/, 2. Монголын дундад үеийн төр, эрх зүй /XIII-XX зууны эх/, 3. Шинэ үеийн төр, эрх зүй /XX зууны 20-иод оноос 90 он/, 4. Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүй /90-ээд он/ гэж ангилсан байна. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997. 9 дэх тал

С.Нарангэрэл. Монгол оронд эрх зүй үүсэж, хөгжиж ирсэн он цагийн үечлэлийг: Нэгдүгээр үе /Монголын улсаатны улс үүсэн буй болсноос эхлэн Юань гүрний Нэвтэрхий хууль үйлчилж байсан үе/, Хоёрдугаар үе /Ойрад-Монголын хууль үйлчилж эхлэснээс хойш 1924 он хүртэлх/, Гуравдугаар үе /1924 оноос 1990/ болгон ангилжээ. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо /Харьцуулсан эрх зүй/ МУИС, ШУА. УБ., 2001. 92 дахь тал

<sup>61</sup> Монгол нутагт амьдарч байсан эртний улсуудын төр, эрх зүйн талаарх судалгаа, шинжилгээний материал байдаг ч бидний судалгаанд хамаарах асуудлаар



2. 1795 оноос 1921 оноос хүртэлх Манжийн үеийн Эрүүгийн хууль тогтоомжуудад хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байдал,

3. 1921 оноос 2015 оныг хүртэлх Эрүүгийн хууль тогтоомжуудад хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байдал, төрийн эрүүгийн бодлого

Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлалыг асуудлыг түүхийн тодорхой үечлэлд ангилан судалж үзэхэд, сүүлийн жилүүдэд “ШИНЭ ТӨРЛИЙН” гэж тодотгогдоод буй “ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ” нь гэмт хэргийн хувьд шинэ төрөл биш бөгөөд харин үйлдлийн арга, тэмцэх арга зүй нь шинэлэг байж болох юм.

### Ном зүй

#### Нэг. Монгол Улсын хуулиуд

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
2. БНМАУ-ын Эрүүгийн хууль. 1986 / шинэчлэн найруулсан/
3. Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2002. №5
4. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. Төрийн мэдээлэл. УБ., 2015
5. Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн З/1111. Төрийн мэдээлэл. УБ., 1996. №6
6. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2002. №6
7. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл. 2013. №29
8. Донорын тухай Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2000. №6
9. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль. 2011. Төрийн мэдээлэл. УБ., 2011. №8

#### 1. Хоёр. Бусад эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”
2. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 234 дугаар тогтоолоор “Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”
3. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол

Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”

4. Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
5. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
6. Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 дугаар тогтоол

#### 2. Гурав. Ном, сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээлүүд

1. Авирмэд.Э, Дашцэдэн.Д, Совд.Г. “Монгол хууль” /Уламжлал, шинэчлэл Монголын төр эрх зүйн түүхэн сэдэв/. УБ., 1997
2. Адъяабазар.Д. “Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил”. УБ., 1998
3. Амарсанаа.Ж, Баярсайхан.Б, Чимэд.Б нар. “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл”. Нэгдүгээр боть /1206-1910 он/. УБ., 2010
4. Амарсанаа.Ж, Баярсайхан.Б, Чимэд.Б нар. “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл”. Хоёрдугаар боть /1206-1910 он/. УБ., 2010
5. Батзориг.Б, Оюунболд.Г, Оюунбилэг.Д. Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал. УБ., 2010
6. БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийн 2 дугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд /1924-1992/. Эмхтгэсэн Д.Батаа. УБ., 1998
7. Баярсайхан.Б. Монгол цаазын бичиг /харьцуулсан судалгаа/. УБ., 2001
8. “Монголын төр, эрх зүйн түүх” /дээж бичиг/. IV дэвтэр. 1, 2-р хэсэг. Эмхтгэсэн Б.Баярсайхан, Б.Батбаяр. УБ., 2008
9. Баярсайхан.Б, Батбаяр.Б, Лхагважав.Б, Сүхбаатар.М. “Монгол Улсын хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн товчоон” /1911-2008/. УБ., 2008
10. Баярсайхан.Б, Батбаяр.Б, Лхагважав.Б. “Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ” /Улаан хацарт/. УБ., 2010
11. Баярсайхан.Б, Жанцан.С, Энхнасан.Ж, Сумъяацэрэн.Д. “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” /1911-2009/. УБ., 2011
12. Баярсайхан.Б, Золбоо.Т. “Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл”. УБ., 2012

нэн ховор байсан тул эртний улс, овог аймгуудад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ирсэн уламжлалын судалгааг XIII зуунаас 1921 он хүртэлх үечлэлд нэгтгэн судалсан болно.



13. Баярсайхан.Б. “Монгол хэлний тайлбар толь”. Монсудар хэвлэлийн газар. УБ., 2011
14. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”. I-V боть. Ерөнхий редактор Л.Болд. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи. УБ., 2012
15. Монголын түүх. Дэд боть. ШУА-ийн Түүхийн хүрээлэн. Хамтын бүтээл. УБ., 2004
16. Гантулга.С, Оюунболд.Г, Тамир.Д нар “Хүүхдийн хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг”. УБ., 2010
17. Дамбажав.И. “Оюун бэлгийн мэлмийг нээгч аялгуу сайхан Монгол үгийн дээж”. /Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь/. УБ., 2010
18. Жалан-Аажав.С. “Халх журам”. УБ., 1994
19. Жанцан.С. нар “Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал”. /1911-2009/. УБ., 2011
20. Жувейни.А. Ерөнцийн байлдан дагуулагчийн түүх. Хөх хот., 1980
21. Лүндээжанцан.Д, Болдбаатар.Ж. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997
22. П.Оюунчимэг. Хүн худалдаалах гэмт хэрэг /шүүгч, прокурор нарт зориулсан сургалтын гарын авлага/. УБ., 2011
23. Төрмандах.З, Гантулга.С. Хүн худалдаалах гэмт хэрэг. УБ., 2008
24. Совд.Г. “БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс” /ерөнхий анги/. УБ., 1973
25. Хүн худалдаалах гэмт хэрэг- эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. Хууль зүйн Үндэсний Хүрээлэн, Хүний эрх хөгжил төв. УБ., 2010
26. Britannica ширээний нэвтэрхий толь. VI боть. Нерко
27. Плано Карпини, Вилгельм де Рубрук. Монголд жуулчилсан тэмдэглэл. Орчуулсан Гэрэлцогт. ӨМСХХХ.,1983
28. Жиованни дел Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1998
29. Вилгельм де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. 1988
30. МАХН-ын тогтоол, шийдвэр, баримт бичгүүд. 1 дэвтэр. УБ., 1981
31. Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга, хэмжээнүүд. УБ., 1954
32. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I боть. УБ., 1966





## МОНГОЛ-ОЙРАДЫН ИХ ЦААЗ ДАХЬ ХУЛГАЙЛАХ ХЭРЭГТ ХАМААРАХ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ТУХАЙ

Б. Жаргалсайхан  
Их Засаг ОУИС-ийн багш

Хураангуй: Монгол – Ойрадын их цааз нь XVII зууны Монголын нийгэм, улс төр, аж ахуйн хөгжил болон өөрчлөлттэй салшгүй холбоотой юм. Их цаазын бичигт: мал унаа, цэргийн эд хэрэгсэл, дээл хувцас, ахуй амьдралын багаж хэрэгсэл, эмээлийн тоног хулгайлах хэрэг зэргийг тодорхой зохицуулж байжээ. Энэ нь тухайн үеийн нийгмийг тогтвортой хөгжихөд түүхэн нөлөө үзүүлсэн байна. Мөн хулгай хийсэн хүнийг малаар торгохоор зохицуулсан нь өмнөх хуулиудын залгамж холбоог хадгалсан өвөрмөц нэгэн онцлог болно.

Түлхүүр үг: Монгол – Ойрадын их цааз, хулгайн хэрэг, төрөл, малаар торгох

XVII зууны эхэн үед Монголчууд харийн түрэмгийлэлд өртөж, өөр зуураа хатгалдан тэмцэлдэж байсан тухайн цаг үед Цахарын Лигдэн хааны төр нурж, Өвөр Монгол Манжийн эрхшээлд орсоны дараа 16 аймаг 49 хошуунд хуваагджээ. Энэ үеэс Дөрвөн Ойрадын нутаг ч мөн хаант Оросын сүрдүүлэл доор нилээд хэдэн жилийг үдсэн байна. Ийм түүхэн нөхцөл байдалд Ойрад Халх олон жил үргэлжилсэн дотоодын дайнаа зогсоож Зүүн гарын хун тайж болон Халхын Засагт Хан аймгийн хүчийг нэгтгэн феодалын ноёрхолын байр сууриа бэхжүүлэн харийн ноёрхолыг эсэргүүцэж, эв нэгдэлээ бэхжүүлэхийн тулд 1640 оны 8-р сарын эхээр Дөрвөд – Ойрадын нутаг Тарвагатайн улаан буураа гэдэг газар Халх – Ойрадын их чуулган болж “Монгол – Ойрадын их цааз”-ыг баталжээ. Уг чуулганд Халхын Эрдэнэ засагт хаан Субадай, Очирбат тулгар түшээт хан аймгийн нөлөө бүхий том ноёд, Ойрадын Эрдэнэбаатар хун тайж, Хөндлөн Убаш, хошуудын гүүш хан Төрбайх, Тэнгэрэй тойн нарын зэрэг Халх – Ойрадын төр шашны зүтгэлтэн болон Хөх нуурын Монголчууд, Ижил мөрний торгуудын ноёдын төлөөлөгчөөс бүрдсэн 30 шахам том ноёд оролцсон байна. Их цааз нь: XVII зууны үеийн Монголчуудын улс төр, аж ахуй, шашин шүтлэг, нийгмийн зохион байгуулалт, үйлдвэрлэл, аж амьдрал, ураг хурим, гэр бүл, ёс зүй, үзэл суртал, зан заншил зэрэг олон зүйлийг

тусгасан түүхэн чухал сурвалж юм. Иймээс дэлхийн Монголч эрдэмтэд уг их цаазыг: “XVII зууны амьдралын толь”, “Богтос бичиг”, “Дөчин дөрвөн хоёрын их цааз”, Чингисийн Их засаг хуультай харьцуулан “Бага засаг” хэмээн өндрөөр өргөмжлөн нэрлэж ирсэнээс гадна, “Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”, “Халх журам” хуулиудтай адилтган Монголчуудын хууль цаазын гурван их эх сурвалж хэмээн эрхэмлэн үздэг байна<sup>[62]</sup>. Нөгөө талаас уг их цааз нь: шарын шашныг ард иргэдэд сурталчлан ухуулсан өнгө аястай байжээ. Тухайлбал уг цааз бичгийн эхлэл хэсэг “Ум сайн амгалан болтугай. Хоёр чуулганы далайн дунд хоосон чанарын номын биеэс хотол агсан бэлэг үлгэрээр цогтойёо чимсэн гурван бие хамтатгасан Очир дарь ламд мөргөмүй<sup>[63]</sup>” гэжээ. Мөн “шашны тус лам нарын үйл аймгийг алж талж авбаас зуун хуяг, зуун тэмээ, зуун адуу авах, гагц заримыг их хэв авах болов<sup>[64]</sup>” гэсэн хүнд шийтгэл тогтоосон байдаг нь шарын шашныг дээдлэн, дархалсан шинж агуулгыг илэрхийлсэн байдаг.

Монгол – Ойрадын их цааз нь агуулгын хувьд 9 бүлэг 121 зүйлээс бүрдэх бөгөөд үүнээс 20 орчим зүйл заалт нь хулгайн хэргийг зохицуулсан байдаг.

### Нэг. Их цааз дахь хулгайн хэргийн төрөл, ангилал

Монгол – Ойрадын их цаазад: хулгайн хэргийн тухай зохицуулалт нилээд ихээр тусгагдсан байдаг нь тухайн үеийн нийгмийн амьдралыг тольдон харуулсан явдал хэмээж болно. Өөрөөр хэлбэл тухайн үед хулгайн (хулгайн хэрэгт дээрэм, булаалтын хэргийг хамтатган зохицуулсан. Өөрөөр хэлбэл хулгай, дээрэм, булаалт хэмээн ялгаж салгалгүй хулгай хэрэг оруулж байжээ) хэрэг онц ноцтойгоор оршиж ард иргэдийн амар амгалан байдалд ноцтой заналхийлэл учруулж байсан бололтой. Тухайн үеийн ноёрхогч ангийн өмнө хулгайн хэрэгтэй тэмцэх тухай асуудал хурцаар тавигдаж байсны улмаас хулгайчийг хатуу чанга шийтгэж, нийгмийн амар амгалан байдлыг тодорхой хэмжээгээр хангаж байжээ.

Хулгайн хэргийг дараах байдлаар ангилан үзэж болно.

<sup>62</sup> Ч. Бат. Монгол – Ойрдын цааз бичгийн үг хэллэгийн судлал, Бээжин 2012 он, 2-р тал

<sup>63</sup> Б. Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр) УБ, 2006 он, 38-р тал

богтос: Адууны урд хөлийг сойж уядаг уяаа

<sup>64</sup> Б. Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр) УБ, 2006 он, 39-р тал



I. Эмээлийн тоног хулгайлах хэрэг. Их цаазад: “Сайн мөнгөн эмээл, хазаар, хударга, булган дахын хэвээр болов. Дунд мөнгөн эмээл хазаар, хударга, чоно, шилүүсний хэвээр болов. Алах дөш өрөлби ест болов. Сайн мууг нь шүүж мэдь<sup>65</sup>” гэж заасан байна. Мөн мөнгөн эмээл, хазаар, хударга хулгайлбал булган арьсан дээл хулгайлсан ялаар шийтгэж, даруй таван ес торгоно. Дунд зэргийн мөнгөн эмээл, хазаар, хударга хулгайлбал чоно, шилүүсний арьс хулгайлсан ялтай адилаар шийтгэж, даруй долоон есөөр торгоно гэж заажээ. Энэхүү зохицуулалт нь Монголчуудын нүүдлийн аж амьдралтай нягт холбоотой өвөрмөц зохицуулалт юм. Эмээл, хазаар, хударга бол Монголчуудын аж амьдрал, нүүдлийн соёл иргэншилтэй салшгүй холбоотойгоос гадна морио эрхэмлэн дээдэлдэг эртний уламжлалтай ч холбоотой байж болох юм.

II. Цэргийн эд хэрэгсэлийг хулгайлах хэрэг. Их Цаазад: “лүвч хуяг хулгайлж авбал арван ес ав, харавч авбал гурван ес ав, дээл хуяг авбал гурван ес ав, дуулга хулгайлж авбал нэг ес ав, буу авбал нэг ес авах болов” мөн “сайн илд сэлэм хулгайлхул сайнаас ес, муугаас тав, жад хулгайлхул сайнаас гурав, муугаас морь ав. Сайн саадаг нум арван сумтай болвол гурван ес ав, дунд саадаг нуман болвол ес ав, муу саадаг нумаас үнээтэй ямаа ав<sup>66</sup>” гэж заасан байна. Энэ хоёр зүйл заалт нь “цэргийн эд хэрэгсэл”-ийг хулгайлах хэргийн тухай зохицуулалт болно. Тус хэрэг нь бусад хулгайн хэргээс онцлог ялгаатай юм.

Малаар торгох шийтгэлийг шийтгэлийн хэр хэмжээг нь удирдлага болгон судлавал:

- Лүвч хуяг хулгайлбал (арван есөөр торгох) оногдуулах шийтгэл нь хамгийн хүнд болно.

-Харавч дээл хуяг хулгайлбал гурван ес торгоно.

- Дуулга, буу хулгайлбал нэг ес торгоно.

- Илд, сэлэм, жад болон нум сум хулгайлсан хүнийг шийтгэхэд сайн, дунд, муу (илд, сэлэм хулгайлбал сайнаас сайнаас ес, муугаас тав. Жад хулгайлбал сайнаас гурав, муугаас морь. Сайн саадаг нум арван сумтай хулгайлбал гурван ес торго, дунд саадаг нум бол ес ав, муу саадаг нумнаас үнээ ямаагаар торгох) гэж хувааж харилцан адилгүй торгох шийтгэл оногдуулдаг байжээ.

Дээр дурьдсан цэргийн эд хэрэглэлийг

<sup>65</sup> Б. Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр) УБ, 2006 он, 44-р тал  
Богтос: адууны урд хөлийг сойж уядаг уяаг хэлнэ.

<sup>66</sup> Б. Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр) УБ, 2006 он, 41-р тал

хулгайд алдвал цэргийн байлдах хүчин чадалд муугаар нөлөөлөх улмаар дайн байлдаанд ялагдах аюулд хүргэж болзошгүйгээс гадна, магадгүй цэргийн эд юмс, зэр зэвсэгийг хулгайлсан хүн төрийн эсрэг бослого гаргах, цэрэг дайчдын амь насанд халдах гэх мэт их хэмжээний хохирол учруулах магадлалтай түүхэн цаг үе байсан. Иймээс цэргийн эд хэрэгсэлийг хулгайлах хэрэг нь бусад хулгайн хэргээс шийтгэлийн хувьд хүнд байжээ.

III. Мал унаа хулгайлах хэрэг. Их цааз бичигт: “Хулгайн цааз эхлэв. Тэмээний ял арван таван ес, агт азаргын арван ес, гүүний найм ес, үхэр даага хонь гурвуулын зургаан ес авах болов. Тэмээ нь есдөө орох болов” гэж зааснаас гадна, “Хулгай хэдий идэхүл төдий зан барь. Илүү барихул ялын нь хагасыг эзэн нь босгомж холбоогоо авах болов<sup>67</sup>” хэмээн заажээ. Дээрхи хоёр зүйлийн зохицуулалтын илрэл нь:

1. Мал хулгайлбал малаар торгох бөгөөд хулгайчаас хулгайлсан малын тоогоор мал хураан авна. Тэмээ хулгайлбал арван таван есөөр торгож, хулгайд алдсан тооны мал хулгайчаас хураан ав. Агт, азарга хулгайлбал арван ес торгож, хулгайд алдсан тооны мал хулгайчаас гаргуулан авна. Гүү хулгайлбал найман ес торгож, хулгайд алдсан тооны мал хулгай хүнээс гаргуулан авна. Үхэр, даага(морь), хонь гэсэн гурван хошуу мал хулгайлбал зургаан ес торгож, хулгайд алдсан тооны мал хулгай хийсэн хүнээс хураан авдаг байжээ.

Дээрх зохицуулалтаас үзвэл: тэмээ нь агт, азарганаас өндөр үнэтэй байжээ. Мөн агт, азарга нь гүүнээс өндөр үнэтэй байсныг харж болох юм. Өөрөөр хэлбэл тэмээ нь таван хошуу мал дотроо хамгийн үнэтэй, чухал уналга эдэлгээний төрөлд тооцогддог байсан бөгөөд аж амьдралдаа өргөнөөр хэрэглэж амь зуулгаа залгуулдаг, тоо ширхэгийн хувьд цөөхөн байсныг харж болох юм.

2. Мөн энэхүү их цаазын нэгэн өвөрмөц зохицуулалт бол “Хулгайд алдсан малын тоог нэмж худлаар мэдүүлэгч зөвхөн торгосон малынх нь хагасаар төлбөр олох болно” гэжээ. Энэхүү зохицуулалт нь Монгол үндэстэн эрт дээр үеэс үнэнч шударгыг эрхэмлэдэг ёстой холбоотой юм.

<sup>67</sup> Б. Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр) УБ, 2006 он, 42-р тал

Хударга: эмээлийн хавтасны хойд талд уяж, морь малын сүүл бөгсөнд бэхлэх бэхэлгээг хэлнэ.

Өрөлбө: халуун төмөр юмыг хавчиж барихад хэрэглэдэг шовх хошуутай, иргүй, хайч мэт хавчих багажыг хэлнэ.

Лүвч: өвч хуягийг хэлнэ.





Худал мэдүүлэг өгсөн хүнийг алах ялаар шийтгэхгүй ч гэсэн хохирлын хагасаар хохирлыг барагдуулдаг байжээ. Мөн тухайн үедээ худал мэдүүлвэл ял шийтгэл оногдуулж, худал мэдүүлгээс урьдчилан сэргийлэх, хулгайчийн эрхийг тодорхой хэмжээнд хамгаалсан ач холбогдолтой түүхэн зохицуулалт байжээ.

IV. Аж амьдралын багаж хэрэгсэл хулгайлах хэрэг. Их цааз бичигт: “хэт хутга, сум, хуурай, аргамж, хээрийн чөдөр, хазаар, зүүсэн алх, хүзүүвч, сайн малгай, годос, өмд, хайч, кийр, төмөр дөрөө, модон эмээл, хэмнэг (цув), жанч, хэжим, учиг, сугсарга, бөс, кийлэг бөс, бүс, хуяг дуулгын гэр, ооль, сүхь сайн хударга, амьгүй идээ, ууттай бүхэл хонины мах болохул, муу дээл, цэгдэг, кирөө, чимэгтэй хонь, чимхүүр, сайн билишэг(балиус), өөш тор, гөлмий, хавх, эднийг авахул хурууг нь огтлох болов. Хуруугаа хайрлавал хоёр бод, гурван хонь ав<sup>[68]</sup>” хэмээн заажээ. Тус зүйлд дээрхи эд зүйлсийг хулгайлбал хулгайчийн хурууг нь тасал(огтол), хэрэв хуруугаа таслуулахгүй гэвэл малаар төлж болох тухай заасан байна. Үүнээс бид хууль тогтоогчийн хүнлэг энэрэнгүйг харж болохоос гадна зөвхөн хулгай дээрмийн хэрэгт хуруу огтлох ял оногдуулдаг байсан байна.

Мөн “Цулбуур, хуйв, бурантаг, зүү, шөвөг, сам, хуруувч, утас, шөрмөс, товч, аяга, шанага, тэвш, хөнгө, хөхүүр, муу малгай, годос, оймс, олом, жирэм, сур, хударга, хавтлага, цөгц, зос, ухми, өрөм, милаа, үхэг, авдар, нэмнээ, нэхий, илэг, хурисха(хурганы арьс), годил, нумны хөвч, нясалбар(няцлуур), ямарваа зүүсэн ихэр чихэр(аахар шаахар) юм энэ цаазад багтав. Сайнаас хургат хонь, муугаас ишигт, ямаа ав” хэмээн заажээ. Мөн “хайс, тулга, хулгайлбал сайнаас ес ав, дундаас тав ав, адгаас гунж ав<sup>[69]</sup>” гэж заажээ. Уг цаазад: хулгайн хэрэгт хамаарал бүхий эд зүйлсийг жишээ аван, тодорхой зааж өгсөн нь хулгайчид ял шийтгэл оногдуулахад ойлгомжтой дөхөм болсон байна. Мөн энэхүү цаазаар хүний амьдралын хэрэгцээний бүхий эд хөрөнгийг, ширхэг зүү, утас ч орхигдуулахгүй зохицуулсан нь онцлог бөгөөд гайхал татна. Энэ нь бусдын тасархай утас, сэтэрхий зүүг ч хөдөлгөж болохгүй гэсэн зорилгыг гүйцэд илэрхийлж, хүний амьдралын бүхий л эд хөрөнгийг зохицуулахыг оролджээ.

<sup>68</sup> Б. Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр) УБ, 2006 он, 43-р тал

<sup>69</sup> Б. Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр) УБ, 2006 он, 45-р тал

“Хүн болбоос идээнээс салж дийлэхгүй болой” гэсэн мэргэн үгний агуулгад нийцүүлэн хоол чанахад хэрэглэдэг тогоо, тулгыг хулгайлбал өрх гэрийн бүх гишүүдийн хоол ундыг тасалдуулсан хэрэг явдал болно. Иймээс сайн тогоо, тулга хулгайлсан хүнийг ес торгох, дунд зэргийн чанартай тогоо, тулга хулгайлбал тав торго, муу чанартай тогоо тулга хулгайлбал гунж торго гэж зохицуулжээ. Ийнхүү торгохдоо хулгайд алдсан тогоо, тулганы сайн болон муугаас шалтгаалан оногдуулах торгуулын хэмжээ харилцан адилгүй байжээ.

Дээл, хувцас хулгайлах хэрэг. Их иааз бичигт: торгон дээл, булган дах, барс, ирвэс, сув хивс, торгон олбог, үен дах эд таван ест болов. Чоно, үнэг, хярс, зээх, халиу бөс, лавшиг дунд дээл эд долоот болов. Булган, үнэгэн, хэрмэн хярсан, мануул, цоохондой, үен эднээс бага араатныг ахлан ихээс нь гунж, багаас нь хонь ав. Хавхад унасан араатан эднийг хэвээр болов хэмээн заажээ. мөн арьсан эдлэл хулгайлсан хэргийг тодорхой зохицуулж байжээ. Тус зүйл заалтаар зохицуулсан ялыг шийтгэлийн хэр хэмжээг нь харгалзан ангилбал:

1. Араатны арьс үнэд хүрэх учраас бусдын тавьсан хавханд орсон араатныг хулгайлсан хүнийг тус араатны арьсыг алсан ялаар шийтгэнэ гэжээ. Энэ зохицуулалтаас үзвэл: тухайн үед барс, ирвэс, булга, чоно, үнэг, хэрэм зэрэг хээрийн амьтдыг агнахыг зөвшөөрсөнөөс биш ан амьтныг хамгаалах зохицуулалт дутмаг байсныг харж болно. Нөгөө талаас энэхүү зохицуулалт нь нүүдлийн соёл, малчин аж амьдралтай холбоотой байж болох юм.
2. Их, бага хэсэг хэмээн ангилаад (булга, үнэг, хирсний арьсан эд) их хэсгийг хулгайлбал гунж, бага хэсгийг хулгайлбал хониор торгон хэмээжээ.
3. Чанар сайн дээл хулгайлсан ял. Барс, ирвэсийн арьс хулгайлсан ял, чанар сайн хивс, сув арьс, торгон цамц хулгайлсан ялыг зохицуулсан ба хэрвээ дээрх өгүүлсэн зүйлийг хулгайлбал нэг есд торгоно.
4. Чоно, үнэг, хирс, халиуны арьс хулгайлвал ял гурван есд торгоно.
5. Торгон дээл хулгайлсан ял, булган арьсан дээл, барс, ирвэс, сув арьсаар хийсэн хивсийг хулгайлбал таван ес торго. Үүнээс тухайн үеийн хүмүүсийнэдэлж хэрэглэж байсан өмсгөл хэрэглэлийг мэдэж болно.
6. Чоно, шилүүс, цэгээн халиуны арьс хулгайлсан ял, бүс цамц хулгайлсан ял, чанар нилээд сайн арьсан дээл хулгайлсан ялын тухай зохицуулсан ба дээр өгүүлсэн



зүйлийг хулгайлбал долоон есд торгоно.

Хоёр. Их цааз дахь хулгайн хэрэгт хамаарах зүйл заалтын зохицуулалтын арга:

1. Золих арга<sup>70</sup>. Их цаазад: “хэт хутга, сум, хуурай, аргамж, хээрийн чөдөр, хазаар, зүүсэн алх, хүзүүвч, сайн малгай, годос, өмд, хайч, кийр, төмөр дөрөө, модон эмээл, хэвнэг (цув), жанч, хэжим, учиг, сугсарга, бөс, кийлэг бөс, бүс, хуяг дуулгын гэр, ооль, сүхь сайн хударга, амьгүй идээ, ууттай бүхэл хонины мах болохул, муу дээл, цэгдэг, кирөө, чимэгтэй хонь, чимхүүр, сайн билишэг(балиус), өөш тор, гөлмий, хавх, эднийг авахуул хурууг нь огтлох болов. Хуруугаа хайрлавал тав, хоёр бод, гурван хонь ав” хэмээн заажээ. Уг зохицуулалтаас хууль тогтоогчийн хүнлэг үзлийг харж болох юм. Золих дүрмийг хэрэглэх эсэх нь ял хийсэн хүний аж амьдралын түвшинг харгалзан харилцан адилгүй тогтоодог байжээ. Золих дүрмийг хэрэглэх нь: хүний амь нас, эрүүл мэнд, бие мах бодийг нь хамгаалж, хүндэлж буйгийн илрэл билээ.

2. Малаар торгох арга. Энэхүү арга нь Монгол үндэстний эртний хууь цаазын уламжлалыг хадгалсан зохицуулалт юм. Малаар торгох журам нь уг их цаазад өргөн хэрэглэгдэж байсан шийтгэлийн төрөл гэдэг нь илэрхий харагддаг юм. Малаар торгох журмыг хэрэглэх шалтгаан нь:

- Мал аж ахуйгаар амь зуулгаа залгуулдаг Монгол үндэстний хувьд мал нь хамгийн чухал эд хөрөнгөд тооцогддог байжээ. Малын бүтээгдэхүүнээр өмсөх хувцас, идэх хоол, унах унаагаа залгуулдаг байсантай холбогдуулан малаар торгох шийтгэл нь хамгийн хүнд шийтгэлд тооцогддог байжээ. Өөрөөр хэлбэл тухайн хулгайч ам зуулгаасаа салж болзошгүйн улмаас хулгайн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх механизм болж чаддаг байсан байна.

- Тухайн үеийн Монгол орон дайн самууны байдалд байснаас гадна, тал нутагт хүн ам цөөн, хөдөлмөрлөх хүч дутмаг байсан нь нийгмийн чухал асуудал байжээ. Мөн хулгайн хэрэг хийсэн хүнийг алах эсхүл хорих, цөлөх ялаар шийтгэвэл цэрэгт явах хүний тоо цөөрөх, ноёрхогч ангийн ашиг сонирхолд нийцэх аюултай болно. Иймээс их цаазад алах болон занчих ялыг багасгаж, малаар торгох шийтгэлийг түлхүү оруулсан байна. Малаар торгохдоо есөөр торгохыг

<sup>70</sup> Золих ял гэдэг нь биеэр эдлэх ялынхаа төлөөсөнд эд зүйл, мөнгө төгрөг өгч мултрахыг хэлнэ

Хэжим: эсгий тохом

Сув: хүч нэмэгдүүлэх үг

Өөш тор: загас, шувуу барих тор

Хэвнэг: цас бороонд өмсөх өмсөх, нөмрөг дөвхөц хувцас

нэгж болгожээ. Монгол үндэстэн эртнээс есийн тоог эрхэмлэдэг байсантай холбоотой байхыг ч үгүйсгэх аргагүй юм. Есөөр торгох гэдэг нь: хэрэг хийсэн хүнийг есийн хүрдний дагуу малаар торгохыг хэлнэ. Тухайлбал: нэг ес, хоёр ес, гурван ес, дөрвөн ес, таван ес, зургаан ес, долоон ес, найман ес, есөн ес гэх мэт дахин тоогоор үржүүлэн торгохыг хэлнэ.

### **Гурав. Их цааз дахь хулгайн хэргийн зохицуулалтын ач холбогдол.**

I. Бие мах бодийн шийтгэлийг малаар торгох ялаар орсон нь. Энэ нь нэг зүйлийн дэвшилтэт зохицуулалт юм. Харгис бүдүүлгээр яллан шийтгэх нь хууль цаазын хоцронгүй, бүдүүлгийн илрэл билээ. Малаар торгох нь: хэрэг хийсэн хүнийг яллан шийтгэх үүргээ сайн биелүүлж, сурган хүмүүжүүлэх, ухааруулах зорилгодоо ч хүрдэг байжээ. Эртний Монголын ял шийтгэлийн аргаас үзвэл: малаар торгох нь зохистой шийтгэл байжээ. Өөрөөр хэлбэл хулгай хийсэн хүний амьдралын түвшин доошлох нөхцлийг ч бүрдүүлж болох юм. Энэхүү хууль цаазын нэгэн онцлог нь малаар торгох явдал юм. Энэ нь хохирлыг барагдуулах болон торгуулийг оновчтой оногдуулах ач холбогдолтой байсан мэт санагдана.

Тэрчлэн иргэд өчүүхэн төдий зүйл хулгайлсаных нь төлөө бие мах бодийн хатуу ял шийтгэлийг оногдуулбал нийгмийн эсэргүүцэлтэй тулгарч, нийгмийн амар амгалан байдал, улс оронд эмх замбараагүй байдалтай тулгархыг ноёрхогч анги бодолцон үзсэн бололтой. Хулгай хийсэн хүнийг малаар торгох нь хүн ам, цэрэг эрс, нийгмийн эмх цэгцийг хамгаалсан зохицуулалт болсон байна.

Их цааз дахь хулгайн хэрэгт хүмүүнлэг энэрэнгүй ял шийтгэлийг хэрэглэх болсон шалтгаан нь:

1. Түүхэн хөгжлийн явц, нийгмийн шинж байдлаас болсон.

2. Монгол оронд хүн ам цөөн, хөдөлмөрлөх хүч дутмагаас болжээ.

3. Дэлхийн глобалчилал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Тухайн үеийн хулгайн хэргийн ял шийтгэл нь гадаад улс орны түрэмгийлэл, болон одоогийн Сибирийн ард иргэдийн хууль цаазанд ч торгох ял илүүтэйгээр журамлан зохицуулагдаж эхэлсэнтэй холбоотой байхыг үгүйсгэхгүй.

Малаар торгох нь эртний Монголын хууль цаазын дэвшил, хөгжлийн илрэл мөн.

II. Хулгайн хэргийг хуульчлан зохицуулсанаар нийгмийн амар амгаланг



тогтоож, ард иргэдийн эд хөрөнгийг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээхэд анхаарсан маш чухал зүйл заалт юм. Жишээ нь малыг хамгийн гол амь зуулга болгосон малчдын хувьд: уг ял шийтгэлийг хэрэглэх нь амжиргааны түвшинд нь нөлөөлөх улмаар амь зуулгаасаа салах, оршин амьдрахад нь дараас болж байжээ. Иймээс иргэдийн ухамсарт нөлөөлөх байдлаар нийгмийн амар амгаланг тогтоож байжээ.

#### **Ашигласан материал**

1. Б. Баярсайхан., Монголын төр эрх зүйн түүх (дээж бичиг I дэвтэр), УБ 2006 он
2. Г. Совд., Монгол хууль, УБ 1997 он
3. Ч. Бат., Монгол – Ойрадын цааз бичгийн үг хэллэгийн судлал, Бээжин 2012 он
4. Дорно тив., Ойрад цааз судлал, Хөх хот 1985 он
5. Ж. Амарсанаа, Д. Баянбилэг ., Монгол үндэстэний бүрэн түүх (II дэвтэр) УБ 2004 он

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ****ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ  
МЭДЭЭЛЛИЙГ САНГААС ИРГЭДЭД  
НЭЭЛТТЭЙ  
БОЛГОХ МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ  
НЬ СУДАЛГААНЫ ҮР ДҮН<sup>71</sup>**

Б.Энхболд (Ph.D), Б.Мөнхдорж,  
Д.Сумъяацэрэн, Б.Мөнхсэргэлэн  
Цагдаа судлалын төв, Эрдэм шинжилгээ,  
хөгжлийн хүрээлэн, Хууль сахиулахын их  
сургууль

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17-д “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй...” гэж заасан хүний суурь эрхийг баталгаажуулж төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Их хурлаас 2016 оны 06 дугаар сарын 16-ний өдөр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг батлан мөрдөж байна.

Тус хууль нь Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Хувь хүний нууцын тухай, Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжид нийцэж гарсан бөгөөд хуульд хориглосноос бусад мэдээлэл авах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн. Энэ хуулиар иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал,

байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авч болохоор тодорхойлсон бөгөөд мэдээлэл авах хэлбэр, төрлийн нарийвчлан зохицуулсан. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглосон дараах нөхцөлийг хуульчилсан байна. Үүнд:

- тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол;

- тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой бол;

- хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол;

- тухайн мэдээлэл нь олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах явцтай холбоотой бол гэж тус тус заажээ.

Түүнчлэн, тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах”, 20 дугаар зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулах”, 21 дүгээр зүйлд “Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн (гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд) бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг тус тус хориглосон байна. Иймд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагаас мэдээллийн ил тод

<sup>71</sup> АНУ-ын Азийн сан, Улсын Ерөнхий прокурорын газрын захиалгаар ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн 2017 онд гүйцэтгэсэн “Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас иргэдэд нээлттэй болгох мэдээллийн хэрэгцээг тодорхойлох” (гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн талаар) судалгааны үр дүнгээс тоймлон авав.



байдлыг хангах үйл ажиллагаа нь энэ хуулиар зохицуулагдах боловч хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны явцад нууцалвал зохих мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэг хүлээхгүй юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 12 дугаар зүйлд Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно гэж заасан нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бүр хэргийн талаар бүх мэдээллийг шаардан авах эрх эдлэхгүй гэдгийг тодорхойлж байна. “Хүснэгт 1”-т үзүүлснээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхмжлэгч, иргэний хариуцагчийн мэдээлэл авах хүрээ, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдээлэл өгөх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт-1

ЭБША-нд оролцогч	Мэдээлэл авах эрх	Мэдээлэл өгөх үүрэг
Сэжигтэн	“...ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх”; “Өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах”.	...Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар хэрэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй, түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн эсхүл өмгөөлөгчид нь 48 цагийн дотор мэдэгдэнэ.
Яллагдагч	...ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх; ...яллагдагчаар татсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах; ...өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах; ...шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах.	...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бүх ажиллагааг хийж дууссан, хэргийг шийдвэрлэх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл энэ тухай яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ.
Өмгөөлөгч	...өмгөөлж байгаа үйлчлүүлэгчийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж...; ...өөрийн байлцсан байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцах...; ...хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хатаст хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах;	...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаныг мэдэгдэх, хэргийн материал танилцуулах
Хохирогч	...Хохирогч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хавтаст хэргийн бүх материалтай танилцах.	...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссан үед хэргийн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгтэй танилцах.
Иргэний нэхэмжлэгч, хариуцагч	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссан үед хэргийн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгтэй танилцах.	...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаныг мэдэгдэх, хэргийн материал танилцуулах
Хөндлөнгийн гэрч	...Хөндлөнгийн гэрч нь өөрийнхөө оролцсон байцаан шийтгэх ажиллагааны талаар гомдол гаргах, байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцах...	

Дээрх мэдээлэл авах эрх зүйн зохицуулалтанд дүн шинжилгээ хийж үзвэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэргийн өөрт холбогдох мэдээллийг авах эрхтэй байдаг бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусмагц хэргийн материалтай бүхэлд нь танилцуулах үүрэгтэй байна.

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан мэдээллийн давхардлыг арилгах, гомдол мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хянан шалгах, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны менежментийг сайжруулан хялбаршуулах, цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор хэрэгжүүлж буй “Хууль зүйн цахим нэгтгэл” төсөл нь 2014 оноос өнгөрсөн он буюу 2016 он хүртэлх хугацаанд Төрийн холбооны газар, ТЕГ-ын Кибер аюулгүй байдлын газар, Үндэсний дата төв, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг байгууллагуудтай хамтран Шүүх, Прокурор, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгон хэрэгжиж төгсгөлийн шатандаа яваа төсөл юм. Тус төслийн хүрээнд нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, нэгдсэн сүлжээний орчин үүсгэх, эрх зүйн орчин бүрдүүлэх,



бүртгэлийн системийг шинээр болон шинэчлэх, шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн тайлан, иргэд хандах боломжтой портал сайтыг хөгжүүлэх зэрэг тогтолцоо бий болох юм.

Бидний судалгааны зорилго хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг тодорхойлох явдал байсан бөгөөд энэ үүднээс тусгайлан боловсруулсан асуултаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаар үйлчлүүлж байсан 99 иргэний дунд судалгаа явуулж, дүгнэлт хийв. Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн ерөнхий шинжийг авч үзвэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцож байсан талаар өөрийн байр суурийг бүрэн илэрхийлэх боломжтой иргэд гэж дүгнэв.

Судалгаанд оролцогчдын 66.7% нь эрэгтэй, 18-40 насны 70 орчим хувь, дээд боловсролтой иргэн 50 орчим хувийг эзэлж байгаа нь эрэгтэй, дээд боловсролтой, дундаж насныхан шүүх, хууль сахиулах байгууллагатай холбогдох нь түгээмэл байна.

**Асуулт-1. “Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай ямар мэдээлэл байдаг бэ?”**

Судалгааны ажлын үндсэн зорилтын нэг нь шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын зүгээс иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээлэл, түүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох явдал байсан. Тиймээс судалгаанд оролцогчдоос “Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай ямар мэдээлэл байдаг бэ?” гэсэн асуултыг нээлттэй тавьж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат тус бүрээр тодорхой санал бичүүлж авсаныг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт -2. Иргэдэд нээлттэй болгох шаардлагатай мэдээллийн жагсаалт

№	Байцаан шийтгэх ажиллагааны үе шат	Хариулт
1	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд	<ul style="list-style-type: none"> <li>-Хэрэг хэзээ шийдэх талаар хэлдэггүй;</li> <li>-Хохирогчийн талаар мэдээлэл өгдөггүй;</li> <li>-Хавтаст хэрэгтэй сайн танилцуулдаггүй;</li> <li>-Хэргийг шалган шийдвэрлэх явц байдал;</li> <li>-Өөрийн хэргийн талаар мэдээлэл авахад тааруу;</li> <li>-Хохирогч санал гомдолтой эсэх;</li> <li>-Хэргийг бүрэн эхээр нь хуулбарлаж авах боломжоор хангах;</li> <li>-Холбогдогч этгээдийн талаарх мэдээлэл;</li> <li>-Эрх, үүргийн талаар тодорхой ойлголт өгдөггүй;</li> <li>-Хэргийн газрын нөхцөл байдал;</li> <li>-Хэргийн талаар хангалттай хэлдэггүй, тодорхой бус байдаг;</li> <li>-Хэргийн талаар тодорхой мэдээлэл огт өгдөггүй</li> <li>-Хэргийн оролцогчдын талаарх мэдээлэл;</li> <li>-Хэргийн зүйлчлэл;</li> <li>-Ажиллагааны нууцлал гэсэн шалтгаанаар бүгд мэдээлэл өгөх дургүй, хүссэн мэдээллээ авахад хүндрэлтэй байдаг;</li> <li>-Хэргийн талаар мэдээлэл бага өгдөг, удаан хүлээлгэдэг;</li> <li>-Хэргийг шалгаж эхэлсэн үеэс мэдээлэл нээлттэй байвал зүгээр;</li> <li>-Бүрэн гүйцэд тайлбарлаж өгдөггүй;</li> <li>-Хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийн хохирогчид ээлтэй, нууцлалыг хангасан орчинд байцаалт өгөх боломжийн талаар мэдээлэл хүсэх, шаардлага тавихад хүлээж авдаггүй;</li> <li>-Тодорхой бус мэдээлэл өгдөг;</li> <li>- ГЭХ МЭТ</li> </ul>



2	Прокурорын хяналтын шатанд	<ul style="list-style-type: none"> <li>-Хэзээ дуудахаа хэлдэггүй;</li> <li>-Мэдээлэл огт өгдөггүй, тухайлбал хэргийг хэзээ шүүхэд шилжүүлэх;</li> <li>-Хяналтын хугацаа;</li> <li>-Эцэслэн шийдвэрлэх хугацаа</li> <li>-Шүүхэд шилжүүлсэн эсэх;</li> <li>-Хэргийг бүрэн эхээр нь хуулбарлаж авах боломжоор хангах;</li> <li>-Нөгөө талаас гаргасан санал, гомдол;</li> <li>-Хувь хүний нууцтай холбоотой;</li> <li>-Өөрөө мэдээгүй байхад ял оноосон байдаг</li> <li>-Гомдол гаргах эрхийг минь хязгаарладаг;</li> <li>-Хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн үндэслэл тодорхойгүй;.</li> <li>-гэх мэт</li> </ul>
3	Шүүх	<ul style="list-style-type: none"> <li>-Хэргийн явц, оногдуулах ял;</li> <li>-Шүүх хуралдааны тов;</li> <li>-Хэргийн талаар тодорхой мэдээлэл огт өгдөггүй;</li> <li>-Ямар хүмүүс шүүх хуралд оролцох нь тодорхойгүй;</li> <li>-Ирц бүрдсэн эсэх талаарх мэдээлэл;</li> <li>-гэх мэт</li> </ul>
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд	<ul style="list-style-type: none"> <li>-Үйлчлүүлэгчийг хаана ямар хорих ангид шилжихийг хэлдэггүй;</li> <li>- Үйлчлүүлэгчид хаана, ямар газар, хэрхэн ял эдлүүлэх талаар мэдээлдэггүй;</li> <li>-Хэн гэдэг шийдвэр гүйцэтгэгч хариуцаж байгаа талаарх мэдээлэл;</li> <li>-Шийдвэр биелүүлэх хугацаа;</li> <li>-Шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгааны талаарх мэдээлэл;</li> <li>-Мэдээлэл авах гэж маш их хугацаа алддаг;</li> <li>-Тогтоол гүйцэтгэлийг хангах үйл явц болох нэхэмжлэлийг барагдуулах ажиллагааны талаар, хугацаа болон нуугдмал орлогын талаар асуусан асуудал;</li> <li>-Хохироосон хүний эд хөрөнгийн мэдээлэл;</li> <li>-Хохирлыг хэрхэн барагдуулах талаар;</li> <li>-Шийдвэрийн биелэлт ямар шатандаа яваа талаарх мэдээлэл;</li> <li>-Төлбөр төлөлтийн хугацааг оруулах;</li> <li>- Хорих, баривчлах болон цагдан хорих ангиас суллагдах хугацаа, он сар өдөр;</li> <li>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурор, түүний байршил, болон бусад мэдээллийн талаар;</li> <li>-гэх мэт</li> </ul>

Дээр дурдсан шаардлагатай гэж үзэж багаа мэдээлэл нь зарим тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалд хамаарах баримт мэдээлэл хамаарч байна. Зарим талаар иргэдэд нээлттэй хүргэж байгаа мэдээллийг хэрхэн хүсэлт гаргаж, хаанаас олж авах талаар тодорхой мэдээлэл байдаггүй бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдаас нэхдэг хүндрэл учирч байна. Түүнчлэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллганы явцад хэргийн материалтай танилцах тодорхой эрх нь тухайн ажиллагаанд оролцогч субъект болон өмгөөлөгчид олгогдсон байдаг. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан гэр бүлийн гишүүд зарим тохиолдолд хэргийн материалтай танилцах хүсэлт гаргадаг боловч хүсэлтийг нь хангах

боломж байдаггүй байна. Тухайлбал, хорих ангид ял эдэлж байгаа ялтан өөрийн талаарх мэдээллээ гэр бүлийнхэндээ өгдөггүй тохиолдол гардаг, нөгөө талаас алба хаагчид шаардлагатай мэдээллийг зөвхөн ялтанд өгдөг байна.

Асуулт-2. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх ямар мэдээ, мэдээллийг хувь хүн Танд нээлттэй болгох шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хүснэгт 3-т үзүүлснээр оролцогчдын хамгийн өндөр санал өгсөн мэдээлэл нь цагдаагийн байгууллагын хувьд иргэд гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн мэдээлэл 91.3%, прокурорын байгууллагын хувьд хяналтын прокурорын шийдвэр





84.0%, шүүхийн байгууллагаас шүүхийн шийдвэр 98.4%, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлсэн байдал 81.5% гэж тус тус хариулсан байна.

## Хүснэгт-3. Иргэнд нээлттэй болгох шаардлагатай мэдээлэл

Байгууллага	Шаардлагатай		Шаардлагагүй		Мэдэхгүй		Дүн
	тоо	(%)	тоо	(%)	тоо	(%)	
Цагдаагийн байгууллагаас							
Гомдол, мэдээлэл, хэргийг шалгаж буй алба хаагч	59	75.6	16	20.5	3	3.8	78
Хэрэгсэхгүй болгох санал гаргасан байдал	54	75.0	13	18.0	5	6.9	72
Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	63	91.3	3	4.3	3	4.3	69
Прокуророос							
Эрүүгийн хэргийг хүлээн авсан огноо	50	73.5	12	17.6	6	8.8	68
Эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй прокурорын нэр	51	75.0	10	14.7	7	10.2	68
Хяналтын прокурорын шийдвэр	58	84.0	5	7.2	6	8.6	69
Прокурорт яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар явуулсан санал, шийдвэр	54	81.8	8	12.1	4	6.0	66
Гомдол хүсэлт гаргах журам, заавар	50	78.1	7	10.9	7	10.9	64
Шүүхээс							
Шүүх хүлээн авсан огноо	38	64.4	16	27.1	5	8.4	59
Хянан шийдвэрлэх шүүгчийн нэр	47	72.3	13	20.0	5	7.6	65
Шүүхийн шийдвэр	65	98.4	0	0.0	1	1.5	66
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас							
Шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлсэн байдал	53	81.5	5	7.6	7	10.7	65
Давж заалдах гомдол гаргах хуулийн заалт	48	72.7	10	15.1	8	12.1	66
Бусад	38	86.3	2	4.5	4	9.0	44

Судалгааны дүнгээс үзэхэд иргэд тухайн байгууллагаас гардаг шийдвэрийн талаар мэдэхийг хамгийн их хүсдэг байна. Гэвч дээрх байгууллагууд ямар нэгэн шийдвэр гаргахдаа заавал холбогдох хүмүүст мэддэг хуулийн болон зохион байгуулалтын зохицуулалттай байдаг. Гагцхүү гэр бүлийн гишүүд эсхүл тодорхой шийдвэр гарахын өмнө урьдчилсан байдлаар хэргийн явц байдлын талаар танилцахыг хүсч мэдээлэл хайдаг нөхцөл байдал дээрх хариултад мөн нөлөөлөх талтай.

Асуулт-3. "Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх мэдээллийг Танд ямар арга замаар нээлттэй болговол зүйтэй вэ?"

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллаганд оролцогч болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаар үйлчлүүлэгчид хурдан шуурхай хүргэж байх нь мэдээллийн ил тод байдлын агуулгыг илэрхийлдэг. Тиймээс бид судалгаанд оролцогчид "Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх мэдээллийг Танд ямар арга замаар нээлттэй болговол зүйтэй вэ?" гэсэн асуулт тавьж хариулт авлаа.

Судалгаанд оролцгчдын 32 буюу 32.3% цахим шуудангийн хаягаар хүргүүлдэг байх, 47 буюу 47.5% нь тусгайлан цахим хуудсанд нэвтэрч, нэр, нууц үгээр ашиглан мэдээлэл авдаг байх, 35 буюу 35.4% нь гар утсанд захидал очдог байх, 11 буюу 11.1% нь амаар, 20 буюу 20.2% нь бичгээр, 1 буюу 1% нь бусад хэлбэрээр гэж тус тус хариулсан байна. Дүнг "хүснэгт 4"-т үзүүлэв.

Хүснэгт-4. Мэдээлэл нээлттэй болгох хэлбэр







№	Үзүүлэлт	Тоо	%
1	Цахим шуудангийн (мэйл) хаягаар хүргүүлдэг байх	32	32,3
2	Тусгайлан сайтад нэвтэрч, нэр, нууц үгээр ашиглан мэдээлэл авдаг байх	47	47,5
3	Гар утсанд захидал очдог байх	35	35,4
4	Амаар	11	11,1
5	Бичгээр	20	20,2
6	Бусад	1	1,0

Судалгаанд оролцогчдын хариултыг нэгтгэн үзвэл өөртэй нь холбогдсон мэдээлэл, хүсэлт, гомдлын хариуг аль болох амаар авах хэлбэрээс татгалзах хандлагатай байгаа бол цахим сүлжээ ашиглан шаардлагатай мэдээлэл, өргөдөл гомдлын хариу авах боломжийг бүрдүүлэхийг хүсч байна. Судалгааны явцад гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг цахим сүлжээ ашиглан иргэдэд хүргэж байгаа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага байгаа эсэх талаар судалгаа хийж үзсэн болно.

Монгол Улсын анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг олон нийтэд ил тод болгосон, мөн шүүх хуралдааны товч, зар мэдээллийг иргэдэд нээлттэй байдлаар хүргэсэн <http://www.shuukh.mn> цахим хуудас ажиллаж байна. Уг сайтад өнөөгийн байдлаар 53148 хэргийн 69881 шийдвэр байна. Мөн эрүүгийн хэргийн шүүхийн тогтоолуудыг байршуулснаас хэргийн эцсийн шийдвэрлэлтийг харах боломж бүрджээ. Харин шүүхэд “иргэн-2014” гэсэн програмыг ашигладаг бөгөөд иргэний хэрэг, маргаан нь аль шатны шүүх дээр ямар шатанд байгаа талаарх мэдээллийг иргэд авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагад <http://www.service.police.gov.mn/> цахим хуудас 2015 оны 08-р сараас эхлэн ажиллуулж байна. Цагдаагийн байгууллагад хандаж иргэдээс амаар, бичгээр, утсаар, цахимаар гаргасан өргөдөл, гомдлыг аль газар, хэлтэс, нэгжийн ямар албан тушаалтан шалгаж, ямар шийдвэр гаргасан талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй болгожээ. Ингэхдээ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 202 код журамд заасны дагуу “Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авсан тухай тэмдэглэл”-г хөтөлж, иргэдэд бүртгэлийн дугаар бүхий хяналтын хуудас өгдөг байна. Өргөдөл, гомдол гаргасан иргэн нь бүртгэлийн дугаар, регистрийн дугаараараа <http://www.service.police.gov.mn/> бүртгүүлж, шийдвэрлэлтийг харах боломжийг бүрдүүлжээ. Ингэснээр цагдаагийн байгууллага болон алба хаагчтай холбоотой мэдээ мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол өгөх, бүртгүүлсэн эрхээрээ нэвтрэн орж өгсөн өргөдөл, гомдлын явц болон шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл, тэмдэглэл зэргийг дэлгэрэнгүйгээр хүлээн авах боломжтой болжээ.





Асуулт-4. “Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг та хэрхэн үнэлэх вэ?”

Мэдээллийн ил тод байдлыг хэмжих өөр нэг аргачлал нь шүүх, хууль сахиулах байгууллагуудад мэдээллийн ил тод байдлын талаарх иргэдийн хандлага юм. Учир нь мэдээлэл ил тод байх нь иргэдийн хандлагад эерэгээр нөөцлөг бол мэдээлэл хаалттай байх нь сөргөөр нөлөөлдөг гэж үздэг. Тиймээс гэсэн асуултыг оролцогчдод тавьж үр дүнг байгууллага тус бүрээр гаргав. “График 1”-т үзүүлснээр цагдаагийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж судалгаанд оролцогчдын 44.7% нь үзсэн бол прокурорын байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж 39.8%, шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж 49.4% нь, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдалд маш сайн буюу сайн гэж 36.5% нь тус тус үнэлсэн байна.




График -1. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлын талаарх иргэдийн төсөөлөл

Судалгаанд оролцогчдын 55.3% нь цагдаад, 60.2% нь прокурорт, 50.6% нь шүүхэд, 63.5 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дунд-муу-маш муу гэсэн үнэлгээг сонгож үнэлсэн байна. Эндээс үзвэл, иргэд шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр гэж дүгнэсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангалтгүй гэж үзсэн байна. Цагдаагийн болон прокурорын багууллагын мэдээллийн ил тод байдал дундаж түвшинд байна. Түүнчлэн, иргэд байгууллагын мэдээллийн ил тод байдлыг үнэлэхдээ алба хаагчдын харилцааны соёл, хандлагаар дүгнэдэг. АНУ-ын Мичиганы Их сургуулийн социологийн




тэнхимээс 2012 онд 4000 иргэний дунд явуулсан “нийгмийн үнэт зүйлсийн судалгаа”-ны үр дүнгээр төрийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, үр чадвар нь иргэдийн мэдээлэл олж авах эрхэд шууд нөлөөлдөг гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, харилцааны соёл үр чадвар муутай алба хаагчидтай байгууллагаас мэдээлэл авахад хүндрэлтэй, хаалттай байдаг гэж үзжээ (Hwang 2014).

Энэ дүгнэлтийг шалгах зорилгоор хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, үр чадварын талаарх иргэдийн хандлагыг тодорхойлох оролдлого хийсэн. Судалгаанд оролцогчдоос “Дараах байгууллагуудын алба хаагчдын иргэдтэй харилцах хандлага, төлөвшлийг та хэрхэн үнэлэх вэ?” гэсэн асуулт тавиад хариултыг байгууллага тус бүрээр нь гаргаж, өмнөх асуулгын үр дүнтэй харьцуулан дүгнэлт хийсэн болно.

“График 2”-д үзүүлснээр шүүхийн алба хаагчдын харилцааны соёл, хандалгад судалгаанд оролцогчдын 59.2% нь сайн буюу маш сайн гэсэн үнэлэлт өгсөн нь бусад байгууллагын алба хаагчтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байсан бол муу буюу маш муу гэж 8.5% нь үнэлсэн нь мөн хамгийн бага үзүүлэлт болж байна. Түүнчлэн, иргэдийн 52.2% нь цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, төлөвшлийг маш сайн буюу сайн гэж дүгнэсэн бол энэ үзүүлэлт прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд 50 хувьд хүрэхгүй байна.

График-2. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын харилцааны соёл, хандлага



Дээрх судалгааны дүнгээс үзвэл иргэд шүүх, цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, төлөвшил, мэдээллийн ил тод байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгаа нь Мичиганы их сургуулийн эрдэмтдийн дүгнэлтийг баталж байна. Түүнчлэн, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, алба хаагчдын харицааны соёл, төлөвшлийн талаарх иргэдийн хандлагын судалгааны үр дүнгийн үнэлгээ дээрх 2 асуултын хувьд ижилхэн гарч байгаа нь прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээрх асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

#### Дүгнэлт

1. Мэдээлэл авах эрх зүйн зохицуулалт бүрдсэн бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэргийн өөрт холбогдох мэдээллийг авах эрхтэй байдаг бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусмагц хэргийн материалтай бүхэлд нь танилцуулах үүрэгтэй байна.
2. Иргэд гэмт хэрэг, зөрчилд хобогдсон гэсэн шалтгаанаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагатай хамгийн их холбогддог бөгөөд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл хамгийн ихээр авдаг бол гомдол, мэдээлэл

шалгаж буй алба хаагчдын талаарх мэдээлэл, хэрэгсэхгүй болгосон санал гаргасан байдал, байцаан шийтгэх ажиллагааны явц байдлын талаар мөн мэдээлэл авдаг байна. Харин эрүүгийн хэрэгт хамааралтай бусад хүмүүсийн талаарх мэдээлэл авдаг гэсэн хариулт хамгийн бага буюу нийт оролцогчдын 5 хувь нь хариулж байгаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад зөвхөн өөртэй нь холбоотой мэдээллийг танилцуулдагтай холбоотой. Мөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын зүгээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хувийн байдалтай холбоотой мэдээлэл авах сонирхол ихтэй байдаг байна. Тухайлбал гэрийн хаяг, төрсөн газар, найз нөхөд гэх



мэт.

3. Судалгаанд оролцогчдын 69 буюу 69.7 хувь нь 1-2 удаа, 15 буюу 15.2 хувь нь 3-4 удаа, 8 буюу 8.1 хувь нь 5-6 удаа, 5 буюу 5.1 хувь нь 6-аас дээш удаа мэдээлэл авч байсан гэж тус тус хариулж байгаа нь иргэдийн мэдээлэл авах хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байгаа юм. Харин хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас авч буй мэдээлэлийн нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа талаар харилцан адилгүй санал илэрхийлсэн байна. Энэ нь тухайн иргэн ямар төрлийн мэдээлэл шаардаж байгаагаас хамааран сэтгэл ханамжийн байдал өөр өөр гарч байна.

4. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай мэдээлэл маш их байдаг талаар судалгаанд оролцогчид санал илрэхийлж байна. ялангуяа ар гэрийнхний хувьд мэдээлэл маш хаалттай байдаг гэж дүгнэж байна. Судалгаанд оролцогчдын хариултыг нэгтгэн үзвэл өөртэй нь холбогдсон мэдээлэл, хүсэлт, гомдлын хариуг аль болох амаар авах хэлбэрээс татгалзах хандлагатай байгаа бол цахим сүлжээ ашиглан шаардлагатай мэдээлэл, өргөдөл гомдлын хариу авах боломжийг бүрдүүлэхийг хүсч байгаа юм.

5. Судалгаанд оролцогчдын 55.3% нь цагдаад, 60.2% нь прокурорт, 50.6% нь шүүхэд, 63.5 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, дунджаар 57.5% нь хуулийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд дунд-муу-маш муу гэсэн үнэлгээг сонгож үнэлсэн байна. Судалгааны дүнгээс үзвэл, иргэд шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр гэж дүгнэсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангалтгүй гэж үзсэн байна. Цагдаагийн болон прокурорын багууллагын мэдээллийн ил тод байдал дундаж түвшинд байгаа бөгөөд тус байгууллагуудын алба хаагчдын харилцааны соёл, ур чадвар нь иргэдийн мэдээлэл олж авах эрхэд шууд нөлөөлж байна.

6. Шүүхийн ажилтнуудын харилцааны соёл, хандалгад судалгаанд оролцогчдын **59.2%** нь сайн буюу маш сайн гэсэн үнэлэлт өгсөн нь бусад байгууллагын алба хаагчтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байсан бол муу буюу маш муу гэж 8.5% нь үнэлсэн нь мөн хамгийн бага үзүүлэлт болж байна. Түүнчлэн, иргэдийн 52.2% нь цагдаагийн алба хаагчдын харилцааны

соёл, төлөвшлийг маш сайн буюу сайн гэж дүгнэсэн бол энэ үзүүлэлт прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд 50 хувьд хүрэхгүй байна. Эдгээр судалгааны үр дүнгээс үзвэл иргэд шүүх, цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, төлөвшил, мэдээллийн ил тод байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгаа нь Мичиганы их сургуулийн эрдэмтдийн дүгнэлтийг баталж байна. Түүнчлэн, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, алба хаагчдын харицааны соёл, төлөвшлийн талаарх иргэдийн хандлагын судалгааны үр дүнгийн үнэлгээ дээрх 2 асуултын хувьд ижилхэн гарч байгаа нь прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээрх асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Судалгааны үр дүнг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллаганы үе шатууд дахь хугацаа, түүнийг сунгах, тухайн шатнаас гарах шийдвэрийг танилцуулах ажиллагааг мөрдлөгө болгох;
2. Байцаан шийтгэх ажиллагааны явцад гарсан цагдаагийн санал, шийдвэр, прокурорын шийдвэр, шүүхийн шийдвэр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хугацаа зэргийг иргэдэд нээлттэй болгох;
3. Тодорхой шийдвэрийг гар утсанд захиагаар очдог систем, гэр бүлийн гишүүдэд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц байдлыг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтнаас хамааралгүй танилцдаг цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
4. Хөдөө орон нутаг дахь байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг холбогдох мэдээ, мэдээллээр хэрхэн хангах асуудлыг харгалзан үзэх;
5. Энэ талаарх гадны орны туршлагыг харьцуулан судалж үзэх (тухайлбал, Check My crime, Trick my crime<sup>[72]</sup>), байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын хувийн нууцтай холбоотой мэдээллийн нууцлалыг хангах асуудлыг харгалзан үзэх нь зүйтэй болов уу.

<sup>72</sup> <https://www.police.wa.gov.au/Police-Direct/Check-my-crime>



## ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХҮЙД НӨЛӨӨЛӨХ СОЦИОГЕНЕТИК /НИЙГМИЙН УДАМШИЛ/-ИЙН АСУУДЛУУД

Н.Манлайбаатар  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх  
албаны тэнхимийн  
дэд профессор, цагдаагийн хошууч

Хураангуй: Гэмт хэрэг мөрдөхүйг нийгмийн удамшил зүйн талаас нь судлах, ийнхүү судлахдаа түүхчлэн авч үзэх, зарим кейсээр /нөхцөл/ энэхүү удамшил зүй байгааг бататгах оролдлого хийхэд чиглэсэн ажил болно.

**Түлхүүр үгс:** Гэмт хэрэг мөрдөхүй, социогенетик- нийгмийн удамшил зүй

### Нэг. Гэмт хэрэг мөрдөхүй

Гэмт хэрэг мөрдөх нь нэг талаас танин мэдэх процесс /философи, логик, сэтгэц судлал, нийгэм хүмүүнлэг, техник зүйн гэх зэрэг/, мөн эрх зүйн процесс, нөгөө талаас нийгэм бүлэг хүмүүсийн хүлээлт агуулсан сэтгэл зүйн асуудал бөгөөд бид энэхүү илтгэлээр аль алиныг нь хамтатган авч үзэхийн зэрэгцээ гэмт хэрэг мөрдөхүйд нийгмийн удамшил хэрхэн нөлөөлж буйг авч үзэхийг зорьлоо.

“Гэмт хэрэг” нь эрх зүйн зөрчлийн хүнд хэлбэр бөгөөд түүний агуулга, мөн чанарыг эрдэмтэн судлаачид судлан өөр өөрийн тайлбар, тодорхойлолтыг онол арга зүйн үндэслэлтэйгээр өгсөн нь нэлээд тохиолдоно.

“Мөрдөх” гэсэн үг нь 1. “юмны зам мөрөөр орох: мөрдөх хөөх, 2. мөрийг мөшгин хянаж шалгах: мөрдөн байцаах /гэмт хэрэг эдүүлсэн явдлыг илрүүлэн гаргах/, мөрдөн мөшгих хорш., 3. “дагаж дууриах, журамлах: дагаж мөрдөх, мөрдөн дагаж яваа хууль дүрэм<sup>[73]</sup>” гэсэн байна. Нэр томьёо, агуулгын хувьд хэдийгээр энэ мэтээр ойлгогдож байгаа хэдий ч бид өргөн ба явцуу утгаар нь нарийн задлан шинжлэх авч үзэж байгаа сэдвийн агуулгаар тайлбарлах нь агуулга, мөн чанарын хувьд зайлшгүй гэж үзэж байна.

Бид гэмт хэрэг мөрдөхүйг судлахдаа эрүүгийн процессын эрх зүйн болон бусад салбараар авч үздэг. Эрх зүйн үүднээс авч үзэх нь оновчтой хэдий ч агуулгын хувьд бүрэн дүүрэн тодорч гарахгүй байна гэх үндэслэлтэй.

“Гэмт хэрэг мөрдөхүй” гэсэн үг гарчигт

<sup>73</sup> Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,

байгааг тодруулах нь зүйтэй. Нийгмийн харилцааны явцад хүн, хуулийн этгээд эрх зүйн зөрчлийн хүнд хэлбэр болох гэмт хэргийг үйлддэг. Үйлдлийн арга нарийн зохион байгуулалттай болж байгаагийн зэрэгцээ гэмт хэрэг мөрдөхүйн тактик, арга зүй хөгжлийн тодорхой шатруу ахисаар байна. Гэмт хэрэг мөрдөхүйг процессын эрх зүйн үүднээс авч үзэхийн зэрэгцээ мөрдөн байцаалт явуулах, зохион байгуулах талаасаа хүний хүчин, тэдний сэтгэлгээний ерөнхий хандлагаар илрэн гарч байгаад дүгнэлт хийж үзвэл энэ ажиллагаа нь өргөн ба явцуу утгаар тайлбарлагдана.

Явцуу утгаараа гэмт хэрэг мөрдөхүй гэж – ЭБШ ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн, эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг, үе шат бүхий хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн цогц ажиллагаа<sup>[74]</sup> юм.

Өргөн утгаараа гэмт хэрэг мөрдөхүй нь – түүхэн үйл явцад хүн төрөлхтний үнэт зүйлс, эрх, эрх чөлөө, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, уламжлал, соёл, газар нутгийн бүрэн бүтэн байдал, аюлгүй байдал зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдснийг сэргээн эдлүүлэх зорилгоор явуулж буй чиг үүргийн хувьд өөр өөр байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлдэг гагцхүү эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг, шинжлэх ухаан, танин мэдэхүй, сэтгэлгээний өрсөлдөөнт<sup>[75]</sup> ажиллагаа гэж үзэж болох юм.

Гэмт хэрэг мөрдөхүйн талаар бид өмнө өгүүлэл нийтлүүлж, илгэл хэлэлцүүлж байсан бөгөөд Гэмт явдалтай тэмцэх асуудал<sup>[76]</sup>, Хууль сахиулахуй<sup>[77]</sup> сэтгүүлээс үзэж болох юм. Илтгэлүүд нь гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний хөгжил, үе шат, мөн чанар, агуулгыг тодруулах зорилгоор бичигдсэн тул энд дэлгэрнгүй бичсэнгүй.

Бид гэмт хэрэг мөрдөхүйг нийгмийн удамшил зүй буюу социогенетик талаас нь авч үзэхийг оролдож байгаа энэхүү илтгэл нь эрхэм судлаачдын судалгааны явцад <sup>74</sup> Эрүүгийн процессын эрх зүйн чиглэлээр судалгаа хийж буй судлаачид энэ талаар нэгдсэн үзэл санаатай байна.

<sup>75</sup> Энэ нь тохиолдлоор сонгож авсан үг бус. Гэмт хэрэг мөрдөхүй нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтооход чиглэсэн, түүний гэмт үйлдлийг нотлох баримтаар тогтоох зорилгоор хийж байгаа ажиллагаа боловч гэмт хэрэг үйлдсэн хүн ямагт өөрийн үйлдлийг нотлогдохгүй байх боломжийг хайж, аливаа баримт сэлт, баримтуудыг өрсөж устгах үйлдэл хийдэг. Өрсөлдөөн гэсэн агуулгад мөрдөгч нарын хоорондын өрсөлдөөн ч байж болох талтай.

<sup>76</sup> Сэтгүүлийн 2015 оны №4. 19-23 дах тал.

<sup>77</sup> Сэтгүүлийн 2014 оны Хууль сахиулахуйн инноваци. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэл-1. 155-159дэх тал. 2015 оны №3. 4. 47-53 дах талд тус тус үзнэ үү.



санаа, сэдэл төрүүлэх, өөрийн хийж байгаа судалгааг улам бүр чамбайруулах зорилго агуулсан болохыг тэмдэглэе.

#### Хоёр: Нийгмийн удамшил зүйн тухай

Социогенетик<sup>[78]</sup> нь нийгмийн ухаанд өнөөгийн байдлаар бага судлагдаж байгаа, бүрэн боловсорч амжаагүй салбар бөгөөд нийгмийн системийн хувьсал дах зүй тогтол, удамшлын механизм, хувьсал, шалгарлыг тодорхойлдог гэж үзэж байгаа судлаач бий. Судлаач Ю.В.Яковец<sup>[79]</sup>-ын үзэж байгаагаар “Юуны өмнө хүн төрөлхтний мөн чанар, гол агуулгыг илэрхийлсэн үеэс үед дамжих удамшлын цөм, нийгмийн генотип хадгалагдах, дамжих зүй тогтол<sup>[80]</sup>” гэжээ. Мөн түүнийхээр “Хэн ч эцэг эхээ, мэндлэх газраа сонгож ирдэггүй. Идэвхитэй амьдралд ормогцоо хүмүүст мэдлэг, туршлага, материал баялаг, оюун сэтгэлгээний үнэт зүйлс, технологи, улс төрийн систем зэргийг өвлөн авна. Тэд үүнийгээ нандигнан баяжуулж, үрэн таран хийж, устгаж ч болно. Хүн гэдэг амьтан өв уламжлалаа сонгох боломжгүй боловч нэгэнт өвөлснөө захиран шийдэх боломжтой<sup>[81]</sup>” гэж тэмдэглэжээ.

Дээрхээс үзэхэд өв уламжлалаа хүлээн авах, түүнийгээ дараагийн үедээ уламжлуулан үлдээх нь нийгмийн удамшил зүйн хувьд зайлшгүй шаардлага гэж үзэх үндэслэл бүхий байна. Учир нь формацийн хувьд бидний туулж ирсэн түүхийн үечлэл ёсоор цаг үе цаг үедээ хүн амьдрахдаа өөрийн өвлөж авсан үнэт зүйл, нийгмийн сайн сайхан хийгээд мөн сайнгүй зүйлсээ ч дараагийн үедээ уламжлуулан үлдээх үйл явц байдаг.

Монгол хүний уламжлан ирсэн эерэг ба сөрөг уламжлал нь социогенетикийн үүднээс тайлбарлагдаж болох талтай. Өөрөөр хэлбэл эртнээс Монголчууд хот айлын тогтолцоонд байсан байна гэж доктор Н.Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” бүтэлдээ авч үзсэн нь сонирхол татна. Түүний үзэж байгаагаар хот айлын хүрээнд айл өрхүүд бие биенээсээ суралцах, үр хүүхдүүдээ хүмүүжүүлэх, хүүхдүүд эцэг эхтэйгээ, залуу үе ахмад үетэйгээ, эхнэр нь нөхөртэйгөө өглөөнөөс орой болтол

<sup>78</sup> Энэхүү салбарыг үндэслэгч нь Питрим Сорокон, Н.Д.Кондратьев нар бөгөөд анхны нийтлэл нь 1990-эд оны эхээр гарсан байдаг. Энэхүү салбар нь нийгмийн системийн хувьсал дахь зүй тогтол, удамшлын механизм, хувьсал шалгарлыг тодорхойлдог.

<sup>79</sup> Оросын санхүүгийн корпорацийн дэд ерөнхийлөгч, олон улсын Н.В.Кондратьевийн фондын ерөнхийлөгчөөр ажилладаг. Социогенетикийн талаар өвөрмөц санаа дэвшүүлсэн судлаач юм.

<sup>80</sup> Ю.В.Яковец. Соёл иргэншлийн түүх. УБ., 2002 он. 14 дэх талд үзнэ үү.

<sup>81</sup> Ю.В.Яковец. Дурьдсан бүтээл. Мөн тэнд.

хамт ажил хөдөлмөрийн дөр сууж, аж төрж байдаг. Хот айлын нөхцөлд нялх бага насандаа эцэг эх, ах эгчээ хайрлах сэтгэл нь лавширч, тэднийгээ хүндлэх, улмаар бишрэх үзэл болон хувирах бөгөөд тэрхүү үзлээ даган үр хүүхэд нь эцэг эхдээ, залуу үе нь ахмад үедээ үг дуугүй захирагдах дорно дахины шүтэн захирагдах ёс ийнхүү өсөн бойждог<sup>[82]</sup> гэж үзсэн нь нийгмийн удамшил зүйн хэлбэр гэлтэй.

Дээр дурьдсанчлан хэдийгээр хот айлын хэмээн тодорхойлж бичсэн нь анхаарал татах хэдий ч энэ нь Монголчуудын төдийгүй дэлхий дахинд ч өөр өөрийн өв уламжлал үнэт зүйлээ уламжлуулан үлдээх, түүнээс нь суралцаж байгаа залуу үе нь үргэлжлүүлэх нийгмийн удамшилд үеэс үед дамждаг гэж үзэх үндэслэлтэй.

Түүхийн ухаанд энэхүү арга зүйг нэлээд өргөнөөр ашиглахын зэрэгцээ аливаа, бүтэц, элементүүдийг түүхийн тодорхой үйл явцад нь нийгмийн удамшил зүйн үүднээс авч үзэн нэлээд өвөрмөц, шинэлэг тайлал хийж байна.

#### Гурав: Нийгмийн удамшил зүй гэмт хэрэг мөрдөхүйд нөлөөлөх нь

Бид дээр нийгмийн удамшил зүйн тухай товчхон авч үзсэн бөгөөд түүний агуулга, мөн чанар судлагдахууны хувьд шинэлэг гэдгийг дахин тэмдэглэе.

Гэмт хэрэг мөрдөхүй нь процессын эрх зүйн болон танин мэдэхүйн талаасаа нэлээд олон хэлбэрээр тайлбарлагдаж болно. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг мөрдөхүй нь агуулгаараа философи, шинжлэх ухаан, технологи, соёл, түүх, уламжлал, үнэт зүйл, сэтгэл судлал, эрх зүйн гээд бүхий л салбараар нэгтгэгдэн эсхүл тус тусын өвөрмөц хэллэгээр тайлбарлагдаж болох ойлголт гэдэг нь тодорхой.

Бид гэмт хэрэг мөрдөхүй нь нийгмийн удамшил зүйн ухаанаар тайлбарлагдаж болох эсэх талаар судалгааг хийсэн бөгөөд дараах ярилцлагаар бататгахыг зорьж байна. Эрүүгийн болон мөрдөн байцаах албанд гүйцэтгэхээс удирдах албан тушаал хашсан 6 хүн<sup>[83]</sup>-ийг сонгон ярилцлага хийсэн үр дүнг нэгтгэв.

#### Асуудал, нөхцөл:

Асуудал: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид ахмад үе зааж сургадаг нь зүй тогтол уу? Та цаг үеэ ахмад үеийнхээ үргэлжлэл бөгөөд эерэг ба сөрөг зүйлсийг сорулацаж ажилдаа хэрэгжүүлж байсан уу?

<sup>82</sup> Н.Хавх. Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан. УБ., 1995 он. 121-125 дах талд үзнэ үү.

<sup>83</sup> Ярилцлага өгсөн хүмүүсийн хувьд өөрөө өөрсдийн хувийн үзэл санаагаа чөлөөт хэлбэрээр илэрхийлсэн тул нэр дурьдахгүй байхыг хүссэн болно.





Улс төрийн хэлбэр нь гэмт хэрэг мөрдөхөд нөлөөлөх үү? Гэсэн нийтлэг асуулт тавигдсан бөгөөд дараах хариулууд байна.

Би хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд багагүй хугацаанд ажиллахдаа ахмад үеэсээ нэлээд зүйлс суралцсан. Мэдээж эерэг, сөрөг зүйлс байна. Үүний цаана цаг үе гэж зүйлс хамгийн хүчтэй нөлөөлдөг гэж ойлгосон. Учир нь социализмын үед нэлээд хугацаанд суралцсан, ажилласан ах нарын арга барил, соёл, ажилдаа хандах хандлага, хувь хүний үзэл санаа тухайн цаг үеийнхээ тусгал байдаг бололтой. Бидэнд заасан сургасан зүйлс нь өнөөгийн залуучуудад ч арга барил соёл болон үргэлжилж байгааг бид харж байна.

Нэг талаар соёлыг уламжлан авахын зэрэгцээ сөргүү талыг ч үлгэрлэн авах нь бий л дээ. Үүний сайн мууг уг нь ялгагдах хэрнээ тухайн үед бид 20-25 насны залуус суралцаж төгсөөд ажлын арга барил, ажилд хэрхэн хандах хандлагаа багш зааснаас илүүтэй практикт олж авсан юм шиг санагддаг. Сөрөг байдлын талаар ярих нь чухал бус ч дараах байдлаар хэлж болох юм. Эерэг зүйлсийг нийгмийн ба бага бүлгийн /тасаг, хэлтэс/ гишүүнийхээ хувиар олж авсан. Одоо ажил үйлс өөдөө байгаа нь сайныг нь аваад саарыг нь орхисон сонголтоос л болсон гэж үздэг.

Гэмт хэрэгтэй тэмцэх явцад ялангуяа аливаа гэмт хэргийн нотлох зорилгоор Эрүүгийн процессын бус арга барил хэрэглэж байсан. Үүнийг өвлөн авсан хэрэг гэж үзэх гэхээсээ даган дуурайж байгаа л үйлдэл болжээ гэж үздэг. Гэтэл даган дуурайж байна гээд бодож байтал аль хэдий нь энэ даган дуурайдаг үйлдэл маань дадал болж орхих янзтай болж байсныг бодоход залуу үе аливаа үзэгдэл, харилцаанд орохдоо үүнийг байх ёстой мэтээр ойлгоод хүлээж авсан байдаг нь аюултай. Үүний хамгийн аюултай нь олон үеийн турш хэрэглэж ирсэн хүлэг бус, эрүүдэн шүүх үйлдэл байжээ.

Гэмт хэрэг мөрдөхөд сэтгэл санааны болон бусад олон хүчин зүйлс нөлөөлнө. Тэр нөлөөллийн хэлбэр нь таны ярьснаас санаа авбал бүлэг хүмүүс эсхүл байгууллагад тогтсон үзэгдэл мэт ойлгогддог олон зүйлсийг хүлээж авч, нэгээсээ нөгөөдөө хэлэхгүй ч гэсэн тээгээд хүргэж байсан нь удамшлын гажиг хэлбэр гэлтэй санагдаж байна. Байгууллага гэдэг өөрөө нийгмийн тодорхой бүлэг, тэнд сайн ч туршлага бий, муу нь ч бий. Тэгэхлээр гэмт хэрэг мөрдөж байгаа тогтолцоо маань бүхэлдээ удамшлын процесс шиг санагдаад байна. Хэдийгээр эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан тодорхой ажиллагааг явуулах замаар нотлох ёстой ч бид үе үе зөрчдөг байсан нь өмнөх үеийнхнээсээ авсан хоцрогдмол аргаар хүнд хүч хэрэглэж байсан.

Улс төрийн үзэл санаа, чиг баримжаа ч мөн гэмт хэрэг мөрдөх явцад нөлөөлөх хэлбэр байсан гэж үзэж болохоор байдаг. Яагаад гэхээр төрийн алба хааж байгаа хүний итгэл үнэмшил төрийн үзэл баримтлал, тухайн цаг үеийнхээ итгэл үнэмшилээс ангид байх боломжгүй бололтой юм билээ<sup>[84]</sup>.

Гэмт хэрэг мөдөхүй нь өмнөх үеэсээ хамаарч процессын бус арга барил хэрэглэж хэргийг нотолдог байжээ гэж үзвэл нөгөө талдаа энэ нь зүгээр л гараад ирээгүй хүнээсээ хүнд өвлөгдөн үлдэхдээ нийгмийн үзэгдлийн нэгэн илрэл гэж үзэж болох юм.

Нийгмийн удамшил зүйн хувьд гэмт хэрэг мөрдөх практик нь өмнөх үеэс дараагийн үедээ сур гэж хэлэх нь бүдүүлэг боловч тухайн хүний үйлдлээс даган дуурайх үзэгдэл нь бүлгийн хувьд удамшил зүйн хандлага гэж үзэх үндэслэл байна. Хэдийгээр эерэг болон сөрөг үзэгдэл удамших шинжтэй байгаа хэдий ч үүний цаана ангиалж болох нийгмийн удамшлын шинжүүд байна гэж үзэж байна.

Д/д	Хүчин зүйлс	Суралцаж буй бүлэг, үе	Удамшлын илрэл
	Ахмад үеийнхэн	Залуу үеийнхэн	Үйлдэл, хэл <sup>2</sup> -нээс удамших шинж /объектив/
	Улс төр, удирдлагаас нөлөөлөх нөлөө <sup>3</sup>	Тухайн цаг үеийнхэн	Үзэл санаа, бодлого, хандлага /субъектив/
	Ёс зүй		Харилцаанд оролцож байгаа үеийнхний сайн мууг ялгаж хүлээн авах байдал /субъектив/
	Орчин	Залуу үеийнхэн	Бүлэгт ажил хэрэгч чанар илүү байвал тухайн бүлэгт тэр чанар удамших зүй тогтолтой. Сөрөг бол мөн ялгаагүй. /объектив/

<sup>84</sup> Баабар. Монголчууд. Нүүдэл, суудал. УБ., 2006 он. 585 дахь талд энэхүү нөхцөл байдлын талаар тэмдэглэсэн байдаг. Ишлэл 14-ийн үзнэ үү.





Хүснэгтэнд байгаа ангилал нь явцуу утгаар илэрхийлж буй хэлбэр бөгөөд бид олон төрлөөр ангилах үндэслэл байгааг цаашид судлах болно.

### Дүгнэлт

1. Гэмт хэрэг мөрдөхүйд соёл, уламжлал, орчин, тухайн цагийн үеийн улс төрийн нөхцөл байдал нөлөөлдөг. Энэ нь ярилцлагаас батлагдаж байгаа нь бидний сонгон авсан сэдэв батлагдах үндэслэлтэй байна.
2. Нийгмийн удамшил зүй нь тухайн нийгмийн үнэт зүйлсийн нэгдэл, түүний эсрэг зүйлсийн нэгдэл гэж үзэж болох юм. Үүнээс гэмт хэрэг мөрдөхүйд эерэг ба сөрөг зүйлс нөлөөж байдаг бололтой.
3. Гэмт хэрэг мөрдөхүйд ахмад үеийн үйлдлээс удамших бүлгийн удамшил зүй байна. Тухайлбал: тасаг, хамт олон, найз нөхөд г.м. Залуу үеийхний төлөөлөлд сөрөг талаа үйлдлээрээ харуулсан зүй тогтол байна.
4. Үе үеийнхний дараа дараагийн үеийнхэндээ хэлж буй зүйлс нь удамших зүй тогтол байна. Энэ нь эерэг мөн сөрөг хэлбэрээ илэрч байна. Ярилцлагаас илэрхий ажиглагдаж байна.
5. Гэмт хэрэг мөрдөхүйн өв уламжлал хэдийгээр процессын эрх зүйн илрэл боловч түүнийг дагасан практик шинжтэй ахмад үеэсээ уламжилж авсан процессын эрх зүйн бус тогтол удамших зүй тогтолтой гэж үзэх үндэслэл байна.
6. Цаг үеийн улс төрийн хийгээд бодлогын сайн ба сөрөг тал нөлөөж удамших шинжтэй байдаг бололтой. Социализмын чиг баримжаагаар төлөвшсөн хүмүүс дараагийн үедээ энэ уламжлалаа үлдээсэн байх боломжтой. Энэ нь ажил хэрэгч чанар, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулдаг чадвараар илэрч байна.

### Санал

1. Гэмт хэрэг мөрдөхүйд нөлөөлж буй нийгмийн удамшил зүйн хүчин зүйлсийг нарийн судалснаар түүний дотоод механизм, хөдөлгөгч хүч, үзэл санааны баримжаа, цаашдын хөгжлийн циклыг тодорхойлох боломжтой бөгөөд энэ талаар нарийвчлан судлах нь зүйтэй.
2. Хэрвээ гэмт хэрэг мөрдөхүйд цаг үе нөлөөлж байдаг гэж үзвэл энэ цаг үе бүхнийг сайтар судалсны үндсэн дээр гэмт хэрэг мөрдөж байгаа тогтолцоогоо сайжруулах, боловсронгуй болгох боломжтой. Үүний тулд практикийн болон онолын судлаачидаас бүрдсэн баг бүрдүүлж нэгдсэн үзэл санаад хүрэх шаардлагатай.
3. Гэмт хэрэг мөрдөхүйн эерэг ба сөрөг талыг тухайн цаг үеийн төлөөлөл гэж үзсэн хүмүүсээс авсан ярилцлагын үр дүн нь энэхүү тогтолцоо нэлээд удаан хугацаанд уламжлан ирсэн гэдгийг бататгаж байна. Иймээс гэмт хэрэг мөрдөхүйн уламжлал шинэчлэлд сөрөг талыг багасгаж, эерэг талыг дэмжих хандлагыг бий болгох.

ХАВСРАЛТ<sup>[85]</sup>

Д/д	Үечлэл	Харгалзах огноо	Онцлог	Үүрэг
	Ахмад үеийнхэн	1950-1961	Дараагийн үеээ бэлтгэсэн, ихэнхи нь чөлөөнд байгаа бүлэг	60 настай чиглүүлнэ.
	Манлайлагч	1961-1970	Улс төрийн лидер, яам, агентлагуудыг удирдаж буй бүлэг	50 дээш насныхан зална.
	У д и р д а н чиглүүлэгч	1971-1980	Байгууллага, газар, албадыг хариуцсан бүлгийн төлөөлөл	40 дээш насныхан залж удирдана.
	Гүйцэтгэгч	1981-1990	Одоогийн нөцхөлд бүхий л ажлуудыг өөрт оногдсон ажил үүргийн дагуу гүйцэтгэж буй бүлгийн төлөөлөл	30 дээш насныхан ачаа үүрнэ.

<sup>85</sup> Энэхүү ангилалыг хийхдээ “Үндэсний аюулгүй байдлын сан” төрийн бус байгууллагын сургалтын явцад багш н.Базрагчийн лекцнээс үлгэрлэв.



	Залгамжлагчид	1991-2000	Бэлтгэгдэж байгаа буюу суралцаж байгаа бүлгийн төлөөл	Суралцаж, ажиллаж, амьдралд өөрийгөө нээж, бие хүн болж төлөвшинө.
	Суралцагч	2001-2010	18 бага наснаасаа идэр болох хүртлээ сурч төлөвшинө.	Суралцана
	Ирээдүй хойч	2011-		Тэднийг өсгөж бойжуулах, эрүүл саруул хүн болгоход дээр байгаа бүхий л үеийнхэн өөр өөрийн өвөрмөц үүрэгтэй.

**ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ****“МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАГДАА  
СУДАЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ”  
СУДАЛГААНЫ ТОЙМ**

Б.Энхболд, Б.Мөнхдорж, Д.Сумъяацэрэн,  
Б.Мөнхсэргэлэн  
Цагдаа судлалын төв, Эрдэм шинжилгээ,  
хөгжлийн  
хүрээлэн, Хууль сахиулахын их сургууль

Орчин цагийн Монголын цагдаагийн байгууллага нь цагдан сэргийлэх нэртэйгээр 1921 онд байгуулагдсан бөгөөд тухайн үеийн цагдан сэргийлэх байгууллага нь ардын хувьсгал, хөрөнгөт бус хөгжлийн болон социализм байгуулах төр засгийн бодлогод үндэслэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагааг 70 гаруй жилийн хугацаанд хэрэгжүүлж ирсэн байна.

1990 оноос эхэлсэн нийгмийн ардчилсан өөрчлөлтийн үзэл санааг 1992 онд баталсан шинэ үндсэн хуулиар баталгаажуулахдаа засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх явдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон баримталдаг, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон тунхагласан. Ардчилалын үзэл санаанд тулгуурласан нийгмийн томоохон өөрчлөлтүүд нь Монгол Улс дахь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, тэр дундаа цагдаагийн байгууллагад томоохон өөрчлөлтүүдийг бий болгосон. Ардчилсан нийгэм дэх цагдаагийн байгууллага нь зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажилд анхаарал хандуулаад зогсохгүй цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь олон нийтийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг. Учир нь ардчилсан улс дахь цагдаагийн байгууллага нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх мэдэлийг ард түмэн, түүний төлөөллийн байгууллагын (Улсын Их Хурал) баталсан хуулиар олж авдаг.

Энэ хүрээнд Монгол Улсын Их хурал 1993 онд Цагдаагийн байгууллагын тухай хуулийг 8 бүлэг, 53 зүйлтэйгээр баталсан нь Монгол Улсын цагдаагийн байгууллагын хөгжилд түүхэн үүрэг гүйцэтгэсэн хэдий ч хууль үйлчлэх явцад засаж сайжруулах шаардлагатай шүүмжлэлүүд 2008 оноос гарч, улмаар цагдаагийн байгууллагын эрх зүйн орчинг дахин авч үзэхэд хүргэсэн юм.

Энэхүү шүүмжлэлийн гол агуулга нь “Өнгөрсөн хугацаанд цагдаагийн байгууллагад хийгдсэн гол өөрчлөлтүүд нь зөвхөн бүтэц зохион байгуулалт, хүн, хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх замаар гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдсэн уламжлалт хандлагыг улам боловсронгуй болгож ирсэн бөгөөд ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, нийгмийн хэв журмыг сахиулахад цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэний хяналтын орчин бүрдүүлэх зэрэг агуулгын томоохон өөрчлөлтүүдийг хийж чадаагүйгээс өнөөг хүртэл хуучин тогтолцооны уламжлалт хэв маяг, хүнд суртал хадгалагдсаар байна гэжээ (Asian Foundation of America 2008).

Дээрх шүүмжлэл, дүгнэлтийг тусгах хэлбэрээр цагдаагийн байгууллагын хуулийг шинэчлэх ажил хийгдэж “Цагдаагийн албаны тухай хууль”-ийг 2013 оны 7 дугаар сарын 05-нд Монгол Улсын Их хурлаар баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн төдийгүй боловсронгуй болгох асуудал өнөөг хүртэл хийгдэж байгаа нь нэг талаараа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ардчилсан улс орнуудын хөгжлийн өнөөгийн жишигт ойртуулах гэсэн оролдлого, нөгөө талаар энэ чиглэлийн эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэх шаардлага буюу үндсийг тавьж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж энэ чиглэлийн тулгамдсан асуудалд хариу өгөх явдал манай орны эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын нэн чухал зорилт болоод байна. Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажиллагааг ардчилсан улс орнуудын жишигт нийцүүлэн эх орондоо бүрэн агуулгаар нь хэрэгжүүлж чадах эсэх нь эдгээр асуудлуудын онолын үндэслэлийг боловсруулж түүнийгээ практикт бүтээлчээр



хэрэглэх явдлаас шалтгаалах нь тодорхой.

Цагдаа судлалын цаашдын хөгжлийг тодорхойлох эхний алхам нь энэ салбарын хөгжиж ирсэн хандлага, өнөөгийн хөгжлийн түвшинг тодорхойлох явдлаас эхлэх бөгөөд түүнийг тодорхойлох хэмжигдэхүүнүүд нь цагдаа судлалын чиглэлээр хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээл, түүний судалгааны арга зүйд дүн шинжилгээ хийх явдлаас эхлэх нь зүйтэй. Энэ учир шалтгааны үүднээс “Монгол Улсдахь цагдаа судлалын төлөв байдал” судалгааг хийх үндэслэл болсон.

Судалгааны ажлын мэдээллийн эх сурвалж нь 1967-2015 оны хооронд Монгол Улсын хэмжээнд цагдаа судлалын чиглэлээр бичигдсэн 5 хэлбэрийн 609 судалгааны бүтээлд үндэслэгдсэн болно. Үүнд:


- 1) ном, сурах бичиг,
- 2) эрдмийн зэрэг горилсон бүтээл(доктор),
- 3) магистрын дипломын ажил,
- 4) илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл,
- 5) суурь болон хэрэглээний судалгааны ажлууд багтсан болно.

Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд Б.Батзориг Л.Отгонбаяр нарын “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны ном зүй”, УБ., 2005, Б.Батбаяр нарын хамтын бүтээл “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэл (1911–2012 он) УБ., 2014, нийт 14 Их, дээд сургуулийн номын сангийн каталоги, нэр хүнд бүхий онол, арга зүйн 10 сэтгүүл,Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээний төв, ХЗҮХ болон төрийн бус байгууллагуудын судалгааны ажлын тайланг тус бүр эх сурвалж болгон ашиглав.

Монгол Улсын хэмжээнд 1967-2015 оны хооронд цагдаа судлалын салбарт хамаарагдах 609 бүтээл, туурвил байгаагаас ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл 98, эрдмийн зэрэг горилсон бүтээл 23, магистрын дипломын ажил 222, эрдэм шинжилгээний өгүүлэл 200, төрийн болон төрийн бус байгууллагаас гүйцэтгэсэн судалгааны ажил 236 байна. Дээрх бүтээлүүдийн 32 буюу 5.6 хувь нь 1990 оноос өмнө нийтлэгдэж байсан бол давхардсан сэдвээр 534 буюу 94 гаруй хувь нь 1990 оноос хойш нийтийн хүртээл болжээ. Эндээс дүгнэхэд, цаг үе, нийгмийн байдалтай холбоотойгоор 1990 он хүртэлх хугацаанд цагдаа судлалын чиглэлийн бүтээл, судалгаа цөөн тоогоор хийгдэж байсан бол 1990 оноос хойш харьцангуй нэмэгдэх хандлагатай болсон.

#### Ном сурах бичиг, нэг сэдэвт бүтээл

Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох анхны бүтээлүүдэд нь ахмад ажилтан Д.Дашдэмбэрэлийн (1967) “Сэргийлэгч” бүтээл байсан бол Б.Даваасамбуу, А.Думбурай, Б.Сэнгэдорж, Р.Сайжаа, Д.Тархаашин (1971) нарын “Энх амгалангийн манаанд”,З.Батсүх (1976) “Цагдан сэргийлэх байгууллагын сэргийлэн хамгаалах алба” зэрэг нэг сэдэвт бүтээлүүд багтаж байсан/Хавсралт-2 үзнэ үү/. График 1-т үзүүлснээр 1967-1990 оны хооронд нийт 15 бүтээл туурвигдаж байсан нь социалист хэв маягийн цагдаагийн байгууллагын үйлжиллагааг тайлбарласан шинжтэй байсан бөгөөд 1990 оноос хойшхи үетэй харьцуулахад харьцангуй бага үзүүлэлттэй байна.



<График 1> Ном сурах бичиг, нэг сэдэвт бүтээл (1968-2015)


Харин ардчилсан хувьсгал ялсаны дараа буюу 1990 оноос хойш хэвлэгдсэн эхний бүтээлүүдэд Ж.Долгорсүрэн(1990) “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа”, мөн 1991 онд “Монгол Улсын цагдаагийн байгууллагын өмчийн болон эдийн засгийн албаны түүхэн замнал”, “Монголын цагдаагийн байгууллагын түүхэн замналын атлас”, Д.Цогт-очир (1994) “Цагдаагийн байгууллагын ажилтны ёс зүйн асуудлууд” зэрэг бүтээлүүдийг дурьдаж болно. Эдгээр бүтээлүүд нь ардчилсан улс орны цагдаагийн байгууллагын онцлог, үйл ажиллагааны зохион байгуулалтыгтайлбарлан таниулахаас



илүү монголын цагдаагийн байгууллагын түүхэн хөгжил, социализмын үеийн онцлогийг харуулахад чиглэгдсэн байв. Ж.Долгорсүрэн (1995) “Монголын цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны онол-практикийн үндсэн асуудал”, Б.Пүрэв (1997) “Монгол Улсын цагдаагийн байгууллын тухай хуулийн тайлбар” Д.Думбурай (1999)Цагдаагийн байгууллагын түүх /I, II боть/, Ж.Долгорсүрэн (2002)“Монголын цагдаагийн эрх зүй” зэрэг бүтээлүүд туурвисан нь орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тодорхойлсон цагдаа судлалын салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бүтээл болжээ.

**Цагдаа судлалын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан байдал**

Манай улсад цагдаа судлалын чиглэлээр хууль зүйн шинжлэх ухааны болон хууль зүйн докторын зэрэг хамгаалсан нийт 22 эрдэмтэн байдаг ба үүнээс 14 буюу нийт эрдэмтдийн 63 хувь нь гадаад улсад үүнээс 11 нь ОХУ-д эрдмийн зэрэг хамгаалсан бол 8 буюу 37 хувь нь дотоодод хамгаалсан байна.График 2-т үзүүлснээр Могол Улсын цагдаа судлалын салбарын анхны эрдэмтэд 1977-1989 онд хуучнаар ЗХУ-д доктор (Ph.D) зэрэг хамгаалж байсан бол 1989-2001 оны хооронд 12 жилийн хугацаанд эрдмийн зэрэг хамгаалсан судлаач байгаагүй байна. 2001 онд Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх Хууль зүйн Шинжлэх Ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд Ж.Долгорсүрэн “Монгол Улсад захиргааны эрх зүйн албадлага хэрэглэж буй өнөөгийн байдал, түүнийг хууль тогтоомжийн хүрээнд судалсан нь” сэдвээр шинжлэх ухааны доктор (Sc.D) зэрэг хамгаалсан нь Монгол Улсад хамгаалсан анхны эрдэмтэн байсан бөгөөд энэ үйл явдал нь салбарын судалгаа, шинжилгээний ажлыг дахин эрчимжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж дүгнэж болно. 2004 оноос цагдаа судлалын салбарт хамаарагдах сэдвээр жилд дунджаар 2 судлаач эрдмийн зэрэг хамгаалж байсан бол 2014 оноос эрдмийн зэрэг хамгаалсан судлаачдын тоо нэмэгдэх хандлагатай байна.



<График 2> Цагдаа судлалын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан байдал (1977-2015)

2001 оныг хүртэл цагдаа судлалын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл харьцангуй цөөн, олон жил тасарсан нь манай улсад цагдаа судлалын салбар төдийлөн хөгжөөгүй, тэдгээрийн судалгааны ажлын үр дүнг хэлэлцэн хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаа жигдрээгүй, ОХУ хуучнаар ЗХУ-д Монгол Улсаас хуульч, судлаачдыг бодлогоор сургадаг байсан тогтолцоо тасарсан зэрэг хэд хэдэн хүчин зүйлстэй холбон авч үзэж болно. Нөгөө талаар ардчилсан хөдөлгөөний дараа бий болсон шилжилтийн үеийн улс төр, нийгэм-эдийн засаг, оюун санааны хүрээнд гарсан томоохон өөрчлөлт, тогтворгүй байдал нь энэ салбарын эрдэм шинжилгээ судалгааны ажилд сөргөөр нөлөөлсөн.2000 оны эхэн үеэс ОХУ болон Монгол Улсын засгийн газрын хэлэлцээрийн дагуу ОХУ-ын их сургуулиудад манай улсын хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг бүх түвшинд сургах талаарх уламжлалт хамтын ажиллагаа дахин сэргээсний үр дүнд 2004 онд 2 судлаач эрдмийн зэрэг амжилттай хамгаалсан байна. 2014 оноос эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо өсч, тогтворжих хандлагатай байгаа нь Хууль сахиулахынх сургуулийг түшиглэсэн докторын зэрэг хамгаалуулах зөвлөл бие даасан байдлаар байгуулагдсантай холбоотой юм.

Цагдаа судлалын салбараар гадаад оронд эрдмийн зэрэг хамгаалах явдал 2012 он хүртэл зөвхөн ОХУ-аар хязгаарлагдаж байсан бол 2013 оноос эхлэн БНТУ, БНСУ-д манай судлаачид эрдмийн зэрэг хамгаалж эхэлсэн байна. Тухайлбал, А.Отгонсүх “Монголын болон Туркын дотоод аюулгүй байдлын салбарын удирдлагын харьцуулсан судалгаа” сэдвээр 2013 онд БНТУ-ын Цагдаагийн Академид хууль зүйн ухааны докторын зэрэг, Б.Дэлгэрмаа “Монгол Улсын цагдаагийн байгууллагын бие даасан тогтолцоон дахь цагдаагийн офицерийн эрх зүйн байдал” сэдвээр БНСУ-ын Сежоны Их сургуульд, Б.Энхболд “Бүгд Найрамдах Солонгос



Улс болон Монгол Улсад оршин суугаа Монголчуудын цагдаад итгэх хандлагын харьцуулан судалгаа: Инструментал болон экспрессив загвараар шалгах нь” сэдвээр БНСУ-ын Кёнги их сургуульд тус тус докторын зэрэг хамгаалсан байна. Цаашид АНУ, ХБНГУ, БНХАУ, Япон, Канад зэрэг өндөр дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад эрдмийн зэрэг хамгаалах судлаачдыг бодлогоор бэлтгэх, дэмжих нь Монгол Улсад цагдаа судлалыг хөгжүүлэх гол зорилтуудын нэг юм.

Цагдаа судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан байдал

Цагдаа судлалын чиглэлээр хууль зүйн магистрын зэргийг 1998-2015 оны хооронд нийт 222 хүн хамгаалсан байна.График 3-т магистрын зэрэг хамгаалсан он дарааллыг харуулсан бөгөөд 2009 он хүртэл жилд дунджаар 5 хүн цагдаа судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалж байсан бол 2009 оноос хойш тогтмол нэмэгдэж жилд дунджаар 20-оос доошгүй хүн хамгаалдаг болжээ. Үүнээс 2013 онд хамгийн их буюу 36 хүн магистрын зэрэг хамгаалсан байна.

Дээрх үзүүлэлтийг хуучнаар цагдаагийн академи, одоогийн Хууль сахиулахын их сургуульд магистрын сургалтын хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн, хувийн хэвшлийн сургуулиудад цагдаагийн судалгааны чиглэл бий болсон, иргэдийн боловсролын зэргээ дээшлүүлэх сонирхол нэмэгдсэн зэрэг хүчин зүйлстэй холбон тайлбарлаж болно.

<График 3> Цагдаа судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан байдал (1998-2015)





График 4-т магистрын зэрэг хамгаалж буй судлаачдыг сургуулиар нь эрэмбэлэн үзүүлсэн байна. Тэдний дийлэнх буюу 109 буюу 49.1 хувь нь Хууль сахиулахын их сургуульд, 23 буюу 10.3 хувь нь Их засаг их сургууль, 23 буюу 10.3 хувь нь Билиг дээд сургууль, 17 буюу 7,6 хувь нь Монголын үндэсний их сургууль, 14 буюу 6.3 хувь нь МУИС-ийн Хууль Зүйн Сургуульд тус тус хамгаалагдсан байна. Харин МУБИС, Түшээ, Орхон, Шихихутуг зэрэг их, дээд, сургуулиудад цөөн тоогоор магистрын зэрэг хамгаалсан байна.



<График 4 > Цагдаа судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан байдал сургуулиар (1998-2015)

Дээрх судалгаааны дүнгээс үзвэл цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх судалгаа нь төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудын судалгааны ажлын нэг үндсэн чиглэл болжээ. Цагдаагийн байгууллагын боловсон хүчинг бэлтгэх, салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төв болдогийн хувьд Хууль сахиулахын их сургуульд энэ






чиглэлийн судалгаа түлхүү хийгдэж байна. Харин МУИС-ийн ХЗС-ийн хувьдэнэ чиглэлийн судалгаа харьцангуй цөөн тоотой байгаа нь тус сургуулийн судалгааны ажлын тэргүүлэх чиглэл, бэлтгэж буй боловсон хүчний онцлогтой холбоотой юм. Нийт хамгаалагдсан магистрын ажлын 42 хувь нь хувийн хэвшлийн их, дээд сургуулиудад ногдож байгаа нь нэг талаас цагдаа судлалыг судалгааны нэг чиглэл болгон хөгжүүлж, цагдаа иргэдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, цагдаагийн үйл ажиллагаанд олон нийтийн санаа бодлыг тусгах талаар анхаарал хандуулж байна. Нөгөө талаар ХСИС-д хамгаалагдсан магистрын ажлын сэдэв, агуулга зарим талаар ижилхэн байгаа нь бусдын судалгааны ажлыг зохиогчийн зөвшөөрөлгүй хуулах явдал түгээмэл байгааг илэрхийлэх юм. Цаашид Их, дээд сургуулиудын хэмжээнд эрдмийн болон магистрын зэрэг хамгаалсан бүтээл, эрдэм шинжилгээний өгүүллийн нэгдсэн санг бий болгож зохиогчийн эрхийг зөрчсөн эсэхийг шалгах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай урган гарч байна.

#### Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл

1970-2015 оны хооронд цагдаа судлалын чиглэлээр нийт 242 эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэгдсэн байна. Нийт өгүүллийн 16 буюу 6,6 хувь нь 1990 оноос өмнө, 191 буюу 93.4 хувь нь 1998 оноос хойш тус тус нийтлэгдсэн байна. График 5-т үзүүлснээр 1998 оноос хойш эрдэм шинжилгээний өгүүлэл тасралтгүй нийтлэгдсэн байна. Харин 1991-1997 онуудад эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдэж байгаагүй нь сонирхол татаж байна.

<График 5> Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл(1970-2015)



Судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх хандлага 2001 оноос өсөх хандлагатай болж 2012 оноос огцом өссөн байна. Энэхүү өсөлтөнд хууль сахиулахын их сургуулиас “Хууль сахиулахуй”, “Гэмт явдал судлал”, “Цагдаа судлал” зэрэг улирал тутмын онол, арга зүйн сэтгүүлүүдийг тогтмол эрхлэн гаргадаг болсонтой холбоотой юм. Түүнчлэн мэргэжлийн сэтгүүлд нийтлэгдэж буй эрдэм шинжилгээний өгүүлэлийн тоо эрс нэмэгдэж байгаа нь магистр, докторын сургалтын хөтөлбөр, шинжлэх ухааны докторын зэрэг горилоч нарт тавигддаг үндсэн шаардлагатай холбоотой юм. БСШУ-ны сайдын 2007/187 тоот тушаалаар батлагдсан Магистр, доктор (Ph.D)–ын зэргийн сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журмын 18.1-т “Докторант судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн өөрийн судалгааны ажлын үр дүнгийн талаар тухайн чиглэлийн дотоодын мэргэжлийн үнэлгээнд үндэслэн шилж сонгон хэвлэдэг мэргэжлийн эрдэм шинжилгээний бие даасан сэтгүүлүүдэд 2-оос доошгүй өгүүлэл заавал хэвлүүлсэн байна” мөн журмын 15.4-т “Магистрын ажлыг хамгаалалтад оруулах зөвшөөрөл өгөх журмыг сургуулийн сургалтын журамд тусгана” гэж заасаны дагуу их дээд сургуулиуд магистрант нарт эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байх шаардлага тавьж байна. Тухайлбал, Хууль сахиулахын их сургуулийн магистр, докторын сургалтын журмын 7.5.2-т “Магистрын судалгааны ажлын үр дүнг хянан магадлагаа бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр нийтлүүлсэн байна” гэж тус тус заажээ.

Хэдийгээр нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч өгүүллийн чанар хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай. Тухайлбал, Хууль сахиулахын



их сургуулийн захирлын 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн чанар” сэдэвт судалгааны ажил гүйцэтгэсэн байна. Судалгаанд тус сургуулийн багш, судлаачдын бичсэн 50 өгүүллийг санамсаргүй түүврээр сонгон авч эрдэм шинжилгээний өгүүллийн олон улсад мөрдөж байгаа стандарт, бүтцийн дагуу 11 шалгуур-ерөнхий үзүүлэлт, 24 дэд үзүүлэлтээр дүн шинжилгээ хийсэн байна. Тус судалгаанд сонгогдсон өгүүллийн 31 буюу 62 хувь нь цагдаа судлалын салбарт хамаарагдах өгүүлэл байсан бөгөөд судалгааны дүнгээр олон улсад мөрдөж байгаа стандартад нийцсэн эрдэм шинжилгээний өгүүлэл байхгүй, нийтлүүлсэн өгүүлэл нь тодорхойлон тайлбарласан шинжтэй, тус өгүүллийг нийтэлж буй сэтгүүлийн редакцийн зөвлөл хангалтгүй ажиллаж байгаа гэсэн дүгнэлтүүд гарчээ (С.Гантулга, Б.Энхболд, 2016).

#### Цагдаа судлалын хүрээнд судлагдсан сэдвийн онцлог

Хүснэгт-1 үзүүлснээр хамгийн их судлагдсан сэдвүүд нь “Цагдаагийн байгууллагын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, системчлэх”, “Гэмт хэрэгтэй тэмцэх тактик”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, практик” гэсэн агуулгын хүрээнд байна. Харин хамгийн бага судлагдсан сэдэв нь “Цагдаагийн байгууллага ба хэвлэл мэдээлэл”, “Цагдаагийн байгууллагын албадын хамтын ажиллагаа”, “Төрийн эрх мэдлийн хүрээн дэх цагдаагийн байгууллагын эрх зүйн байдал” зэрэг багтаж байна. Цөөн тоогоор судалсан боловч, онолын болон практикийн түвшинд агуулга мөн чанарыг нь бүрэн илэрхийлээгүй судалгааны салбарт “Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа”, “Цагдаагийн онол судлал”, “Харьцуулсан цагдаа судлал”, “Гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэл”, “Цагдаагийн байгууллага ба олон нийтийн үнэлэмж” зэрэг сэдвүүд тус тус хамаарч байна. Түүнчлэн “Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал”-ын талаар цөөн тооны судалгаа хийгдсэн боловч цагдаагийн алба хаагчийн хүн ам зүйн шинж талаас судалсан ажил хараахан байхгүй байна. Тухайлбал, цагдаагийн алба хаагчдын насжилт, эмэгтэй цагаадгийн алба хаагчдын онцлог, цагдаагийн алба хаагчийн стресс, амиа хорлолт, албандаа хандах сэтгэл ханамж зэрэг судалгаа төдийлөн хийгдээгүй байна.

<Хүснэгт 1>Хамгийн их судлагдсан сэдвийн жагсаалт  
(1968-2015)

№	Судалгааны сэдэв /чиглэл/	Бүтээлийн Тоо
	Цагдаагийн байгууллагын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, системчлэх	98
	Гэмт хэрэгтэй тэмцэх тактик	71
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, практик	52
	Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй	40
	Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа	32
	Цагдаагийн алба хаагчийн нийгэм, эрх зүйн баталгаа	32
	Цагдаагийн байгууллагын сургалтын тогтолцоо	31
	Цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, бүтэц, тогтолцоо	29
	Захиргааны зөрчилтэй тэмцэх ажиллагаа	26
	Нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах	25
	Цагдаагийн байгууллагын түүх судлал	24
	Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа	23
	Цагдаагийн байгууллага ба албадлага	21
	Цагдаагийн албаны шинэчлэл	20
	Цагдаагийн байгууллага ба хүний эрх	20
	Цагдаагийн байгууллагын тусгай хэрэгсэл, зэвсэглэмж	19
	Харьцуулсан цагдаа судлал	18



Цагдаагийн байгууллага ба олон нийтийн үнэлэмж	17
Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа	16
Цагдаагийн эргүүл, харуул, хамгаалалтын үйл ажиллагаа	15
Гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэл (статистик)	14
Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал	14
Цагдаагийн онол судлал	13
Цагдаагийн байгууллагын техник, технологи	12
Албан хаагчийн ажлыг дүгнэх, хяналт шалгалт, аюулгүй байдал	11
Цагдаагийн байгууллагын боловсон хүчний (хүний нөөцийн) бодлого	10
Цагдаагийн байгууллагын соёл	9
Төрийн эрх мэдлийн хүрээн дэх цагдаагийн байгууллагын эрх зүйн байдал	4
Цагдаагийн байгууллагын албадын хамтын ажиллагаа	1
Цагдаагийн байгууллага ба хэвлэл мэдээлэл	1

Дээрх судалгааны дүнгээс үзвэл гэмт хэрэгтэй тэмцэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг гадагш чиглэсэн судалгааны ажил өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд давамгайлж иржээ. Энэ учир шалтгааныг дараах хэд хэдэн хүчин зүйлсээр тайлбарлаж болох юм. Үүнд: 1) Тухайн улсын засаглалын хэлбэр, 2) гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдал, 3) Цагдаа судлалын хөгжлийн түвшин зэргээр тодорхойлж болно.

1) Тухайн улсын засаглалын хэлбэр: Судалгаа шинжилгээний ажил нь тухайн улс орны засаглалын хэлбэр, түүний бодлогыг хэрэгжүүлж буй цагдаагийн байгууллагын бодлоготой шууд холбогддог (Shaw, 2004). Ардчилсан улс орон дахь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлого нь гэмт хэрэгтэй тэмцэх уламжлалт арга, хэлбэрээс татгалзаж олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаанд үндэслэгддэг. Цагдаагийн байгууллагын уламжлалт арга хэлбэр нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагад ирсэн дуудлага, бүртгэсэн гэмт хэрэг, түүний илрүүлэлт, өсөлт, бууралтын хувь зэргээр шууд хэмждэг асуудалд суурилсан цагдаагийн онолоор тайлбарлагддаг (Jang 2014). Тиймээс төр, засгийн зүгээс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг төр, түүний механизмаар дамжуулан тэмцэхийг оролдож хуульчлан баталгаажуулдаг.

Монгол Улсын Их хурлаас 1993 онд баталж 20 гаруй жил үйлчилсэн Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 10 дугаар

зүйлд “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага мөн” гэж тодорхойлсон. Энэ учир шалтгааны улмаас гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх арга зам, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг хөндсөн судалгааны ажил ихээр хийгдсэн байх талтай.

2) Гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдал: Аливаа судалгааны ажлын үндэслэл нь нийгмийн хэрэгцээ шаардлагаас урган гарсан байдаг. Улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдал 1990-ээд оны дунд үе хүртэл хүндэрч 1997 оноос тогтворжих хандлагатай байсан бол 2004 оноос дахин хүндэрч хүн, төр, нийгэмд учруулах хор уршиг нэмэгдэх хандлага ажиглагдсан (Б.Энхболд, 2014). Энэ нөхцөл байдлаас шалтгаалан гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг судлах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажил цагдаагийн байгууллага, эрдэмтэн судлаачдын өмнө тулгамдсан зорилт болсон нь энэ төрлийн судалгаанд анхаарал хандуулахад хүргэсэн.

3) Цагдаа судлалын хөгжлийн түвшин: Гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдлын асуудал нь нийгмийн бүхий л цаг үеийн туршид байсан сөрөг үзэгдэл агаад үүнтэй тэмцэх арга тактик, онол урсгал хувьсан өөрчлөгдөж түүнийг даган судалгаа шинжилгээний ажил тасралтгүй хөгжиж байна. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, захиргааны зөрчил зэрэг нийгмийн сөрөг үзэгдэлтэй дангаараа тэмцээд үр дүнд

хүрэхгүй гэсэн хандлага хүлээн зөвшөөрөгдөж олон нийтэд түшиглэсэн цагдаа, цагдаагийн байгууллагын технологийн инноваци, хагархай цонхны онол гэх мэт гэмт хэрэгтэй тэмцэх шинэ онол, хандлагууд бий болсон нь манай улсын хэмжээнд хараахан судлагдаагүй мэдлэгийн салбар болж байна. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд олон ургальч үзэл хандлагаар бус зөвхөн цагдаагийн байгууллагын тухай хууль, түүний үзэл санаа, нэр томъёо, үйл ажиллагааг тайлбарласан хязгаарлагдмал хүрээнд судалгаа хийж ирсэнтэй холбон үзэж болно.

### **Цагдаа судлалын салбарт хэрэглэж буй судалгааны арга зүй**

Цагдаа судлалын салбарт хийгдэж байгаа судалгааны ажил, үнэн бодит байдалд нийцэж байгаа эсэх, түүний чанарыг үнэлэх гол шалгуур үзүүлэлт нь тухайн ажлыг гүйцэтгэсэн судалгааны арга зүйгээр тодорхойлогддог. Тиймээс энэ судалгааны ажлын нэг зорилт нь цагдаа судлалын тодорхой сэдвээр судалгаа явуулахдаа ашиглаж буй судалгааны арга зүйд дүн шинжилгээ хийх явдал байсан.

Судалгааны арга зүйн ерөнхий ойлголт

Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй нь тоон судалгаа (quantitative) болон чанарын судалгаа (qualitative) гэсэн ерөнхий 2 ангилалд хуваагддаг (G.Maxfield, 2007). Тоон судалгааны мэдээллийн эх сурвалжийг хэмжих боломжтой тооны илэрхийлэлүүдээс цуглуулдаг бол чанарын судалгааны мэдээллийн эх сурвалжийг ямар нэгэн тоон илэрхийлэлээр бус хүний болон аливаа юмс үзэгдлийн өөрийнх нь шинж чанараас цуглуулдаг арга зүй юм.

Аливаа судалгааны ажлын арга зүйн хэсгээр төрлийн судалгаа байгаагаас үл хамааран дараах үе шатуудаас бүрддэг (График 6).

<График 6> Судалгааны ажлын арга зүйн үеЭх сурвалж: *Research methodes for Criminal Justice and criminology. 2007*



**Судалгааны арга зүйг боловсруулах (Survey designing):** Судлах гэж буй асуудал, судалгааны гол асуудлыг агуулсан судалгааны объект буюу түүврийн нэгжийн шинж чанараас шалтгаалаад судалгааны өөр өөр аргачлал арга зүйг дангаар нь болон хослуулан ашиглах шаардлага гардаг. Энэ хүрээнд зөвхөн тоон судалгааны аргыг дангаар нь ашиглах бус чанарын судалгааны аргууд болох фокус бүлгийн ярилцлага (Focus Group Discussion (FGD)), гол мэдээлэгч нартай хийх ганцаарчилсан ярилцлага (Key Informants Interview (KII) or In-Depth Interview (IDI)), ажиглалт, туршилт судалгаа, кэйс шинжилгээ болон баримт бичгийн судалгаа (Desk review)-ны аргуудыг ашиглах хэрэгтэй.

**Эх олонлогоос түүвэрлэлт хийх (Sampling design):** Ямар нэгэн зүйлийнхувьд судалгаа явуулахад уг зүйлд харьяалагдах боломжит бүх элементүүдийн олонлогийг

эх олонлог гэнэ. Судалгааг эх олонлогийн бүх элементүүдийг хамруулан хийх нь цаг хугацаа, зардлын хувьд ихээхэн хүндрэлтэй байх нь олон тул судалгаанд ихэвчлэн эх олонлогийн элементүүдээс тодорхой хэсгийг сонгон авч шинжилгээ хийгээд эх олонлогийн талаар дүгнэлт гаргадаг. Эх олонлогоос сонгон авсан элементүүдийн олонлогийг түүвэр гэнэ. Судалгааны нэгжийг тодорхойлох, тэдгээр нэгжийн мэдээллийг багтаасан түүврийн хүрээг бэлтгэн, төлөөлөх чадвартай түүврийг хийх нь судалгааны үр дүнд шууд нөлөөлдөг. Түүвэрлэлтийг практикт маш олон аргаар хийдэг бөгөөд түүвэрлэлтээ аль болох санамсаргүй байлгах нь зүйтэй.

**Судалгааны мэдээлэл цуглуулалт (Data collection):** Судалгааны мэдээлэл цуглуулалтын шатанд судлаачийн ёс зүйн асуудал, мэдээлэл цуглуулалтын арга болон мэдээллийн чанарт тавих чанарын



хяналтонцгой ач холбогдолтой. Судалгааны бүхий л үе шатанд судалгаанд оролцогчийн мэдээллийг нууцлалыг хадгалах, судалгааг сайн дурын үндсэн дээр авах гэх зэрэг ёс зүйн дүрэм журам шаардлагатай болдог. Орчин үед мэдээллийн технологи, техник технологийг дэвшлийг судалгааны мэдээлэл цуглуулалтад өргөнөөр ашиглах болсон. Ингэснээр мэдээллийн чанарт тавигдах хяналт сайжрах, мэдээлэл цуглуулалтыг богино хугацаанд үр дүнтэй хийх, судалгааны объектын талаар илүү бодитой мэдээлэл олж илрүүлэх зэрэг боломжийг олгож байна(Ч.Даваасүрэн 2016).

**Мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ (Data analysis):** Цуглуулсан мэдээллийн бүрдэл хэсэг бүрт логик үндэслэлтэй задлан шинжилгээ хийх, үнэлэх процесс юм. Цуглуулсан мэдээллийг боловсруулах нь судалгааны ихээхэн хугацаа, хөдөлмөр шаардах үе шатны нэг бөгөөд боловсруулалтын чанараас судалгааны эцсийн үр дүн ихээхэн шалтгаална. Судалгааны мэдээллийг боловсруулахад зориулсан олон тооны програм зохиогдсон ба Windows-ын орчинд хэрэглэгддэг програмууд нь цонхны бүтэц, үндсэн үйлдлүүд нь ижил, хэрэглэхэд хялбар байдаг. Тухайлбал, Microsoft Excel, SPSS, DBASE, STATISTICA, ACCESS зэрэг болно.

### **Судалгааны арга зүйд хийсэн шинжилгээ**

Монгол Улсад цагдаа судалалын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудад дүн шинжилгээ хийж үзэхэд нийгмийн шинжлэх ухааны салбарт түгээмэл хэрэглэгддэг баримт бичигт дүн шинжилгээ хийх, санал асуулга авах, хууль тогтоомжид дүгнэлт хийх аргыг түгээмэл хэрэглэж байгаа бол чанарын судалгааг фокус бүлгийн ярилцлагын хэлбэрээр зохион байгуулах, математик, статистикийн CSPRO, SPSS програмын анхан шатны боловсруулалт хийх арга зүйг цөөн тохиолдолд хэрэглэж байна.

Магистрын болон эрдэм шинжилгээний өгүүлэлд дээр дурьдсан судалгааны арга зүйг удирдлага болгон хийсэн бүтээл байхгүй байна. Хууль сахиулахын их сургууль болон Их засаг их сургууль, Билиг дээд сургуулийн эрдэм шинжилгээний номын санд ашиглагдаж буй 173 магистрын зэрэг горилсон бүтээлээс санамсаргүй түүврийн аргаар 103 ажлыг сонгон авч судалгааны арга зүйн хэсэгт дүн шинжилгээ хийж үзэхэд 95 буюу 92.3 хувь нь дэвшүүлсэн зорилгодоо хүрэх судалгааны арга зүйг оновчтой

сонгоогүй, судалгааны түүвэрлэлтийг хэрхэн хийсэн, мэдээлэл хэрхэн цуглуулсан, ямар арга зүй, аргачлалаар мэдээлэлд дүн шинжилгээ хийсэнэ тайлбарлаагүй байна.

Түүнчлэн түүвэрт сонгогдсон бүтээлүүдийн удиртгал хэсгийн судалгааны арга зүйн хэсэгт дурьдагдсан мэдээлэл хоорондоо ижилхэн, маш ерөнхий агуулгаар бичигдсэн байна. Тухайлбал, Түүвэрт сонгогдсон 103 бүтээлээс 84 буюу 81.5 хувь нь хүснэгт 2-т үзүүлсэн бичвэрийг ижилхэн байдлаар хуулбарлан оруулсан бол 56 буюу 54.3 хувь нь судалгааны арга зүйн хэсэгт дурьдагдсан арга зүйгээ бүрэн хэрэглээгүй байна. Эндээс үзвэл судлаач судалгааны арга зүйд анхаарал хандуулдаггүй болох нь дүгнэгдэж байна. Энэ нь тухайн судалгааны ажлын үр дүн, дүгнэлт, санал бодитой эсэхэд эрэглэээ төрүүлж байна.

<Хүснэгт 2> Магистрын дипломын судалгааны арга зүйн хэсэг

Энэхүү судалгааны ажлыг хийхдээ байгаль, нийгмийн аливаа юмс үзэгдлийг хөгжлийнх нь хөгжил хөдөлгөөнд нь бусад юмс үзэгдлүүдтэй харилцан уялдаа холбоонд авч үзэж судалдаг танин мэдэхүйн диалектик аргад тулгуурлан нийгмийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг шинжлэх ухааны нийтлэг болон тусгай аргууд болох анализ, синтез, индукци, дедукци, түүхчилсэн, статистик, ажиглалтын, эрх зүйн харьцуулсан судалгаа хийх зэрэг аргуудыг ашигласан болно.

Цагдаа судлалын чиглэлээр бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл хамгийн ихээр нь нийтлэгддэг “Хууль сахиулахуй”, “Гэмт явдалтай тэмцэх асуудал”, “Цагдаа судлал” сэтгүүлүүдийн сүүлийн 2 жилийн дугаараас санамсаргүй түүврийн аргаар 50 өгүүлийг сонгон авч дүн шинжилгээ хийж үзэхэд 46 буюу 92 хувь нь судалгааны арга зүйн хэсгээ тодорхойлоогүй байна. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хянан магадлагаа бүхий сэтгүүлийн редакцийн зүгээс эрдэм шинжилгээний өгүүлэлд тавьдаг нийтлэг шалгуурт үзүүлэлтэд судалгааны арга зүйн хэсэг онцгой үүрэг гүйцэтгэдэг байна.

Магистрын ажил болон эрдэм шинжилгээний өгүүлэл бичихдээ ашигласан мэдээллийн эх сурвалж нь ихэнх тохиолдолд хоёрдогч эх сурвалж (secondry data)-ийн



хэлбэртэй байгаа нь судлаачид бие даасан хэлбэрээр судалгаа явуулж анхдагч эх сурвалж (first data)-г цуглуулах ажил хангалтгүй байгааг илэрхийлж байна. Түүвэрт хамрагдсан 103 магистрын ажил, 50 эрдэм шинжилгээний өгүүллийн мэдээллийн эх сурвалжид дүн шинжилгээ хийж үзвэл 132 буюу 86 хувь нь шүүх, прокурор, цагдаа болонбусад байгууллагуудаас гаргасан статистик мэдээ, төрийн болон төрийн бус байгууллагаас хийсэн судалгааны тайланг мэдээллийн эх сурвалжаар ашигласан бол 21 буюу 13.7 хувь баримт бичиг болон хавтаст хэрэгт дүн шижилгээ хийх, ярилцлага болон санал асуулгын аргыг ашиглах хэлбэрээр анхдагч мэдээлэл цуглуулж дүгнэлт хийсэн байна. Харин цагдаа судлалын салбарт ажиглалт, туршилтын аргаар судалгаа явуулж дүгнэлт хийсэн бүтээл хараахан гараагүй байна.

Мэдээлэл боловсруулалтын түвшинд орчин үеийн програм ашиглан математик статистикийн аргачлалаар боловсруулалт хийж, нарийвчилсан дүгнэлт гаргадаг чадвар бүхий судлаач нар ховор байна. Харин 2008-2015 оны хооронд засгийн газар ЦЕГ болон УБ хотын Цагдаагийн газрын захиалгаар төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн санал асуулгын судалгааны мэдээллийг зарим байгууллагууд SPSS.20 програм ашиглан 1 асуулгын аргаар боловсруулт хийсэн байна.

2015 онд УБ хотын цагдаагийн газрын захиалгаар “Шударга Монгол Цагдаа” ТББ байгууллагаас явуулсан “Нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн алба хаагчдын иргэдтэй харилцах харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох хоёр хувьсагчийн судалгаа”-нд SPSS.20 програмыг ашиглан регрессийн шинжилгээ хийсэн нь өмнөх судалгаануудаас дэвшилттэй боловсруулалт болжээ. Түүнчлэн Б.Энхболд (2015) “Монголчуудын цагдаад итгэх хандлагын харьцуулсан судалгаа: инструментал болон экспрессив загварчлалаар шалгах нь” сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээлдээ Монгол Улсын нийслэл Улаанбаатар болон БНСУ-ын нийслэл Сөүл хотын оршин суугч 992 монголчуудаас санал асуулгын аргаар судалгаа авч үр дүнг SPSS.20, HLM (hierarchical linear models) програм ашиглан статистикийн “Корреляцийн шинжилгээ”, “Ложистик регресс” болон “Олон хүчин зүйлсийн шугаман регресс”-ийн аргачлалаар боловсруулалт хийж дүгнэлт гаргасан нь цагдаа судлалын салбарын анхны судалгаа болжээ.

### **Цагдаагийн судалгааны ажлын санхүүжилтийн байдал**

Судалгааны ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, үр дүнг практикт нэвтрүүлэхэд санхүүжилтийн асуудал чухал үүрэгтэй.

Цагдаагийн байгууллага алба хаагчдынхаа боловсролын зэргээ ахиулахыг дэмжих, цагдаа судлалын чиглэлээр судалгааны ажил хийлгэх зорилгоор гадаадын болон дотоодын их дээд сургуулиудад магистр, докторын сургалтын төлбөрт хамруулж, сургалтын төлбөр болон амжиргааны өртгийн зардлыг шийдвэрлэж байна. Хууль зүйн сайдын 2012 оны Б/20 дугаар тушаалаар баталсан Хууль сахиулахын их сургуулийн бүтцэд Шинжлэх ухаан, технологийн газар байгуулан, түүний харьяанд Цагдаа судлалын төвийг 5 хүний орон тоотойгоор байгуулсан нь салбарын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэхэд чухал шийдвэр болсон. Гэсэн хэдий ч эрдмийн зэрэг горилсон бүтээл, магистрын судалгааны ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, судалгаа явуулахад шаардлагатай эрдэм шинжилгээний ажлын төсөв, санхүүжилтийг шийдвэрлэхгүй байгаа нь судалгааны ажлын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 3-т цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөллийг тандах хөндлөнгийн судалгаа, түүний санхүүжилтийн байдлыг харуулсан байна. 2008 оноос хойш 9 жилийн хугацаанд нийт 10 удаа хөндлөнгийн байгууллагаар нийт 66.4 сая төгрөгөөр судалгаа хийлгэжээ. 2015 онд судалгааны ажилд зарцуулсан хөрөнгө хамгийн өндөр буюу 25 сая төгрөг байсан бол 2011 онд хамгийн бага буюу 1.5 сая төгрөг байжээ.

<Хүснэгт 3> Цагдаагийн судалгааны ажлын санхүүжилтийн байдал (2008-2015)

№	Хугацаа	Судалгааны ажлын нэр	Гүйцэтгэсэн байгууллага	Санхүүжилт / төгрөг/	Тайлбар
	2008 он	Цагдаагийн байгууллагын болон цагдаагийн албан хаагчийн талаарх “Улаанбаатар хотын иргэдийн санал бодол”	Максима судалгааны төв	7 сая төгрөг	Ц Е Г - ы н захиалга





	2008 он	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох чиглэл	ШУА-ын Философи социологи эрхийн хүрээлэн	3 сая төгрөг	Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын захиалга
	2011 он	Цагдаагийн байгууллагын 2011 оны үйл ажиллагаанд хэрэглэгчдээс өгсөн үнэлгээ”	ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор	1.5 сая төгрөг	ЦЕГ-ын захиалга
	2013 он	Монгол Улсын Цагдаагийн байгууллагаас иргэдэд хүргэдэг үйлчилгээний мониторинг	“IRIM”хараат бус судалгааны хүрээлэн	8 сая төгрөг	ХЗЯ-ны захиалга, ЦЕГ-ын санхүүжилт
	2013 он	<b>Цагдаагийн эргүүлийн хөтөлбөрийг боловсруулах хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын шинжилгээ</b>	Максима судалгааны төв	4сая төгрөг	УБХЦГ-ын захиалга
	2014 он	<b>Цагдаагийн байгууллагын Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа</b>	Хууль зүйн үндэсний хүрээлэн	8 сая төгрөг	ЦЕГ-ын захиалга
	2015 он	“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ” судалгаа	Судалгаа, шинжилгээний “ЭсАйСиЭй” (SICA) ХХК	4.910.000 төгрөг	ЦЕГ-ын захиалга
	2015 он	Нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн алба хаагчдын иргэдтэй харилцах харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох хоёр хувьсагчийн судалгаа	“Шударга МонголЦагдаа” ТББ	УБХЦГ-аас бичгийн цаас, унаа, зохион байгуулалтын хувьд дэмжлэг үзүүлсэн.	УБХЦГ-ын захиалга
	2015 он	Улаанбаатар хотын цагдаагийн үйл ажиллагааны талаар олон нийтийн сэтгэгдлийг судлах	“Vision group” business solutions	20 сая төгрөг	УБХЦГ-ын захиалга
	2016 он	Улаанбаатар хотын цагдаагийн үйл ажиллагааны талаар олон нийтийн сэтгэгдэл	“Vision group” business solutions	18сая төгрөг	УБХЦГ-ын захиалга ба одоо дахин хийлгэж байгаа гэв.
	Нийт		<b>10 хөндлөнгийн судалгааны ажил</b>	<b>66.4 сая төгрөг</b>	

Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлал”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг үндэслэн Цагдаагийн ерөнхий газар хэрэглэгчийн үнэлгээний тайланг жил

бүр гаргах үүрэг хүлээсэнтэй холбоотойгоор санхүүжилтын асуудал шийдвэрлэгдэж байна.

Эдгээр судалгааны ажлын санхүүжлтийн эх үүсвэр нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, эсхүл өөр бусад үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлсэн шинжтэй байгаа нь цагдаагийн байгууллагын хэмжээнд мөн эрдэм шинжилгээ, судалгааны



ажилд зарцуулах төсөв байхгүйг илэрхийлж байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай төрийн бус байгууллага, Олон улсын байгууллагууд нь судалгааны ажлыг дэмжих зорилгоор олон тооны судалгаа, төслүүдийг санхүүжүүлдэг боловч цагдаа судлалын чиглэлээр харьцангуй цөөхөн байна. Гадаадын зарим оронд засгийн газрын санал болгосноор дотоодын аж ахуй нэгж, олон улсын байгууллагуудаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн олон тооны төсөл хөтөлбөрүүд зарлаж, санхүүжилтийг шийдвэрлэдэг нь энэ салбарын судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байна.

#### **Судалгааны ажлын үр дүнг Олон Улсын түвшинд танилцуулсан байдал**

Цагдаа судлалын салбарын судалгааны ажлын явцын болон эцсийн үр дүнг олон улсын хэмжээнд танилцуулах, тухайн салбарын хэрэглэгчдэд дамжуулж, оюуны бүтээлийг судалгааны эргэлтэнд оруулах хамгийн сонгодог хэлбэр нь “Эрдэм шинжилгээний өгүүлэл” юм. Эрдэм шинжилгээний өгүүлэлээр дамжуулж судлаач судалгааны салбарын хөгжлийн түвшинг олон улсад харуулах, тус салбарын хөгжилд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ, тэндэх өөрийн байр суурь нь тодорхойлогдож байдаг.

Эрдэм шинжилгээний өгүүллийг олон улсын хэмжээнд танилцуулахад нэр хүнд бүхий шинжлэх ухааны сэтгүүлд хэвлэгдсэн байх нь чухал. Шинжлэх ухааны сэтгүүлүүдийн чансааг Impact Factor (IF) хэмээх үзүүлэлтээр тодорхойлдог. Өндөр чансаатай сэтгүүлд өгүүлэл хэвлүүлнэ гэдэг нь тухайн судлаачаар тогтохгүй сургууль, судалгааны байгууллагын, бүр цаашилбал улс орны хөгжлийг илтгэх том үзүүлэлт болдог.

2015 оны эцсийн байдлаар нийгмийн шинжлэх ухааны салбарт хүлээн зөвшөөрөгдсөн импакт фактор бүхий криминологи, гэмт хэрэгтэй тэмцэх салбарын 53 мэргэжлийн сэтгүүл байгаагаас цагдаа судлалын салбарт хамаарагдах дараах 3 сэтгүүл байна. Үүнд: “Police Quarterly” (PQ), “Policing: An International Journal of Police Strategies & Management” (PI-JPSM), болон “Policing and Society: An International Journal of Research and Policy” (P&S). Эдгээр сэтгүүлүүдийн нийтлэлийн бодлого нь “Цагдаагийн үйл ажиллагааны онол, практик, харьцуулсан судалгаа, шүүмжлэл зүй, инноваци, цагдаа судлалын Олон Улсын хөгжлийн чиг хандлага, практик, менежмент, боловсролын тогтолцоо болон шинжлэх ухаан, технологийн орчин үеийн ололтыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх” чиглэлээр судалгааны үр дүнг нийтэлдэг.

Хүснэгт 4-т үзүүлснээр 2003-2015 оны байдлаар дээрх 3 сэтгүүлд нийт 1123 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэнээс зөвхөн 38 буюу 3,3 хувь нь Зүүн болон зүүн өмнөд азийн 5 орноос хэвлүүлсэн байна. Эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн орнуудыг хувиар авч үзвэл БНСУ 16 буюу 42,1 хувь, БНХАУ 12 буюу 31 хувь, Тайвань 6 буюу 15,7 хувь, Япон болон Хонгконг тус бүр 2 буюу 5,2 хувийг эзлэж байна (Kim Bitna 2015) .

#### **<Хүснэгт 4> Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудас цагдаагийн мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл (2003-2015 он)**

Сэтгүүл	Улс	Нийтлүүлсэн өгүүлэл тоо	(%)
Police Quarterly	БНХАУ	3	4 (10.5)
	Япон	-	
	Өмнөд Солонгос	-	
	Тайвань	1	
	Хонгконг	-	




Policing	БНХАУ	6	29 (76.3)
	Япон	1	
	Өмнөд Солонгос	15	
	Тайвань	5	
	Хонконг	2	
Policing and Society	БНХАУ 3		5 (13,1)
	Япон	1	
	Өмнөд Солонгос	1	
	Тайвань	-	
	Хонконг	-	
Нийт	5	38	(100)

Дээрх статистик мэдээнээс үзвэл, БНСУ цагдаа судлалын салбарын судалгааны үр дүнг олон улсын хэмжээнд танилцуулах түвшинхамгийн өндөр, энэ салбарын эрдэмтэн судлаачдын тоо өсч байгааг харуулж байна. Харин БНХАУ болон Япон харьцангуй өндөр тоон үзүүлэлттэй байгаа хэдийч хүн амын тоотой харьцуулбал доогуур үзүүлэлт юм.


Харин бусад шинжлэх ухааны салбаруудаар Монголын судлаачид 1967-2015 онуудад Томсон-Ройтерсын индекстэй олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлүүдэд 3005 өгүүлэл нийтлүүлсэн байна. Анхны өгүүлүүд 1993 онд гарч эхэлсэн боловч нийт хэвлэгдсэн өгүүлүүдийн ихэнх нь 2007 оноос хойш хэвлэгдсэн байна. график 7-д үзүүлснээр нийтлүүлж буй өгүүллийн тоо 2006 он хүртэл бага хэмжээгээр тогтвортой өсч байсан бол 2008 онд 220 өгүүлэл нийтлэгдсэн нь 2006 онтой харьцуулахад бараг 3 дахин өссөн үзүүлэлттэй байжээ. Харин 2014 онд 259, 2016 онд 263 өгүүлэл болж тогтмол өссөөр байгаа нь Монгол Улсад шинжлэх ухааны салбар хөгжиж байгааг хэмжих үзүүлэлт юм.

<График 7> Томсон-Ройтерсын индекстэй олон улсын сэтгүүлүүд нийтлүүлсэн өгүүлэл (1967-2016)



Хамгийн олон өгүүлэл нийтлүүлсэн 20 мэргэжлийн чиглэлийг график 8-д харуулсан бөгөөд мэргэжлийн чиглэлийн хувьд инженер, физик, экологи, геологи, хими гэх мэт байгалийн ухаан, инженерчлэлийн чиглэлээр түлхүү хэвлэгддэг байна. Энэ нөхцөл байдлыг доктор Ж.Даваадулам (2016) дүгнэхдээ Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэл, Монгол орны байгалийн нөөц, тогтоцын баялаг онцлог чанар, Байгалийн ухааны салбаруудын хувьд дэлхийн шинжлэх ухаан глобал чанартай зэрэг нөхцөл байдлуудтай холбон үзсэн байна.

<График 8>Хамгийн олон өгүүлэл нийтлүүлсэн 20 мэргэжлийн чиглэлийг (1967–2015)



Дээрхээс үзвэл Монгол Улсын хувьд нийгмийн шинжлэх ухааны салбараар хэвлэгдэж буй эрдэм шинжилгээний өгүүлэл байгалийн шинжлэх ухааны салбаруудтай харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн импакт, фактор бүхий сэтгүүлийн эрдэм шинжилгээний өгүүлэлд тавих хамгийн гол шалгуур нь сайнметриксийн ухагдахуунууд юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн шинжлэх ухааны хийсвэр нэр томъёо, ойлголтуудад хэмжилт хийх болон тэдгээрийг нарийвчлах, тайлбарлахад статистик, математикийн аргачлалыг ашиглах явдал юм.

Тиймээс нийгмийн шинжлэх ухаан, тэр дундаа цагдаа судлалын судалгааны үр дүнг олон улсад танилцуулахад онол, түүнийг практикт шалгасан судалгаа, боловсруулалтын аргачлалд сайнметриксийн аргыг ашиглах явдал юм.

### Дүгнэлт

Монгол Улсын хэмжээнд 1967-2015 оны хооронд цагдаа судлалын салбарт хамаарагдах 5 хэлбэрийн 609 судалгааны бүтээл олны хүрээл болжээ. Үүнээс 534 буюу 94 орчим хувь нь 1990 оноос хойшхи цаг хугацаанд хамаарагдаж байгаа нь 1990 оноос өмнө цаг үеийн нөхцөл байдлаас

шалтгаалан цагдаа судлалын эрдэм, шинжилгээ, судалгааны ажил харьцангуй цөөн (4.6 хувь) хийгджээ.

Судалгааны ажлын сэдвийн ерөнхий хүрээг авч үзвэл гэмт хэрэгтэй тэмцэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг гадагш чиглэсэн судалгааны ажил нийт бүтээлийн 30 гаруй хувийг эзлэж байгаа бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөн чанарыг нээн илрүүлэх, гадаад орны сайн туршлагыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн цагдаагийн онол, харьцуулсан цагдаа судлал, цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа зэрэг сэдвүүд харьцангуй бага судлагдсан байна.

Цагдаа судлалын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудад нийгмийн шинжлэх ухааны салбарт түгээмэл хэрэглэгддэг баримт бичигт дүн шинжилгээ хийх, санал асуулга авах, хууль тогтоомжинд дүгнэлт хийх, фокус бүлгийн ярилцлага хийх зэрэг аргуудыг түгээмэл хэрэглэжбайгаа бол нийгмийн шинжлэх ухааны онолын хийсвэр ойлголт, нэр томъёонуудад хэмжилт хийх, нарийвчилсан дүгнэлт гаргахад ач холбогдол бүхий математик, статистикийн аргачлал ашиглахгүй байгаа нь судалгааны үр дүнг олон улсын хэмжээнд танилцуулахад



хүндрэл учруулж байна. 2015 оны байдлаар импакт, фактор бүхий олон улсын сэтгүүлд цагдаагийн судалгааны ажлын үр дүнг танилцуулах онол, арга зүйн бүтээл нийтлэгдээгүй байгаагаар тодорхойлогддо.

Цагдаа судлалыг хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудал хангалтгүй байна. Цагдаагийн байгууллага алба хаагчдынхаа боловсролын зэрэг ахиулах, гадаадын болон дотоодын их дээд сургуулиудад магистр, докторын сургалтын төлбөрт хамруулж, сургалтын төлбөр болон амжиргааны өртгийн зардлыг шийдвэрлэх, ХСИС-ийн Эрдэм шинжилгээ хөгжлийн хүрээлэнгийн бүтцэд Цагдаа судлалын төв байгуулах зэргээр олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байгаа хэдий ч эрдмийн зэрэг горилсон бүтээл, магистрын судалгааны ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, судалгаа явуулахад шаардлагатай эрдэм шинжилгээний ажлын төсөв, санхүүжилтийг шийдвэрлэхгүй байгаа нь судалгааны ажлын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

### Санал

1. Цагдаа судлалын үндсэн чиглэлийг судалгааны онцлог, хамрах хүрээг харгалзан цагдаагийн үйл ажиллагаа судлал буюу **(study of policing)**, гэмт явдал судлал буюу **(Criminology)** гэсэн 2 хэлбэрээр томъёолж, цагдаагийн үйл ажиллагаа судлалын тэргүүлэх чиглэл нь цагдаагийн онол судлал, цагдаагийн бодлого, цагдаагийн түүх судлал, олон улсын цагдаа судлал, цагдаа иргэний харилцаа судлал, цагдаагийн боловсрол-инноваци судлал, олон нийтийн аюулгүй байдал судлал байна. Харин гэмт явдал судлалын тэргүүлэх чиглэл нь криминологийн онол судлал, гэмт явдлын шалтгаан нөхцөл судлал, гэмт хэрэг илрүүлэхүй судлал, гэмт хэргийн чиг хандлага судлал гэж тодорхойлох нь зүтэй.

2. “Цагдаа судлалын үндэс”, “Судалгааны арга зүй” зэрэг суурь бүтээлүүдийг бодлогоор бичиж ХСИС-ийн сургалтад нэвтрүүлэх,

3. Цагдаа судлалын чиглэлээр цагдаа судлалын төв, магистр, докторын сургалтын түвшинд хийгдэж байгаа судалгааны ажлыг үнэлэхдээ энэ тайлангийн 2.3-т заасан үе шатуудаар судалгаа явуулсан эсэх шалгуурыг харгалзан үзэж судалгааны ажлын бодит байдлыг тодорхойлдог болох.

4. Судалгааны ажлыг чанарыг сайжруулах хүрээнд судлаачдын амжиргааны өртгийн зардлаас гадна эрдэм, шинжилгээ судалгааны ажлын зардлыг нэмэгдүүлэх.

5. “Цагдаа судлал”, “Гэмт явдал судлал”-ын чиглэлээр ХСИС-ийн Ахисан шатны

боловсролын сургууль болон Удирдлагын академид хамгаалагдсан магистрын судалгааны ажилд чанарын судалгаа хийх, үр дүнгийн мөрөөр тодорхой арга хэмжээг бүрэлдэхүүн сургуулиудтай хамтран хэрэгжүүлэх.

6. Цагдаагийн онол, гадаад орнуудын цагдаа судлал зэрэг Монгол Улсад төдийлөн их судлагдаагүй байгаа хавсралт-6-д дурьдагдсан тэргүүлэх чиглэлийн хүрээнд магистр, докторын түвшинд судалгаа хийж, үр дүнг практикт хэрэглэх боломж нөхцлийг тодорхойлж нэвтрүүлэх.

7. 2017 онд Олон улсын импакт, фактор бүхий сэтгүүлд “Цагдаа судлал”-ын тодорхой сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлэх, улмаар Зүүн болон Зүүн өмнөд Азийн оронуудаас тус шалгуур бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн 6 дахь улс, Монгол Улсаас анхны их сургууль болох зорилтыг хангаж ажиллах.

8. Цагдаа судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг гадаадын ижил төстэй эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, судлаач, багш нарын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар судалгааны ажилд шинэлэг арга зүйг нэвтрүүлэх.

9. Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацийн газрын Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн болон Цагдаагийн сургуулиас эрхлэн гаргасан “Цагдаа судлалын нэр томъёоны гарын авлага”/2017/-д орсон нэр томъёоноос цаашид дэлгэрүүлэн судлах зэрэг болно.



## НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР, ТҮҮНИЙ ТОГТОЛЦООГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Д.Булган  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн  
Цагдаагийн  
эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн  
магистр, цагдаагийн хошууч

**Хураангуй:** Цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээний үед иргэд олон нийтийн аюулгүй байдал хангах, нийтийн хэв журмыг сахиулах, эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хор уршгийг даамжруулахгүй, хэвийн болгохтой холбоотой хамгаалалтын төлөвлөгөөг цагдаагийн байгууллагаас боловсруулдаг. Энэхүү өгүүллээр нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах асуудалд илүү анхаарал хандуулж, түүний загвар, тогтолцоо, бүрэлдэхүүн хэсгийг тодруулан авч үзэж, боловсронгуй болгохоор зарим санал дэвшүүллээ. Энэхүү сэдвийн хүрээнд нэгд, нийтийг хамарсан арга хэмжээний тухай ойлголт, төрөл, эрх зүйн зохицуулалт, хоёрт, хамгаалалтын төлөвлөгөө, түүний бүрэлдэл хэсэг, гуравт, хамгаалалтын төлөвлөгөөний загвар, боловсронгуй болгох асуудал гэсэн агуулгын хүрээнд судалсан.

**Түлхүүр үг:** Нийтийг хамарсан арга хэмжээ, хамгаалалтын төлөвлөгөө, олон нийтийн аюулгүй байдал, хамгаалалтын төлөвлөгөөний бүрдэл хэсэг, хамгаалалтын төлөвлөгөөний тогтолцоо.

### Удиртгал

“Цагдаагийн албаны тухай хууль”-д заасан “олон нийтийн аюулгүй байдлыг хангах” чиг үүргийн гол бүрэлдэхүүн хэсэг нь нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх **ажиллагааг хамааруулан заасан.**

**Цагдаагийн байгууллагаас** нийтийг хамарсан арга хэмжээний үед иргэд олон нийтийн аюулгүй байдал хангах, нийтийн хэв журмыг сахиулах, эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хор уршгийг даамжруулахгүй, хэвийн болгохтой холбоотой хамгаалалтын төлөвлөгөө боловсруулахад анхаарал

хандуулах нь зайлшгүй юм. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөг сайтар боловсруулснаар гэмт хэрэг, зөрчил, нийтийн эмх замбараагүй байдал, террорист халдлага гарахаас бүрэн сэргийлж, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх гол үндэс болно.

Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр иргэд, олон нийтэд аюул бий болох, гэмт хэрэг үйлдэгдэх, танхай, хүчирхийлэл, алан хядах ажиллагаа, террорист халдлага гарах зэрэг заналхийлэл нь нийгэмд асар их хор уршигийг бий болгодог. Үүнтэй холбогдуулан нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөг сайтар боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг зөв тодорхойлсноор хууль бус үйлдлийг гарахаас өмнө урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд хор уршгийг нэмэгдүүлэхгүй, тусламж үзүүлэх зэрэг байх бодит үр дүнг бий болгодог байна.

Тиймээс нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах асуудалд илүү анхаарал хандуулж, түүний загвар, тогтолцоо, бүрэлдэхүүн хэсгийг тодруулан авч үзэж, боловсронгуй болгохоор зарим санал дэвшүүлэхийг зорилгоо. Энэхүү сэдвийн хүрээнд нэгд, нийтийг хамарсан арга хэмжээний тухай ойлголт, төрөл, эрх зүйн зохицуулалт, хоёрт, хамгаалалтын төлөвлөгөө, түүний бүрэлдэл хэсэг, гуравт, хамгаалалтын төлөвлөгөөний загвар, боловсронгуй болгох асуудал гэсэн агуулгын хүрээнд судаллаа.

Нэг. нийтийг хамарсан арга хэмжээний тухай ойлголт, төрөл, эрх зүйн зохицуулалт.

Нийтийг хамарсан арга хэмжээний талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт төдийлөн байхгүй бөгөөд Европ дахь Аюулгүй байдлын Үндэсний Судалгааны хөтөлбөрийн зохицуулах томоохон арга хэмжээний үеэр олон улсын шинжээчид, оролцогчдын туслалцаатайгаар олон нийтийн арга хэмжээг юу бүрдүүлдэг болон оновчтой тодорхойлолт өгөхөөр ажилласан. Нийтийг хамарсан арга хэмжээнд 30 гаруй үйл явдлыг хамааруулан үзжээ.

Нийтийг хамарсан арга хэмжээг түвшингөөс нь хамаараад жижиг, дунд болон томоохон арга хэмжээ хэмээн хуваан авч үздэг байна. Мөн нийтийг хамарсан тусгай арга хэмжээ -ний бэлэн байдлын түвшин тодорхойлон заасан байдаг

Томоохон арга хэмжээнд хамааруулах гол үндэслэл нь терроризмын эрсдэл, аюул болон бусад эрсдэл учрах бололцоо бүрдэх, олон тооны цагдаа хамгаалах, олон улсын



цагдаагийн хамтын ажиллагаа бий болох, дэмжигчид болон жагсагчдын эрсдэл нэмэгдэх (эмх замбараагүй байдал бий болох), их хэмжээний хүн оролцох, хэвлэл мэдээллийн ажиллагаа өргөн хүрээтэй оролцох зэрэг шинжээс нь хамаарч ангилдаг.

Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг нь олон хүн цугласан нийтэд хамааралтай, анхаарал татахуйц олон төрлийн арга хэмжээ, үйл явдал юм.

Монгол Улсад нийтийг хамарсан арга хэмжээнд нийгэм, улс төрийн арга хэмжээ /жагсаал, цуглаан, ажил хаялт, суулт, эдийн засаг, улс төрийн шинжтэй уулзалт, зөвлөгөөн, чуулган/;

➤ спортын арга хэмжээ /тив, дэлхийн болон олон улс, улс, орон нутгийн чанартай аварга шалгаруулах уралдаан, тэмцээн, марафон гүйлт, бусад арга хэмжээ/;

➤ соёл, урлагийн арга хэмжээ /баяр, ёслолын арга хэмжээ, урлагийн шоу, наадам, бүх нийтийн зугаалга, шашны зан үйл/;

➤ Улсын баяр болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдаж байгаа бүсийн даншиг наадам, хурдан морины уралдааны үеийн;

➤ Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулийн үеийн арга хэмжээ гэх мэт.

Ийнхүү манай улсад нийтийг хамарсан арга хэмжээ гэдэгт жагсаал цуглаан, хурал, уулзалт, зөвлөгөөн, соёл урлаг, спорт тэмцээн, наадам, морины уралдаан бусад үзвэр үйлчилгээ, иргэдийн амралтыг зөв зохистой өнгөрүүлэх соёлын үр шимийг хүртээх зорилготой нийгмийн олон янзын үйл явдлуудыг багтаан авч үздэг байна.

Доктор Д.Таванжин: “нийтийг хамарсан арга хэмжээ” гэдэг нь хүмүүсийн улс төр, бие бялдар, оюуны хэрэгцээг хангах зорилготой тэдгээрийн эрх ашигт нийцсэн олон түмний оролцоотойгоор явагдаж байгаа иргэдийн эрх, эрх чөлөө хэрэгжих, өөр хоорондоо харилцах хэлбэр, бие хүн, хамт олон, нийгэм бүхэлдээ үзэл бодол, үйл хөдлөл чиглэлээ нэгтгэх арга хэрэгсэл болсон зохион байгуулалтай үйлдлийн илрэл юм гэж тодорхойлсон.

Нэг. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөө, түүний зорилго. “Хамгаалалтын төлөвлөгөө” гэдэг нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хэрэгжүүлэхэд нөөц бололцоо болон нөхцөл байдалд зохицон

ажиллах, мэдээ мэдээллийг боловсруулах менежментээр дамжуулан олон нийтийн аюулгүй байдлыг хангах, аюул заналын эсрэг хариу үйлдэл үзүүлдэг арга хэрэгсэл юм .

Хамгаалалтын төлөвлөгөөний зорилго нь арга хэмжээг аюулгүй зохион байгуулах хэрэгжүүлэх явдал бөгөөд, тухайн үеийн нөхцөл байдал, гэнэт гарч болох аюул, эрсдэлээс ард, иргэдийг өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох явдал юм.

Хамгаалалтын төлөвлөгөө нь

- Үйл ажиллагаа зохиогдох объектын доторх хүрээнд хүний амь нас, эд хөрөнгийг гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалахад чиглэх;

- Үйл ажиллагаа зохиогдох объектын гадуурх хүрээний хүний амь нас, эд хөрөнгийг гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалахад чиглэх;

- Гэнэтийн нөхцөл байдал, аюул, ослоос урьдчилан сэргийлэхэд аюулгүй байдлын хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах .

Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтыг зохион байгуулан явуулахдаа Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах” (код 500), “Жагсаал, цуглааныг албадан тараах” (код 503)-д журамд иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын төрөл, арга, хэлбэр, дэг горимыг тогтоосон харилцааг зохицуулсан

“Монгол Улсын Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль” -ийн 13 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллага нь хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалж, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй , 11 дүгээр зүйлд зааснаар жагсаал, цуглаан зохион байгуулагчид жагсаал, цуглаан хийх газарт нийтийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй гэж зөвхөн жагсаал, цуглаан хийхтэй холбогдон үүсэх нийтийн хэв журам сахиулах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулж байна.

“Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”ийн 9 дүгээр зүйлд зааснаар аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд нь байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэг хүлээдэг.





Дээрх хууль тогтоомжид зааснаар цагдаагийн байгууллага нь гүйцэтгэх засаглалын болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн хурал, жагсаал, цуглаан, бусад нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагчидтай хамтран иргэдийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахиулах; хууль тогтоомжийн хүрээнд соёл урлаг, спортын болон бусад нийтийг хамарсан цэнгээнт арга хэмжээг зохион байгуулагч нарт иргэдийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахиулахад нь туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх газар, хэлтэс, албыг цагдаагийн байгууллагад шинэчлэн зохион байгуулсан.

Нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангах төлөвлөх, удирдан зохион байгуулахдаа цагдаагийн байгууллага нь дараахь зүйлд анхааран ажиллана . Үүнд:

-Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр хүндрэлтэй нөхцөл байдал үүсч болзошгүй, тухайн үед хэрхэн ажиллах талаар зайлшгүй төлөвлөнө. Жишээлбэл: жагсаал цуглааны үеэр гэмт хэрэг гарах, эсэргүүцэгчдээс хүчирхийлэл үзүүлэх, террорист халдлага, байгалийн гамшиг бий болох бүхий л нөхцөл байдлыг тооцоолж төлөвлөгөөг боловсруулах, жирийн гэмт хэрэг болон зөрчил мөргөлдөөний үед ч хэрхэн ажиллах талаар бүрэн бэлтгэлтэй байна;

- Нийтийг хамарсан арга хэмжээг аюулгүй, амгалан тайван байдлыг хангах, зохион байгуулахад саад болж болох бүх нөхцөл байдлыг урьдчилан үнэлэх. (гудамжны хаалт, эрэл хайгуул, нэгжлэг, шуурхай бэлэн байдлыг тактикийн нэгжүүдийг олны нүдэн дээр ил байрлуулах);

-Жагсаж цугларах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хүндэтгэхийн хажуугаар олныг хамарсан арга хэмжээ аюулгүй үргэлжлэх нөхцөл байдлыг хангах;

-Холбоо харилцааг анхаарч аргууд, удирдлага зохион байгуулалтын бүтэц, үр нөлөөтэй, шинэ боловч түр хугацаанд ашиглах байгууллагын дотоод зохицуулалтыг бий болгох;

-Арга хэмжээний хамрах цар хүрээ, ач холбогдлоос үл хамааран арга хэмжээ явагдаж байгаагаас бусад нутаг дэвсгэрт хууль сахиулах байгууллагын үйлчилгээг саадгүй авч байх нөхцөлийг бүрдүүлэх;

-Үндэсний болон Олон улсын ач холбогдол бүхий томоохон арга хэмжээний талаар Холбооны төв байгууллагууд

урьдчилан мэдсэн байх, шаардлагатай үед дэмжлэг авах бэлтгэлийг хангахын тулд Эх орны Аюулгүй байдлын газрын аюулгүй байдлын зөвлөхүүд зэрэг холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэх

Нийтийг хамарсан арга хэмжээний үед цагдаагийн байгууллага дараахь зорилтыг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд: хотын оршин суугчдад цагдаагийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ. Энэ эрхэм зорилтын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах болон бусад үйлчилгээг үзүүлнэ. Мөн тухайн арга хэмжээний аюулгүй байдлыг хангаж, оролцогчдыг хамгаалах явдал юм. Энэ эрхэм зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Цагдаагийн байгууллага нь хууль сахиулах болон бусад байгууллага, хамт олонтой хамтын ажиллагааг дэмжиж, үйл ажиллагаагаа уялдуулан, уг арга хэмжээнд оролцож байгаа хувь хүн бүрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Хоёр. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөний бүрдэл хэсэг. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын арга хэмжээний үеэрх аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргахын тулд дараахь хэдэн чухал элементүүдийг анхаарах хэрэгтэй байдаг.

Хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулахад заавал байх 12 бүрдэл хэсэг (элемент) байдаг . Үүнд:

1. Удирдлага. Төлөвлөлтийг зохион байгуулах, удирдах, гол үйл явдлын хэрэгжүүлэх аюулгүй байдлыг хангах шаардлагатай манлайлах шинж чанартай, ур чадвар, туршлага шаардсан хамт олны хүч хөдөлмөрийг удирдах ажиллагаа чухал юм.

2. Үйл ажиллагааны менежмент. Төлөвлөгөө нь судалгаа хийхээс эхэлнэ. Судалгаанд томоохон арга хэмжээний шилдэг практикийг тодорхойлон, жагсагчид болон оролцогчдын тактикт дүн шинжилгээ хийх зэргийг оролцуулж болно.

Төлөвлөлтөд анхаарах зүйлсийн жагсаалтыг гаргаж, тухайн арга хэмжээний хамгаалалт, замын хөдөлгөөний удирдлага, нийтийн хэв журам, хүний нөөц, тушаал болон хяналтын гэх мэт гол салбарыг тодорхойлохыг зорино.

Эдгээр салбаруудаас үндсэн төлөвлөгөөг гаргана. Салбар тус бүрийн хүрээнд ажлын хэсэг ажиллана.

3. Мэдээлэл цуглуулах. Аюул, эмзэг байдал, эрсдэлийн талаарх өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, үнэлгээ



боловсруулна. Цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээний үед аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь олон төрлийн, өөр өөр мэдээлэлд суурилж, дүн шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөө боловсруулахад анхаарч үздэг байна.

4. Хэвлэл мэдээлэл ба PR хийх. Цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээтэй холбоотой мэдээллийг үнэн зөв, цаг тухайд нь зохион байгуулалттай хүргэх нь ямар ч гэмт хэрэг бусад аюул, заналаас урьдчилан сэргийлэх, эсвэл бууруулах ач холбогдолтой болно. Учир нь хэвлэл мэдээллээр нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдалтай холбоотой зөвлөгөө, мэдээллийг олон нийт болон оролцогчид, үзэгчдэд хүргэснээр нийтийг хамарсан арга хэмжээг үр дүнтэй гүйцэтгэлийг бий болгох стратеги болдог.

5. Тухайн байршлын аюулгүй байдлыг шалгах. Дараагийн алхам бол тухайн байршлын хяналтын болон хамгаалалтын нөхцөл байдлыг судалж, төлөвлөгөө боловсруулах явдал юм.

6. Хяналтыг тогтоох

- Үр дүнтэй мэдээллийг цуглуулж, хариу арга хэмжээг боловсруулах;
- Нийтийг хамарсан арга хэмжээний үед саад учруулж болзошгүй хүнийг илрүүлэх, орохоос урьдчилан сэргийлэх;
- Хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх;
- Үйл явдлын талаарх мэдээллийг цуглуулах, хуваалцах, солилцож үйл ажиллагаа сайжруулах;

7. Замын хөдөлгөөний удирдлага

- Авто замын сүлжээг аюулгүй байлгах, хамгаалах
- Зам тээврийн осол, замын түгжрэл, жагсагчдын бөөгнөрөл зэрэгт урьдчилан төлөвлөгөө боловсруулах
- Тухайн арга хэмжээний үеэр нийтийн тээврийн маршрутыг гаргах

8. Арга хэмжээний хамгаалалт. Энд стратегийн болон тактикийн төлөвлөгөө боловсруулах ёстой. Тухайлбал төлөвлөгөөнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүмүүс, эд хөрөнгийг хамгаалах талаар зохих арга хэмжээ тусгасан байна.

Төлөвлөгчид дараахь зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Арга хэмжээний бүхэлдэхүүн хэсгийн эмзэг байдлыг тодорхойлох, хэрэв дайралтад өртвөл иргэд, олон нийтийн аюулгүй байдал, эрүүл мэнд болон үндэсний аюулгүй байдалд ямар хэмжээний хохирол учрах талаар;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд оролцогч талуудын мэдлэг, хамтын ажиллагаа, хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарах;

- Гэнэтийн нөхцөл байдлын үед эрт зарлан мэдээлэх болон бусад хариу арга хэмжээний загваруудыг боловсруулах;

9. Хүний нөөц болон бусад арын албаны дэмжлэг. Аюулгүй байдлын төлөвлөгчид хүн, материал, техник, технологийн нөөц бүхий аюулгүй байдлын төлөвлөгөөг бий болгох хэрэгтэй.

- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд үүргээ гүйцэтгэх хангалттай алба хаагчдыг сургаж, бэлтгэх

- Хоол, орон байр, тээврийн хэрэгсэл гэх мэт асуудлаар дэмжлэг үзүүлэхэд бэлэн байх;

- найдвартай тоног төхөөрөмж, харилцаа холбооны хэрэгсэл болон технологийн орчин үеийн шийдэл бүхий хангамжийн асуудлыг сайжруулах.

10. Харилцаа холбоо болон технологи.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн шийдэл: Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед радио, утас, харилцаа холбооны аюулгүй, үр дүнтэй мэдээллийн технологийн шийдлийг бий болгох шаардлагатай;

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хяналт: Удирдлагын төвийн байранд мэдээлэл, технологийн системийг бий болгох, эрчим хүчний хангамж, бүх зүйлийг тохируулан, аюулгүй байдлыг шалгаж, баталгаажуулсан байх;

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн ажиллагаа: Энд мэдээлэл, харилцаа холбооны урсгалын тодорхой горимыг бий болгох бөгөөд ингэснээр бүх оролцогч талууд хэзээ, хэнд, юуг мэдээлэх ёстой вэ гэдгийг тодорхойлсон байна;

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хамгаалалт: Нийтийг хамарсан арга хэмжээний үед аюул, занал учрах, террорист болон эсэргүүцэгчийн халдлага, осол, байгалийн гамшиг гэх мэт онцгой нөхцөл байдлын үед холбоо барих төлөвлөгөө боловсруулах, харилцаа холбооныхоо системийг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

11. Хамгаалалтын төлөвлөгөөг нэгтгэх болон хоорондын уялдааг хангах. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөнүүд хоорондоо харилцан улдаатай болон бие биенээ нөхөх байдлаар хийгдэх нь зүйтэй.

- Хамгаалалтын төлөвлөгөөг нэгтгэх, харилцан нөхөх, уян хатан байдал, үр дүнг шалгах; (хэзээ, хаана хамтад нь хийх);
- Хувь хүний болон багийн ур чадварыг шалгах (хэн, хэзээ, хаана, юу, хэрхэн хийх);
- Аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай хууль, байгууллагын үйл ажиллагааны журамд нийцэж байгаа эсэхийг шалгах;
- Тоног төхөөрөмж нь нөхцөл байдалд тохиромжтой эсэхийг шалгах;

12. Гэнэтийн нөхцөл байдлын төлөвлөлт ба хямралын үеийн менежмент. Террорист халдлага, нийтийн эмх замбараагүй байдал, байгалийн гамшиг, осол, онцгой болон бусад хүчин зүйл үүссэн, үр дагавар нь сүйрлийн байж болох тийм нөхцөл байдлын төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байдаг. Гэнэтийн нөхцөлийн төлөвлөгөө нь

- Хүний амь нас амрах, эд хөрөнгийг хамгаалах;
- Хохирогсдыг эмчлэх, аврах, түргэн тусламж үзүүлэх, шилжүүлэх;
- Нүүлгэн шилжүүлэлтийг удирдах;
- Нийтийг хамарсан арга хэмжээг зогсоох;
- Хүрээлэн буй орчныг хамгаалах;
- Байгууллагын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг мэдээллээр хангах;
- Аль болох хурдан хугацаанд хэвийн байдалд оруулах (нөхөн сэргээх);
- Нотлох баримтыг хадгалах;
- Мөрдөн шалгах болон хэрэг бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулах гэх мэт зүйлсийг оруулж төлөвлөнө.

Гурав. Хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах загвар. НҮБ-ын Гэмт хэрэг, Хууль зүйн судалгааны хүрээлэн (UNICRI)-гээс боловсруулсан хамгаалалтын төлөвлөгөөний дараахь загварыг энэхүү судалгааны ажилд санал болгож байна. Энэхүү загвар нь хамгаалалтын төлөвлөгөө боловсруулагчдад хэрхэн төлөвлөхийг заах биш, төлөвлөлтийн үйл явцын гол бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлоход тусалж, гол ойлголтуудыг нэгтгэсэн тусгасантай судлаачийн хувьд санал нийлж, анхаарал хандуулан авч үзлээ.

Энэхүү загвар нь дараахь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ

- 1) Хамгаалалтын төлөвлөгөөний тогтолцоо (систем);
- 2) Хамгаалалтын төлөвлөгөөний хүрэх боломж (нийлүүлэх бүтээгдэхүүн);
- 3) Эрсдэлийг хянах ажиллагаа гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна.


Зураг 1. Хамгаалалтын төлөвлөгөөний загвар.



**1) Хамгаалалтын төлөвлөгөөний тогтолцоо.** Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөө нь 4 чухал бүрэлдэхүүн хэсэгтэй. Аюулгүй байдлыг хангахдаа дараахь 4 чухал бүрэлдэхүүнийг зайлшгүй бодолцох шаардлагатай. Үүнд:

- Нөөц бололцоо – энэ нь хамгаалалтыг төлөвлөгөө боловсруулагчдад буй материалын болон хүн хүчний, технологийн нөөц бололцоо юм.
- Хязгаарлалт - Хязгаарлалт нь байж болох боломжуудыг тохируулан ашиглах бөгөөд нөөц бололцоонд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах чиглэл тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл хууль эрх зүйн, цаг хугацааны, санхүүгийн гэх мэт бусад хүчин зүйлүүдийн хязгаарлагдмал нөхцөл байдалд хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.
- Мэдээлэл боловсруулалт – Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөө боловсруулахад мэдээлэл зайлшгүй цуглуулах бөгөөд мэдээлэлд дүн шинжилгээ хийж, түүнийг боловсруулан, эрсдэлийн үнэлгээ хийж, гэмт хэрэг болон бусад аюул, заналд өртөх боломж, түүнийг бууруулах үйл ажиллагааны үндэс суурь тавигдах болно.

Зураг 2. Хамгаалалтын төлөвлөгөөний тогтолцооны бүрэлдэхүүний зарим хэсэг.



Хамгаалалтын төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд нөөц бололцоо, хязгаарлалт, мэдээллийн боловсруулалт хийх ажиллагаа нь зайлшгүй шаардлагатай бөгөөд эдгээрийг хооронд нь удирдлага, менежментээр холбож, түүнийг бодиттой бүрдүүлэх боломж бүрдэнэ.

Энэхүү тогтолцоонд удирдлагын асуудал чухал үүрэгтэй бөгөөд нийтийг хамарсан арга хэмжээг амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлэх, удирдан чиглүүлэх үйл ажиллагааг явуулна. Өөрөөр хэлбэл тогтолцооны 4 дэх нэг бүрэлдэхүүн хэсэг нь удирдлага, менежментийн асуудал байдаг (Зураг 3-т харуулав).



Зураг 3. Хамгаалалтын төлөвлөгөөний тогтолцооны бүрэлдэхүүн.

Хамгаалалтын төлөвлөгөө боловсруулахад анхаарах гол асуудал бол удирдлага, менежмент, зохион байгуулалтын ажил юм. Удирдлага, зохион байгуулалт нь хамгийн богино хугацаанд, үр дүнтэй үйлчилгээг бий болгох, сайн арга барил, хувилбарыг хэрэгжүүлэх, сонгох чадвартай үйлдэл, менежментийн асуудал байдаг юм. Өөрөөр

хэлбэл энэ нь хамгаалалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх аюулгүй байдлын арга хэмжээг үр дүнтэй, ухаалгаар хэрэгжүүлэх гол зүрх болдог.

**2) Хамгаалалтын төлөвлөгөөний хүрэх боломж (хамрах хүрээ).** Энэ нь хамгаалалтын төлөвлөгөө боловсруулахад хоёр дахь чухал бүрэлдэхүүн хэсгийг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл хамгаалалтын төлөвлөгөө нь тухайн арга хэмжээний дотоод болон гадаад хамгаалалтыг хэрэгжүүлж, аюул, эрсдэлтэй нөхцөл байдал бий болсон үед хамгаалалтыг амжилттай хэрэгжүүлэх үндэс суурийг тодорхойлж байдаг.

Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөө нь дараахь зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэдэг байна. Үүнд:

➤ Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтыг тухайн арга хэмжээ явагдаж буй газрын доторх хэсэгт хүний амь нас, өмч хөрөнгийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюул, эрсдэл учрахаас хамгаалах явдал юм;

➤ Тухайн хамгаалалтын газрын гадуур хэсэгт хүний амь нас, өмч, эд хөрөнгийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюул, эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөтэй байна;

➤ Гэнэтийн нөхцөл байдлын үеийн нөөц төлөвлөгөөтэй байж, хамгаалалтыг хэрэгжүүлэх.

**Дотоод:** Энд тухайн арга хэмжээнд оролцогчдыг шууд хамгаалах зорилготой төлөвлөгдөж, хэрэгжинэ. Оролцогчид нь тухайн арга хэмжээнд оролцох бүхий л хүмүүс хамаарна. Тухайлбал тамирчид, улс төрчид, тэмдэглэлт баярын эзэд, хамгаалалтын болон хамгаалалтын бус ажилчид, олон нийтийн төлөөлөл, байгууллага, агентлагийн хүмүүс, сэтгүүлчид, сайн дурынхан гэх мэт нийтийг хамарсан арга хэмжээнд оролцогчид байна.

**Гадаад:** Энд хамгаалалтын үйл ажиллагааны гадуурх иргэдийн амь нас эд хөрөнгийг хамгаалах зорилготой. Өөрөөр хэлбэл нийтийг хамарсан арга хэмжээнд оролцогчдоос гадна хүрээлэн буй ойр орчимд хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах явдал юм.

**Гэнэтийн нөхцөл байдлын төлөвлөгөө.** Ямар нэгэн таамаглаагүй нөхцөл байдал илэрвэл түүнд тохирсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх бэлтгэлтэй байх, мөн аюул заналыг эсрэг арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байх нь зүйтэй.

Ийнхүү хамгаалалтын төлөвлөгөөний



хүрэх үр дүн, боломжийг тухайн арга хэмжээний гадаад болон дотоод аюулгүй байдлыг хангах, гэнэтийн нөхцөл байдлын үеийн төлөвлөгөөг авч хэрэгжүүлснээр тодорхойлогдоно.

**3)** Мэдээлэл цуглуулах, эрсдэлийн үнэлгээ хийх. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах загварын 3 дахь бүрэлдэхүүн бол эрсдэлийн үнэлгээ хийх явдал юм. Гарч болзошгүй эрсдэлийн жагсаалтыг гаргаж, түүнд эрсдэлийн үнэлгээ хийх аргыг боловсруулж эрсдэлийг тодорхойлон, хариу арга хэмжээг төлөвлөх явдал юм.

Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр дараахь төрлийн аюул, эрсдэл үүсэх магадлалтай байдаг.



- Терроризмын үйл ажиллагаа;
- Олон нийтийн эмх замбараагүй байдал үүсэх;
- Гарч болох гэмт хэргүүд;
- Байгалийн гамшиг, зам тээврийн болон бусад осол, аюулт үзэгдэл;
- Ажил хаялт, жагсаал цуглаан нь саад тотгор үүсгэх үйл явдлууд бий болох гэх мэт.

Хамгаалалтын төлөвлөгөөний эрсдэлийн үнэлгээ хийх нь цикл бүхий боловсруулалттай, байнгын үйл ажиллагааны хяналттай, явцын үнэлэлт дүгнэлтээр дамжин хэрэгждэг. Хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулагчид дараахь зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. (Зураг 4-өөс харна уу) Үүнд:

- Эрсдэлийг үнэлэхийн тулд мэдээ мэдээллийг боловсруулах;
- Хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж болон хязгаарлалтуудыг үнэлэх;
- Үнэлсэн эрсдэлээ бууруулах тактикийн сонголтыг зөв тодорхойлох;
- Давуу болон сул талыг тодорхойлохын тулд тактикийн бүх сонголтуудыг үнэлж дүгнэх;
- Хамгийн зөв тактикийг сонгох, сонгох болсон шалтгаан болон бусдаас нь татгалзах болсон шалтгааныг тэмдэглэж, дүгнэх;
- Байнгын үнэлэлт дүгнэлт өгөх, үр дүнтэй механизмыг нэвтрүүлэх шаардлагатай.

Ийнхүү нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөө нь оновчтой, үр дүнд хүрэхийн тулд дээрх тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг, хүрэх боломж, эрсдэлийн үнэлгээ хийх гэсэн үндсэн хэсгүүдийг өөртөө багтаасан, зайлшгүй шаардлагатай хүчтэй манлайлагч, үр ашигтай менежментээр (менежмент, удирдлага) дамжуулан үр дүнд хүрэх үйл ажиллагаа байдаг. Энэхүү үйл ажиллагааны загварын үндсэн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог дараахь 5 дугаар зургаас харж болно.

Зураг 5. Хамгаалалтын төлөвлөгөөний загвар



Зураг 4. Эрсдэлийн үнэлгээ хийх цикл.

Дээрх зургаас харахад нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын төлөвлөгөөний бүрдэл хэсгүүдийг хооронд нь харьцуулан уялдааг нь харах боломжтой боллоо. Ийнхүү арга хэмжээний үеийн сайн төлөвлөгөөтэй байх, тэрхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нөөц бололцоо болон хязгаарлалтуудын дунд хамгаалалтыг зохион байгуулан ажиллах, мэдээ мэдээллийг боловсруулан ажиллах, төлөвлөгөөг удирдан зохион байгуулах зэрэг харилцан хамаарал бүхий ажиллагаа болох нь харагдана.



**Дүгнэлт, санал.** Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын тухай ойлголт, онолын үндэслэл судлагдсан байдал, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийснээр цаашид боловсронгуй болгох асуудлын хүрээг тодорхойлж, дараахь байдлаар дүгнэлт хийлээ. Үүнд:

Онолын хүрээнд:

1. Онолын хувьд нийтийг хамарсан арга хэмжээний талаар төдийлөн судлагдаагүй. Доктор Д.Таванжингийн тодорхойлолтоос өөр судалгаа хийгдэгүй байна. Өөрөөр хэлбэл цагдаагийн эрх зүйн судлаачдын анхаарлыг хандуулж, энэ чиглэлийн судалгааг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

2. Судлаачийн хувьд дараахь тодорхойлолтыг боловсрууллаа. “Нийтийг хамарсан арга хэмжээ” гэдэг нь **олон хүн цугласан нийтэд хамааралтай, тэдгээрийн анхаарал татахуйц соёл урлаг, спорт, улс төр, баяр наадам, нийгэм эдийн засгийн шинж чанартай олон төрлийн үйл явдлыг хамааруулан ойлгоно.**

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. **Монгол Улсын жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг баримтлан бусад нийтийг хамарсан арга хэмжээг шууд зохицуулах боломжгүй, учир нь тэд бүгд өөр өөрийн гэсэн онцлогтой. Соёл урлаг, спортын, цэнгээнт болон бусад арга хэмжээтэй холбогдох харилцааг бие даасан эрх зүйн зохицуулалтаар зохицуулах нь зүйтэй.**

2. Олон нийтийн аюулгүй байдалд нөлөөлж буй аюул, эмзэг байдал, эрсдэлийн талаарх судалгааг эрсдэл судлалын өнцгөөс шинжлэх нь эрсдэл судлалруу давамгайлсан ялгарах онцлогтой байх болно. Нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдалд нөлөөлж буй эрсдэлийн үнэлгээг дараахь дарааллаар гүйцэтгэх нь зүйтэй юм. 1) Арга хэмжээний аюулгүй байдалд нөлөөлж буй аюул, занал, эмзэг байдал, эрсдэлийг илрүүлэх, шалтгаан, үр дагаврын нарийвчлалыг тооцох; 2) Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу нөхцөл байдлын таамаглал болон магадлалын шинжилгээ, эрсдэлт нөхцөл байдлын дараахь нөлөөллийн шинжилгээ гэх мэт ажиллагааг явуулж шийдвэр гаргахад

зайлшгүй чухал ач холбогдолтой юм.

3. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын түвшинг тогтоох аргачлал, эрсдэлийн үнэлгээ хийх арга зүйг боловсруулж, практикт туршиж, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.





## СҮХБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ХЭРЭГ БҮРТГЭГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Олзбаяр

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэгч,  
хууль зүйн магистр, цагдаагийн ахмад

### **Ажиглалт-зураглалын үзүүлэлт**

Ажиглалт-зураглалд Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн 5 хэрэг бүртгэгчийг хамруулж, ажлын 1 өдрийн зураглал хийлээ. Хүйсээр авч үзвэл эрэгтэй-2, эмэгтэй-3 байлаа. Ажилласан жил, цол зэргээр авч үзвэл цагдаагийн ахмад-2, цагдаагийн байгууллагад 10-12 жил ажиллаж байгаа бөгөөд үүнээс хэрэг бүртгэгчээр 2-4 жил ажиллаж байна. Цагдаагийн ахлах дэслэгч-3, цагдаагийн байгууллагад 4-5 жил ажиллаж байгаа бөгөөд үүнээс хэрэг бүртгэгчээр 2-3 жил ажиллаж байна.

Ажиглалтыг таталган тэмдэглэлээр ажиглагч ба ажиглуулагч нарын хооронд үүссэн харилцааны хэв шинжийг тодруулах зорилготой байсан. Ажиглалтад хамрагдсан 5 хэрэг бүртгэгч ажиглалт хийх саналыг таатай хүлээн авч, өөрсдийн ажлын ачаалал болон нөхцөл байдлыг харуулах эрмэлзэлтэй байсан.

Цаг хугацаагаар хөтөлсөн тэмдэглэлээр хэрэг бүртгэгчийн ажлын цагийн ачааллыг тодруулах зорилго тавьсан. Цаг хугацааны тэмдэглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг хүснэгтээр харуулбал:

№	Хийж гүйцэтгэсэн ажил	Зарцуулсан цаг
1	Рапортонд суух, хоногийн нөхцөл байдлын мэдээтэй танилцах	8.30-10.00
2	Хоногийн хугацаанд материалжуулсан гомдлыг хүлээн авах	10.00-10.10
3	Иргэнээс тайлбар авах, хэргийн оролцогчдыг дуудах, гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаар татаж байцаах	Хэрэг бүртгэгч нарын тайлбар, мэдүүлэг авах цаг хугацаа өөр өөр байсан бөгөөд 1 хүнээс мэдүүлэг авах хугацаа 10-30 минут байсан. Энэхүү ажиллагааг өдрийн туршид хэрэг бүртгэгч бүр гүйцэтгэж байв. Хэрэг бүртгэгч бүр өдөрт тайлбараар 2-6 хүн, хэргийн оролцогчид 1-5 хүн байцаасан. Тайлбар, мэдүүлэг авах дундаж хугацааг нийт хүнд үржүүлэхэд 30-300 минут болж байна.
4	Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авах	Хорооны гэмт хэргийн гаралтаас шалтгаалан 3 хэрэг бүртгэгч 2 хороо, 2 хэрэг бүртгэгч 1,1 хороо хариуцаж ажилладаг бөгөөд хэрэг бүртгэгч нарт 1-4 гомдол шинээр цохогдож байсан. 2 хэрэг бүртгэгч байцаалт авч байсан тул шинээр ирүүлсэн гомдолд иргэнээс тайлбар авалгүй явуулсан. Шинээр ирүүлсэн гомдлыг хүлээн авах, тайлбар авахад 1 хүн дээр 5-20 минут зарцуулсан. Нийт хугацааг бодоход 1 цаг 20 минут
5	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас лавлагаа, тодорхойлолт авах	Албан бичгийг хэрэг бүртгэгч нар өөрсдөө бичиж, бичиг хэргийн эрхлэгчээс дугаар авахад 5-20 минут зарцуулж байсан. Албан бичгийг байгууллагад аваачиж өгөх зарлага цагдаа байхгүй байгаа нь ажилд хүндрэл учруулж байв. Ял шалгах, Эрүүгийн хэргийн төв архиваас лавлагаа авах, эд зүйлийн үнэлгээ хийлгэх, Мобиком, Юнител, Скайтел, Жи мобайл ХХК-д албан бичиг өгөх, хариу авах, шүүх эмнэлэгээс дүгнэлт авах зэрэг ажиллагаа өдөр бүр хийгддэг боловч хариу нь 5-14 хоногт ирдэг нь хамгийн их цаг хугацаа зарцуулдаг, гар дээрх ачааллыг нэмэгдүүлэх шалтгаан болж байв.



6	Хаягаар явах, хэргийн оролцогчыг олох	Ажиглалтын өдөр энэхүү ажиллагаа хийгдээгүй. Хэрэг бүртгэгч нараас гадуур явсан хүн байхгүй
7	Эрүүгийн цагдаагийн тасагт эрэн сурвалжлах тогтоол, хэрэг бүртгэгчийн даалгавар өгөх	2 хэрэг бүртгэгч эрүүгийн цагдаагийн тасагт даалгавар өгсөн. Даалгавар бичих техник ажиллагаанд 5-10 минут зарцуулсан
8	Асап санд алдагдсан эд зүйл, хүн эрэн сурвалжлах	Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах Асап санд алдагдсан эд зүйл, хүн эрэн сурвалжлахад 5-10 минут зарцуулагдаж байв. 3 хэрэг бүртгэгч Асап санд эд зүйл эрэн сурвалжилсан.
9	Хэрэг материалын санал гаргах, товъёоглох, үдэх, тасгийн даргаар батлуулах	Хэрэг, материалын тогтоол, санал гаргах ажиллагаанд 5-10 минутыг зарцуулах бөгөөд үдэх, товъёоглох ажиллагаанд 10-15 минут, тасгийн даргаар батлуулах ажиллагаанд 5-10 минут зарцуулж байсан.
10	Прокуророор явах, хэрэг материал хүлээлгэж өгөх, эрүүгийн хэргийн дугаар авах, гомдол хэрэг танилцуулах, хугацаа сунгах	Тус хэлтэс нь дүүргийн прокурортой ойр зайд буюу 800 орчим метр зайд оршидог бөгөөд прокурорлуу алхаж явахад 5-15 минут зарцуулсан. Хэрэг хүлээлгэж өгөх, дугаар авах, прокуроруудтай уулзах, хугацаа сунгах зэрэгт 30-60 минутын хугацаа зарцуулсан.
11	Байцаан шийтгэх тодорхой ажиллагаа хийж гүйцэтгэх /үзлэг, нэгжлэг, таньж олуулах, нгүүрэлдүүлэн байцаах, хураан авах/	Хэрэг бүртгэгч нар эд зүйл хураан авах, хүлээлгэн өгөх ажиллагааг хийж гүйцэтгэж байсан бөгөөд бусад байцаан шийтгэх ажиллагааг гүйцэтгээгүй. Энэхүү ажиллагаанд 10-20 минут зарцуулж байв.
12	Цагдаагийн байгууллагын нэгдсэн санд гомдол, хэргийн шийдвэрлэлт, хохирогч, хохирол, сэжигтэн, яллагдагч, хохирол нөхөн төлүүлэлт, таслан сэргийлэх арга хэмжээний бүртгэл зэргийг шивих	Цагдаагийн байгууллагын санд мэдээлэл шивж оруулахад 1 хэргийн хувьд бүх картыг шивихэд 5-10 минут, гомдлын шийдвэрлэлт 3-5 минут зарцуулж байв.

Дээрх ажиглалтаас үзэхэд, хэрэг бүртгэгчийн ажлыг тогтсон хугацаагаар үнэлэх боломжгүй бөгөөд нэг ажиллагааг гүйцэтгэж байхад шинээр өргөдөл ирэх, дуудсан хэргийн оролцогч ирэх, төлөвлөөгүй ажил /албан бичиг хүргэх, хариу авах, камерын бичлэг очиж шүүх, үзлэг хийх/ гарч ирэх тохиолдол их байна. Хэрэг бүртгэгч нар прокурорруу 17 цагт явж, гомдлын хугацаа сунгуулах, хэрэг, материал танилцуулах зэргээр 1 цагийг прокурорт зарцуулж байна. Прокуророос буцаж ирээд хэрэг бүртгэгчид дахин иргэнээс тайлбар, хэргийн оролцогчоос мэдүүлж авах, албан бичиг төлөвлөх, цагдаагийн байгууллагын санд мэдээлэл оруулах зэрэг ажиллагааг хийж байсан. Хамгийн эрт явсан хэрэг бүртгэгч 18 цаг 30 минут, хамгийн орой явсан хэрэг бүртгэгч 21 цаг хүртэл ажилласан. Үүнээс харахад, хэрэг бүртгэгч дунджаар өдөрт ажиллах 8 цагаас 1-3 цагаар илүү ажиллаж байна. Хэрэг бүртгэгч нийт гүйцэтгэсэн ажлын 85 хувийг өрөөндөө хүн асуух, байцаах, хойшлуулашгүй болон байцаан шийтгэх ажиллагаа явуулах, компьютер дээр юм шивэх ажилд зарцуулсан. Мөн хэрэг бүртгэгч нарын нэг ажиллагааг хийж гүйцэтгэх хугацаа нь ажилласан жил, туршлага зэргээс шалтгаалан харилцан адилгүй байсан.

5 хэрэг бүртгэгчээс 2 нь цайндаа гадуур гарч хооллосон бөгөөд үүнд 40 минутаас 1 цаг зарцуулсан. Харин 3 хэрэг бүртгэгч цайны цагаар гаралгүй өрөөндөө хооллосон. Ажиглалтанд оролцсон хэрэг бүртгэгч нарын ажлын байрны нөхцөл хэвийн, хэрэг бүртгэгч нар 2,2-оороо нэг өрөөнд суусан, компьютер, принтерээр хангагдсан байсан.

Хэрэг бүртгэгч нарын өдөрт хийсэн ажлыг ажиглахад харилцаа, хэл ярианы чадвар, унших, бичих, техник хэрэгслийг ашиглах чадвар, түргэн шуурхай ажиллах, өөрийгөө хурдан хугацаанд тайвшруулах сэтгэл зүйн бэлтгэлжилт, өөрийгөө хянах, ачааллаа тэнцвэржүүлэх, хувийн зохион байгуулалт өндөр байхыг тус тус шаардаж байгаа нь харагдаж байв. Мөн хууль эрх зүйн мэдлэгийг хамгийн их шаардаж байв.

Хэрэг бүртгэгч нарын иргэдтэй харьцах харьцаанд ажиглалт хийхэд бусдад үзэл бодлоо тулгадаг байдал давамгайлалт илрэх бөгөөд иргэд, хэрэг бүртгэгч нарын хооронд зөрчилдөөн гарах шалтгаан болох хандлагатай. Үг хэллэгийн хувьд албархаг, үгээ зөв сонгодог, харилцааны байр суурийн хувьд албархаг, нөхцөл байдалдаа зохицсон байдал давамгайлалт харагдаж байв.



Ажиглалтын үр дүнг дүгнэхэд, хэрэг бүртгэгч нар нийт ажлын цагийн 65 хувийг иргэн асуух, хэргийн оролцогч байцаах, 25 хувийг албан бичиг төлөвлөх, цагдаагийн мэдээллийн сантай ажиллах техник ажиллагаа, 10 хувийг гадуур ажиллах, явах ажилд зарцуулж байна.

Статистик мэдээнд тулгуурласан судалгаа:

Судалгааны ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1,2 дугаар хэлтсийг сонгон авч өнөөгийн нөхцөл байдлын талаар дүн шинжилгээ хийсэн бөгөөд Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1-р хэлтэст ахлах хэрэг бүртгэгч-1, хэрэг бүртгэгч-5, хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий алба хаагч 9, нийт 14 алба хаагч тус дүүргийн 1-9 хорооны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна. Тус хэлтэс нь нийслэлийн хотын төв хэсэгт байрлаж, Чингэлтэй дүүргийн 1-9 дүгээр хорооны 279,2 га хавтгай талбайг хариуцаж байгаа ба 6 хороо нь төвийн байшин хороолол эзэлж байна. Аж үйлдвэрийн бүс байхгүй, дунд хэмжээний оёдол, сүлжмэлийн үйлдвэрүүдтэй, төрийн яам, тамгын газар, олон нийтийн байгууллага, хувийн томоохон компани, банк, худалдаа, үзвэр үйлчилгээний газруудын барилга байгууламжууд олноор байрладаг.

Чингэлтэй дүүргийн хүн амын 47.8 хувь нь 1-9 дүгээр хороонд 23727 өрхийн 100,061 хүн оршин суудаг. Иргэдээс ирүүлж буй гомдол мэдээллийн дийлэнх хувийг халаасны хулгай, алдуул, гээгдэл санамсаргүй олдсон эд зүйлийг завшиж үрэгдүүлэх, залилан, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах, борлуулах зэрэг гомдол мэдээлэл эзэлдэг байна.

2015, 2016 онд тус хэлтэст хүлээн авч шалгасан хөнгөн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгасан алба хаагчаар нь харьцуулбал<sup>[86]</sup>:

ЧД-1 2015		Гомдол		Сарын дундаж ачаалал		Хэрэг		Сарын дундаж ачаалал	
		2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015
1.	Хэрэг бүртгэгч-6	1979	2356	29.9	35.6	505	921	7,6	13.9
2.	Эрх бүхий алба хаагч нар-9	686	680	6,9	6.8	82	131	0,82	1,3
Нийт		<b>2665</b>	<b>3036</b>			<b>587</b>	<b>1052</b>		

Чингэлтэй дүүргийн цагдаагийн 2-р хэлтэст ахлах хэрэг бүртгэгч-1, хэрэг бүртгэгч-4, хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий алба хаагч 10, нийт 15 алба хаагч тус дүүргийн 10-19 хорооны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна. Тус хэлтэс нь Чингэлтэй дүүргийн 10-19 дүгээр хорооны 8616,6 га хавтгай талбайг хариуцаж байгаа ба гэр хороолол, зуслангийн газар эзэлж байна. Томоохон зах, худалдааны төв, мал бүхий иргэд, гэр хороолол, сургууль, цэцэрлэг байрладаг.

Чингэлтэй дүүргийн хүн амын 52,2 хувь нь 10-19 хороонд 20890 өрхийн 102,493 хүн оршин суудаг. Иргэдээс ирүүлж буй гомдол мэдээллийн дийлэнх хувийг бусдын биед гэмтэл учруулах, гэр бүлийн хүчирхийлэл, хулгайн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлдэг байна.

2015, 2016 онд тус хэлтэст хүлээн авч шалгасан хөнгөн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгасан алба хаагчаар нь харьцуулбал:

ЧД-2 2015		Гомдол		Сарын дундаж ачаалал		Хэрэг		Сарын дундаж ачаалал	
		2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015
1.	Хэрэг бүртгэгч-5	991	878	18	15,9	302	354	5,4	6,4
2.	Эрх бүхий алба хаагч нар-10	189	367	1,7	3,3	23	28	0,2	0,2
Нийт		<b>1180</b>	<b>1212</b>			<b>325</b>	<b>382</b>		

Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1-р хэлтэст ахлах хэрэг бүртгэгч-1, хэрэг бүртгэгч-6, хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий алба хаагч 8, нийт 15 алба хаагч тус дүүргийн 1-8 дугаар

<sup>86</sup> Цагдаагийн ерөнхий газар. Гэмт хэрэг, зөрчлийн цагаан мэдээ. (2015,2016). Улаанбаатар хот.



хорооны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна. Тус хэлтэс нь нийслэлийн хотын төв хэсэгт байрлах бөгөөд Сүхбаатар дүүргийн 1-8 дугаар хорооны 584,84 га хавтгай талбайг хариуцаж, 8 хороог төвийн байшин хороолол буюу орон сууц, үйлчилгээний төв, зах худалдааны төв эзэлж байна. Аж үйлдвэрийн бус байхгүй, төрийн яам, тамгын газар, олон нийтийн байгууллага, зочид буудал, хувийн томоохон компани, банк, худалдаа, үзвэр үйлчилгээний газруудын барилга байгууламжууд байрладаг.

Сүхбаатар дүүргийн хүн амын 34,2 хувь болох 53,977 хүн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг. Иргэдээс ирүүлж буй гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн дийлэнх хувийг халаасны хулгай, алдуул, гээгдэл санамсаргүй олдсон эд зүйлийг завшиж үрэгдүүлэх, залилан, иргэдийн өмчийн эсрэг үйлдэгддэг гомдол мэдээлэл эзэлдэг байна.

2015, 2016 онд тус хэлтэст хүлээн авч шалгасан хөнгөн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгасан алба хаагчаар нь харьцуулбал:

СБД-1		Гомдол		Сарын дундаж ачаалал		Хэрэг		Сарын дундаж ачаалал	
		2016	2015	2016	2015	2016	2015	2016	
1.	Хэрэг бүртгэгч-7	2479	2390	32,1	31	960	966	12,4	12,5
2.	Эрх бүхий алба хаагч нар-8	961	68	10,9	0,7	167	17	1,8	0,2
Нийт		<b>3440</b>	<b>2458</b>			<b>1127</b>	<b>983</b>		

Сүхбаатар дүүргийн цагдаагийн 2-р хэлтэст ахлах хэрэг бүртгэгч-1, хэрэг бүртгэгч-4, хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий алба хаагч 12, нийт 16 алба хаагч тус дүүргийн 9-20-р хорооны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна. Тус хэлтэс нь Сүхбаатар дүүргийн 9-20 дугаар хорооны 563,04 хавтгай талбайг хариуцаж байгаа ба гэр хороолол, зуслангын газар эзэлж байна.

Сүхбаатар дүүргийн хүн амын 65,7 хувь болох 109,610 хүн 10-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг. Иргэдээс ирүүлж буй гомдол мэдээллийн дийлэнх хувийг бусдын биед гэмтэл учруулах, орчиндоо аюул учруулах амьтаныг зохих хамгаалалтгүй байлгасан, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлдэг байна.

2015, 2016 онд тус хэлтэст хүлээн авч шалгасан хөнгөн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгасан алба хаагчаар нь харьцуулбал:

СБД-2		Гомдол		Сарын дундаж ачаалал		Хэрэг		Сарын дундаж ачаалал	
		2016	2015	2016	2015	2016	2015	2016	
1.	Хэрэг бүртгэгч-5	1050	1612	19	29,3	364	567	6,6	10,3
2.	Эрх бүхий алба хаагч нар-12	1124	828	8,5	6,2	124	130	0,9	0,9
Нийт		<b>2174</b>	<b>2440</b>			<b>488</b>	<b>697</b>		

Дээрх судалгаанаас үзэхэд, цагдаагийн 1-р хэлтсүүдийн хэрэг бүртгэгч нар нь 2 дугаар хэлтсийн хэрэг бүртгэгч нараасаа шалгасан гомдол, хэргийн хувьд илүү ачаалал авч ажиллаж байгаа нь харагдах бөгөөд газар нутгийн хэмжээ болон хүн амын тооноос шалтгаалахгүйгээр иргэдийн хөл хөдөлгөөн цуглардаг үйлчилгээний төв, баар ресторан, зочид буудал, төрийн болон төрийн бус байгууллага их байгаа газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байна.

Мөн хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий алба хаагч болох 4 цагдаагийн хэлтсийн 39 хэсгийн байцаагч сард гэмт хэргийн шинжтэй 1-10 гомдол мэдээлэл, 1-2 эрүүгийн хэрэг шалгаж байна.

Санал асуулгын судалгааны үр дүн.



Хоёр дүүргийн 4 цагдаагийн хэлтэст ажиллаж буй нийт 23 хэрэг бүртгэгчээс ажлын ачааллын талаар санал асуулга авсан бөгөөд судалгаанд оролцсон хэрэг бүртгэгчийг насны ангиллаар авч үзэхэд:

Судалгаанаас үзэхэд хэрэг бүртгэгч нар насны хувьд харьцангуй залуу буюу 100 хувь 40 хүртлэх настай байна. Энэ нь цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч нар залуу, ажиллах эрч хүчтэй, ажиллах чадвартай боловсон хүчнээр хангагдсан гэж харагдаж байна.

Алба хаагчдын хүйс /хувиар/




хэлтсийн хэрэг бүртгэх тасаг бүрээс 1 хэрэг бүртгэгчийг ахлах хэрэг бүртгэгчийн орон тоонд шилжүүлэн ажиллуулах болсноор судалгаанд хамрагдсан 23 хэрэг бүртгэгчээс 4 буюу 17,3 хувь нь ахлах хэрэг бүртгэгч, 19 буюу 82,6 хувь нь хэрэг бүртгэгч албан тушаалд ажиллаж байна.

Хэрэг бүртгэгч нараас авсан санал асуулгаар ажиллаж байгаа дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хэрхэн үнэлэх талаарх асуулгад 1 буюу 4,3 хувь нь ердийн түвшинд, 18 буюу 78,2 хувь нь хүнд түвшинд, 4 буюу 17,3 хувь нь маш хүнд гэж хариулсан байна.


Өдөрт хэдэн цаг ажилладаг талаарх судалгаанд: 1 хэрэг бүртгэгч 8 цаг, 12 хэрэг бүртгэгч 9-10 цаг, 10 хэрэг бүртгэгч 11 цаг ба түүнээс дээш цагаар ажилладаг гэж хариулжээ.

Судалгаанаас харахад, 1 хэрэг бүртгэгч л хөдөлмөрийн хуульд заасан өдрийн 8 цаг

Насны ангилал /хувиар/



Боловсролын түвшин /хувиар/




Судалгаанаас харахад хэрэг бүртгэгч нар жендерийн байдал тэгш байгаа бөгөөд хэрэг бүртгэгч нар ихэвчлэн эмэгтэй байдаг гэдэг ойлголтоор ханддаг байсан хандлага өөрчлөгдсөн болох нь харагдаж байна.

Судалгаанаас харахад хэрэг бүртгэгч нар насны хувьд харьцангуй залуу байгаа бөгөөд бакалаврын зэргийн боловсролтой хэрэг бүртгэгчид 65,2 хувийг эзэлж байгаагаас үзвэл хэрэг бүртгэгч нарыг чадавхжуулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

2016 оны 03-р сарын 15-ны өдрөөс Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар дүүргүүдийн цагдаагийн

Илүү ажилласан цаг хувиар



ажилладаг, 12 хэрэг бүртгэгч буюу 52,1 хувь нь 1-2 цагаар илүү ажилладаг, 10 хэрэг бүртгэгч буюу 43,4 хувь нь 3 буюу түүнээс



дээш цагаар илүү ажилладаг болох нь харагдаж байна.



Хэрэг бүртгэгч нараас ажлын ачаалал ихтэй ажилладаг эсэх талаарх санал асуулгад 1 буюу 4,3 хувь нь ажлын ачаалал хэвийн гэж үзсэн бол 22 буюу 95,6 хувь нь ажлын ачаалал ихтэй гэж үзсэн байна.


Ажилдаа сэтгэл хангалуун байдаг эсэхийг судлахад 10 буюу 43,4 хувь нь сэтгэл хангалуун, 11 буюу 47,8 хувь нь сэтгэл хангалуун биш, 2 буюу 8,6 хувь нь дунд

зэрэг гэж хариулсан байна.



Судалгаанаас үзвэл хэрэг бүртгэгч нар ажилдаа хандах хандлага, ажлын үр бүтээл, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үйлчилгээгээ үзүүлэхдээ 47,8 хувь нь сэтгэл хангалуун бус байгаа нь хууль зөрчих, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилго хангагдахгүйд хүрч байна.


Сэтгэл хангалуун бус байгаа шалтгаанаа тайлбарлахдаа:



Судалгаанаас харахад хэрэг бүртгэгчийн ажилдаа сэтгэл хангалуун бус байгаа шалтгаан ажлын ачааллаас үүдэлтэй байгаа бөгөөд цаашид хэрэг бүртгэгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын үр бүтээмжийг дээшлүүлэх, ажилдаа дур сонирхолтой, сэтгэлээсээ хийх урам зоригтой болгох арга хэмжээг авах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Хэрэг бүртгэгчийн ажлын ачаалал ямар учраас их байгаа гэж үзэж байна бэ асуулгад:





Судалгаанаас харахад хэрэг бүртгэгчийн ажлын ачааллыг хэрэг бүртгэгчийн орон тоо хүрэлцэхгүй байна гэж 19 буюу 82,6 хувь нь үзсэн байна. Мөн бусад шалтгаанаа тайлбарлахдаа зарим арга хэмжээнд олон цагаар татан оролцуулдаг гэж 2 буюу 8,6 хувь нь, дүүргийн нутаг дэвсгэрийн хувьд онцлог том аж ахуйн нэгж ихтэй, хүний хөдөлгөөн ихээр цуглардаг гэж 1 буюу 4,3 хувь нь, өргөдөл, гомдол маш их гэж 1 буюу 4,3 хувь нь тус тус үзсэн байна.

Хамгийн их цаг хугацаа шаарддаг ажлыг ихээс багаруу эрэмбэлж, зарцуулах цаг хугацааг бичих асуулгад:

1. Лавлагаа тодорхойлолт авах- 23 буюу 100 хувь хамгийн их цаг хугацаа зарцуулдаг ажлаар сонгосон бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас авах лавлагаа, албан бичгийн хариу 3-14 хоногийн хугацаа зарцуулдаг нь хэрэг бүртгэгчийн гар дээрх гомдол, хэргийн ачааллыг нэмэгдүүлдэг гэж үзсэн.
2. Шаардлагатай хүмүүсийг олж ирэх, хаягаар явах- 18 буюу 78,2 хувь нь хаягаар явах, шаардлагатай гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг олоход 2-4 цаг зарцуулдаг тул ачааллыг нэмэгдүүлэх шалтгаан гэж үзсэн.
3. Тайлбар, мэдүүлэг авах-15 буюу 65,2 хувь нь гомдол мэдээлэлд иргэн албан тушаалтнаас тайлбар авах, эрүүгийн хэрэгт оролцогчдоос мэдүүлэг авах ажиллагааг цаг хугацаа их зарцуулдаг гэж үзсэн бөгөөд хэргийн оролцогчидоос мэдүүлэг, иргэнээс тайлбар авахад 1 хүнд 20-40 минутын цаг хугацаа зарцуулдаг байна.
4. Байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах- 10 буюу 43,4 хувь нь байцаан шийтгэх ажиллагаа явуулахад 10-40 минут зарцуулдаг гэж үзсэн байна.

5. Хэрэг материал прокурорт танилцуулах, хүлээлгэн өгөх, дугаар авах- 9 буюу 39,1 хувь нь 30-60 минут зарцуулдаг.

6. Хэрэг материал товъёоглох-7 буюу 30,4 хувь нь 10-30 минут зарцуулдаг.

7. Тогтоол санал гаргах-5 буюу 21,7 хувь нь нь 5-20 минут зарцуулдаг гэжээ.

Хэрэг бүртгэгчийн ажлын ачааллыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх санал санаачлагатай ажил, арга хэмжээний талаар өөрийн саналаа хуваалцах асуулгад: Хэрэг бүртгэгчийн ажлын байрны орон тоог нэмэгдүүлэх гэж 19 буюу 82,6 хувь нь, эргүүл, жижүүр, хамгаалалтанд татах, ажлын байрны тодорхойлолтонд тусгагдаагүй ажил үйлчилгээ болох хамтарсан багийн ажилд оролцуулахгүй байх гэж 6 буюу 26 хувь нь, хэрэг бүртгэгч нарт ачааллыг зөв хуваарилах гэж 3 буюу 13 хувь, 1 хэрэг бүртгэгчийг 1 хороо хариуцан ажиллуулах арга хэмжээ авах гэж 1 буюу 4,3 хувь, иргэд өөрсдөө анхаарал, сонор сэрэмжтэй байх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хийх гэж 1 буюу 4,3 хувь, ажиллах нөхцөл байдлыг сайжруулах гэж 1 буюу 4,3 хувь, хэсгийн байцаагч, эрүүгийн төлөөлөгчөөр хэрэг, материал шалгуулах гэж 1 буюу 4,3 хувь нь тус тус саналаа гаргасан байна.

Ярилцлагын судалгааны дүн:

Хэрэг бүртгэгчийн ажлын байрны онцлог, өнөөгийн нөхцөл байдал, ажлын ачааллыг судлах, ажлын ачааллыг бууруулах, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор 2 дүүргийн 4 цагдаагийн хэлтсийн нийт 3 ахлах хэрэг бүртгэгч, 19 хэрэг бүртгэгчийн дунд ярилцлага зохион байгуулав. Ярилцлагыг хэлтэс бүрт очиж дараах нийтлэг асуултыг асууж ярилцсан. Үүнд:



1. Хэрэг бүртгэгчийн ажлын ачаалал ямар түвшинд байна вэ?
2. Ажлын ачаалал их бол ямар учраас их гэж үзэж байна вэ?
3. Ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үйлчилгээгээ мэдэх үү?
4. Ажлын байрны тодорхойлолтонд заагдсанаас өөр ажил үйлчилгээ хийдэг үү?
5. Ажил гүйцэтгэж байхад дарга, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэхэд ямар хугацаа зарцуулдаг вэ?
6. Ажлын ачаалал ямар учраас нэмэгдээд байна вэ?
7. Ажлын ачаалал гэдгийг хэрхэн юу гэж ойлгож байна вэ?
8. Ажлын ачааллыг бууруулах таны санал юу байна бэ? гэсэн асуултын хүрээнд ярилцаж, тэмдэглэл хөтөлсөн болно.

Ярилцлагаар 22 алба хаагчаас 21 буюу 95,4 хувь нь ажлын ачаалал ихтэй гэж үзсэн бөгөөд өргөдөл гомдол, хэрэг ихтэй, цаг чөлөө, амралт байхгүй, иргэд болон прокурорын зүгээс дарамт ихтэй, ажил хийхэд их стресстэй, илүү цагаар байнга ажилладаг болохоор ажлын ачаалал ихтэй гэж хариулсан. Ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үйлчилгээг мэдэх үү? гэсэн асуултанд 100 хувь гомдол мэдээлэл шалгах, хөнгөн хэрэг шалгах, ахлах хэрэг бүртгэгч нарын хувьд түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийг хариуцах гэж хариулсан боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үйлчилгээ бүрийг заалт бүрээр мэдэхгүй байсан.

Ажлын байрны тодорхойлолтод заагдснаас өөр ажил үйлчилгээг хийдэг эсэх талаар ярилцахад 20 буюу 86,9 хувь нь эргүүл, шалгалт, хамгаалалтанд тогтмол татаж ажилуулдаг, АСЕМ, наадам, шинэ жил, сар шинийн баяруудад тогтмол хамгаалалт, эргүүлд олон цагаар ажиллуулдаг. Энэ хугацаанд гомдол, хэрэгт ямар нэг ажиллагаа хийх боломжгүй байдаг тул хугацаа алддаг. 2 буюу 9 хувь нь хамтарсан баг гэж хэлтэст байгуулж, нэмэгдэл үүрэг хүлээлгэдэг. Дарга удирдлагаас үүрэг өгөхөд ямар хугацаа зарцуулдаг талаар ярилцахад хэрэг бүртгэгч нар тухайн бичиг, төлөвлөгөөний биелэлт хааяа өгдөг гэж 1 буюу 4,5 нь хариулсан бол 3 ахлах хэрэг бүртгэгчийн хувьд тасгийн хугацаатай бичиг, төлөвлөгөөний биелэлт зэргийг тогтмол гаргадаг, ирсэн бичгийн нөхцөл байдлаас хамаарч хугацаа зарцуулдаг тул хугацааг тодорхойлох боломжгүй гэж хариулсан. Ажлын ачаалал ямар учраас

нэмэгдэж байгаа талаар ярилцахад худалдаа үйлчилгээний төвүүд нэмэгдэж, хүний хөл хөдөлгөөн ихэссэн гэж 6 буюу 27,2 хувь нь, ухаалаг гар утас хүн бүр ашигладаг болсон бөгөөд үүнийг дагаад гэмт хэрэг ихэссэн гэж 13 буюу 59 хувь нь, иргэд анхаарал болгоомжгүй байдлаасаа болж гар утас, эд зүйлээ мартаж гээх асуудал их болсон гэж 2 буюу 9 хувь нь, хэрэг бүртгэгчийн орон тоо дутуу гэж 21 буюу 95,4 хувь нь хариулсан. Ажлын ачаалал гэдгийг хэрхэн юу гэж ойлгож байгаа талаар ярилцахад амралт байхгүй, маш их гомдол хэрэг шалгадаг гэж 15 буюу 68,1 хувь нь хариулсан бөгөөд амралтгүй, илүү цагаар байнга ажиллаж байгааг ажлын ачаалал гэж ойлгож байгаа нь харагдаж байв. Ажлын ачааллыг бууруулахад ямар арга хэмжээ авах талаар ярилцахад хэрэг бүртгэгчийн ажлын байрны орон тоог нэмэгдүүлэх гэж 19 буюу 82,6 хувь нь, эргүүл, жижүүр, хамгаалалтанд татах, ажлын байрны тодорхойлолтонд тусгагдаагүй ажил үйлчилгээ болох хамтарсан багийн ажилд оролцуулахгүй байх гэж 6 буюу 26 хувь нь, хэрэг бүртгэгч нар ачааллыг зөв хуваарилах гэж 3 буюу 13 хувь, 1 хэрэг бүртгэгчийг 1 хороо хариуцан ажиллуулах арга хэмжээ авах гэж 1 буюу 4,3 хувь, иргэд өөрсдөө анхаарал, сонор сэрэмжтэй байх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хийх гэж 1 буюу 4,3 хувь, ажиллах нөхцөл байдлыг сайжруулах гэж 1 буюу 4,3 хувь, хэсгийн байцаагч, эрүүгийн төлөөлөгчөөр хэрэг, материал шалгуулах гэж 1 буюу 4,3 хувь нь хариулж байв.

### Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгчийн ажлын ачааллын өнөөгийн байдалд хийсэн дээрх судалгаануудаас үзэхэд хэрэг бүртгэгч нар өөрсдийн ажиллаж байгаа нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хүнд, ажлын ачаалал ихтэй, ажил хийхэд стресс ихтэй гэж үзэж байгаа нь харагдаж байгаа бөгөөд ажлын ачааллыг бууруулах, хэрэг бүртгэгчийн орон тоог нэмэгдүүлэх санал хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Гэхдээ хэрэг бүртгэгч нар ажлын ачаалал их гэдгийг хэрхэн, юу гэж тайлбарлах тал дээр нэгдсэн ойлголт байхгүй байгаа бөгөөд амралт байхгүй, стресс ихтэй, ажлын цаг их гэдэг үзүүлэлтийг ажлын ачаалал гэж ойлгож байгаа нь харагдаж байна.

Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгчийн ажил үйлчилгээ чанартай, түргэн шуурхай байх нь цагдаагийн байгууллагын нэр хүнд, цагдаагийн байгууллагад иргэдийн зүгээс



итгэх итгэлтэй шууд хамааралтай гэдэг нь цагдаагийн байгууллагад ирүүлсэн гомдол, хэргийн тоон үзүүлэлтээс шууд харагдаж байна. Гэтэл хэрэг бүртгэгч нараас авсан судалгаагаар ажилдаа сэтгэл хангалуун байдаг эсэхийг судлахад 10 буюу 43,4 хувь нь сэтгэл хангалуун, 11 буюу 47,8 хувь нь сэтгэл хангалуун биш, 2 буюу 8,6 хувь нь дунд зэрэг гэж хариулсан байна. Үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч тухайн албан тушаалдаа сэтгэл хангалуун бус байгаа нь ажлын үр бүтээл, байгууллагын нэр хүндэнд сөргөөр нөлөөлөх гол шалтгаан болох тул алба хаагчдыг албандаа сэтгэл зүрхтэй, ажилдаа дур сонирхолтой, ард иргэдийнхээ амар тайван амьдралын төлөө хоёргүй сэтгэлгээр зөвхөн хуулинд захирагдан хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсэн эрхийг сэргээж, гэмт буруутай этгээдэд зохих хариуцлагыг хүлээлгэн ажиллахын тулд зайлшгүй шударга байж, хэн нэгнээс хараат бус, ганцхан хуульд захирагдах зарчмыг хангаж ажиллах нөхцөл боломжыг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

Иймд цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгчийн ажлын ачаалал их байгаа нь алба хаагчын эрүүл мэнд, эрх нь зөрчигдсэн иргэдийн эрхийг ханган хамгаалах, гэм буруутай этгээдэд зохих ял шийтгэлийг шударгаар оногдуулахад болон байгууллагын дэвшүүлэн зорилгод хүрэхэд сөргөөр нөлөөлөх шалтгаан болж байгаа тул ажлын ачааллыг бууруулахын тулд ямар арга хэмжээ авах, хэрэг бүртгэгчийн ажлыг хэрхэн яаж зохион байгуулах шаардлагатай байгаа талаар авч үзэх шаардлага урган гарч ирж байна.

**КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ****ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
БАЙГУУЛЛАГА БОЛОН ХУУЛЬ  
САХИУЛАХ БУСАД БАЙГУУЛЛАГУУДЫН  
АЖЛЫН УЯЛДАА, ЭРХ ЗҮЙН  
ЗОХИЦУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ТЕХНИК,  
ТЕХНОЛОГИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

Т.Очирбат

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газрын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн хурандаа

Шүүхийн шинжилгээний байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нотлон тогтоох ажилд хуулиар хүлээсэн үүргийн дагуу хувь нэмрээ оруулсаар ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд шүүхийн шинжилгээтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд, тухайлбал шинжилгээний чанар, стандарт, хугацаа, бүртгэл, лавлагаа, объектын бүрэн бүтэн байдалд анхаарал хандуулсны хүчинд мэдэгдэхүйц ахиц гаргасан байна. Гэвч эрх зүйн зохицуулалт, байгууллагуудын уялдаа холбоо, бүтэц, зохион байгуулалт, сургалт, хүний нөөц буюу гадаад хүчин зүйлээс хамаарсан тулгамдсан асуудлууд байсаар байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2013 онд 57980 шинжилгээ хийсэн нь өмнөх оныхоос 3,58 хувиар өссөн байна. Нийт шинжилгээг чиглэлээр нь авч үзвэл 14 хувийг криминалистикийн шинжилгээ, 20 хувийг хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ, 66 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ эзэлж байна<sup>[87]</sup>. Мөн Шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчид улсын хэмжээнд 28728 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бол шинжээч эмч нар 3669хэргийн газрын үзлэгт оролцсон байна<sup>[88]</sup>. Тус байгууллага Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний

<sup>87</sup> Шүүх шинжилгээний статистик. УБ., 2013. 4 дэх тал.

<sup>88</sup> Шүүх шинжилгээний статистик. УБ., 2013. 34 дэх тал.

тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын дагуу үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа боловч гэмт хэргийн өсөлт, гэмт үйлдлийн шинж, нийгмийн бусад өөрчлөлттэй холбоотойгоор тулгамдаж байгаа олон асуудал байна. Эдгээр асуудлууд нь хуулийн болон хууль сахиулах бүхий л байгууллагуудын өмнө тулгарч байгаа асуудлууд гэж үзэж болох бөгөөд энэхүү судалгааны ажлаар зөвхөн шүүх шинжилгээ хийхтэй холбоотой зарим асуудлыг авч үзлээ. Тулгамдаж буй асуудлуудыг хоорондоо уялдаа холбоо бүхий 5 үндсэн чиглэлд багцлан хувааж үзэж болохоор байна.

1. Эрх зүйн зохицуулалт, байгууллагын уялдаа холбооны асуудал
2. Бүтэц, зохион байгуулалтын асуудал
3. Сургалт, хүний нөөцийн асуудал
4. Техник, технологийн асуудал
5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, түүний үр шимийн тухай асуудал

Дээрх тулгамдаж байгаа асуудлуудаас Эрх зүйн зохицуулалт, байгууллагын уялдаа холбооны асуудал, Сургалт, хүний нөөц, Техник, технологийн асуудлыг нэн даруй шийдэх шаардлагатай гэж үзэж энэхүү илтгэлд орууллаа.

**ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,  
БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА  
ХОЛБООНЫ АСУУДАЛ:**

Шүүх шинжилгээ хийхтэй холбоотой, цаашилбал гэмт хэргийг илрүүлж, нотлохтой холбоотой харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актууд нь байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж чадахгүй байна, Хангаж чадаж байлаа чхуулийг хэрэгжүүлж, хуулийн заалтыг зөв ойлгож ажиллаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нэгэнтээ хэлсэнчлэн “хуулийн байгууллагууднь байшин барилгынхаа бохирын шугамаар холбогдож байгаагаас бус алба хаагчдын уураг тархиар холбогдохгүй байна” гэж үзэж болох юм. Энэ нь дараахь үйл ажиллагаануудад илэрхий ажиглагдаж, ажлын доголдол үүсгэж байна.

Лавлагаа мэдээлэл;хэргийг шийдвэрлэх явцад сэжигтэн, бусад эд зүйл, танигдаагүй цогцосны талаарх лавлагаа мэдээлэл олж авах, солилцох механизм тааруу байгаагаас хэрэг мөрдөх чиг үүрэг бүхий албан хаагчдад хүндрэл үүсгэж, цаг алдахад хүргэж байна. Аймаг, нийслэлийн ЦГ, ЦХ-



үүдийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нартай уулзаж судалгаа явуулахад “хэргийг шалгах явцад байгууллагуудаас сэжигтний талаар лавлагаа авахад маш их цаг хугацаа зарцуулж байна” гэжээ.

Хэргийг шалгах явцадхууль сахиулах байгууллагын албан хаагчЦагдаагийн албаны тухай хуулийн 29-р зүйлд заасан 21 төрлийн лавлагаанаас гадна УЕП-ын Эрүүгийн хэргийн төв архиваас эрүүгийн хэргийн лавлагаа, ШШҮХ-ээс гарын хээний лавлагаа, сум, хонгио, генетикийн мэдээлэлийн лавлагаа, нэр хаяг тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцосны лавлагаа авч байна. Мөн бусад 18 байгууллагаас лавлагаа авах шаардлага тулгардаг. Тухайлбал,

- УБЕГ-аас иргэн, хуулийн, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа,

- Татварын ерөнхий газраас өр, аж ахуйн нэгж, үйл ажиллагааны лавлагаа,

- Арилжааны 16 банкнаас данс эзэмшигчийн, дансны үлдэгдлийн гэх мэт,

- Нийгмийн даатгалын газраас даатгал төлж байгаа эсэх талаар,

- Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас Монгол Улсын хилээр нэвтэрсэн эсэх талаар,

- ШШГЕГ-аас ял шийтгэл эдэлж байгаа эсэх талаар,

- Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс хувьцаа эзэмшиж байгаа талаар,

- Зэвсэгт хүчний жанжин штабаас цэргийн алба хаасан эсэх талаар гэх мэт лавлагааг авч байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Нэр хаяг тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй цогцосны мэдээллийн сангаас 135, гарын хээний Папилон сангаас 34, галт зэвсгийн хошуу, хонгионы сангаас 8, гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийлгэсэн эсэх талаар 307 лавлагааг 2013 онд бусад хууль сахиулах байгууллагын алба хаагчид авсан байна. Мөн 181 хэргийн газраас олдсон гарын мөр ШШҮХ-ийн гарын мөрний Папилон санд буй гарын мөртэй тохирсон боловч эдгээрээс 64 хэрэг нь гэмт хэргийн мэдээнд бүртгэгдэж, 107 гэмт хэргийн мэдээ бүртгэгдээгүй байна. Энэ нь мөн хууль сахиулах байгууллагын уялдаа холбоо муу байгаагийн нэг илрэл юм.

- шинжээчийн тусгай мэдлэгт хамаарахгүй асуудлаар дүгнэлт гаргуулахаар тогтоол, захирамж гаргадаг байдал; Өнгөрсөн жил зам тээврийн осол хэргийг шийдвэрлэх явцад осол гарсан зам нь нийтийн хэрэгцээний замд

хамаарах эсэхийг шийдвэрлүүлж, дүгнэлт гаргуулахаар шинжээчид хандсан тогтоол Прокурорын байгууллагаас 2 удаа ирүүлсэн байна. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16.1.7-д “шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуулт шинжээчийн тусгай мэдлэгийн хүрэнээс хэтэрсэн, эсхүл тавьсан асуултад шинжлэх ухааны арга, хэрэгсэл ашиглан хариулах боломжгүй бол шинжилгээ хийхээс татгалзана” гэж заасан. Дээрх тохиолдолд хуулийн заалтаар шийдэх асуудлыг шинжээчид тавьсан байна.

- шинжээч томилох тухай тогтоол, захирамж алдаатай, утга, агуулга нь тодорхойгүй байдаг асуудал. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн тогтоол, захирамжийн утга, агуулга нь шинжээчдэд ойлгомжгүй байх тохиолдол багагүй гардаг. Үүнээс үүдэн тавьсан асуулыг буруу ойлгох, улмаар шийдвэрлэх гэж буй асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй байх явдал гарч байна. Энэ асуудал нь шүүх, хууль сахиулах байгууллагуудын өмнө тулгарч байгаа асуудлын нэг хэсэг гэж үзэж байна. Тухайлбал Авлигатай тэмцэх газраас 2013 онд ирүүлсэн 32 тогтоолыг баталгаажуулсан гарын үсэг байхгүй байна. Шүүхээс ирүүлсэн 5 захирамжид шинжээчээс асуусан асуулт байхгүй, өөрөөр хэлбэл “энэхүү хэргийн учрыг олж өгнө үү” гэсэн утгаар захирамж гаргасан байх жишээтэй. Тогтоол захирамжид дараахь нийтлэг дутагдлууд байнга тохиолдож байна. Үүнд:

- Тогтоол бүрийн агуулга, бүтэц өөр өөр, нэг загвартай биш;

- Болсон хэргийн товч утгыг огт дурьдаагүй;
- Шинжээчээс ямар асуулт асууж байгаа нь тодорхойгүй, заримдаа байхгүй;

- Зарим асуулт нь шинжээчийн тусгай мэдлэг шаардахааргүй, өөрөөр хэлбэл мөрдөн байцаагч үзлэг хийж, тодорхойлон бичих асуудал байна;

- Шинжилгээнд ямар объектуудыг, яаж битүүмжлэн хургүүлсэн нь тодорхойгүй;

- шинжээчийн дүгнэлтийг “шүтэх” хандлага бий болсон; Шинжээчийн дүгнэлтийг шүтэж байгаадаа бус, бусад баримтаар нотлох ажиллагааг хийхгүй байгаа тал ажиглагдаж байна. Энэ хандлага хуулийн байгууллагуудын дунд бий болоод зогсохгүй нийгэмд бий болсон сөрөг ойлголт юм. Жишээ нь 2014 оны 05 сарын 12-ны өдөр SBN телевизийн мэдээгээр “БЗД-ийн нутагт 2 хүний амь насыг хохироосон хэрэг гарсан байна. Шүүх эмнэлгийн дүгнэлт гарснаар уг хэрэг эцэслэн шийдэгдэх юм” гэж мэдээлж



байсан бөгөөдийм жишээ олон байна. Энэ нь аливаа хэрэг Шүүхээр эцэслэн шийдэгдэх ёстой атал шинжээчийн дүгнэлтээр шийдэгддэг гэсэн буруу ойлголтыг нийгэмд төрүүлсэн буруу ойлголтуудаас болж Шүүхийн шинжилгээний байгууллагын нэр хүнд, цаашлаад хууль сахиулах байгууллагын нэр хүнд унаж байна.

- шинжилгээний хугацаа; Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11.2-т “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно” гэж заасан. Энэ заалт амьдралд хэрэгжихэд төвөгтэй байгаа нь анзаарагддаг. Учир нь шинжээч томилж буй албан тушаалтан тухайн шинжилгээний цар хэмжээ, онцлогийн талаар мэдлэг муутай, нөгөө талаар шинжээчдийн ажлын ачаалалтай холбоотойгоор хууль зөрчигдөх байдал харагдаж байна. Мөн шинжилгээний хугацаанаас болж хэрэг шийдэгдэхгүй удааширч байна гэсэн шүүмжлэлийг Шүүхийн шинжилгээний байгууллага хүлээн авч энэ тал дээр ахиц дэвшил гаргаж байгаа ч, нөгөө талаар энэ шүүмжлэлийг шүүхийн шинжилгээг ойгодоггүй, нэгдмэл ойлголтгүй, бурууг бусдад тохоох хандлагаар гаргаж байгаа нь анзаарагддаг. Жишээ нь, УЕП-ын туслахБ. Үнэнбат хэвлэлд өгсөн ярилцлагадаа “зарим хүнд төрлийн гэмт хэргүүд шинжилгээний дүгнэлтийг хүлээсээр байгаад хөөн хэлэлцэх хугацаа нь дуусч хэрэгсэхгүй болдог байна<sup>[89]</sup>” гэсэн ярилцлага өгсөн байх юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас бүх төрлийн шинжилгээ хийхэд шаардагдах “жишиг хугацаа”-ны талаар хууль сахиулах байгууллагын алба хаагчдад хүргүүлсэн боловч түүнийг төдийлөн баримтлахгүй байна. Тогтоосон хугацаанаас хэтрүүлэн гаргасан дүгнэлтийн талаар хэдэн төрлийн шинжилгээнд судалгаа хийж үзэхэд дараах дэвшилтэй тал харагдаж байна.

Шүүх эмнэлгийн шинжилгээ:

Шинжилгээний төрөл		Судалгаа хийсэн шинжилгээний тоо	Хугацаа хэтэрсэн дүгнэлт	
			2013	
		2012		
Шүүх эмнэлгийн шинжилгээ	Цогцосны задлан шинжилгээ	556	14,5%	10,2%
	Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	3857	11,8%	4,7%
	Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	185	15,1%	5%

Криминалистикийн шинжилгээ:

Шинжилгээ хийсэн хугацаа	Шинжилгээний тоо /100 шинжилгээнд судалгаа хийв/	
	2012	2013
Өдөртөө гарсан дүгнэлт	-	2
1-3 хоног	6	22
4-7 хоног	11	26
8-14 хоног	23	34
15-20 хоног	36	7
20-дээш хоног	24	9

Биологи, ДНХ, Бактериологи, Хими, Физикийн шинжилгээний чиглэлээр:

Хэтэрсэн хоног	Хугацаа хэтэрсэн шинжилгээ /500 шинжилгээнд судалгаа хийв/	
	2012	2013
1-4 хоног	23	
5-7 хоног	4	
7-дээш хоног	12	

Мөн шинжилгээний хугацаа алдалтыг багасгахад Шүүхийн шинжилгээний байгууллагаас

<sup>89</sup><http://www.medeer.mn/main.php?eid=47044>





авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар шинжилгээ томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас авсан санал асуулгаас харахад санал асуулгад хамрагдсан 70 мөрдөн байцаагч, шүүгчийн 3-аас бусад нь “ахиц гарсан” гэсэн үнэлэлт өгсөн байна.

Хэдийгээр хугацаа алдаж буй шинжилгээ багассан дүр зураг харагдаж байгаа боловч энэ нь шинжилгээний чанарт нөлөөлж болзошгүй гэсэн болгоомжлол байна. Тухайлбал, цогцсыг шинжилгээний байгууллагад авчирмагц нэн даруй шинжилгээ хийхийг шаарддаг явдал. Цогцос хөшиж, хөрөөгүй байхад задлан шинжилгээ хийснээр үхлийн шалтгаан тодорхой тогтоогдохгүй байх талтай гэж шинжээч эмч нар үздэг. Учир нь үхлийн шалтгааныг илэрхийлэх шинж тэмдгүүд 24 цагаас илүү хугацааны дараа эд, эс, эрхтүүдэд илэрдэг байна.

- хүний биед хийх шинжилгээ, гэмтлийн зэрэг тогтоох асуудал; Шүүхийн шинжилгээний байгууллагад хийж байгаа шинжилгээний тал хувийг хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ эзэлж байна. Өнгөрсөн жил 29370<sup>[90]</sup> шинжилгээ хийсэн нь нийт шинжилгээний 50,6% болж байгаа бөгөөд өдөрт дунджаар 80 хүнд шинжилгээ хийж байна гэсэн үг юм. Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 189/385 дугаар тушаалаар баталсан Гэмтлийн зэрэг тогтоох журмын дагуу хийдэг. Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг хийх явцад хэд хэдэн асуудал тулгарч байна. Үүнд:

- Бичиг баримтгүй хүнийг явуулдаг, оронд нь өөр хүн үзүүлсэн тохиолдол гарч байсан байна.
- Согтуу хүнд тогтоол өгөөд явуулдаг
- Их хэмжээгээр бэртэж гэмтсэн хүнийг шууд Шүүх эмнэлэгт үзүүл гэж явуулдаг, зөвхөн өнөөрсдийнажлаабодохбиштухайнхүнийэрүүлмэнд, амьнасыгбодоххэрэгтэй байна.
- Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг хэргийн оролцогчдын аль нэг тал нь хүлээн зөвшөөрөхгүй байх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, гэмтсэн, гэмтээсэн аль нэг талд ашиггүй нөхцөл байдлыг бий болгодгоос шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх шалтгаан болж байна. Энэ нь гэмтлийн зэрэг тогтоох журамд гэмтлийг 3 зэрэгт ангилж үздэгтэй нэг талаар холбоотой гэж үзэж байна.

- шинжилгээний төлбөртэй холбоотой

<sup>90</sup> Шүүх шинжилгээний статистик. УБ., 2013. 5 дахь тал.

асуудал: Шүүхийн шинжилгээний байгууллагад хийж буй хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, цогцот хийх шинжилгээ, эцэг, эх тогтоох ДНХ-ийн шинжилгээ төлбөртэй байдаг. Төлбөрийг Монгол улсын ХЗДХ-ийн болон Сангийн сайдын 2008.07.07-ны өдрийн 170/271 тоот тушаалаар баталсан “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ын дагуу хураан авч Төрийн сангийн дансанд төвлөрүүлдэг. 2013 онд 217,910,100 төгрөгийн орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Төлбөрийн орлого ШШҮХ-д шаардлагатай техник хэрэгсэл, урвалж бодис худалдан авахад зарцуулагддаггүй, төлбөрөөс болж иргэдэд чирэгдэл учирдаг, шүүхийн шинжилгээний байгууллага иргэдийн хооронд үл ойлголцол бий болгож, тэр хэмжээгээр хуулийн байгууллагуудын нэр хүндийг унагаадаг асуудал юм.

- эдийн засгийн шинжилгээний дүгнэлтийг комиссын хурлаар оруулдаг асуудал; Эдийн засгийн шинжилгээ хийх журмын 4.3-т “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд шинжээчийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж мэргэжлийн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Орон тооны бус төв комисс ажиллах ба бүрэлдэхүүнийг Шүүхийн шийнжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал батална”<sup>[91]</sup> гэж заасан бөгөөд энэ журмын дагуу дүгнэлтээ 14 хоногт нэг удаа хуралддаг комиссын хуралдаанаар хэлэлцүүлж байгаа нь шинжилгээний хугацаа удаашрах нэг шалтгаан болж байна. Мөн шинжээч хараат бус байх, нууцыг хадгалах хуулийн зарчим алдагдахад хүрч байгаа асуудал юм.

- дахин, бүрэлдэхүүнтэй шинжилгээний талаар; Ихэвчлэн гарын үсгийн шинжилгээ, гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээнд дахин шинжилгээ томилох явдал гарч байна. Нэг шинжилгээг хэд хэдэн удаа томилдог, шинжээчдийн тоог 3,5,7,9 гэх мэтээр заадаг асуудал нь дээр хэлсэнчлэн шинжээчийн дүгнэлтээр бүх асуудлыг шийдэхээр хүлээж суудаг хандлага газар авсантай холбоотой юм. 2013 онд 1000 орчим шинжилгээг дахин шинжлүүлсэн нь нийт шинжилгээний 1,7 хувийг эзэлж байна. Дахин шинжилгээ хийлгэх эрх нь шинжээч томилох эрх бүхий субъектүүдэд хуулиараа нээлттэй боловч маргааныг зөвхөн шинжээчийн дүгнэлтээр эцэслэн шийдэх хандлага практикт бий болсон нь сайн үр дүн авчрахгүй юм.

Мөн дахин шинжилгээ хийлгэхдээ шинжээчийн бүрэлдэхүүнийг гаднын

<sup>91</sup> Эдийн засгийн шинжилгээ хийх журмын 4.3 дахь заалт.



байгууллагаас томилох нь нийтлэг тохиолдол бөгөөд тэдгээр мэргэжилтнүүдийг шинжээч өөрөө олж шинжилгээ хийлгэх, дүгнэлтэнд хүрсний дараа гарын үсэг зуруулах гэх мэт бэрхшээлтэй асуудлууд хэргийн материалаар хийдэг шүүх эмнэлгийн шинжилгээн дээр ихэвчлэн тохиолдож байна. Хуулинд зааснаар шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэсэн тохиолдолд шинжээчээр томилогдсон этгээд нь шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн дуудсанаар ирж, тавьсан асуултын дагуу дүгнэлт гаргах ёстой. Гэвч дээрх шинжилгээг шинжилгээний байгууллагад ирүүлдэг, бүрэлдэхүүнд оролцох ихэнх нарийн мэргэжлийн эмч нарыг гаднаас томилдог асуудал хуулиар зохицуулагдаагүй байсаар байна. Жишээ нь Дүүргийн шүүхээс иргэний нэхэмжлэлтэй иргэний хэрэгт шинжилгээ хийлгэхээр шинжилгээний хүрээлэнд 2014-02-10-ны өдөр ирснийг хүлээж аваад 2014-02-11-ны өдрийн нарийн мэргэжлийн салбар зөвлөлийн эмч нарыг томилон нэрсийг ирүүлэхийг хүссэн албан бичиг хүргүүлсэн байна. Тус шүүхээс 2014-03-06-ны өдөр мэргэжлийн салбар зөвлөлийн эмч О, Ш нарыг томилсон тухай албан бичгийг ирүүлжээ. Ингээд томилогдсон нарийн мэргэжлийн эмч нарруу хэргийг явуулсан бөгөөд 2014-05-01-ны өдөр хариу ирсэн байна. Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтсээс бүрэлдэхүүнд орсон шинжээч эмч нар 2014-05-08-ны өдөр дүгнэлтийг гаргажээ.

Дүгнэлтэнд нарийн мэргэжлийн эмчийн нарын гарын үсгийг зуруулах тухай шүүгчийн туслахад мэдэгдэхэд та нар зуруулчих гэсэн хариуг хэлсэн бөгөөд тухайн эмч нарруу дүгнэлтийг явуулсан боловч нэг эмч нь одоо хүртэл гарын үсгээ зураагүй байна. Дээрх процессийг тухай бүрт нь шүүгч, шүүгчийн туслахад мэдэгдэж байсан боловч 2014-05-12-ны өдөр Шинжилгээний хүрээлэнд ирүүлсэн албан бичигт “2014-01-29-ны өдөр хүртэл гараагүй хугацаа алдаж байна” гэсэн утгатай албан бичиг ирүүлсэн байх юм. Үүнээс харахад шинжилгээ хийлгэхээр 01 сарын 29-нд шүүгчийн захирамж гарсан боловч Шүүх болон Эрүүл мэндийн салбар зөвлөлөөс томилогдсон шинжээчийн хариуцлагүй байдлаас болж одоо хүртэл дүгнэлт нь гараагүй байна. Үүний цаана хохирсон иргэд Шүүхийн шинжилгээний байгууллагаас болоод хэрэг шийдэгдэхгүй байгаа гэсэн ойлголттой хүлээж суугаа нь тодорхой юм.

- талуудын тэгш байдал, шинжилгээ

хийлгэх тухай иргэдийн хүсэлтийг хангах асуудал; Шүүхийн шинжилгээний тухай хуулинд зааснаар шинжилгээ хийх үндэслэл нь “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын хүсэлт байна”<sup>[92]</sup>. Энэ заалт нь хэргийн оролцогчдын эрхийг зөрчиж байна гэж зарим судлаачид үздэг. Зөвхөн яллах талд үйлчилсэн заалт гэж үзэх нь бий. Мөн иргэдийн зүгээс эцэг, эх тогтоох шинжилгээ ДНХ-ийн шинжилгээ хийлгэх хүсэлтийг өнгөрсөн жилд 150 орчим удаа гаргасан байгаа судалгаа байна. Овог солиулах, хүүхдээ өөрөөрөө овоглох, ЭСЯ-нд виза мэдүүлэх зэрэг хүсэлтийг Шүүх “маргаангүй” гэсэн шалтгаанаар хүлээж авдаггүй, УБЕГ “шинжээчийн дүгнэлт гаргуулаад ир” гэсэн шаардлага тавьдаг, ЭСЯ-нд өөрсдийн улсын хуулийн дагуу “нотолгоо” шаарддаг гэх мэт асуудлуудаас болж иргэд хаана хандахаа мэдэхгүй байдалд хүрч байгаа жишээ олон байна.

СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ:

- **сургалтын бодлого:** Хуулийн байгууллагуудын дунд шүүх шинжилгээний талаар нэгэн буруу ойлголт байдаг, “криминалистик” гэсэн нэр томъёогоор илэрхийлэгдсэн бүхнийг Криминалистикийн шинжилгээний байгууллагатай холбож үзэх болсон явдал юм. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг илрүүлэх шинжлэх ухаан болох криминалистикийн шинжлэх ухааныг явцуу байдлаар ойлгох болсон гэсэн үг. Энэ нь криминалистик зөвхөн шинжээчид хамаатай гэсэн ойлголт юм. Энэхүү буруу ойлголт өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа нь хууль сахиулах байгууллагын удирдах бүрэлдэхүүн, хууль сахиулах ажилтныг бэлддэг боловсролын тогтолцоонд ч ажиглагдсаар байдаг. Тухайлбал хэргийн газрын үзлэгээр биет нотлох баримт цуглуулах ажлыг гэмт хэрэг мөрдөх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтан гүйцэтгэх эрхтэй атал зөвхөн шинжээчид хамаатай мэтээр ойлгодог. Мөн гэмт хэрэг мөрдөх чиглэлээр сурч буй сонсогчид криминалистикийн хичээлээс илүү эрх зүйн хичээлд ач холбогдол өгдөг тал ажиглагддаг. Энэ нь жолооч болох гэж байгаа хүн машин барьж сурахаасаа замын хөдөлгөөний дүрэм сурах нь илүү ач холбогдолтой гэж үзэж байгаатай адил юм. Мөн ХСИС-иас бусад хуулийн сургуулийг төгссөн мэргэжилтнүүд Шүүх, прокурорын байгууллагад ажиллаж байна. Зарим сургуулиудад криминалистик, шүүх

<sup>92</sup> Шүүхийн шинжилгээний тухай хууль. 5.1 дэх заалт.



шинжилгээний хичээлийг мэргэжлийн бус хүн зааж байгаа жишээ бий.

- ажлын хэт ачаалал; Хуулийн заалтыг хэрэгжүүлэх нь хууль сахиулагчдын үүрэг боловч хэргийн хугацаа, ажлын хэт ачааллаас болж аливаа хэрэг маргааныг бүрэн төгс шийдвэрлэж чадахгүй байгаа тал бүх хуулийн байгууллагуудын нийтлэг дүр төрх болсон байна. Энэ байдал нь эрх зүйн зохицуулалт, байгууллагын уялдаа холбоо, бүтэц зохион байгуулалтаас шалтгаалж байгаа боловч хүний нөөцийн бодлоготой шууд хамаатай асуудал гэж үзэж байна. Хэргийг гардаж мөрддөг, шийдвэрлэдэг, шинжилдэг албан хаагчдын тоо бага байгаагаас хэт ачаалалтай ажиллаж байна. Өөрөөр хэлбэл шинжилгээг “үйлдвэрлэл”-ийн загвараар хийж байгаа нь шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримт бүрдүүлэх явдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн төв лабораториуд буюу Криминалистикийн шинжилгээний хэлтэс, Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс, Тусгай шинжилгээний хэлтэс, Эдийн засгийн шинжилгээний хэлтэст 2013 оны байдлаар нийт 121 шинжээч, лаборант, оператор, туслах ажилтан ажиллаж байна<sup>93</sup>.

Криминалистикийн шинжилгээний хэлтэс	Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс	Тусгай шинжилгээний хэлтэс	Эдийн засгийн шинжилгээний хэлтэс
46 албан хаагч (үүнээс 38 шинжээч)	Нийт 45 албан хаагч (үүнээс 26 шинжээч эмч)	22 албан хаагч (үүнээс 15 шинжээч)	8 албан хаагч

2012 онд хийсэн шинжилгээг шинжээчдийн тоонд харьцуулбал:

Шинжилгээний төрөл	Криминали-стикийн шинжилгээ	Шүүх эмнэлгийн шинжилгээ	Хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ	Эдийн засгийн шинжилгээ
Нийт шинжилгээ	4042	17783	12691	278
Нэг шинжээчид оногдох шинжилгээ	106	683	846	35

Дээрх судалгаанаас харвал зарим төрлийн шинжилгээ, тухайлбал биологийн шинжилгээ гэхэд 1 шинжээч жилд 800 гаруй өдөрт 3,3 шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж байгаа байдал харагдаж байна.

### ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН АСУУДАЛ:

Техник, технологийг шинэчлэх, шинээр авч ашиглах олон асуудал тулгарч байна. Тэдгээрээс эн тэргүүнд шийдвэрлэх асуудал нь бидний судалгаагаар Шүүх эмнэлгийн шинжилгээнд буюу хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний явцад шаардлагатай болдог нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношлогоо, шаардлагатай техник хэрэгслийн (КТГ, MRI, Рентген, Тархины цахилгаан бичлэгийн төхөөрөмж, ЭХО, Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат гэх мэт) асуудал гэж үзэж байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэст 2014 онд хийсэн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 3000 шинжилгээнд судалгаа хийхэд 1706 шинжилгээнд нь гаднын эмнэлэг, лабораторийн нарийн мэргэжлийн эмч, техник хэрэгслийн тусламжийг авсан байна. Энэ байдал нь шинжилгээ хийхэд хугацаа алдахаас гадна шинжээчийн дүгнэлтэнд ч буруугаар нөлөөлөхийг үгүйсгэхгүй юм. Өөрөөр хэлбэл, шинжлүүлэгч ямар нэгэн эмнэлэг, лабораторийн хариуг өөрт ашигтай байдлаар гаргуулан авчрах магадлал өндөр байна.

<sup>93</sup> Т.Очирбат. Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны орчин, түүнд хийх шинэтгэл сэдэвт судалгааны ажлын дэд тайлан. УБ., 2013. 8 дахь тал.



1	Дотрынэмчид
1	Зүрхний цахилгаан бичлэг
799	КТГ
117	Лабораторийн шинжилгээ
13	MRI
26	Мэдрэлийн эмчид
55	Нүдний эмчид
1	Нүдний эхо-д
376	рентген
1	Сонстголын бичлэг
6	Тархины цахилгаан бичлэг
2	урологи
52	Цээж гэрэлд харах
51	Чих хамар хоолойн эмчид
6	Шүдний эмчид
8	Эмэгтэйчүүдийн эмчид
3	Эрүүнүүрниймэсэаслын эмчид
1	Бөөрний эмчид
166	эхо-д /дотор, эмэгтэйчүүд/
21	нэмэлт
1706	Нийт

ДҮГНЭЛТ, САНАЛ

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБООНЫ АСУУДАЛ:

1. **Хууль сахиулах байгууллагуудын лавлагаа, мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож ашиглах;**



2. Шинжээчийн тусгай мэдлэгт хамаарахгүй асуудлаар дүгнэлт гаргуулахаар тогтоол, захирамж гаргадаг байдал цөөнгүй гарч байгаа тул хуулийн хоёрдмол утгатай заалтуудад тайлбар гаргуулж, нэгдмэл ойлголттой болох, шүүх, прокурорын байгууллага хуулийг зөв ойлгож, хэрэглэдэг болоход анхаарах хэрэгтэй байна;

3. Шинжээч томилсон тогтоол, захирамжийн агуулга, бүтэц харилцан адилгүй, өөрөөр хэлбэл, тогтоол, захирамжийг гаргахдаа шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч өөрийн дураар бичих хандлага түгээмэл ажиглагдаж байна(Хавсралт-1). Цаашид шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд "Шинжилгээ хийлгэх хүсэлт"-ийн маягтыг бөглөж байх нь зүйтэй гэж үзэж байна. Дээр дурьдсан "Шинжилгээ хийлгэх хүсэлт"-ийн талаар Монгол улсын нөхцөл, уламжлал, хуулийн орчинд нийцүүлэн боловсруулж Шүүх шинжилгээний үйл ажиллагааны тухай хуулинд тусгуулах шаардлагатай бөгөөд "Шинжилгээ хийлгэх хүсэлт"-ийн маягтыг PDF форматаар шууд татаж авах, компьютер дээр бөглөх боломжтой байхаар цахим хэлбэрээр



байрлуулах нь зүйтэй гэсэн саналтай байна. Хуулийн төсөлд оруулахдаа:

а. Эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх хүсэлтийг шинжилгээний байгууллага, шинжээчид гаргана.

б. Хүсэлтийн маягыг хууль зүйн асуудал эрхэлсэн сайд батална... гэсэн агуулгатай байж болох юм;

4. Аливаа хэрэг Шүүхээр эцэслэн шийдэгдэх ёстой атал шинжээчийн дүгнэлтээр шийдэгддэг гэсэн буруу ойлголтыг нийгэмд төрүүлсэн буруу ойлголтуудаас болж Шүүхийн шинжилгээний байгууллагын нэр хүнд, цаашлаад хууль сахиулах байгууллагын нэр хүнд унаж байна. Буруу ойлголт, хандлагыг өөрчлөх арга хэмжээг хууль сахиулах байгууллагууд шат шатандаа хамтран хэрэгжүүлэх;

5. Шинжилгээний хугацаа нь тухайн шинжилгээний цар хүрээ, онцлогоос гадна байгууллагын ажлын ачаалал, шинжилгээнд ирүүлсэн объект, загвар, дээжийн бүрдэлтэй холбоотой байгаа тул түүнийг харгалзан үзэж шинжилгээний хугацааг Шүүхийн шинжилгээний байгууллагаас гаргасан журмыг баримтлан тогтоож байхаар хуулинд өөрчлөлт оруулах;

6. Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний дүгнэлтэд хүнд, хүндэвтэр, хөнгөн, гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэж шууд заах нь буруу гэж үзэж байна. Шинжээч эмч зөвхөн гэмтлийн зэрэгт хамаарах эсэх, гэмтлийн шинж байдал, түүнийг үүсгэсэн хүчин зүйл, хугацаа, амь насанд аюултай эсэхийг тогтоосон дүгнэлт гаргадаг, харин шүүгч тухайн гэмтлийн шалгуур шинжээс үндэслэн гэмтлийн ямар зэрэгт хамаарахыг тогтоодог байх нь зүйтэй юм болов уу гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл шинжээч эмч “Эрүүл мэндийг хохироосон шалгуур шинжийг тогтоох стандарт”-ын дагуу шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг, шүүгч “Гэмтлийн зэрэг тогтоох журам”-ыг үндэслэн гэмтлийн ямар зэрэгт хамаарахыг тогтооно. Мөн гэмтлийг 3 зэрэгт ангилж байгаа нь практикт үл ойлголцол, маргаан дагуулах шалтгаан болж байна. Жишээлбэл, иргэн С, Н харилцан зодолдсоноос С-ийн зүүн гуян дээр түүний алганы хэмжээнээс арай том хэмжээтэй зөөлөн эдийн няцрал үүссэн, харин Н-ийн биед дээрхтэй адил гэмтлээс гадна хоёр нүд нь хөх няц болсон, хамар нь муруйсан, 2 шүд нь булгарч унасан гэмтэл үүссэн тохиолдолд гэмтлийн зэрэг тогтоох шалгуур шинжээр хоёул хөнгөн зэрэгт хамаарч байна. Гэмтлийн зэрэг тогтоолгохоор ирж буй шинжлүүлэгчдийн нэлээд хувь нь

бусдын халдлагад өртөж, бичиг баримт, мөнгө төгрөгөө дээрэмдүүлсэн байдаг. Иймд Улсын бүртгэлийн газартай холбоотой ажиллаж, тухайн хүний мэдээллийг бичиг баримтаар бус, хурууны хээгээр нь мэдэх боломжийг судлаж нэврүүлэх шаардлагатай юм.

7. Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журмыг хүчингүй болгож, Эрүүгийн хэргийг шийдвэрлэх явцад хүний бие, цогцост хийж байгаа шинжилгээг төлбөргүй болгох асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Иргэн хүн амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах гэж төрд татвар төлдөг, гэтэл төр нь иргэнийхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалж чадаагүйнхээ төлөө нэмж төлбөр авч байгаа нь утгагүй хэрэг юм.

8. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн шинжилгээ хийхэд баримтлах зарчмуудыг заасан бөгөөд 4.1.3-т “хараат бус байх”, 4.1.4- т “нууцыг хадгалах” гэж тусгажээ. Иймд “Эдийн засгийн шинжилгээ хийх журам”-д заасан “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд шинжээчийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж мэргэжлийн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Орон тооны бус төв комисс ажиллах ба бүрэлдэхүүнийг Шүүхийн шийнжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал батална” гэж заасан нь хууль зөрчиж байна. Иймд журмын дээрх заалтыг хүчингүй болгуулах нь зүйтэй гэсэн саналтай байна.

9. Дахин шинжилгээг 1-ээс дээш удаа томилох асуудлыг судлан үзэж, таслан зогсоох шаардлагатай гэж судлаачийн хувьд үзэж байна. Харин зөрүүтэй дүгнэлт гарсан тохиолдолд Шүүх хуралдаанд шинжээчдийг оролцуулж аль шинжээч нь шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт гаргасан болохыг шүүгч үнэлдэг байх нь зүйтэй юм. Мөн шинжилгээ хийх бүрэлдэхүүнд орсон нарийн мэргэжлийн эмч нарыг томилох, шинжилгээ хийхэд оролцуулах харилцааг хуулиар зохицуулах, шүүхийн хүнд суртлыг арилгах, хэргийг шийдвэрлэдэг механизмыг нь боловсронгуй болгох талаар холбогдох газрууд санаачлагатай ажиллах шаардлагатай байна. Хуулийн байгууллагуудын тусгай шууданг бий болгох, шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэж байгаа шинжилгээний ажлын хөлсийг хэрхэх тухай шийдвэрлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

10. Өмгөөлөгч нар Хуульчдын холбоогоор дамжуулан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах боломжийг судлан, шинэчлэн найруулж буй



шүүх шинжилгээний тухай хуулинд тусгах. Талуудын тэгш байдлыг эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэсэн жишээ нь АНУ-ын Арканзас мужийн Криминалистикийн лаборатори зөвхөн хууль сахиулах үүрэгтэй агентлагуудаас ирүүлсэн хүсэлтээр шинжилгээ хийдэг байсан боловч хууль сахиулах байгууллагуудын 79-р чуулганы үеэр Улсын өмгөөлөгчдийн хороонд /Public Defender Commission/ лабораторийн үйлчилгээг ашиглах эрх мэдэл өгсөн туршлага юм<sup>94</sup>.

**СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ:**

11. Хууль сахиулахын их сургуулийн сонсогчдод хамгийн түрүүнд хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо, чиг үүрэг, хоорондын уялдаа холбоо, аль чиглэлээр ажиллахад ямар мэдлэг чухал болохыг ойлгуулах сургалтыг оруулах. Бусад хуулийн сургуулиудад шүүх шинжилгээний чиглэлийн хичээлийг мэргэжлийн багш нараар заалгах ажлыг бодлогоор дэмжих;

12. Хууль сахиулах салбарын хэмжээнд хэрэг мөрддөг, шинжилгээг гардан хийдэг, шинжилгээ хийхэд туслах үүрэгтэй оролцдог (лаборант, туслах ажилтан, бага эмч зэрэг) хүний нөөцийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Шаардлагагүй орон тоог багасгаж шинжээчдийн орон тоонд шилжүүлэх шаардлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

**ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН АСУУДАЛ:**

13. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийж буй шинжилгээний 50 хувийг эзэлж байгаа хүний биед хийх шинжилгээний талаас илүү хувьд нь буюу 15 000 шинжилгээнд нарийн мэргэжлийн эмчийн оношлогоо, багаж төхөөрөмж шаардлагатай болж байгаа тул КТГ, MRI, Рентген, Тархины цахилгаан бичлэгийн төхөөрөмж, ЭХО, Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат гэх мэт багаж, тоног төхөөрөмжийг яаралтай авч ашиглах, түүн дээр ажиллах нарийн мэргэжлийн эмч нарын орон тооны асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Хавсралт-1

WASHINGTON STATE PATROL – CRIME LABORATORY REQUEST FOR LABORATORY EXAMINATION				CRIME LAB BAR CODE HERE FOR LAB USE ONLY			
PRIMARY AGENCY CASE NUMBER		RELATED AGENCY CASE NUMBER(S)					
HAS OTHER EVIDENCE IN THIS CASE BEEN PREVIOUSLY SUBMITTED TO A WSP CRIME LAB? <input type="checkbox"/> YES <input type="checkbox"/> NO				OFFENSE	DATE OF OFFENSE		
SUSPECT(S) – LAST, FIRST, MI (SID #, if available)	DOB	VICTIM(S) – LAST, FIRST, MI	ALSO USE THIS SPACE FOR SUBMISSION PRINTS	DOB			
1		1					
2		2					
3		3					
4		4					
INVESTIGATING OFFICER/DETECTIVE (Can be different from submitter) <input type="checkbox"/> RUSH				COURT DATE			
NAME (TYPE OR PRINT) (LAST NAME, FIRST NAME)	RANK/POSITION	BADGE #	SIGNATURE	DATE			
E-MAIL ADDRESS(ES)			PHONE	EXTENSION			
AGENCY	STREET ADDRESS		CITY	ZIP CODE			
EVIDENCE ITEM # (prioritized)	ITEM DESCRIPTION	EXAM CODES	SPECIAL INSTRUCTIONS				
			For DNA: Please submit Supplemental form on initial submission and Consumption form as needed.				
<b>FOR LAB USE ONLY</b>							
SUBMITTED BY: (PRINT NAME—LAST NAME, FIRST NAME)		SIGNATURE	DATE	TIME			
SUBMITTAL METHOD		TRACKING NUMBER					
RECEIVED BY: (PRINT NAME—LAST NAME, FIRST NAME)		SIGNATURE	DATE	TIME			
FOR LAB USE ONLY	Evidence Item #	TRANSFERRED BY	TO	VIA	DATE-TIME	RECEIVED BY	DATE-TIME
	TRACKING NO.						
	TRACKING NO.						
	TRACKING NO.						
Item(s) being released:							
RELEASED TO: (PRINT NAME—LAST NAME, FIRST NAME)		SIGNATURE	DATE	TIME			
RELEASE METHOD <input type="checkbox"/> IN PERSON <input type="checkbox"/> UPS <input type="checkbox"/> FED EX <input type="checkbox"/> U.S. CERT. MAIL		TRACKING NUMBER					
RELEASED BY: (PRINT NAME—LAST NAME, FIRST NAME)		SIGNATURE	DATE	TIME			

<sup>94</sup> <http://www.crimelab.arkansas.gov/>



## ЗАХИРГАА, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



**АУТСОРСИНГ**

Д.Оюунбат  
Отгонтэнгэр их сургуулийн хувийн эрх  
зүйн тэнхимийн багш  
Ж.Дашхүү  
Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд  
сургуулийн багш,  
доктор Ph.D, профессор

**Хураангуй:** Хөдөлмөрийн зах зээлд хувийн зуучлалын аутсорсинг үйлчилгээг нэвтрүүлж байгаа олон улсын хандлага, Монгол оронд нэвтэрсэн нөхцөл байдлыг судалж түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх дүгнэлт, санал гаргалаа.

**Түлхүүр үг:** Аутсорсинг, хүний нөөцийн аутсорсинг, хувийн хөдөлмөрийн зуучлал

Эдийн засгийн хөгжил нь автоматчилал, компьютержилтийг нэмэгдүүлснээр мэдээлэл технологийн хөгжлийн өнөөгийн үед хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэр шаардагдах болжээ. Мөн нөгөө талаас сүүлийн жилүүдэд дэлхийд олборлох үйлдвэрлэлийн хэмжээ буурснаар эдийн засгийн бүтцэд өөрчлөлт орж түүнийг үйлчилгээний салбарын өсөлт нөхсөн байдал нь хөдөлмөрийн зах зээлд шинэ зохицуулалтын эрх зүйн бодлого хэрэгжүүлэх тодорхой арга механизмыг шаардагджээ. Сүүлийн 50 жилийн хугацаанд хөдөлмөрийн зэх зээлийн энэхүү бүтцийн өөрчлөлт нь хөдөлмөрийн захын зуучлалын уламжлалт бус үйлчилгээний эхлэлийг тавьж эрсдэлийг бууруулж бизнес эрчимтэй хөгжихэд түлхэц болсноор олон улсын хэмжээнд энэ асуудал чухлаар тавигджээ.

XXI зуунд дэлхийд гарсан нэг томоохон өөрчлөлт нь мэдээллийн технологийн хөгжлийн үр дүнд бий болсон оюуны ажил хөдөлмөрийг “офшооринг” хийх бололцоотой болсон явдал бөгөөд үүнийг “Аутсорсинг” хэмээн нэрлэдэг.

1. Аутсорсингийн түүх

Аутсорсинг нь эрт дээр үеэс үүсэлтэй бөгөөд

анх Ромын эзэнт гүрэнд аутсорсингтой холбоотой ойлголтууд бий болсон гэж үздэг, тухайлбал 16-р зууны дунд үед Атлантын далайн тээвэрт хөлслөгдсөн далайчдын гуравны нэг нь амь эрсэддэг байснаас эдгээр ажилчдыг нэг л байгууллага дангаараа хөлслөхөд хүндрэлтэй болжээ. Ийм учраас далайчдын хөдөлмөрийг хөлслөх мэргэжлийн байгууллага анх байгуулагдаж байжээ.

Хөдөлмөрийн захад ажиллах хүчийг зуучлах хөдөлмөрийн бирж нь 19-р зууны дунд үеэс үйлдвэрлэл, төмөр замын хөгжлийг дагаж АНУ-д анх үүсч байжээ. Тухайлбал, компаниуд орон тооны шууданчийг хөлслөн ажиллуулахад бэрхшээлтэй, энэ ажил нь эрсдэлтэй байснаас шууданчийг хөлслөх хөдөлмөрийн биржүүд тусдаа байгуулагдаж байжээ. 19 дугаар зууны дунд үед Англи улсад гэрийн үйлчлэгч ажиллуулах хөдөлмөрийн биржийн үйлчилгээ нийтлэг байжээ.

Харин анхны аутсорсингийн компаниуд дэлхийн хоёрдугаар дайны үед байгуулагдаж бизнесийн нарийн мэргэжлийн чиглэлээр хөдөлмөрийн зуучлалын үйлчилгээ үзүүлдэг байжээ.

АНУ-д 1949 онд анхны аутсорсингийн компани болох ADR байгуулагдаж нарийн мэргэжлийн чиглэлээр буюу нягтлан бодогчийг ажилд зуучлах үйлчилгээ үзүүлжээ. Харин 1969 онд Далласд IT чиглэлээр хөдөлмөрийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх EDS аутсорсингийн компани байгуулагдаж байжээ. Энэ байгууллага нь банкуудын балансыг гаргах үйлчилгээ үзүүлснээр тооцоолон бодох зардлыг багасгаж General motors компани жилд 4 сая доллар хэмнэж чаджээ. Альфред Слоун 1921 онд Женерал Моторсыг тэргүүлэх үед энэ байгууллага нь дампуурлын эрмэг дээр байсан боловч аутсорсингийн тусламжтай богино хугацаанд гол өрсөлдөгч Хенри Фордыг түрүүлж чаджээ.

Харин 21 зууны өнөө үед Энэтхэгийн Бангалор, Хятадын Далянь хотыг аутсорсингийн төв хэмээн зүй ёсоор нэрлэдэг. Далянь хот нь Японы программ хангамжийн аутсорсингийн зах зээлийн 60%-ийг дангаараа эзэлж байна. Дээрх улсуудад аутсорсингийг амжилттай хөгжүүлэхэд төрийн хүчтэй дэмжлэг, англи хэлний мэдлэг, шаардлагатай дэд бүтэц, мэдээлэл холбооны сүлжээ, мэдээллийн технологийн





өргөн хэрэгцээ үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь боловсон хүчний хангалттай нөөц, татварын хөнгөлөлт, зардлын хэмнэлт юм.

## 2. Аутсорсингийн тухай ойлголт

Аутсорсинг нь байгууллагынхаа ажлыг гадны мэргэшсэн боловсон хүчнээр богино хугацаанд чанартай, хямд өртгөөр гүйцэтгүүлэхийг хэлнэ. Аутсорсинг гэдэг нь  $OUTSIDE+RESOURCING=OUTSOURCING$  үгний нийлбэр бөгөөд гадны нөөц гэсэн утгатай.

Аутсорсинг нь гэрээнд үндэслэгддэг бөгөөд түүний дагуу хувийн хөдөлмөрийн зуучлалын чиглэлээр мэргэшсэн байгууллага тодорхой төрлийн ажилд иргэнийг зуучлан авч ажлуулах зорилготой байна. Аутсорсингийн гэрээ нь удаан хугацаанд үргэлжлэх онцлогтой бөгөөд ганц удаагийн болон богино хугацааны үйлчилгээнээс ялгагдана.

Байгууллага аутсорсингийн гэрээний үндсэн дээр зарим төрлийн үйл ажиллагааг аутсорсингийн байгууллагад шилжүүлснээр байгууллагын нөөц хөрөнгө, зардлыг хэмнэх, байгууллагын өгөөжийг дээшлүүлэх ач холбогдолтой бөгөөд хөдөлмөрийн нөөц, хөрөнгийг зөв зарцуулах, хэрэгцээтэй чиглэлд зарцуулах мөнгөн хөрөнгөө дайчлах боломж нэмэгдэж байгууллагын хөгжлийг зөв чиглэлд хандуулах давуу талтай.

Байгууллагын ажлыг гадны мэргэшсэн этгээдээр гүйцэтгүүлэх нь хүний нөөцийн аутсорсингийн төрөл бөгөөд өөрөөр “хувийн хөдөлмөрийн зуучлал”<sup>[95]</sup> шинэ ойлголт, нэр томъёо бий болжээ.

Хөдөлмөрийн нөөцийн аутсорсинг буюу ажилтны “хөдөлмөрийг зуучлах нь” байгууллагын хөдөлмөрийн нөөцийг хөлслөх, зохион байгуулах, ажлаас халах, өөр ажилд шилжүүлэх болон түр болон удаан хугацаагаар ажилтныг хөлслөх ажлыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагаар хийлгэхийг ойлгоно.

Аутсорсинг нь байгууллагын хоёрдогч зарим бизнесийн үйл ажиллагаа болох үйлдвэрлэлийн, үйлчилгээний, санхүүгийн, удирдлагын гэх мэт үйл ажиллагааг аутсорсер буюу аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад шилжүүлэхийг хэлнэ.<sup>[96]</sup>

Аутсорсингийн онцлог нь удаан хугацаагаар буюу 1 жил ба түүнээс дээш хугацаагаар үргэлжилж байгууллагын хэвийн, тасралтгүй

<sup>95</sup> А.Шабанов, Как развивался аутсорсинг, история вопроса, 2013г, с.13

<sup>96</sup> В.М.Кицис, Аутсорсинг: понятие, сущность, предпосылки и преимущества использования, 2012 г, с. 22

үйл ажиллагааг хангах онцлог, давуу талтай.

Хөдөлмөрийн зуучлалын үйлчилгээ нь хүмүүн капиталын онолд суурилдаг бөгөөд хүмүүн капитал нь хүнд байж болох ур чадвар, мэдлэг, чадвар зэрэг ойлголтуудын цогц юм. Хүмүүн капитал нь хүнд оруулж буй хөрөнгө оруулалт бөгөөд боловсрол олгох, үйлдвэрлэлийн дадлага олгох, мэргэжлийн ур чадвартай болгох асуудал техник-технологийн реинженерингийн өндөр түвшинд инновацийн удирдлагыг хөгжүүлж байна.

Жирийн ажилтны хөдөлмөр болон хүмүүн капиталын хооронд ялгаа байна. Ажилтны хөдөлмөрийн үнэлэмж нь цалин хөдөлмөрийн хөлс харин хүмүүн капиталын үнэлэмж нь түүний хөдөлмөрийн эрэлт хэрэгцээ, үнэлэмж аутсорсингийн гэрээгээр хөдөлмөрийг олон байгууллага дамжуулан хөлслөх өндөр эрэлт хэрэгцээ бүхий хөдөлмөр юм.

Хүмүүн капиталын онолын үндэслэгчдийн нэг болох Т.Шульц нь “ажилтан компанийн хувьцаа худалдан авч хөрөнгөжих бус харин мэдлэг, ажлын туршлага, ур чадвар олж авах нь хамгийн чухал хөрөнгө оруулалт юм. Өндөр авьяас чадвар шаардсан хөдөлмөр нь хамгийн үнэтэй хүмүүн капитал” юм гэжээ.<sup>[97]</sup>

Ажилтны хөдөлмөр нь хамгийн том капитал буюу хөрөнгө байгаа нь энэхүү хөдөлмөрийг хэрэглэх, удирдан зохион байгуулж хөдөлмөрийн зуучлалын нэгэн хэсэг болгож байна.

Хувийн хөдөлмөрийн зуучлал нь хөдөлмөрийг хөлслөх бүхий л хэлбэрийг агуулж хөдөлмөрийн гэрээнээс ялгагдана. Гадаад орнууд тухайлбал, Латин Америк, Карибын тэнгисийн орнуудын туршлагаас харахад дараахи хандлага ажиглагдаж байна. Үүнд:

1. Ажлын байр нь өндөр хэмжээнд хамгаалагдаж хөдөлмөр эрхлэлт өндөр түвшинд байдаг боловч нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлд шинэ боловсон хүчин орж ирэхэд саадтай ялангуяа залуучууд болон залуу ээж нар, удаан хугацаанд ажилгүй байсан хүмүүст ихээхэн хүндрэлтэй байдаг байна.

2. Байнгын ажлын байранд хөдөлмөрийн хугацаагүй гэрээ байгуулагдснаар хугацаат хөдөлмөрийн гэрээ байгуулах боломж буурдаг.

<sup>97</sup> Т.Ю.Коршунова, правовое регулирование отношений, связанных с направлением работников для выполнения работ в других организациях (заёмный труд) Трудовое право, 2005г, №6(64), с.7



3. Хугацаат хөдөлмөрийн гэрээ байгуулах зохицуулалт нь уян хатан бус байдлаас байгуулагад илүүдэл хөдөлмөрийн хүч буй болдог нь хөдөлмөрийн хөлсний хэмжээ буурахад хүргэдэг байна.

4. Эдийн засгийн шалтгаанаар ажлаас халахыг хориглох зохицуулалт болон хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулах нь албан бус хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх шалтгаан болдог.

Эдгээр нь хувийн хөдөлмөрийн зуучлалын давуу болон сул талын хандлага илэрснийг харуулж байна. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан уламжлалт хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрээс гадна өөр илүү боловсронгуй хөдөлмөр эрхлэлтийн арга, хэлбэр шаардагдаж хөдөлмөрийн зах зээлд залуучууд, эмэгтэйчүүд болон бусад хөдөлмөр эрхлэлтийн түвшин бага ангилалд багтдаг хөдөлмөрийг зохицуулах шаардлагатай болжээ.<sup>[98]</sup>

Мөн нөгөө талаас ажил олгогч ажилтны хөдөлмөрийг хөдөлмөрийн гэрээгээр хөлслөхөөс гадна бизнесийн байгууллагатай хөдөлмөрийн зуучлалын гэрээ байгуулж зарим ажилтныг хөдөлмөрийн зуучлалын гэрээгээр хөлсөлж эхэлжээ. Эхэн үед хөдөлмөрийн зуучлалын мэргэжлийн байгууллага байгаагүй бөгөөд энэхүү үйлчилгээг бизнесийн байгууллага гүйцэтгэж иржээ. Энэхүү хөдөлмөрийн зуучлалын шинэ хэлбэр буй болсноос эхлэн “нэг байгууллага нэг ажил олгогч” хэмээн энэхүү загвар эвдэгдэж хөдөлмөрийг иргэний ажил гүйцэтгэх, зуучлалын гэрээгээр зохицуулах болжээ.<sup>[99]</sup>

Хөдөлмөрийн харилцааг иргэний гэрээгээр зохицуулахад ажилтны хөдөлмөрийг хөдөлмөрийн хуулиар зохицуулахаас хөдөлмөрлөх эрх нь хамгаалагдах боломж баталгаа нь багасах сөрөг талтай байна.

ОУХБ нь Аутсорсингийн хөдөлмөрийн зуучлалд болгоомжтой хүлээцтэй хандаж байна. Хувийн хөдөлмөрийн зуучлалын асуудлыг ОУХБ 1993, 1994, 1995 онуудад удаа дараа авч хэлэлцэж хувийн хөдөлмөрийн асуудлыг ажил гүйцэтгэх гэрээгээр зохицуулах тухай асуудлыг хэлэлцсэн боловч тодорхой шийдэлд хүрээгүй, энэ асуудлыг ОУХБ-ын бага хурлын хэлэлцэх асуудалд оруулаагүй байна.

Ийм учраас энэ асуудлаар ОУХБ-ын хууль

<sup>98</sup>Труд на условиях подряда. Доклад VI (1). Международное бюро труда, Женева, 1997 г, с.3

<sup>99</sup>Т.Ю.Коршунова, Правовое регулирование отношений, связанных с направлением работников для выполнения работ в других организациях, Трудовое право, 2005г, №6(64), с.9

тогтоомж болон зөвлөмж гаргаагүй.

Гэвч 1997 онд ОУХБ-ын илтгэлд:

“ОУХБ-ын шинжээчид хувийн хөдөлмөрийн зуучлалын үйлчилгээг хоёр эсвэл гурван талт байж болно хэмээн тэмдэглээд эхний тохиолдолд талууд нь ажил олгогч болон зуучлуулагч байгууллага, харин гуравдагч тал нь бүртгэлтэй мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсвэл хоёрдахь хувилбар нь хувийн хөдөлмөрийн зуучлалын байгууллага байж болно” гэж тэмдэглэжээ.<sup>[100]</sup>

### **3.Хувийн хөдөлмөрийн зуучлалын тухай ойлголт**

Байгууллага нь үндсэн биш үйл ажиллагааны зарим хэсгийг гэрээний дагуу компанид даатгаж тэрхүү компани нь тодорхой төрлийн мэргэжлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг байна. Тухайлбал, байгууллагын өрөөний цэвэрлэгээ, харуул хамгаалалтын үйлчилгээ, it үйлчилгээ гэх мэт.

Компани болон байгууллагын хооронд аутсорсингийн харилцаа үүсэх эрх зүйн үндэслэл нь иргэний эрх зүйн гэрээ байна. Ажилтан нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагын орон тоонд багтан хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэнэ. Хөдөлмөрлөх үүргийн онцлог шинж нь ажилтан үйлчилгээ үзүүлэгч байгууллагын орон тоонд багтах хэдий ч үнэндээ хөдөлмөрлөх үүргээ өөр байгууллагад гүйцэтгэж хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль тогтоомжид захирагдана, энэ тохиолдолд хяналтын үүргийг зуучлагч зүүчлуулагч хоёр байгууллага зэрэг гүйцэтгэнэ. Үйлчилгээ үзүүлэгч буюу зуучлагч байгууллагын ажилтнууд зуучлалын гэрээний үндсэн дээр хүлээсэн үүргээ биелүүлж гэрээгээр тохиролцсон тодорхой хөдөлмөрлөх үүргийг биелүүлнэ. Энэхүү гэрээний дагуу зуучлагч байгууллага ажилтны хооронд хөдөлмөрийн харилцаа үүсч түүний дагуу ажил олгогчийн хүлээх үүрэг, эдлэх эрхийг хэрэгжүүлж нөгөөтэйгүүр ажилтан гэрээгээр хүлээсэн хөдөлмөрлөх үүргээ ёсчлон гүйцэтгэнэ.

Хүний нөөцийн аутсорсингийн үйлчилгээ нэвтэрснээр ажил олгогч цалин хөдөлмөрийн хөлс, байгууллагын орон тоогоо хэмнэж үндсэн үйл ажиллагааны чиглэлээс бусад туслах чанартай хөдөлмөрлөх үүргийг аутсорсингийн компанид шилжүүлнэ. Хүний нөөцийн аутсорсинг гэдэг нь аутсорсингийн нэгэн төрөл бөгөөд

<sup>100</sup> Труд на условиях подряда. Доклад VI(1), международное бюро труда, Женева, 1997 г, с.5



хүний нөөцийн зарим эсвэл бүхий л үйл ажиллагааг гадны мэргэшсэн байгууллагад шилжүүлэх тухайлбал, ажилтныг хөлслөх, нийгмийн даатгалын дэвтрийг хөтлөх, тушаалыг төлөвлөх, цалин хөдөлмөрийн хөлс, урамшууллын тооцоог гаргах, албан тушаалын заавар гаргах, хүний нөөцийн сургалт зэргийг зохион байгуулна.


Аутсорсинг нь хүний нөөцийн удирдлагын үүргийг төгөлдөржүүлэх үүргийг хэрэгжүүлнэ. Аутсорсинг нь тухайн байгууллагын үндсэн чиглэл болсон хөдөлмөрийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад түшиглэх бөгөөд энэхүү байгууллага нь хөдөлмөрийн нөөцийн чиглэлээр мэргэшсэн байна.

### Аутсорсингийн үйл ажиллагаа Монгол улсад

Монгол улсад хувийн хөдөлмөрийн бирж нь 2008 оноос эхлэн хөгжиж эхэлсэн. Харин аутсорсингийн хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрийг 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хэрэгжүүлэгч байгууллага нь Монгол Улсын Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ судалгаа мэдээллийн үндэсний төв болон холбогдох мэргэжлийн байгууллага байсан.



Монгол Улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй Аж ахуйн нэгжүүдийн 40 гаруй хувь нь аутсорсингийг дагнан болон хавсрага байдлаар эрхэлдэг болох нь судалгаанаас харагдсан.

Компаниудын аутсорсинг эрхлэлтийн байдал 2013 оны байдлаар



Хувь хүмүүсийн аутсорсинг гүйцэтгэдэг байдал

Манай оронд ч мөн адил энэ төрлийн хөдөлмөр эрхлэлт голлох байр суурьтай болсон нь илэрхий байна. Аутсорсингийн хөдөлмөр эрхлэгчид нь албан ёсоор бүртгэлгүй байдаг бөгөөд нийгмийн даатгалыг хууль ёсоор төлдөггүй нь далд хөдөлмөр эрхлэлтийн нэгэн хэлбэр болж



явдаг. Иймээс эдгээр хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэлжүүлж, нийгмийн асуудлуудыг нь шийдэх, тэд нарт төрийн үйлчилгээг хүртээх нь чухал болоод байна.

Монгол улсад аутсорсингийн дараахи үндсэн хэлбэрүүд хөгжиж ирсэн бөгөөд үүнд:

1. МТ-ийн аутсорсинг (ИТО)
  - Програм хангамж хөгжүүлэлт
  - МТ-ийн үйлчилгээ
2. Бизнес, үйл ажиллагааны аутсорсинг (ВРО)
  - САМ/CAD
  - Санхүүгийн тооцоо
  - График дизайн, анимэшин
  - Өгөгдөл оруулах, боловсруулах
  - Дуудлагын төв (Call center) гэх мэт.
3. Мэдлэгийн аутсорсинг (КРО)
  - Хуулийн зөвлөгөө
  - Консалтинг

Монгол улсад 2013 онд хөдөлмөрийн 44 хувийн зуучлалын алба боловсрол, барилга, уул уурхай, боловсруулах үйлдвэр, зам тээвэр, үйлчилгээний 6 салбарт 1016 хүнийг зуучилсан байна. Харин 2015 оны байдлаар 5000 хүн ажилд зуучилсан байна. "Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам"-ын дагуу зуучлагдсан ажил олоход хүндрэлтэй иргэн нь 6 сараас дээш хугацаагаар тогтвортой



ажиллаж байгаа бол 120.0 мянган төгрөг, 12 сараас дээш хугацаагаар тогтвортой ажиллаж байгаа бол 240.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хүн тус бүрээр тооцож олгодог.<sup>[101]</sup> Харин 2016 оны 3-р сарын байдлаар 3875 хүнийг ажлын байранд зуучлаад байна. (доорхи хүснэгтээс харна уу)

Он	Аутсорсингийн зарчмаар хувийн хөдөлмөр зуучлах үйлчилгээ явуулж буй байгууллагын тоо	Зуучилсан хүний тоо	Санхүүжилт
2016	58 байгууллага	3867	149 825 900 төг

<sup>101</sup> Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж санхүүжилт олгох журам, Хөдөлмөрийн сайдын 2013 оны А 92 тоот тушаал

Харин Хөдөлмөрийн сайдын 2014 оны А /123 тоот тушаалын дагуу санхүүжилтийг тарифаар тооцдог болсон байна.

Аутсорсингийн үйлчилгээ эрхлэх нь олон давуу талуудтай бөгөөд заавал захиалагчийн ажлын байранд очилгүйгээр зайнаас хөдөлмөрлөх боломжтой байдаг нь хөдөө орон нутгийн алслагдсан сум суурингуудын иргэдийг ажлын байраар хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэртээ суугаад ажил хөдөлмөр эрхлэх зэрэг боломжоор хангаж өгдөгөөрөө чухал ач холбогдолтой юм.

### Дүгнэлт

Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд аутсорсингийн зарчмаар хувийн хөдөлмөр зуучлалын үйлчилгээ явагдаж байгаа нь дээр дурьдсан баримт материалаас харагдаж байна.

Хэдий тийм боловч албан бус хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хамрагдаж байна. Ийм учраас аутсорсингийн зарчмаар хөдөлмөр зуучилж буй байгууллагын үйл ажиллагаа нь Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээлэлд орохгүй байна. Үүнээс болж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас авсан хөрөнгийн үр дүнгээр шинээр ажилд зуучлагдсан мэдээлэл бүрэн биш гарч байна.

Мөн хувийн хөдөлмөр зуучлалын үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн ганц заалтаар зохицуулж байгаа нь хангалттай бус, тухайн харилцааг зохицуулах холбогдох дүрэм журмууд дутагдалтай байна.<sup>[102]</sup>

Энэ төрлийн үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдэд төрийн зүгээс хяналт тавих эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүйн улмаас зуучлагдаж байгаа иргэдийн эрх зөрчигдөх өндөр магадлалтай. Харин ОУХБ-ын 1997 оны "Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын" тухай конвенцид нэгдэн орсноор зуучлагдсан иргэдийн эрх ашиг хохирохгүй байх, ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалах эрх зүйн зохицуулалт

<sup>102</sup> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9-р зүйл : Ажилд зуучлах тухай, 2011 оны 6-р сарын 17-ны өдөр

сайжирч, улмаар хөдөлмөр эрхлэлтийн хувийн албадын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх боломж бүрдэнэ.

### Санал

Аутсорсингийн хэлбэрийн хувийн хөдөлмөр зуучлалын үйлчилгээг шаардлагатай цаг үед нь хэрэгцээтэй салбар нэгжид нь хэрэгжүүлж хөдөлмөрийн статистикийн үндэсний тооцооллын системд тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

1 Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг статистикийн эмхтгэлийн 2016 оны дугаар хараахан гараагүй бөгөөд 2015 оны дугаарыг судлан үзэхэд "гэмт хэрэг" гэсэн үзүүлэлтээр 10 төрлийн үзүүлэлтийг багтаан нийтэлсэн байна.

2 Философи. УБ., 2012 он. 273 талд Эммануиль Левинасын үзэж байгаагаар "Оюун ухаан нь хэлээр дамжиж амьдардаг" гэсэн нь бидний хувьд анхаарал татаж байна.

3 1937 оны 09 дүгээр сарын 10-аас хэлмэгдүүлэлтийн баривчилгаа эхэлжээ. ДЯЯ-ны сайд маршал Х.Чойбалсан мөн яамны төвийн ажилтнуудын чуулган дээр 1937 оны 09- дүгээр сарын 11-нд хэлсэн үгнээс. "Манайд японы эсэргүү тагнуулын хэрэг баригдаад байна. Гэндэн нарын удирдлагатай бүлгэм эсэргүү Лхүмбийн хэргийг үргэлжлүүлж ирсэн... Толгой нь Гэндэн, Мэнд, Намсрай, Аюуш... Туйлдаа хүрсэн тул нам засгаас баривчлахыг даалгасан... Байцаахдаа эрс хатуу байх хэрэгтэй. Гэндэнгийн мэдүүлгийг баримттай зүйлээс байцаахад болно. Энэ оройноос эхлэн байцаалтанд орох хэрэгтэй. 25 хоногоос хэтрүүлэлгүй зориуд дуусгахыг тушаал болгон хэлье. Хайрлах явдал хэрэггүй. Хайр найргүйгээр илрүүлэх хэрэгтэй. Эдний гол бодлого нь Японы колони! Хүчтэй ажиллахыг даалгаж байна" гэсэн тушаал буулгасан байна.